



**МОНГОЛ УЛСЫН МӨНГӨ  
УГААХ, ТЕРРОРИЗМЫГ  
САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ  
ТОГТОЛЦООНЫ  
ХАРИЛЦАН ҮНЭЛГЭЭНИЙ  
ТАЙЛАН**

2017 оны 9 дүгээр сар





Мөнгө угаахтай тэмцэх Ази, Номхон далайн бүсийн байгууллага (АНДББ) нь 1997 онд Тайланд улсын Бангкок хотноо байгуулагдсан эгнээндээ 41 гишүүн улс орон, олон улсын болон бүс нутгийн хэд хэдэн ажиглагчдыг багтаасан бие даасан, олон улсын хамтын ажиллагааны байгууллага билээ. АНДББ-ыг дэмжиж хамтран ажилладаг байгууллагын тоонд Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (ФАТФ), Олон улсын валютын сан, Дэлхийн банк, ЭЗХАХБ, Мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн НҮБ-ын алба, Азийн хөгжлийн банк болон Санхүүгийн мэдээллийн албадын Эгмонт бүлэг ордог.

АНДББ-ын гишүүд болон ажиглагчид нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандартыг, ялангуяа ФАТФ-ын 40 зөвлөмжийг хэрэгжүүлж биелүүлэхийг эрмэлздэг болно.

АНДББ-ын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг [www.apgml.org](http://www.apgml.org) цахим хуудаснаас авна уу.

Энэхүү Харилцан үнэлгээний тайланг 2017 оны 7 дугаар сард болсон АНДББ-ын жилийн уулзалтын үеэр батлав.

© АНДББ 2017 оны 9 дүгээр сар

Энэхүү тайланг зөвхөн бичгээр авсан зөвшөөрлийн дагуу олшруулах буюу орчуулах боломжтой. Энэхүү тайланг бүхлээр эсхүл хэсэгчлэн олшруулах зөвшөөрлийг авахын тулд дараахь хаягаар хүсэлт гаргана уу:

APG Secretariat  
Locked Bag A3000  
Sydney South  
New South Wales 1232  
AUSTRALIA  
Утас: +61 2 9277 0600

Цахим хаяг: [mail@apgml.org](mailto:mail@apgml.org)  
Вэб: [www.apgml.org](http://www.apgml.org)

Хавтасны зураг: Монгол Улсын Засгийн газраас авав

Тайлангийн англи хэл дээрх эхийг доорхи холбоосоос авна уу:

<http://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/mer-fsrb/Mongolia%20MER%202017%20-%20published%20version.pdf>

Орчуулгыг: Санхүүгийн мэдээллийн алба. 2018.03.19.

## АГУУЛГА

|   |    |
|---|----|
| <b>ТОВЧ ХУРААНГУЙ</b> .....   | 4  |
| А. Хураангуй.....   | 4  |
| В. Эрсдэл ба Ерөнхий нөхцөл байдал.....   | 7  |
| С. Үр дүнтэй байдал болон техникийн хэрэгжилтийн ерөнхий байдал.....                            | 8  |
| D. Нэн түрүүнд авах арга хэмжээ.....  | 13 |
| E. Техникийн хэрэгжилт болон Үр дүнтэй байдлын үнэлгээ.....                                     | 14 |
| <b>ХАРИЛЦАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН</b> .....   | 17 |
| Оршил.....  | 17 |
| <b>БҮЛЭГ 1. МУТСТ ЭРСДЭЛ БОЛОН ОРЧИН НӨХЦӨЛ</b> .....   | 18 |
| МУТСТ Эрсдэл ба өндөр эрсдэлтэй асуудлуудын хамрах хүрээ .....                                  | 18 |
| Эдийн засгийн нөхцөл байдал.....  | 24 |
| Бүтцийн хүчин зүйлс.....  | 26 |
| Суурь болон бусад хүчин зүйлс .....   | 29 |
| <b>БҮЛЭГ 2. ҮНДЭСНИЙ МУТСТ БОДЛОГО БА ЗОХИЦУУЛАЛТ</b> .....                                     | 40 |
| Дүгнэлт ба авах арга хэмжээний зөвлөмж .....  | 40 |
| Шууд Хэрэгжилт 1 (Эрсдэл, Бодлого ба Зохицуулалт) .....   | 41 |
| <b>БҮЛЭГ 3. ЭРХ ЗҮЙН СИСТЕМ БА ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АСУУДАЛ</b> .....                                | 48 |
| Дүгнэлт ба авах арга хэмжээний зөвлөмж .....  | 48 |
| Шууд Хэрэгжилт 6 (МУТСТ Санхүүгийн мэдээлэл).....   | 50 |
| Шууд Хэрэгжилт 7 (МУ мөрдөн шалгах ба шийдвэрлэх).....  | 57 |
| Шууд хэрэгжилт 8 (Хөрөнгө хураах) .....   | 61 |
| <b>БҮЛЭГ 4. ТЕРРОРИЗМЫГ БОЛОН ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ<br/>ДЭЛГЭРҮҮЛЭХИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ</b> ..... | 65 |
| Дүгнэлт ба авах арга хэмжээний зөвлөмж .....  | 65 |
| Шууд хэрэгжилт 9 (ТС мөрдөн шалгах ба шийдвэрлэх) .....   | 67 |
| Шууд хэрэгжилт 10 (ТС- ээс урьдчилан сэргийлэх болон санхүүгийн хориг арга<br>хэмжээ) .....     | 69 |
| Шууд хэрэгжилт 11 (ҮОХЗДС эсрэг хориг арга хэмжээ) .....  | 71 |
| <b>БҮЛЭГ 5. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ</b> .....   | 73 |
| Дүгнэлт ба хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж .....   | 73 |
| Шууд хэрэгжилт 4 (Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа) .....                                      | 74 |
| <b>БҮЛЭГ 6. ХЯНАЛТ ШАЛГАЛТ</b> .....  | 81 |
| Дүгнэлт ба авах арга хэмжээний зөвлөмж .....  | 81 |

|   |     |
|---|-----|
| ШУУД ХЭРЭГЖИЛТ 3 (ХЯНАЛТ, ШАЛГАЛТ) .....  | 82  |
| БҮЛЭГ 7. ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛОН БУСАД ЗОХИЦУУЛАЛТ БҮХИЙ ЭТГЭЭДҮҮД .....                                     | 93  |
| Дүгнэлт болон хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж.....   | 93  |
| Шууд хэрэгжилт 5 (Хуулийн этгээд/бусад зохицуулалт бүхий этгээд).....                                     | 94  |
| БҮЛЭГ 8. ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА .....  | 98  |
| Дүгнэлт ба хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж .....   | 98  |
| Шууд хэрэгжилт 2 (Олон улсын хамтын ажиллагаа).....   | 99  |
| ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ.....  | 105 |
| Зөвлөмж 1 – Эрсдэлийн үнэлгээ, эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх.....                              | 105 |
| Зөвлөмж 2 – Үндэсний хамтын ажиллагаа, уялдаа холбоо .....  | 107 |
| Зөвлөмж 3 – Мөнгө угаах гэмт хэрэг.....   | 108 |
| Зөвлөмж 4 – Хөрөнгө хураан авах болон түр зуурын арга хэмжээ .....  | 110 |
| Зөвлөмж 5 – Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг .....   | 111 |
| Зөвлөмж 6 – Терроризм болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ ..... | 113 |
| Зөвлөмж 7 –Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ.....    | 115 |
| Зөвлөмж 8 – Ашгийн бус байгууллагууд .....  | 116 |
| Зөвлөмж 9 – Санхүүгийн байгууллагын нууцлалтай холбоотой хууль тогтоомж.....                              | 119 |
| Зөвлөмж 10 – Харилцагчийг таньж мэдэх .....   | 120 |
| Зөвлөмж 11 – Баримт, материал хадгалалт .....   | 123 |
| Зөвлөмж 12 – Улс төрд нөлөө бүхий этгээд /УТНБЭ/ .....  | 124 |
| Зөвлөмж 13 – Корреспондент банкны үйл ажиллагаа .....   | 125 |
| Зөвлөмж 14 – Мөнгө болон үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ.....  | 126 |
| Зөвлөмж 15 – Шинэ технологи .....   | 127 |
| Зөвлөмж 16 – Цахим шилжүүлэг .....  | 128 |
| Зөвлөмж 17 –Гуравдагч этгээдэд тулгуурлах .....   | 130 |
| Зөвлөмж 18 – Дотоод хяналт болон гадаад дахь салбар, охин компани.....                                    | 131 |
| Зөвлөмж 19 – Өндөр эрсдэлтэй улс орнууд .....   | 132 |
| Зөвлөмж 20 – Сэжигтэй гүйлгээг мэдээлэх.....  | 133 |
| Зөвлөмж 21 – Мэдээллийг задруулах болон нууцлал.....  | 134 |
| Зөвлөмж 22- СББМҮҮ Харилцагчийг таньж мэдэх .....   | 135 |
| Зөвлөмж 23- СББМҮҮ Бусад арга хэмжээ.....   | 136 |
| Зөвлөмж 24- Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон тод байдал .....                                       | 137 |
| Зөвлөмж 25- Эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн ил тод байдал болон эцсийн өмчлөгч.....            | 140 |

|  |     |
|--|-----|
| Зөвлөмж 26- Санхүүгийн байгууллагуудын зохицуулалт, хяналт шалгалт .....       | 142 |
| Зөвлөмж 27-Хянан шалгагчдын эрх мэдэл .....                                    | 144 |
| Зөвлөмж 28 – СББМҮҮ-ийн зохицуулалт, хяналт шалгалт.....                       | 146 |
| Зөвлөмж 29- Санхүүгийн мэдээллийн алба .....                                   | 146 |
| Зөвлөмж 30- Хууль сахиулах болон мөрдөн шалгах байгууллагуудын хариуцлага .... | 149 |
| Зөвлөмж 31- Хууль сахиулах болон мөрдөн шалгах байгууллагуудын эрх мэдэл.....  | 150 |
| Зөвлөмж 32- Бэлэн мөнгө тээвэрлэгчид .....                                     | 151 |
| Зөвлөмж 33 - Статистик .....   | 153 |
| Зөвлөмж 34- Зааварчилгаа эргэх холбоо .....                                    | 153 |
| Зөвлөмж 35- Шийтгэлийн арга хэмжээ .....                                       | 154 |
| Зөвлөмж 36- Олон улсын хамтын ажиллагааны арга хэрэгслүүд.....                 | 157 |
| Зөвлөмж 37- Эрх зүйн харилцан туслалцаа .....                                  | 158 |
| Зөвлөмж 38 - Эрх зүйн харилцан туслалцаа: Хөрөнгө царцаах, хураах .....        | 159 |
| Зөвлөмж 39- Гэмт хэрэгтнийг шилжүүлэх.....                                     | 160 |
| Зөвлөмж 40- Олон улсын хамтын ажиллагааны бусад хэлбэр.....                    | 161 |
| Хураангуй: Техникийн хэрэгжилтийн үндсэн сул талууд.....                       | 165 |
| ҮГИЙН ТОВЧЛОЛЫН ТАЙЛБАР .....  | 173 |

## ТОВЧ ХУРААНГУЙ

1. Энэ тайланд Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд харилцан үнэлгээ хийсэн багийн айлчлал хийх үе буюу 2016 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн байдлаар дүгнэн харуулсан болно. ФАТФ-ын 40 зөвлөмжийн биелэлт болон МУТСТ тогтолцоонд дүн шинжилгээ хийж, хэрхэн сайжруулах талаар зөвлөмж өгсөн болно.

### А. Хураангуй

- Монгол Улс мөнгө угаах (МУ) олон төрлийн эрсдэл, эмзэг сул талтай нүүр тулж байна. Өндөр эрсдэлтэй суурь гэмт хэрэгт залилан, байгаль орчны эсрэг гэмт хэрэг, татвараас зайлсхийх, авлига; дундаж эрсдэлтэй гэмт хэрэгт хэрэгт хар тамхи, контрабанд буюу хилээр хууль бусаар нэвтрүүлэх, зохион байгуулалттай гэмт хэрэг, банкны зохицуулалтын эсрэг гэмт хэрэг, хулгай, гадаадад үйлдсэн гэмт хэргийн хөрөнгө мөнгөтэй холбоотой эрсдэл багтаж байна. Эдгээр суурь гэмт хэрэг үйлдэж олсон орлогын үндсэн хэсгийг Монгол Улсад, үлдсэн хэсгийг (ялангуяа авлигын) оффшор бүсэд угааж байна.
- Монгол Улсын терроризмыг санхүүжүүлэх эрсдэлд өртөх магадлал харьцангуй бага байж магадгүй. Мэдээллийн нээлттэй эх сурвалжаас харахад Аль Каида, Талибан эсхүл Исламын улстай холбоотой үйл ажиллагаа Монгол Улсад бүртгэгдээгүй бөгөөд алан хядагчдыг бэлтгэдэг буюу нутгаараа дамжин өнгөрүүлдэг улс орны тоонд Монгол Улс багтдаггүй байна. Монгол Улсад террорист халдлага гарсан эсхүл террорист бүлэглэлүүд үйл ажиллагаа явуулсан гэх тохиолдол бүртгэгдээгүй аж.
- Монгол Улсын 1, 3, 4, 5, 6, 7, 9, 10 болон 11-р Шууд Хэрэгжилтийн үр дүнтэй байдал доогуур түвшинд байна. Монгол Улсын 2 болон 8-р Шууд Хэрэгжилтийн үр дүнтэй байдал дундаж түвшинд байна.
- Монгол Улс өөрийн анхны МУТС Үндэсний эрсдэлийн үнэлгээ (ҮЭҮ)-г 2016 онд гүйцэтгэж, үнэлгээний баг Монголд ажиллах үеэр эцэслэж хэвлүүлсэн болно. ҮЭҮ-нд МУ сэдвийг голчлон хөндсөн ч асуудлыг тал бүрээс нь (аюул занал, үр дагавар, эмзэг сул тал) задлан шинжилсэн Монгол Улсын МУ-ын эрсдэлийн цогц үнэлгээ болж чадаагүй байна. Хувийн секторын болон ҮЭҮ-г боловсруулахад оролцоогүй засгийн газрын агентлагуудын МУ эрсдэлийн талаарх ойлголтыг эрс дээшлүүлэх шаардлагатай.
- ҮЭҮ-нд ТС-ийн аюул занал, эмзэг сул талын дүн шинжилгээг хангалтгүй түвшинд хийсэн байна. Засгийн газрын агентлагууд, хувийн секторын ТС эрсдэлийн талаарх ойлголтыг эрс дээшлүүлэх шаардлагатай.
- Монгол Улсад МУТСТ ажлын уялдааг хангах үүрэгтэй бүтэц, нэгжүүд бий ч тэдний үйл ажиллагааг уялдуулж зохицуулах чадвар сул байна. Үнэлгээний баг Монголд ажиллах хугацаанд Монгол Улсад МУТСТ үндэсний стратеги байгаагүй буюу ҮЭҮ-нд энэ талаар дурдаагүй болно.
- Санхүүгийн мэдээлэлд (тухайлбал, СМА-ны үйл ажиллагааны шинжилгээг) суурилан МУ болон суурь гэмт хэргийн мөрдөн шалгалтыг эхлүүлсэн тохиолдол ховор байна. СМА-ны ажил юуны түрүүнд ХСБ-уудын хэрэгцээ шаардлагыг хангах, тухайлбал

лавлагаанд хариу өгөхөд чиглэгдэж байна. СМА-ны зүгээс стратегийн шинжилгээ гүйцэтгэсэн эсхүл шилжүүлсэн тохиолдол байхгүй байна.

- Монгол Улсад МУТС тэмцэх үндэсний бодлого үгүйлэгдэж байна. ХСБ-уудын дотоод дүрэм журам, удирдамж чиглэлд МУ гэмт хэргийг онцгойлон авч үзэж чадахгүй байна. ХСБ-уудын зүгээс мөнгө угаасан байж болзошгүй олон хэргийг шалгадаг ч мөрдөн шалгах шатанд ердөө 46 хэрэг шилжсэн байна. Эдгээрээс зөвхөн 2 хэрэгт ял оногдуулсан ч анхан шатны шүүхийн шийдвэрийг Дээд шүүхээс хэрэгсэхгүй болгожээ. ХСБ-ууд ихэвчлэн суурь гэмт хэргүүд дээр ажилладаг байна.

- Монгол Улсын хөрөнгө хураах эрх зүйн зохицуулалт нь ФАТФ-ын шаардлагыг хангахуйц байна. Дээр дурьдсан хоёр хэргийг хэрэгсэхгүй болж МУ хэргээр хөрөнгө хураагдаагүй ч анхан шатны шүүхээс хураахаар тогтоосон хөрөнгийн хэмжээг Дээд шүүх өөрчлөөгүй байна. ХСБ-ууд суурь гэмт хэрэгтэй холбоотой хөрөнгийг битүүмжлэх, харин шүүхээс хөрөнгө (тухайлбал, өндөр эрсдэлтэй суурь гэмт хэрэгтэй холбоотой) хураах үйл ажиллагаа хэрэгждэг байна.

- ТС гэмт хэрэгтэй холбоотой эрх зүйн зохицуулалт нь ФАТФ-ын шаардлагыг хангахуйц байна. СМА-наас шалгуулахаар шилжүүлсэн ТС-тэй холбоотой байж болзошгүй 5 хүнд хамаарах 3 тохиолдлыг л ТЕГ-аас шалгасан байна. Үнэлгээний багийн авсан мэдээллээр ТС-д хамаарч болох өөр тохиолдол байхгүй ба тайлант хугацаанд ТС-ийг мөрдөн шалгах эсхүл яллах тохиолдол гараагүй байна.

- Монгол Улс НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1267 болон 1373 дугаар тогтоолын дагуу санхүүгийн хориг арга хэмжээ авах ёстой. Гэвч хөрөнгө битүүмжлэх үүрэг авах; хөрөнгө зориулан гаргахыг хориглох; холбогдох санхүүгийн байгууллагууд (СБ) болон санхүүгийн бус бизнесийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид (СББМҮҮ) хураагдсан хөрөнгө, авсан арга хэмжээгээ тайлагнах хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломжгүй байна. Томоохон банкууд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн Нэгдсэн хоригийн жагсаалттай автоматжуулсан тулгалт хийдэг байна. Банк бус секторын зарим СБ-ууд гараар тулгалт хийдэг бол СББМҮҮ үүнийг огт хийдэггүй аж. Одоогоор жагсаалттай тохирсон данс буюу гүйлгээг царцаасан тохиолдол гараагүй ажээ. Монгол Улс НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1267 болон 1373 дугаар тогтоолын дагуу хувь хүн, хуулийн этгээдийг жагсаалтад нэмээгүй байна. Гэхдээ ийм этгээд байхгүй байгаа нь Монгол Улсын ТС-ийн эрсдэлийн талаарх төсөөлөлтэй нийцэхгүй байна гэсэн үг биш юм.

- Монгол Улсад үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх (ҮОХЗДС)-ийн эсрэг санхүүгийн хориг арга хэмжээ авах хууль, эрх зүйн орчин үгүйлэгдэж байна. ҮОХЗДС-ийн асуудлыг зохицуулж, хамтын ажиллагааг хангаж буй бүтэц, бусад зохицуулалт бүхий этгээд байхгүй байна. ҮОХЗДС-ийн хориг арга хэмжээнээс зайлсхийх эрсдэлд Монгол Улс өртөж болзошгүй байна.

- Монгол Улсын МУТСТ хууль тогтоомжид СББМҮҮ-ийн хүрээг зөвхөн үл хөдлөх хөрөнгийн агентууд болон нотариатчдаар хязгаарласны дээр хууль сахих үүрэг зөвхөн нотариатчдад оногддог байна. Өнөөдрийг хүртэл СББМҮҮ-дийн секторт МУТС хяналт, шалгалт хийгдээгүй аж.

- Банкны секторыг зохицуулагч Монголбанк (МБ) нь МУ эрсдэлийн талаар зарим нэг ойлголттой аж. МБ нь зайнаас тавих хяналт шалгалтын үр дүнд үндэслэн эрсдэлд

суурилсан МУТС хяналт шалгалтыг газар дээрх 4 удаагийн шалгалтын хамтаар гүйцэтгэсэн байна. Үнэлгээний баг Монголд ажиллах хугацаа дуусах үед энэхүү хяналт шалгалтын тайлан эцэслэгдээгүй байсан. Үүнээс өмнө МБ дүрэмд суурилсан хяналт шалгалтыг гүйцэтгэдэг байсан ба МУСТ хууль тогтоомжийн зөрчилд оногдуулах шийтгэл нь дахин үйлдэхээс сэргийлэх шинжгүй байв. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг гүйцэтгэсэн нь банкууд МУТС-ийн шаардлагыг тодорхой түвшинд ойлгож, биелүүлж эхлэхэд түлхэц болов.

- Банкнаас бусад секторын СБ-уудын зохицуулагч Санхүүгийн зохицуулах хорооны (СЗХ) МУ эрсдэлийн талаарх ойлголт бүрдэж эхлэх шатандаа байна. СЗХ нь МУТС-ийн эрсдэлд суурилсан хяналт шалгалтын аргачлалыг нэвтрүүлэхээр ажиллаж байна. СЗХ-ноос өнөөдрийг хүртэл хийж ирсэн цөөн тооны МУТС хяналт шалгалт нь дүрэмд суурилсан, хамрах хүрээ нь хязгаарлагдмал, зөрчил илэрлээ гэхэд ямар нэгэн шийтгэл оногдуулдаггүй байв. Банкнаас бусад секторын СБ-ууд МУТС-ийн шаардлагыг ойлгохгүй, биелүүлэхгүй явж ирсэн нь эрсдэлд суурилсан МУТС хяналт шалгалт байхгүй байсантай шууд холбоотой.

- Монгол Улс хуулийн этгээдүүдтэй холбоотой МУТС эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгээгүй болно. Хуулийн этгээдийн төрөл, хэрхэн байгуулах талаарх мэдээлэл олон нийтэд нээлттэй байдаг. ХСБ-ууд Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар (ОӨУБЕГ)-ын мэдээллийн санд нэвтрэн хуулийн этгээдийн талаарх ерөнхий мэдээллийг шуурхай авч чаддаг. Мэдээлэл 100 хувь бодитой бус ч Монгол Улс сүүлийн үед ОӨУБЕГ-ын бүртгэлийг сайжруулах алхмуудыг хийж байна. Түүнчлэн ХСБ-ууд болон СМА нь мэдээлэх үүрэгтэй этгээд (МэҮЭ)-үүдийн харилцагчийг таньж мэдэх (ХТМ) явцад олж авсан эцсийн өмчлөгч (ЭӨ)-ийн талаарх мэдээлэлд нэвтрэх эрхтэй ажээ.

- Монгол Улсад экспресс траст, түүнтэй адил төстэй бүтэц, чиг үүрэг бүхий хэлцэл, гэрээ, бусад зохицуулалт бүхий этгээд байгуулахыг хуулиар хориглосон байдаг. Гадаадын трастууд нь Монголын эдийн засагт онцгой хамаарах зүйл биш болох нь Монгол Улсад ажиллах үеэр тодорхой болсон билээ. Монгол Улсад гадаадын трастуудыг бий болгох, аль эсхүл удирдахад СББМҮҮ-ид оролцдог гэх баримт алга. Гэсэн хэдий ч Монгол Улс эрх зүйн хэлцэл, гэрээ, бусад зохицуулалт бүхий этгээдтэй холбоотой (тухайлбал, гадаадын эрх зүйн гэрээ, бусад зохицуулалт бүхий этгээд) МУТС эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгээгүй болно.

- Монгол Улсын олон улсын хамтын ажиллагааны эрх зүйн зохицуулалт нь ФАТФ-ын шаардлагыг хангахуйц байна. Монгол Улс суурь болон МУ гэмт хэргүүд дээр эрх зүйн харилцан туслалцаа (ЭЗХТ) авах/үзүүлэх, гэмт хэрэгтэн шилжүүлэх зэрэг олон улсын хамтын ажиллагааны арга хэлбэрийг ашиглаж байна. 2014 оноос хойш Монгол Улс 25 удаагийн ЭЗХТ үзүүлсэн ч цагаа олж үзүүлсэн эсэх нь тодорхойгүй байна. 2014 оноос хойш Монгол Улс МУ болон өндөр эрсдэлтэй суурь гэмт хэрэгт хамаарах 27 түүнээс МУ болон өндөр эрсдэлтэй суурь гэмт хэрэгтэй холбоотой дөрвөн удаагийн хүсэлт гаргажээ. Түүнчлэн, ХСБ болон СМА нь гадаадын түншүүд, Эгмонт болон Интерполтой байгуулсан харилцан ойлголцлын санамж бичиг (ХОСБ)-ийн хүрээнд мэдээлэл солилцож байна.

- Монгол Улс ТС-тэй холбоотойгоор ЭЗХТ буюу гэмт хэрэгтэн шилжүүлэх үйл ажиллагаанд оролцоогүй болно. Гэхдээ энэ нь Монгол Улсын ТС-ийн эрсдэлийн талаарх

төсөөлөлтэй нийцэхгүй байна гэсэн үг биш юм.

*В. Эрсдэл ба Ерөнхий нөхцөл байдал*

2. Монгол Улсын МУТСТ эрсдэлийн талаарх үнэлгээний багийн энэхүү тойм нь Монгол Улсаас гаргаж өгсөн мэдээлэл (тухайлбал ҮЭҮ); эрх бүхий байгууллагууд болон хувийн сектороос авсан тайлбар, тодруулга; болон нээлттэй эх сурвалжийн мэдээлэлд тулгуурлав.

*Мөнгө угаах*

3. Монгол Улс МУ олон төрлийн эрсдэл, эмзэг сул талтай нүүр тулж байна. МУ өндөр эрсдэлтэй гэмт хэрэгт залилан, байгаль орчны эсрэг гэмт хэрэг, татвараас зайлсхийх, авлига багтаж байгаа бол дундаж эрсдэлтэй гэмт хэрэгт хэрэгт хар тамхи, контрабанд буюу хилээр хууль бусаар нэвтрүүлэх, зохион байгуулалттай гэмт хэрэг, банкны зохицуулалтын эсрэг гэмт хэрэг, хулгай, гадаадад үйлдсэн гэмт хэргийн хөрөнгө мөнгөтэй холбоотой хэрэг багтаж байна.

4. Суурь гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг Монгол Улсад болон гадаадад угааж байна. Монгол Улсад ийм орлогыг гол төлөв үл хөдлөх хөрөнгө, автомашин, хэрэглээний бусад барааг худалдан авахад ашиглаж байгаа ба хуулийн этгээдээр дамжуулан угааж байна (тухайлбал, барилгын салбарт). Авлигын хувьд гэр бүлийн гишүүдийн банкны дансанд хүлээн авсан мөнгийг гадны банк буюу оффшор дансанд шилжүүлэх, гадаадад компани байгуулахад ашиглаж байна. МУ зарим тохиолдолд энэхүү хөрөнгө банкны системээр дамжин Монголд буцаан орж ирдэг байна.

5. Монгол Улсын үндсэн эмзэг тал нь банкны сектор болон СББМҮҮ-тэй холбоотой. Санхүүгийн секторын хөрөнгийн 95.7 хувийг бүрдүүлж буй банкны сектор нь (үүн дээр цөөн хэдэн банк бус шилжүүлэгчид нэмэгдэнэ) хил дамнасан эрсдэлд өртөж болох салбарын нэг юм. Үнэлгээний баг Монголд ажиллах үетэй давхцан Монголбанкнаас банкны эрсдэлд суурилсан МУТСТ хяналт шалгалтыг (газар дээрх шалгалт нь эрсдэлд суурилаагүй) гүйцэтгэсэн болно. Банкны сектор нь банк бус секторын “хаалгачийн” үүргийг мөн гүйцэтгэдэг. Банк бус сектор нь төрөл бүрийн үйлчилгээ үзүүлж буй олон байгууллагаас бүрдэж байна. Банк бус СБ-ууд үндсэндээ МУТСТ хяналт шалгалтаас орхигдохын сацуу тэд урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлдэггүй байна.

6. Хуульчид, нотариатчид болон нягтлан бодогч нарыг эс тооцвол СББМҮҮ-дийн салбарын хөгжил эхлэл төдий байна. СББМҮҮ-дээс МУТСТ тогтолцоонд зөвхөн үл хөдлөх хөрөнгийн агентууд болон нотариатчид хамрагдаж байгаа ч МУТСТ шаардлагыг нотариатчид л биелүүлэх үүрэгтэй аж. Өөрөөр хэлбэл, МУТСТ хууль тогтоомжийн үйлчлэл үл хөдлөх хөрөнгийн агентуудад хамаарахгүй байна. Үл хөдлөх хөрөнгийн секторт зохицуулалт байхгүйн дээр борлуулалтын шатанд олон төрлийн бизнес оролцдог ажээ. Тэд бэлэн мөнгө төлж буй худалдан авагчид хямдруулалт амладаг байж болзошгүй байна. Түүнчлэн, Монгол Улсад алт олборлож, улмаар албан бус дилерүүд/зуучлагчдад

зарж борлуулдаг хууль бус уул уурхайн томоохон сектор (олон тооны гар олборлогчдыг оролцуулаад) ажилладаг байж болзошгүй байна.

*ТС*

7. Монгол Улсын ТС эрсдэлд өртөх магадлал харьцангуй бага байж болзошгүй. Мэдээллийн нээлттэй эх сурвалжуудаас харахад Аль Каида, Талибан эсхүл Исламын улстай холбоотой үйл ажиллагаа Монголд бүртгэгдээгүй бөгөөд алан хядагчдыг бэлтгэдэг буюу нутгаараа дамжин өнгөрүүлдэг улс орны тоонд Монгол багтдаггүй ажээ<sup>1</sup>. Монголд алан хядах халдлага буюу алан хядах бүлэглэлүүд үйл ажиллагаа явуулдаг гэх тохиолдол бүртгэгдээгүй аж.

8. Нөгөө талаас, холбогдох байгууллагуудын чадавхи сул; санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн зохицуулалт байхгүй; ашгийн бус байгууллагын секторын хяналт сул; санхүүгийн хориг арга хэмжээний биелэлт банк бус секторын хувьд хангалтгүй бол СББМҮҮ-д огт хэрэгжүүлдэггүй зэрэг нь Монгол Улсын ТС-тэй тэмцэх тогтолцооны сул тал нь болж байна.

*ҮОХЗДС-ийн хориг арга хэмжээнээс зайлсхийхэд өртөх эрсдэл*

9. ҮОХЗДС-ийн эсрэг хориг арга хэмжээнээс зайлсхийх эрсдэлд Монгол Улс өртөх боломжтой. Монголд ойролцоогоор 1500 БНАСАУ-ын иргэд ажиллаж байгаа бөгөөд тэд БНАСАУ, Монгол Улсын хооронд байгуулсан албан ёсны гэрээ хэлцлийн дагуу цалинждаг байна. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй хэд хэдэн хуулийн этгээд нь БНАСАУ-тай шууд холбоотой ба Монголын компаниуд БНАСАУ-ын төрийн мэдлийн компаниудад хувь эзэмшдэг буюу эзэмшиж байна. Монгол Улсын БНАСАУ болон Ирантай хийж буй гадаад худалдааны хэмжээ төдийлөн том биш ажээ.

### *С. Үр дүнтэй байдал болон техникийн хэрэгжилтийн ерөнхий байдал*

*С.1. Эрсдэл, зохицуулалт болон бодлого боловсруулалтын үнэлгээ (БҮЛЭГ 2 - ШХ.1; 3.1, 3.2, 3.33)*

10. Монгол Улс МУТСТ тогтолцооны Үндэсний эрсдэлийн анхны үнэлгээг 2016 онд гүйцэтгэж үнэлгээний баг тус улсад ажиллах үеэр хэвлүүлсэн болно. ҮЭҮ-нд МУ сэдвийг голчлон хөнджээ.

11. Зарим байгууллага эрсдэлийн үнэлгээг өөрсдөө хийсэн гэх боловч үнэлгээний багт ямар нэгэн мэдээ, материалыг ирүүлээгүй болно. Үнэлгээний баг зөвхөн банкны хянан шалгагчдын банкны МУТСТ эрсдэлийг үнэлэхдээ ашигладаг мэдээлэл болон ТЕГ-ын терроризмын эрсдэлийн жилийн үнэлгээг хүлээн авсан болно.

12. ҮЭҮ-нд МУ аюул заналтай холбоотой сэдвийг голчлон хөндсөн ч (дээр өгүүлсэнчлэн) Монгол Улсын МУ-ын эрсдэлийн асуудлыг тал бүрээс нь (аюул занал, үр дагавар, эмзэг сул тал) задлан шинжилсэн цогц үнэлгээ болж чадаагүй байна. ҮЭҮ-нд оролцоогүй Засгийн газрын агентлагуудын МУ эрсдэлийн талаарх ойлголтыг эрс дээшлүүлэх шаардлагатай.

<sup>1</sup> [http://soufangroup.com/wp-content/uploads/2015/12/TSG\\_ForeignFightersUpdate3.pdf](http://soufangroup.com/wp-content/uploads/2015/12/TSG_ForeignFightersUpdate3.pdf)

## ТОВЧ ХУРААНГУЙ

13. ҮЭҮ-нд ТС-ийн аюул занал, сул талд хийсэн дүн шинжилгээ хангалтгүй түвшинд байна. Монгол Улс ТС-тэй холбоотой зарим дүгнэлтэд хэрхэн хүрсэн нь ҮЭҮ-нээс харагдахгүй байна. ЗГ-ын агентлагууд, хувийн секторын ТС эрсдэлийн талаарх ойлголтыг эрс дээшлүүлэх шаардлагатай.

14. Хувийн секторын ҮЭҮ-нд оруулсан хувь нэмэр нь мэдээлэл гарган өгөх, цөөн тооны семинарт хамрагдах төдийхнөөр хязгаарлагджээ. Том банкуудыг эс тооцвол хувийн секторын МУТС эрсдэлийн талаарх ойлголт туйлын нимгэн байна.

15. Монгол Улсад МУТСТ үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохицуулах 2 төрлийн бүтэц бий. Хамтын ажиллагааны зөвлөл (ХАЗ) нь МУ, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүрэгтэй бол Терроризмтэй тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөл (ТТАЗЗ) нь 2004 оны Терроризмтой тэмцэх тухай хуулийн (2013 онд нэмэлт, өөрчлөлт орсон) хэрэгжилт, хяналтыг зохицуулах үүрэгтэй юм. Үнэлгээний баг Монголд ажиллах хугацаанд ХАЗ-өөс боловсруулсан МУТСТ үндэсний стратегийн төсөл батлагдаагүй байсан буюу ҮЭҮ-нд энэ талаар тусгагдаагүй байсан болно. ХАЗ болон ТТАЗЗ-ийн МУТСТ үйл ажиллагааг зохицуулах чадвар сул байна.

16. Монгол Улсад ҮОХЗДС-ийн асуудлыг зохицуулах бүтэц байхгүй байна.

*С.2. Санхүүгийн мэдээлэл, МУ болон хөрөнгө хураах (БҮЛЭГ 3 - ШХ 6-8; 3.3, 3.4, 3.29-32)*

17. Санхүүгийн мэдээллийг (тухайлбал, СМА-ны үйл ажиллагааны шинжилгээг) ашиглан МУ болон суурь гэмт хэргийн мөрдөн шалгалтыг эхлүүлсэн тохиолдол ховор аж. СМА-ны санхүүгийн мэдээлэл боловсруулах чадвар сул байгаад сэжигтэй гүйлгээний тайлан (СГТ) бүрдүүлэлт нөлөөлж байгаа бололтой. Гэмт хэрэг, тэр дундаа өндөр эрсдэлтэй суурь гэмт хэрэг үйлдэж олсон орлогын талаарх СГТ цөөн, банк бус сектор СГТ бараг мэдээлдэггүй бол СББМҮҮ-д СГТ огт мэдээлдэггүй зэргээс шалтгаалан СГТ нь Монгол Улсын МУ эрсдэлийн илрэл болж чадахгүй байна.

18. Тайлант хугацаанд СМА-наас шалгуулахаар шилжүүлсэн материалын дийлэнхи нь ТЕГ-г шилжсэн ба өндөр эрсдэлтэй улс орнууд, тухайлбал БНАСАУ-тай холбоотой байжээ. Монгол Улс эдгээр шилжүүлсэн материалын үр дүнгийн талаар ямар нэгэн мэдээллээр хангаагүй болно. Харин Цагдаагийн Ерөнхий газар (ЦЕГ) СМА-аас шалгуулахаар шилжүүлсэн материалуудыг тодорхой түвшинд (тухайлбал, МУ мөрдөн шалгалтыг эхлүүлэхэд) ашиглаж байна. СМА нь ХСБ-уудад шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх байдлаар тэдний үйл ажиллагааг идэвхитэй дэмжин ажиллаж байна.

19. Тайлант хугацаанд СМА-наас ТС-тэй холбоотой байж болзошгүй 5 хүнд хамаарах 3 тохиолдлыг ТЕГ-г шилжүүлэн шалгуулжээ. Эдгээрээс хоёр тохиолдлыг ТС-тэй холбогдолгүй гэж үзсэн бол гурав дахь СГТ-ийн мөрдөн шалгалт үргэлжилж байна.

20. СМА нь стратегийн шинжилгээг хийдэггүй, мэдээлдэггүй байна..

21. Монгол Улсын МУ хууль тогтоомж (тухайлбал, ХСБ-ын эрх мэдэл) нь ерөнхийдөө ФАТФ-ын шаардлагыг хангахуйц байна. Гэхдээ Монгол Улсад үндэсний МУТСТ бодлого байхгүйн дээр ХСБ-уудад МУ гэмт хэргийг тэргүүн ээлжинд авч үзэх дотоод дүрэм

## ТОВЧ ХУРААНГУЙ

журам, удирдамж чиглэл дутагдаж байна. ХСБ-ууд МУ-тай холбоотойгоор 4345 хүнийг шалгаснаас 46 тохиолдолд мөрдөн шалгалт явуулж, 20-ийг нь Улсын Ерөнхий Прокурорын газар (УЕПГ)-т шилжүүлсэн ба шүүхээс 2 хэрэгт яллах дүгнэлт үйлдсэн байна. Анхан шатны шүүхээс шийдвэрлэсэн тус 2 хэргийг Дээд шүүхээс хэрэгсэхгүй болгожээ. Монгол Улсын ХСБ-ууд суурь гэмт хэргүүдийг мөрдөн шалгаж байгаа боловч тайлант хугацаанд Монгол Улс өргөн хүрээтэй өршөөлийн хуулийг баталжээ.

22. Монгол Улсын хөрөнгө хураах эрх зүйн зохицуулалт нь ФАТФ-ын шаардлагыг хангахуйц байна. Хууль сахиулах болон прокурорын байгууллагуудын үндэсний зорилтуудад хөрөнгө хураах заалт зохих түвшинд тусгагддаггүй ч ХСБ-ууд суурь гэмт хэрэгтэй холбоотой хөрөнгийг битүүмжилж, шүүхээс хөрөнгө (тухайлбал, өндөр эрсдэлтэй суурь гэмт хэрэгтэй холбоотой) хураадаг байна. Гэсэн хэдий ч эдгээр өндөр эрсдэлтэй суурь гэмт хэрэгтэй холбоотойгоор хураагдсан хөрөнгийн гэмт хэргийн төрлөөр ангилсан дэлгэрэнгүй тоо мэдээг Монгол Улс гаргаж өгөөгүй болно. Монгол Улс гадаадаас хөрөнгө шилжүүлэн авчраагүй боловч БНСУ болон Чех улс руу гэмт хэргийн хураагдсан хөрөнгө шилжүүлсэн байна.

23. Дээр дурьдсан хоёр хэрэг хэрэгсэхгүй болсны улмаас МУ-тай холбоотой хөрөнгө хураагдаагүй ч анхан шатны шүүхээс тогтоосон хөрөнгийн хэмжээг Дээд шүүхээс өөрчлөөгүй байна (дээр авч үзсэнчлэн).

### *С.3. ТС ба ҮОХЗДС (БҮЛЭГ 4 - ШХ 9- 11; 3.5-8)*

24. ТС-ийн гэмт хэрэгтэй холбоотой эрх зүйн зохицуулалт нь ФАТФ-ын шаардлагыг хангахуйц байна.

25. Монголын эрх баригчдын ТС-ийн эрсдэлийн талаарх ойлголт туйлын нимгэн байгаагийн дээр терроризмтэй тэмцэх стратеги нь стратегийн аргачлалд суурилаагүй байна. Тайлант хугацаанд ТЕГ нь СМА-аас шалгуулахаар шилжүүлсэн ТС-тэй холбоотой материалыг шалгаж үзжээ. Монгол Улс үүнээс өөр ТС-тэй холбоотой буюу ТЕГ-ын ТС-ийг илрүүлэх чадварыг илтгэх мэдээ, материал хангаагүй болно.

26. Монгол Улсад ТС-ийн гэмт хэрэг бүртгэгдсэн тохиолдол байхгүй болно. Гэхдээ энэ нь Монгол Улсын ТС-ийн эрсдэлийн талаарх төсөөлөлтэй нийцэхгүй байна гэсэн үг биш юм.

27. Монгол Улс НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1267 болон 1373 дугаар тогтоолын дагуу санхүүгийн хориг арга хэмжээ авах цар хүрээг тодорхойлсон ч хүлээвэл зохих үүргүүд (хөрөнгө битүүмжлэх, хөрөнгө зориулан гаргахыг хориглох г.м.) болон СБ-ууд болон СББМҮҮ-дэд тавибал зохих шаардлага (хураагдсан хөрөнгө, авсан арга хэмжээгээ тайлагнах г.м.) хэрэгжихгүй байна. Санхүүгийн сектор дахь санхүүгийн хориг арга хэмжээний хэрэгжилт харилцан адилгүй байна. Тухайлбал, СББМҮҮ-д хориг арга хэмжээг огт хэрэгжүүлдэггүй аж. Томоохон банкууд бүх гүйлгээ, шинэ болон хуучин харилцагчдыг НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн Нэгдсэн Жагсаалттай тулгаж автоматжуулсан харьцуулалт хийдэг. Одоогоор тус жагсаалттай тохирсон, данс эсхүл гүйлгээг царцаасан тохиолдол бүртгэгдээгүй байна.

## ТОВЧ ХУРААНГУЙ

28. Монгол Улс НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1267 болон 1373 дугаар тогтоолын дагуу хувь хүн болон хуулийн этгээдийг жагсаалтад оруулаагүй болно. Гэхдээ энэ нь Монгол Улсын ТС-ийн эрсдэлийн талаарх төсөөлөлтэй нийцэхгүй байна гэсэн үг биш юм.

29. Монгол Улсын ашгийн бус байгууллагын секторын ТС эрсдэлийн талаарх ойлголт хангалтгүй байна. Тус сектортой холбоотой ямар нэгэн эрсдэлийн үнэлгээ, судалгаа хийгдээгүй байна. Ашгийн бус секторын засаглалтай холбоотой анхан шатны зохицуулалтын дэглэм үйлчилж байна.

30. Монгол Улсад БНАСАУ, Ирантай холбоотой санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдээгүй болно. ҮОХЗДС-ийн хориг арга хэмжээнээс зайлсхийх явдалд Монгол Улс өртөх магадлалтай гэсэн ойлголт МэҮЭ-үүдэд байгаа бөгөөд томоохон банкууд өндөр эрсдэлтэй улс орнуудтай (тухайлбал, БНАСАУ) холбоотой СГТ мэдээлдэг байна.

### *С.4. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ (БҮЛЭГ 5 - ШХ4; 3.9-23)*

31. Санхүүгийн сектор дахь МУТС-ийн эрсдэлүүд, тэдгээрийг бууруулах үүрэг хариуцлага, арга замын талаарх ойлголт харилцан адилгүй түвшинд байна. МУ, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам (УСҮАЖ)-ыг 2016 онд баталсан нь Монгол Улсын урьчилан сэргийлэх тогтолцоог ФАТФ-ын стандартад ойртуулах алхам болов. Монгол Улсын МУТС-ийн урьдчилан сэргийлэх тогтолцоог эрсдэлтэй нь харьцуулбал туйлын хангалтгүй түвшинд байгаа нь саяхан хийгдсэн МУТС-ийн хяналт шалгалт, хэвлэгдсэн ҮЭҮ-нээс харагдаж байна. Харин томоохон банкуудын урьдчилан сэргийлэх тогтолцоо нь МУТС-ийн эрсдэлтэй илүү дүйцэхүйц түвшинд байна.

32. МэҮЭ-ийн зүгээс харилцагчийг таньж мэдэх, мэдээллийн сан үүсгэж баяжуулах, харилцагчийг таньж мэдэх өндөржүүлсэн арга хэмжээ зэргийг хэрхэн хэрэгжүүлж буйг илтгэх тоо, мэдээг Монгол Улс хангаагүй болно. МэҮЭ-үүд 2011 оноос 2016 оны 10 дугаар сарын хооронд 1006 СГТ мэдээлжээ. СГТ-ийн дийлэнхи олонхийг банкууд өндөр эрсдэлтэй улс орнуудтай холбоотойгоор мэдээлсэн бол СББМҮҮ-д нэг ч СГТ мэдээлээгүй байна. СГТ-ийн мэдээлсэн байдал нь үнэлгээний багийн Монгол Улсын МУТСТ эрсдэлийн талаарх ойлголттой дүйцэхээргүй байна.

33. Монгол Улсын МУТСТ хууль тогтоомжид СББМҮҮ-ийн хүрээг зөвхөн үл хөдлөх хөрөнгийн агентууд болон нотариатчдаар хязгаарласны дээр хууль сахих үүргийг зөвхөн нотариатчдад оногдуулжээ. СББМҮҮ-ид МУТС эрсдэлийн талаар ойлголтгүй төдийгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоогүй ажээ.

### *С.5. Хяналт шалгалт (БҮЛЭГ 6 - ШХ3; 3.26-28, 3. 34-.35)*

34. Банкны лиценз олгох болон бусад хяналтын механизм нь банкны секторт гэмт хэрэгтэн, тэдэнтэй холбоотой этгээд нэвтрэхээс урьдчилан сэргийлэх боломжийг Монгол

## ТОВЧ ХУРААНГУЙ

Улсад тодорхой түвшинд олгож байгаа бол банк бус секторын хувьд хяналт хавьгүй сул байна.

35. Салбарын зохицуулагчийн хувьд Монголбанк банкуудын МУ эрсдэлийн талаар зарим нэг ойлголттой аж. Монголбанк 2016 оны 6 дугаар сард зайнаас шалгалт хийж банкуудын эрсдэлийг тогтоосон байна. Улмаар өндөр эрсдэлтэй 4 банкинд газар дээрх шалгалтыг хийжээ. Үнэлгээний баг Монголоос буцахын өмнө энэхүү шалгалт хийгдсэн тул шалгалтын тайлан бэлэн болоогүй байв. Гэхдээ үүнээс хойш ч Монгол Улс шалгалтын тайланг хангаагүй болно. Үүнээс өмнө Монгол Улс дүрэмд суурилсан МУТС-ийн хяналт шалгалтыг хэрэгжүүлдэг байв.

36. Монголбанк нь гаргасан зөрчилд олон төрлийн арга хэмжээг шат дараатай ногдуулах боломжтой. Эдгээрээс Монголбанк зөвхөн МУТС-ийн зөрчлөө арилгах үүрэг даалгавар өгч иржээ. Монголбанкны хяналт шалгалт нь МУТСТ үүргийг ухамсарлуулж, хэрэгжүүлэхэд нөлөө багатай байв.

37. Банк бус салбарын зохицуулагчийн хувьд СЗХ-ны МУ, тэр дундаа хариуцсан салбарынхаа МУ эрсдэлийн талаарх ойлголт сул байна. СЗХ нь эрсдэлд суурилсан аргачлалыг МУТС-ийн хяналт шалгалтад нэвтрүүлэхээр ажиллаж байна. Өнөөг хүртэл СЗХ-ны хяналт шалгалт нь дүрэмд суурилсан, тоо болон хамрах хүрээний хувьд хязгаарлагдмал байв. СЗХ-ны шийтгэл оногдуулах эрх мэдэл сул тул зөвхөн анхааруулга хэлбэрийн захиргааны шийтгэл оногдуулсаар иржээ. СЗХ-ны банк бус секторын хяналт шалгалт нь МУТСТ үүргийг ухамсарлуулж, хэрэгжүүлэхэд нөлөө багатай байв.

38. СББМҮҮ-ийн секторт хяналт шалгалт хийгдээгүй болно.

*С.6. Хуулийн этгээд буюу бусад зохицуулалт бүхий этгээдийн ил тод байдал (БҮЛЭГ 7 - ШХ5; 3. 24-25)*

39. Монгол Улс хуулийн этгээдэд хамаарах МУТСТ эрсдэлийн үнэлгээг тухайлбал, ҮЭҮ-ий хүрээнд гүйцэтгээгүй байна. Монгол Улс хуулийн этгээдүүдийн (нийтийн, Монгол Улсад бүртгэлтэй гадаадын компаниуд болон нөхөрлөл) эрсдэлүүдийн талаар ойлголтгүй байна.

40. Хуулийн этгээдийн төрөл, хэрхэн байгуулах талаарх мэдээлэл ОӨУБЕГ-аар дамжин олон нийтэд нээлттэй байдаг. ХСБ-ууд ОӨУБЕГ-ын мэдээллийн санд шууд нэвтрэн хуулийн этгээдийн талаарх ерөнхий мэдээллийг шуурхай авч чаддаг. ОӨУБЕГ мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг магадлах механизмгүй, шийтгэл оногдуулж ирээгүй тул мэдээлэл нь 100 хувь үнэн зөв гэхэд хэцүү. Түүнчлэн ХСБ-ууд болон СМА нь МЭҮЭ-үүдийн ХТМ явцад олж авсан ЭӨ-ийн талаарх мэдээлэлд нэвтрэх эрхтэй ажээ. ХТМ өргөтгөсөн шаардлагыг (тухайлбал, хуулийн этгээд буюу бусад зохицуулалт бүхий этгээдийн ЭӨ-ийг тодорхойлох г.м.) урьдчилан сэргийлэх журамд тусгаад удаагүй байна.

41. Хуулийн этгээдийг МУТС гэмт хэрэгт оролцохоос урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улс ХТМ процедурт ЭӨ-ийн мэдээллийг оруулснаас гадна дараахь шаардлагыг тавих болов. Үүнд: (i) хувьцаа эзэмшигч болохыг нотлох нэр бичээгүй үнэт цаасыг

бүртгэх, (ii) эцсийн өмчлөгчдийн өмнөөс хувьцаа гаргах эсхүл захирлуудыг томилохыг хориглох, (iii) ОӨУБЕГ-ын хуулийн этгээдийн бүртгэлийг сайжруулах, шинэчлэх.

42. Монгол Улс экспресс траст, түүнтэй адил төстэй бүтэц, чиг үүрэг бүхий гэрээ, бусад зохицуулалт бүхий этгээд байгуулахыг хуулиар хориглосон байдаг<sup>2</sup>. Гадаадын трастууд нь Монголын эдийн засагт онцгой хамааралтай зүйл биш болох нь Монгол Улсад ажиллах үеэр тодорхой болсон. Монгол Улсад гадаадын трастуудыг бий болгох эсхүл удирдахад СББМҮҮ-д оролцдог гэх баримт алга. Гэсэн хэдий ч Монгол Улс эрх зүйн гэрээ, бусад зохицуулалт бүхий этгээдтэй холбоотой (тухайлбал, гадаадын эрх зүйн гэрээ, бусад зохицуулалт бүхий этгээд) МУТС эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгээгүй болно.

*С.7. Олон улсын хамтын ажиллагаа (БҮЛЭГ 8 - ШХ2; 3. 36-40)*

43. Монгол Улсын олон улсын хамтын ажиллагааны эрх зүйн зохицуулалт нь ФАТФ-ын шаардлагыг хангахуйц байна. Монгол Улс Эрүүгийн байцаан шийтгэх хууль 2001 (ЭБШХ); хоёр талын гэрээ буюу механизм; харилцан дэмжлэг туслалцаа үзүүлэх зарчмын дагуу өргөн хүрээтэй ЭЗХТ үзүүлэх, гэмт хэрэгтэн шилжүүлэн өгөх боломжтой.

44. Монгол Улс суурь болон МУ гэмт хэргүүд дээр эрх зүйн харилцан туслалцаа (ЭЗХТ), гэмт хэрэгтэн шилжүүлэх зэрэг олон улсын хамтын ажиллагааны арга хэлбэрийг тодорхой түвшинд ашиглаж байна. 2014 оноос хойш Монгол Улс нийт 34 удаагийн ЭЗХТ, гэмт хэрэгтэн шилжүүлэх хүсэлт хүлээн авснаас 25-ыг нь биелүүлсэн бол 4 нь биелэх шатандаа байна. Гэхдээ энэхүү туслалцаа, дэмжлэгийг тэр болгон шуурхай үзүүлээгүй байна. 2014 оноос хойш Монгол Улс гадаадын болон бүс нутгийн хэмжээнд 27 удаагийн хүсэлт гаргаснаас 4 нь МУ-тай, бусад нь өндөр эрсдэлтэй суурь гэмт хэрэгтэй холбоотой байв.

45. ХСБ-ууд болон СМА нь гадаад түншүүдтэй мэдээлэл солилцохдоо харилцан ойлголцлын санамж бичиг, Эгмонт Бүлгийн тусгай веб болон Интерполын I-24/7 холболтыг ашиглаж байна.

46. Хянан шалгагч нарын олон улсын хамтын ажиллагаа нь гадны лавлагаанд хариу өгсөн СЗХ-ны 2 тохиолдлоор хязгаарлагдаж байна. Хяналт шалгалт, эцсийн өмчлөгчтэй холбоотой мэдээллийг гадны байгууллагатай солилцсон тохиолдол байхгүй аж.

47. Монгол Улс ТС-тэй холбоотойгоор ЭЗХТ үзүүлэх буюу авах; гэмт хэрэгтэн шилжүүлэх тухай хүсэлт гаргаагүй болно. Гэхдээ энэ нь Монгол Улсын ТС-ийн эрсдэлийн талаарх төсөөлөлтэй нийцэхгүй байна гэсэн үг биш юм.

***D. Нэн түрүүнд авах арга хэмжээ***

---

<sup>2</sup> Монгол Улс Иргэний хуулийн 406-р зүйлийн дагуу итгэлцлийн трастыг “траст гэрээ” хэлбэрээр зохицуулсан хууль тогтоомжтой. 2008 онд Банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээний журам батлагдсанаар “траст гэрээ”-ний бүтэц, чиг үүрэг тодорхой болжээ. Эндээс үнэлгээний баг энэхүү механизм нь экспресс траст буюу түүнтэй адил төстэй бүтэц, чиг үүрэгтэй хуулийн механизм биш гэдгийг тогтоосон болно.

48. Монгол Улс нэн түрүүнд дараахь арга хэмжээг авбал зохино. Үүнд:
- i. Монгол Улсын ТС эрсдэлийг зохих түвшинд тодорхойлж, үнэлж, ойлговол зохино (үүнд ашгийн бус байгууллагын секторыг мөн хамруулна); эрх бүхий байгууллагууд болон хувийн секторын МУ эрсдэлийн талаарх ойлголтыг улам сайжруулах; МУТСТ эрсдэлийг тал бүрээс нь ойлгон цэгнэсний үндсэн дээр МУТСТ Үндэсний стратегийн төслийг боловсруулах шаардлагатай. МУТСТ Үндэсний стратеги нь эрх бүхий байгууллагуудад нэн түрүүнд авах арга хэмжээг тодорхойлж, дотооддоо мөрдөх дүрэм, журмыг боловсруулахад түлхэц болох учиртай юм.
  - ii. Монгол Улс Зөвлөмж 36<sup>3</sup> -д хамаарах эрх зүйн орчны доголдлоо залруулж; НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1267 болон 1373 дугаар тогтоолтой холбоотой санхүүгийн хориг арга хэмжээний хэрэгжилтийг сайжруулбал зохино. НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1373 дугаар тогтоолыг биелүүлэх Монгол Улсын Үйл ажиллагааны төлөвлөгөөг зүйл анги тус бүрээр хэрэгжүүлбэл зохино.
  - iii. Банкны хянан шалгагч нар Монгол Улсын МУТСТ эрсдэлийн талаарх ойлголтоо улам сайжруулбал зохино. Хянан шалгагч нар эрсдэлд суурилсан банкны хяналт, шалгалт явуулах туршлагаа арвижуулж, зөрчилд нь тохирохуйц, дахин үйлдэхээс сэргийлэхүйц шийтгэл оногдуулах замаар банкуудын МУТС урьдчилан сэргийлэх тогтолцоог (ялангуяа СГТ тайлагналын хувьд) боловсронгуй болгох шаардлагатай.
  - iv. Банкны бус сектор болон СББМҮҮ-дтэй холбоотой МУТСТ эрсдэлийг тал бүрээс нь дүгнэн цэгнэсний үндсэн дээр Монгол Улсын МУТСТ тогтолцоонд орхигдсон нэгжүүдийг хамруулж, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг (тухайлбал, зөрчилд нь тохирсон, дахин үйлдэхээс сэргийлэхүйц шийтгэл оногдуулах) хэрэгжүүлэн МУТС урьдчилан сэргийлэх шаардлагыг (ялангуяа сэжигтэй гүйлгээг тайлагнах) хангуулбал зохино.
  - v. Ахисан түвшний санхүүгийн мэдээллийн арга хэрэгслээр (тухайлбал, стратегийн шинжилгээ) ХСБ-ын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.
  - vi. Санхүүгийн мэдээллийг хөгжүүлж ашиглах талаарх бодлого, зааварчилгаа, удирдамж боловсруулан ХСБ-уудыг хангах; хууль сахиулагчид, прокурорууд, шүүгчдэд МУТСТ сургалт зохион байгуулж МУТСТ лавлагаа, мөрдөн шалгах болон таслан шийдвэрлэх ажлын үр дүнтэй байдлыг хангах.
  - vii. Зөвлөмж 7-г биелүүлэхийн тулд холбогдох хууль тогтоомжийг баталж мөрдөх, ҮОХЗДС-ийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх процедур, арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх, тухайлбал, зохицуулалт, хамтын ажиллагааны бүтэц нэгжийг бий болгох г.м.

### ***Е. Техникийн хэрэгжилт болон Үр дүнтэй байдлын үнэлгээ***

*Үр дүнтэй байдлын үнэлгээ (Өндөр, Үлэмж, Дунд зэрэг, Доогуур)*

<sup>3</sup> Харилцан үнэлгээний багийн айлчлалын дараа Монгол улс эдгээр дутагдлыг засч залруулахад чиглэгдсэн хууль тогтоомжийг батлав.

## ТОВЧ ХУРААНГУЙ

|   |   |   |  |  |                                   |
|---|---|---|--|--|-----------------------------------|
| <b>ШХ.1</b> - Эрсдэл, бодлого болон зохицуулалт               | <b>ШХ.2</b> – Олон улсын хамтын ажиллагаа | <b>ШХ.3</b> – Хяналт шалгалт                                  | <b>ШХ.4</b> – Урьдчилан сэргийлэх арга хэмжээ                            | <b>ШХ.5</b> – Хуулийн этгээд бусад зохицуулалт бүхий этгээд      | <b>ШХ.6</b> – Санхүүгийн мэдээлэл |
| <b>Доогуур</b>  | <b>Дунд зэрэг</b>                         | <b>Доогуур</b>  | <b>Доогуур</b>   | <b>Доогуур</b>   | <b>Доогуур</b>                    |
| <b>ШХ.7</b> – МУ мөрдөн шалгах болон шийдвэрлэх үйл ажиллагаа | <b>ШХ.8</b> – Хөрөнгө хураах              | <b>ШХ.9</b> – ТС мөрдөн шалгах болон шийдвэрлэх үйл ажиллагаа | <b>ШХ.10</b> - ТС урьдчилан сэргийлэх болон санхүүгийн хориг арга хэмжээ | <b>ШХ.11</b> – ҮОХЗДС-тэй холбоотой санхүүгийн хориг арга хэмжээ |                                   |
| <b>Доогуур</b>  | <b>Дунд зэрэг</b>                         | <b>Доогуур</b>  | <b>Доогуур</b>   | <b>Доогуур</b>   |                                   |

*Техникийн Хэрэгжилтийн үнэлгээ (БС – биелүүлсэн, ДБ – дийлэнхийг биелүүлсэн, ХБ – хэсэгчлэн биелүүлсэн, БГ – биелүүлээгүй)*

|  |  |  |  |   |   |
|--|--|--|--|---|---|
| <b>3.1</b> – Эрсдэлийн үнэлгээ, эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх                             | <b>3.2</b> – Үндэсний хамтын ажиллагаа, уялдаа холбоо        | <b>3.3</b> – МУ гэмт хэрэг                             | <b>3.4</b> – Хөрөнгө хураах болон түр зуурын арга хэмжээ | <b>3.5</b> – ТС гэмт хэрэг                  | <b>3.6</b> –Терроризм болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ – |
| <b>ХБ</b>  | <b>ХБ</b>  | <b>ДБ</b>  | <b>ДБ</b>  | <b>ДБ</b>                                   | <b>ХБ</b>   |
| <b>3.7</b> –Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ – | <b>3.8</b> – Ашгийн бус байгууллагууд                        | <b>3.9</b> – СБ-ын нууцлалтай холбоотой хууль тогтоомж | <b>3.10</b> – Харилцагчийг таньж мэдэх                   | <b>3.11</b> – Баримт, материал хадгалалт    | <b>3.12</b> – Улс төрд нөлөө бүхий этгээд   |
| <b>БГ</b>  | <b>ХБ</b>  | <b>ДБ</b>  | <b>ДБ</b>  | <b>БС</b>                                   | <b>ДБ</b>   |
| <b>3.13</b> - Корреспондент банкны үйл ажиллагаа   | <b>3.14</b> – Мөнгө болон үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ | <b>3.15</b> – Шинэ технологи                           | <b>3.16</b> – Цахим шилжүүлэг                            | <b>3.17</b> – Гуравдагч этгээдэд тулгуурлах | <b>3.18</b> – Дотоод хяналт болон гадаад дахь салбар, охин компани                                    |
| <b>ДБ</b>  | <b>ХБ</b>  | <b>ДБ</b>  | <b>ДБ</b>  | <b>БГ</b>                                   | <b>ДБ</b>   |

## ТОВЧ ХУРААНГУЙ

|  |   |   |   |                                   |  |
|--|---|---|---|-----------------------------------|--|
| 3.19 – Өндөр эрсдэлтэй улс орнууд  | 3.20 – Сэжигтэй гүйлгээг мэдээлэх                             | 3.21 – Мэдээллийг задруулах болон нууцлал | 3.22 – СББМҮҮ Харилцагчийг таньж мэдэх            | 3.23 - СББМҮҮ Бусад арга хэмжээ   | 3.24 – Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон ил тод байдал          |
| ХБ   | ДБ  | ХБ  | БГ  | БГ                                | ХБ   |
| 3.25 – Эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн ил тод байдал болон эцсийн өмчлөгч | 3.26 – Санхүүгийн байгууллагуудын зохицуулалт, хяналт шалгалт | 3.27 – Хянан шалгагчдын эрх мэдэл         | 3.28 - СББМҮҮ-ийн зохицуулалт, хяналт шалгалт     | 3.29 – Санхүүгийн мэдээллийн алба | 3.30 - Хууль сахиулах болон мөрдөн шалгах байгууллагуудын хариуцлага |
| ХБ   | ХБ  | ДБ  | БГ  | ХБ                                | БС   |
| 3.31 - Хууль сахиулах болон мөрдөн шалгах байгууллагуудын эрх мэдэл                  | 3.32 – Бэлэн мөнгө тээвэрлэгчид                               | 3.33 - Статистик                          | 3.34 – Зааварчилгаа эргэх холбоо                  | 3.35 – Шийтгэлийн арга хэмжээ     | 3.36 – Олон улсын хамтын ажиллагааны арга хэрэгслүүд                 |
| БС   | ХБ  | ХБ  | ХБ  | ХБ                                | БС   |
| 3.37 - Эрх зүйн харилцан тусалцаа  | 3.38 – Эрх зүйн харилцан тусалцаа: Хөрөнгө царцаах, хураах    | 3.39 – Гэмт хэрэгтнийг шилжүүлэх          | 3.40 – Олон улсын хамтын ажиллагааны бусад хэлбэр |                                   |  |
| БС   | ДБ  | ДБ  | ДБ  |                                   |  |

## ХАРИЛЦАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

### *Оршил*

Тус тайланд Монгол Улсын МУТСТ тогтолцоог 2016 оны 11 дүгээр сарын байдлаар үнэлж дүгнэв. Тайланд ФАТФ-ын 40 зөвлөмжийн биелэлт болон МУТСТ тогтолцоонд дүн шинжилгээ хийж, сайжруулах зөвлөмж өгөв.

Энэхүү үнэлгээг ФАТФ-ын 2012 оны зөвлөмж дээр тулгуурлан 2013 оны аргачлалыг ашиглан бэлтгэв.

Энэхүү үнэлгээ нь Монгол Улсаас хангасан мэдээлэл болон үнэлгээний багийн 2016 оны 10 дугаар сарын 24-нөөс 11 дүгээр сарын 4-ний Монгол Улсад ажиллах үеэр олж авсан мэдээлэлд тулгуурласан болно.

Үнэлгээг дараахь баг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Хатагтай Дарья Кудряшова, Росфинмониторинг, ОХУ (санхүүгийн шинжээч);
- Хатагтай Ванита Махадеван, Үнэт цаасны комисс, Малайз (санхүүгийн шинжээч);
- Хатагтай Жонгюан Жанг, Хятадын Ардын банкны МУ-тай тэмцэх товчоо (санхүүгийн шинжээч);
- Ноён Жозе Карапинха, Санхүүгийн тагнуулын алба, Хятадын Макао (хуулийн мэргэжилтэн);
- Ноён Сисира Жаясекара, Шри-Ланка улсын Санхүүгийн тагнуулын алба (СТА/хууль сахиулах мэргэжилтэн);
- Ноён Саид Имран, Индонезийн Санхүүгийн гүйлгээний тайлан, шинжилгээний төв (Санхүүгийн тагнуулын алба/хууль сахиулах мэргэжилтэн);
- Ноён Айбек Турдукулов, МУТСТ Евразийн бүлгийн нарийн бичгийн алба.

Үнэлгээний явцыг АНДББ-ын нарийн бичгийн албанд харьяалагдах ноён Дэйвид Бекер Типологи хариуцсан захирал, ноён Шэннон Рутерфорд Типологи хариуцсан дэд захирал нар удирдаж ажиллав.

Тайланг ФАТФ-ын нарийн бичгийн алба, хатагтай Эрин Любовиц (Шинэ Зеланд), хатагтай Сью Вонг (Австрали) болон хатагтай Кэти Виллямсон (Австрали) нар хянав.

Монгол Улсын өмнөх харилцан үнэлгээ 2004 оны ФАТФ-ын аргачлалын дагуу 2007 онд хийгдсэн болно. 2007 оны харилцан үнэлгээг [www.apgml.org](http://www.apgml.org) цахим хуудаснаас үзнэ үү.

2007 оны харилцан үнэлгээгээр Монгол Улс 2 зөвлөмжийг биелүүлсэн; 7 зөвлөмжийг дийлэнхийг биелүүлсэн; 22 зөвлөмжийг хэсэгчлэн биелүүлсэн; 17 зөвлөмжийг биелүүлээгүй; 1 зөвлөмжийг хэрэгжүүлэх боломжгүй гэсэн үнэлгээтэй байв. Монгол Улс 16 Суурь болон үндсэн зөвлөмжийн 13-ыг нь хэсэгчлэн биелүүлсэн эсхүл биелүүлээгүй байв.

## БҮЛЭГ 1. МУТСТ ЭРСДЭЛ БОЛОН ОРЧИН НӨХЦӨЛ

1. Монгол Улс бол далайд гарцгүй, 1 564 100 км<sup>2</sup> нутаг дэвсгэртэй, ОХУ (Орос) болон БНХАУ (Хятад)-тай хиллэдэг. Монгол улс 3 057 778 (2015 оны байдлаар) хүн амтай ба хүн амыг газар нутагтай нь харьцуулбал дэлхийн хамгийн сийрэг хүн амтай улсын тоонд орно. Монгол Улсын нийслэл бөгөөд хамгийн том хот Улаанбаатарт хүн амын 45 хувь нь амьдардаг бол 30 хувь нь нүүдэлчин буюу хагас нүүдэлчин амьдралтай хүмүүс юм.
2. 1990-ээд оны эхэнд Монгол Улс олон намын тогтолцоог нэвтрүүлж зах зээлийн эдийн засагт шилжсэн. 1992 оны Үндсэн хуулийн дагуу Монгол Улс нь хагас ерөнхийлөгчийн төлөөллийн ардчилсан бүгд найрамдах улс бөгөөд гүйцэтгэх, хууль тогтоох болон шүүхийн гэсэн засаглалын хэлбэртэй. Гүйцэтгэх засаглалыг төрийн тэргүүн, цэргийн ерөнхий командлагч Ерөнхийлөгч болон Засгийн газрын тэргүүн Ерөнхий сайд нар хэрэгжүүлнэ. Хууль тогтоох засаглалыг Улсын Их хурал гэсэн нэг танхимтай, 76 гишүүнтэй парламент хэрэгжүүлнэ.
3. Монгол Улсын иргэний эрх зүй нь Ром-Германы эрх зүйн уламжлалаас үүдэлтэй. Шүүх засаглал нь гурван шатлалт тогтолцоотой (анхан шатны шүүх, давж заалдах шатны шүүх, Дээд шүүх) бөгөөд дотроо иргэний, эрүүгийн болон захиргааны гэж хуваагдана. Монгол Улсын хамгийн дээд шатны шүүх нь Үндсэн хуулийг тайлбарлах үүрэгтэй Үндсэн хуулийн цэц юм.
4. Монгол Улсын эдийн засаг хурдацтай өөрчлөгдөж ДНБ-ий өсөлтөөр дэлхийд тэргүүлэгчдийн нэг болов. Эдийн засгийн уламжлалт үйл ажиллагаа нь ДНБ-ний 16 хувийг бүрдүүлж байсан мал аж ахуй болон хөдөө аж ахуйн салбар байв. Харин сүүлийн 10 жилд уул уурхайн салбарын хурдацтай өсөлтийг ГШХО тодорхойлсоор ирэв. Сүүлийн жилүүдэд түүхий эдийн үнэ ханш болон экспортын бууралтаас шалтгаалан ДНБ-ний өсөлт 2015 онд 2.3 хувь буурч 28.78 их наяд төгрөг болж буурсан<sup>4,5</sup> ч уул уурхайн салбар ДНБ-ний 20<sup>6</sup> орчим хувийг бүрдүүлж, эдийн засгийн өсөлтийг тодорхойлогч салбар хэвээр байв<sup>7</sup>. Бусад чухал салбарт үйлчилгээ, барилга, боловсруулах салбар орно.
5. Монгол Улс улс төрийн хувьд нэгдмэл улс бөгөөд засаг захиргааны нэгжийн хувьд 21 аймаг, нийслэл Улаанбаатар хотод хуваагдана. Аймаг нь сумдад, Улаанбаатар хот дүүргүүдэд хуваагдана. Аймаг, нийслэлийн засаг дарга нар, иргэдийн төлөөлөгчдийн хурал нь засаг захиргааны үүргийг хэрэгжүүлнэ.

### *МУТСТ Эрсдэл ба өндөр эрсдэлтэй асуудлуудын хамрах хүрээ*

#### *(a) МУТСТ Эрсдэлийн тойм*

<sup>4</sup> Монголбанкны 2015 оны жилийн тайлан

<sup>5</sup> Энэхүү тайлангийн зорилгод нийцүүлэн 1 төгрөгийг 0.00041 ам.доллартай тэнцүү байхаар авав

<sup>6</sup> <http://www.worldbank.org/en/country/mongolia/overview>

<sup>7</sup> Монголбанкны 2015 оны жилийн тайлан

## БҮЛЭГ 1. МУТСТ ЭРСДЭЛ БОЛОН ОРЧИН НӨХЦӨЛ

6. Энэхүү үнэлгээ нь Монгол Улсаас хангасан мэдээлэл болон үнэлгээний багийн 2016 оны 10 дугаар сарын 24-нөөс 11 дүгээр сарын 4-ний хооронд Монгол Улсад ажиллах үеэр олж авсан мэдээлэлд тулгуурласан болно.

Тоймыг бэлтгэхдээ Монгол Улсаас хангасан мэдээлэл, тухайлбал ҮЭҮ (үнэлгээний баг Монголд 10-р сарын 24-нөөс 11-р сарын 4 хүртэл ажиллах үед нийтлэгдсэн), эрх бүхий агентлагууд болон хувийн секторын төлөөлөгчдөөс авсан тайлбар, тодруулга, нээлттэй эх сурвалжаас олж авсан мэдээ материалыг ашиглав.

Мөнгө угаах

7. Монгол Улс МУ олон төрлийн эрсдэл, эмзэг сул талтай нүүр тулж байна. МУ өндөр эрсдэлтэй гэмт хэрэгт залилан, байгаль орчны эсрэг гэмт хэрэг, татвараас зайлсхийх, авлига багтаж байгаа бол дундаж эрсдэлтэй гэмт хэрэгт хар тамхи, контрабанд буюу хилээр хууль бусаар нэвтрүүлэх, зохион байгуулалттай гэмт хэрэг, банкны зохицуулалтын эсрэг гэмт хэрэг, хулгай, гадаадад үйлдсэн гэмт хэргийн хөрөнгө мөнгөтэй холбоотой хэрэг багтаж байна.

8. Суурь гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг Монгол Улсад болон гадаадад угааж байна. Монгол Улсад ийм орлогыг гол төлөв үл хөдлөх хөрөнгө, автомашин, хэрэглээний бусад барааг худалдан авахад ашиглаж байгаа ба хуулийн этгээдээр дамжуулан угааж байна (тухайлбал, барилгын салбарт). Авлигын хувьд гэр бүлийн гишүүдийн банкны дансанд хүлээн авсан мөнгийг гадны банк буюу оффшор дансанд шилжүүлэх, гадаадад компани байгуулахад ашиглаж байна. МУ зарим тохиолдолд энэхүү хөрөнгө банкны системээр дамжин Монголд буцан орж ирдэг байна.

9. Монгол Улсын үндсэн эмзэг тал нь банкны сектор болон СББМҮҮ-тэй холбоотой. Санхүүгийн секторын хөрөнгийн 95.7 хувийг бүрдүүлж буй банкны сектор нь (үүн дээр цөөн хэдэн банк бус шилжүүлэгчид нэмэгдэнэ) хил дамнасан эрсдэлд өртөж болох салбарын нэг юм. Үнэлгээний баг Монголд ажиллах үетэй давхцан Монголбанкнаас банкны эрсдэлд суурилсан МУТСТ хяналт шалгалтыг (газар дээрх шалгалт нь эрсдэлд суурилагагүй) гүйцэтгэсэн болно. Банкны сектор нь банк бус секторын “хаалгачийн” үүргийг мөн гүйцэтгэдэг. Банк бус сектор нь төрөл бүрийн үйлчилгээ үзүүлж буй олон байгууллагаас бүрдэж байна. Банк бус СБ-ууд үндсэндээ МУТСТ хяналт шалгалтаас орхигдохын сацуу тэд урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлдэггүй байна.

10. Хуульчид, нотариатчид болон нягтлан бодогч нарыг эс тооцвол СББМҮҮ-дийн салбарын хөгжил эхлэл төдий байна. СББМҮҮ-ээс МУТСТ тогтолцоонд зөвхөн үл хөдлөх хөрөнгийн агентууд болон нотариатчид хамрагдаж байгаа ч МУТСТ шаардлагыг нотариатчид л биелүүлэх үүрэгтэй аж. Өөрөөр хэлбэл, МУТСТ хууль тогтоомжийн үйлчлэл үл хөдлөх хөрөнгө зуучлалын агентуудад хамаарахгүй байна. Үл хөдлөх хөрөнгийн секторт зохицуулалт байхгүйн дээр борлуулалтын шатанд олон төрлийн бизнес оролцдог ажээ. Тэд бэлэн мөнгө төлж буй худалдан авагчид хямдруулалт амладаг байж болзошгүй байна. Худалдан авалтыг ипотекийн зээлээр санхүүжүүлэх тохиолдолд банкууд сарын төлбөрийн эх үүсвэрийг зөв тодорхойлж буй гэсэн баталгаагүйг ҮЭҮ-нд дурьджээ.

11. Үнэт металл, чулууны диллерүүд Монгол Улсын МУТСТ тогтолцооны гадна үлдэж байна. “Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох” (Эрүүгийн хуулийн

## БҮЛЭГ 1. МУТСТ ЭРСДЭЛ БОЛОН ОРЧИН НӨХЦӨЛ

214 дүгээр зүйл) зэрэг байгаль орчны эсрэг үйлдэж буй гэмт хэргийг ҮЭҮ-нд өндөр эрсдэлтэй суурь гэмт хэрэг хэмээн тодорхойлжээ. Монгол Улсад гар аргаар олборлолт хийдэг “нинжа” нар болон хууль бус уул уурхайн сектор үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэд цэвэршүүлээгүй алтыг албан бус диллерүүд/”ченжүүд”-эд зарах замаар сүүдрийн эдийн засаг, хууль бусаар хил давуулах үзэгдлийг цэцэглүүлж байж болзошгүй юм.

12. Хил дамнасан хууль бус хөрөнгийн урсгал Монгол Улсаар дамжин өнгөрөх эрсдэл бага юм. Түүнчлэн, гадаадад, тэр дундаа хөрш орнуудад үйлдсэн гэмт хэргийн хөрөнгө мөнгөтэй холбоотой авлигын хэрэг Монгол Улсад буурсан нь сүүлийн жилүүдэд Монголын эдийн засаг удааширч, гадаадын хөрөнгө оруулалт агших болсонтой холбоотой.

### *Терроризмыг санхүүжүүлэх*

13. Монгол Улсын ТС эрсдэлд өртөх магадлал харьцангуй бага байж болзошгүй. Мэдээллийн нээлттэй эх сурвалжуудаас харахад Аль Каида, Талибан эсхүл Исламын улстай холбоотой үйл ажиллагаа Монгол Улсад бүртгэгдээгүй бөгөөд алан хядагчдыг бэлтгэдэг буюу нутгаараа дамжин өнгөрүүлдэг улс орны тоонд Монгол Улс багтдаггүй байна<sup>8</sup>. Монгол Улсад террорист халдлага гарсан эсхүл террорист бүлэглэлүүд үйл ажиллагаа явуулсан гэх тохиолдол бүртгэгдээгүй аж.

14. Нөгөө талаас, холбогдох байгууллагуудын чадавхи сул, хууль тогтоомжийг сайжруулах шаардлага, тухайлбал, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1267 болон 1373 дугаар тогтоолын дагуу хөрөнгө битүүмжлэх, хөрөнгө гаргахыг хориглох үүргийг хуульд тусгаагүй, санхүүгийн байгууллагууд болон СББМҮҮ-ид хураагдсан хөрөнгө, авсан арга хэмжээг тайлагнах зохицуулалт байхгүй; ашгийн бус байгууллагын секторын талаарх ойлголт, хяналт дутуу дулимаг; НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1267 болон 1373 дугаар тогтоолын биелэлт банк бус секторын хувьд хангалтгүй, СББМҮҮ-ийн хувьд огт хэрэгждэггүй зэрэг нь Монгол Улсын ТС-тэй тэмцэх сул тал болохоор байна.

### *ҮОХЗДС-ийн хориг арга хэмжээнээс зайлсхийх эрсдэлд Монгол Улс өртөж болох нь*

15. ҮОХЗДС-ийн эсрэг хориг арга хэмжээнээс зайлсхийх явдалд Монгол Улс өртөх эрсдэлтэй юм. Монголд ойролцоогоор 1500 БНАСАУ-ын иргэд ажиллаж байгаа бөгөөд тэд БНАСАУ, Монгол Улсын хооронд байгуулсан албан ёсны гэрээ хэлцлийн дагуу цалинждаг байна. Төрийн бус байгууллагын судалгаагаар гадаадад ажиллаж буй Солонгос иргэдийн цалингийн тодорхой хувийг БНАСАУ-ын засгийн газар хураан авдаг аж<sup>9</sup>. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй хэд хэдэн хуулийн этгээд нь БНАСАУ-тай шууд холбоотой ба Монголын компаниуд БНАСАУ-ын төрийн мэдлийн компаниудад хувь эзэмшдэг буюу эзэмшиж байсан<sup>10</sup>. Монгол Улс хориг арга хэмжээнээс зайлсхийх эрсдэлд хэр өртөж болохыг: (i) 2010-2015 онд СГТ-нд БНАСАУ-ын 177 иргэн холбогдсон, (ii) олон улсын анхаарлын төвд байгаа улс орнууд (тухайлбал, БНАСАУ)-ын зүгээс Монгол Улсын үл хөдлөх хөрөнгө, уул уурхай, банкны секторыг ашиглаж болзошгүйг анхааруулсан албан тоот 2012 оны 2 дугаар сард СМА-наас бүх банкинд

<sup>8</sup> [http://soufangroup.com/wp-content/uploads/2015/12/TSG\\_ForeignFightersUpdate3.pdf](http://soufangroup.com/wp-content/uploads/2015/12/TSG_ForeignFightersUpdate3.pdf)

<sup>9</sup> <http://www.wsj.com/articles/north-koreas-lucrative-labor-exports-come-under-pressure-1467916815>;  
<https://www.nknews.org/pro/mongolia-enforces-latest-sanctions-on-north-korean-ships/>

<sup>10</sup> <http://koreajoongangdaily.joins.com/news/article/article.aspx?aid=3016554>

## БҮЛЭГ 1. МУТСТ ЭРСДЭЛ БОЛОН ОРЧИН НӨХЦӨЛ

хүргүүлсэн зэргээс харж болно. Монголын далбааг ашиглаж байсан БНАСАУ-ын бүх хөлөг онгоцны бүртгэлийг Монгол Улс сүүлийн үед хүчингүй болгожээ.

*(b) Монгол Улсын эрсдэлийн үнэлгээ ба өндөр эрсдэлтэй асуудлын хамрах хүрээ*

16. Монгол Улс МУТСТ тогтолцооны Үндэсний эрсдэлийн анхны үнэлгээг 2016 онд гүйцэтгэж Монголбанкны цахим хуудаст байршуулжээ (үнэлгээний баг Монголд 2016 оны 10-11 дүгээр сард ажиллах үеэр). Зарим байгууллага эрсдэлийн үнэлгээг өөрсдөө хийсэн гэх боловч үнэлгээний багт ямар нэгэн мэдээ, материалыг ирүүлээгүй болно. Үнэлгээний баг зөвхөн банкны хянан шалгагчдын банкны МУТСТ эрсдэлийг үнэлэхдээ ашигладаг мэдээлэл болон ТЕГ-ын терроризмын эрсдэлийн жилийн үнэлгээг хүлээн авсан болно.

17. СМА нь ХАЗ-ийн гишүүн байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн Ажлын хэсгийн дэмжлэгтэйгээр ҮЭҮ-г боловсруулах ажлыг манлайлав. ҮЭҮ-г боловсруулах ажил дараахь 3 үе шаттай хэрэгжсэн байна:

- *1 дүгээр үе шат, 2015 оны 10 дугаар сард эхэлсэн* – Ажлын хэсэг нь мэдээлэл цуглуулах маягт боловсруулахдаа Европын Аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (OSCE)-ын туршлагад тулгуурласан ба холбогдох байгууллагууд, хувийн секторын төлөөлөгчдөд ҮЭҮ-ний талаар сургалт хийв. Монголбанкны хянан шалгагч нар ОУВС-гийн тусламжтайгаар боловсруулсан эрсдэлд суурилсан хэрэгслүүдийг ашиглан банкны секторын талаарх мэдээллийг боловсруулав.
- *2 дугаар үе шат, 2016 оны 4 дүгээр сард эхэлсэн* – цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, мэдээллийн дутууг төсөөллөөр нөхөв. Төсөөлөл мэдээлэл гэдэг нь МУТС болон суурь гэмт хэрэгтэй холбоотой мөрдөн шалгах, хууль сахиулах, урьдчилан сэргийлэх эрх бүхий байгууллагуудын төлөөлөлтэй хийсэн ярилцлага, нөхүүлж авсан судалгаа юм. Түүнчлэн төсөөлөл мэдээллийг асуулгын тусламжтайгаар банкны 30 ажилтан, банк бус санхүүгийн 30 байгууллага, үл хөдлөх хөрөнгийн 5 агент, хөрөнгийн биржийн 5 брокер, 60 нягтлан бодогч (ня-бо) болон 22 нотариатчдаас авчээ. Энэхүү 2 дугаар үе шатанд хууль сахиулах байгууллагуудын төлөөлөлтэй ярилцаж бүртгэлд хамрагдахгүй байгаа гэмт хэргийн түвшин, түүний орлогын хэмжээг үнэлэх гэж оролдов.
- *3 дугаар үе шат, 2016 оны 8 дугаар сард эхэлсэн* – эрсдэл, эмзэг сул талын магадлалыг тооцож, холбогдох секторууд болон иргэдийн гэмт хэрэгтэй холбоотой МУТС эрсдэлийг тогтоохын тулд эрсдэлийн үнэлгээний маягтыг ашиглав. Энэ шатанд ҮЭҮ-ний төсөлд ХАЗ-ийн гишүүд санал өгчээ.

18. ҮЭҮ нь гол төлөв МУ эрсдэл дээр төвлөрч, эмзэг сул тал болон үр дагаварыг мөн тодорхой хэмжээнд авч үзжээ. ҮЭҮ нь МУ өндөр эрсдэлтэй дараахь төрлийн суурь гэмт хэргийг тодорхойлжээ (ач холбогдлын эрэмбээр): (i) залилан, (ii) байгаль орчны журмын эсрэг гэмт хэрэг, (iii) татвараас зайлсхийх, болон (iv) авлига. Үнэлгээний баг үүнтэй ерөнхийдөө санал нийлж байгаа ч авлигын асуудлыг хэт доогуур эрэмбэлсэн гэж үзэж байна. Мэдээллийн нээлттэй эх сурвалжуудаас харахад Монгол Улс ялангуяа эрдэс баялгийн салбарт (ДНБ-д хамгийн өндөр жин эзэлж буй) авлигатай нүүр тулж, авлигын эсрэг тэмцлийн үр дүн муу байгаа нь илт байна (Монгол Улсын авлигын үнэлгээний тайлангийн асуудлыг дор үзнэ үү).

## БҮЛЭГ 1. МУТСТ ЭРСДЭЛ БОЛОН ОРЧИН НӨХЦӨЛ

19. МУ дундаж эрсдэлтэй гэмт хэрэгт (ач холбогдлын эрэмбээр): хар тамхи; контрабанд (хүний наймаа үүнд хамаарна); зохион байгуулалттай гэмт хэрэг; терроризм болон ТС; банкны зохицуулалтын эсрэг гэмт хэрэг; хулгай; гадаадаас үүсэлтэй гэмт хэргийн мөнгө орж байна. Эрсдэлийн ангилалд (өндөр ба дундаж) статистикийн мэдээлэл, тухайлбал суурь гэмт хэргийн тоо; тэдгээрээс учирсан хохирол; битүүмжилсэн болон хураасан хөрөнгө; эрсдэлийг хэмжихэд ашиглаж буй судлаачийн эрэгцүүлэл зэрэг нөлөөлжээ. Үнэлгээний багийн хувьд гэмт хэргийн эрсдэлийн дээрх эрэмбэтэй ерөнхийдөө санал нийлж байгаа боловч терроризм болон ТС дундаж эрсдэлтэй гэмт хэрэг мөн эсэх нь тодорхойгүй үлдэж байна (энэ асуудлыг дор үзнэ үү).

20. ҮЭҮ-нд банкны сектор, үл хөдлөх хөрөнгийн сектор, ня-бо нарыг өндөр эрсдэлтэй, нотариатчдыг дундаж эрсдэлтэй, үнэт цаасны арилжаа эрхлэгчид болон даатгалын секторыг бага эрсдэлтэй хэмээн дүгнэжээ. ББСБ-ууд тооны хувьд олон, газар зүйн байршлын хувьд өргөн тархсан тул МУТС эрсдэл нь банкны бус сектор дахь бусад СБ-уудтай харьцуулахад илүү өндөр ажээ. Хэдийгээр дээрх ангилал нь хязгаарлагдмал тоо мэдээ, судлаачдын эргэцүүлэлд тулгуурласан ч ерөнхийдөө зөв хийгдсэн гэж үнэлгээний баг үзэж байна.

21. ҮЭҮ-нд Монгол Улсын ҮОХЗДС-ийн эрсдэл, эмзэг талын шинжилгээг үндсэндээ орхигдуулсан ба ҮОХЗДС-тэй холбоотой зарим дүгнэлтэд Монгол Улс хэрхэн хүрсэн нь ойлгомжгүй байна. Тухайлбал, Монгол Улсыг дамжин өнгөрүүлэх улс болгон ашиглах ТС-ийн эрсдэл өндөр аль эсхүл терроризм/ТС нь МУ-ын хувьд дунд зэргийн эрсдэл болохыг хэрхэн тогтоосон нь тодорхойгүй байна. Дээр өгүүлсэнчлэн, Монгол Улсын ТС эрсдэлд өртөх магадлал харьцангуй бага байж болзошгүй. Мэдээллийн нээлттэй эх сурвалжуудаас харахад Аль Каида, Талибан эсхүл Исламын улстай холбоотой үйл ажиллагаа Монгол Улсад бүртгэгдээгүй бөгөөд алан хядагчдыг бэлтгэдэг буюу нутгаараа дамжин өнгөрүүлдэг улс орны тоонд Монгол Улс багтдаггүй байна<sup>11</sup>. Түүнчлэн Монгол Улсад террорист халдлага гарсан эсхүл террорист бүлэглэлүүд үйл ажиллагаа явуулсан гэх тохиолдол бүртгэгдээгүй аж.

### *(с) Эрсдэл өндөр/бага асуудлын хамрах хүрээ*

22. Үнэлгээний баг Монгол Улсад ажиллах хугацаанд дараахь өндөр эрсдэлтэй асуудалд анхаарал хандуулав. Үнэлгээний баг Хамрах хүрээтэй холбоотой тэмдэглэлийг боловсруулахдаа нээлттэй эх сурвалжуудын мэдээлэл болон эцэслэгдээгүй байсан ҮЭҮ-ний үр дүнг ашигласан болно.

23. *Суурь гэмт хэрэг* – Монгол Улсад сүүлийн жилүүдэд эдийн засгийн гэмт хэрэг<sup>12</sup> огцом нэмэгдэж ирснийг мэдээллийн нээлттэй эх сурвалжууд өгүүлж байна. Үнэлгээний баг дараахь 5 төрлийн суурь гэмт хэрэгт анхаарал хандуулав. Үүнд:

- *Татвараас зайлсхийх* – ҮЭҮ болон Монгол Улсын 2007 оны ХҮТ-д гэмт хэрэг үйлдэж орлого олох томоохон эх үүсвэрийн нэгээр татвараас зайлсхийх явдлыг нэрлэжээ. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ч үүнийг (ялангуяа уул уурхайтай холбоотойгоор) нотолдог<sup>13</sup>.

<sup>11</sup> [http://soufangroup.com/wp-content/uploads/2015/12/TSG\\_ForeignFightersUpdate3.pdf](http://soufangroup.com/wp-content/uploads/2015/12/TSG_ForeignFightersUpdate3.pdf)

<sup>12</sup> <https://www.osac.gov/pages/ContentReportDetails.aspx?cid=17237>

<sup>13</sup> <http://www.bloomberg.com/news/articles/2015-01-30/mongolia-finds-southgobi-employees-guilty-of-tax-evasion>

## БҮЛЭГ 1. МУТСТ ЭРСДЭЛ БОЛОН ОРЧИН НӨХЦӨЛ

- *Байгаль орчны журмын эсрэг гэмт хэрэг* – ҮЭҮ-нд гэмт хэрэг үйлдэж орлого олох томоохон эх үүсвэрийн нэгээр байгаль орчны журмын эсрэг гэмт хэргийг нэрлэжээ. Монгол Улсад хууль бусаар үйл ажиллагаа явуулдаг уул уурхайн салбар бий. Тэд гар аргаар олборлолт хийж буй “ченжүүд” алт худалдаалах албан бус сувгуудыг ашигладаг байж болзошгүй<sup>14</sup> юм (дэлгэрэнгүйг дор үзнэ үү).
- *Авлига ба хээл хахууль* – ҮЭҮ-нд гэмт хэрэг үйлдэж орлого олох томоохон эх үүсвэрийн нэгээр авлигыг нэрлэжээ. Трансперенси Интернешнл байгууллагаас тооцсон Монгол Улсын авлигын төсөөллийн индекс сүүлийн жилүүдэд сайжирч 2015 онд 168 орноос 72-т орсон байна. Түүнчлэн Эрэн сурвалжлах сэтгүүлчдийн олон улсын консорциумаас оффшор компаниудын талаар (тухайлбал, Mossack Fonseca) хийсэн судалгаанд Монголоос хэд хэдэн улс төрд нөлөө бүхий этгээд холбогдсон байна. Зохицуулалт хангалтгүй байгаагаас уул уурхайн салбарт авлига газар авсан гэх мэдээлэл байна<sup>15</sup>.
- *Залилан* – ҮЭҮ-нд гэмт хэрэг үйлдэж орлого олох томоохон эх үүсвэрийн нэгээр залиланг нэрлэжээ.
- *Хууль бусаар хил нэвтрүүлэх* – Монгол Улсын 2007 оны ХҮТ-д гэмт хэрэг үйлдэж орлого олох томоохон эх үүсвэрийн нэгээр хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэргийг нэрлэжээ. Энэхүү гэмт хэргийн цар хүрээ, ялангуяа алтыг хууль бусаар хил давуулахтай холбоотойгоор буураагүй гэх мэдээлэл байна<sup>16</sup>.

24. *Банкны Сектор* – Монгол Улсын 14 банк нь санхүүгийн секторын актив хөрөнгийн 95.7 хувийг бүрдүүлж ашгийн 80 хувийг бий болгож байна. Үүний сацуу банкууд нь банкны бус сектор болон СББМҮҮ-дийн “хаалгачийн” үүргийг гүйцэтгэдэг. Монгол Улс эрсдэлд суурилсан банкны хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлээд удаагүй байгаа нь түүний эмзэг тал болохоор байна.

25. *СББМҮҮ* – ҮЭҮ-нээс харахад үл хөдлөх хөрөнгийн секторт МУ эрсдэл өндөр байна. Мөн алт хууль бусаар хил давуулах болон уул уурхайн албан бус секторт МУ эрсдэл байгааг мэдээллийн нээлттэй хэд хэдэн эх сурвалж өгүүлж байна. Үүгээр зогсохгүй СББМҮҮ-дийг хамрах хүрээнд асуудал байгаа төдийгүй СББМҮҮ-дийн МУТСТ хяналт шалгалт хийгдээгүй байна.

26. *Албан бус болон бэлэн мөнгөн давамгайлсан эдийн засаг* – Монгол Улсын сүүдрийн болон бэлэн мөнгөний сектор нь МУ-тай тэмцэх тогтолцооны эмзэг байдлыг нэмэгдүүлж байна. Тухайлбал, ҮЭҮ-нд үл хөдлөх хөрөнгийг бэлэн мөнгөөр худалдан авбал хямдрал үзүүлэх боломжтойг дурьдсан байна. ҮЭҮ-нд Монгол Улсын албан бус секторын хэмжээг тооцсон хэд хэдэн эх сурвалжийг иш татжээ. Эдгээр тооцоо нь харилцан адилгүй аргачлалд<sup>17</sup> суурилсан тул албан бус секторын хэмжээ нь ДНБ-ий 8-13

<sup>14</sup>[http://www.bgr.bund.de/EN/Themen/Zusammenarbeit/TechnZusammenarb/Downloads/mongolei\\_MRAM\\_GoldMongolia.pdf?\\_\\_blob=publicationFile&v=4](http://www.bgr.bund.de/EN/Themen/Zusammenarbeit/TechnZusammenarb/Downloads/mongolei_MRAM_GoldMongolia.pdf?__blob=publicationFile&v=4)

<sup>15</sup> Монголын уул уурхайн салбарын авлигын эрсдэлийн үнэлгээ 2016 – Хараат бус судалгааны хүрээлэн ТББ

<sup>16</sup> <http://mram.gov.mn/wp-content/uploads/2015/04/11.pdf>

<sup>17</sup> Эдгээр тайланд өөр өөр онд харъяалагдах тоо мэдээллийг ашигласан болно.

## БҮЛЭГ 1. МУТСТ ЭРСДЭЛ БОЛОН ОРЧИН НӨХЦӨЛ

хувиас 50 хувийн<sup>18</sup> хооронд хэлбэлзэж байна. Сүүлийн үед Монгол Улс хууль тогтоомждоо өөрчлөлт оруулж албан бус секторын хэмжээг багасгахыг зорьж байна.

27. *ҮОХЗДС* –*ҮОХЗДС*-тэй холбоотой хориг арга хэмжээг хэрэгжүүлэх нь Монгол Улсын хувьд хүндрэлтэй байж болзошгүй (МУТСТ Эрсдэлийн тойм хэсэгт нарийвчлан авч үзнэ) – Энэ нь Монголд ажиллаж буй БНАСАУ-ын ажилчид, БНАСАУ-тай холбоотой хуулийн этгээдүүд, БНАСАУ-ын төрийн мэдлийн компаниуд Монголын талын эзэмшиж байсан/эзэмшиж буй хувь хэмжээтэй холбоотой.

28. *МУТСТ Хамтын Ажиллагаа Үндэсний түвшинд* – Монгол Улсад МУТСТ асуудлыг хариуцсан ХАЗ болон аюулгүй байдал (тухайлбал, ТС эсрэг хориг арга хэмжээ)-ыг хариуцсан ТГАЗЗ ажиллаж байгаа ч эрсдэлд суурилсан МУТСТ үндэсний стратеги байхгүй байна. Иймээс үнэлгээний баг Монгол Улсын МУТСТ бодлого, үйл ажиллагааны зохицуулалт, хамтын ажиллагааны түвшинг ухаж ойлгохыг хичээсэн болно.

### *Эдийн засгийн нөхцөл байдал*

29. 2015 онд Монгол Улсын ДНБ 23 их наяд төгрөг (11.8 тэрбум ам.доллар), нэг хүнд ногдох үндэсний нийт орлого 9.6 сая төгрөг (3870 ам.доллар); ДНБ-ний бодит өсөлт 2.3 хувь байв.

30. Сүүлийн жилүүдэд Монгол Улс уул уурхайн салбарт ГШХО татсанаар дэлхийн хамгийн хурдан өсөлттэй эдийн засгийн нэг болж чадав. 2010-2014 оны хооронд ДНБ-ний дундаж өсөлт 11.1 хувьтай байжээ. 2014 оноос хойш Монгол Улсын эдийн засгийн өсөлт Хятадын эдийн засгийн нөхцөл байдал, түүхий эдийн уналтаас шалтгаалан саарсан байна<sup>19</sup>. 2017 оны 2 дугаар сард Монгол Улс ОУВС-тай эдийн засгийг тогтворжуулах 5.5 тэрбум ам.долларын хэлцлийг тохиролцож чадсан байна<sup>20</sup>.

31. Монгол Улсын эдийн засаг Хятад руу гаргаж буй эрдэс баялгийн экспортоос үлэмж их хамааралтай билээ. 2015 онд уул уурхайн салбар ДНБ-ний 20%-ийг<sup>21</sup>, экспортын 88%-ийг тус тус бүрдүүлжээ. Сүүлийн жилүүдэд экспортын хэмжээ саарсан ч 2015 онд Монгол Улсын гадаад худалдааны ашиг 872 сая ам.долларт хүрэв<sup>22</sup>. 2015 онд Монгол Улсын экспорт 4.67 тэрбум ам.доллар болсон ба уул уурхайн бүтээгдэхүүний араас амьтны гаралтай бүтээгдэхүүн (нийт экспортын 6%), боловсруулах салбарын бүтээгдэхүүн (экспортын 5%), газар тариалангийн салбарын бүтээгдэхүүн (экспортын 1%) орж байна. Эдгээр бүтээгдэхүүнийг гол төлөв БНХАУ (нийт экспортын 83%), ИБУИНВУ (экспортын 7%), Швейцар (экспортын 2%), ОХУ (экспортын 1.5%) руу гаргажээ. 2015 онд Монгол Улсын импорт 3.79 тэрбум ам.долларт хүрсэн ба импортыг БНХАУ, ОХУ, Япон, БНСУ-аас авсан хэрэглээний бараа (нийт импортын 29%), тоног төхөөрөмж (импортын 38%), боловсруулсан бүтээгдэхүүн (импортын 14%), шатахуун (импортын 19%) бүрдүүлж байв.

<sup>18</sup> С. Бямбацэрэн, 2000, Сектор хоорондын баланс – ДНБ-ий 17%; Үндэсний Статистикийн хороо, 2005-2011 – ДНБ-ий 8-13%; Судлаач Баттөр, 2012 – ДНБ-ий 50%; Монголбанк (Судлаач Д.Энхзаяа), 2013 – ДНБ-ий 35%.

<sup>19</sup> Монголбанкны 2015 оны жилийн тайлан.

<sup>20</sup> <http://www.imf.org/en/News/Articles/2017/02/19/PR1754-Mongolia-IMF-Reaches-Staff-Level-Agreement-on-3Yr-EFF>

<sup>21</sup> <http://www.worldbank.org/en/country/mongolia/overview>

<sup>22</sup> Монголбанкны 2015 оны жилийн тайлан

## БҮЛЭГ 1. МУТСТ ЭРСДЭЛ БОЛОН ОРЧИН НӨХЦӨЛ

32. Монгол Улсын БНАСАУ болон Ирантай хийж буй худалдааны хэмжээ том дүнтэй биш юм. 2000 оны эхэн үетэй харьцуулахад Монгол улсын БНАСАУ-тай хийж буй худалдааны хэмжээ өсч байгаа ч 2015 онд экспорт, импортын аль аль нь 1 сая ам.долларт хүрэхгүй байв – Монгол Улс тамхи экспортлож, хүнсний бүтээгдэхүүн, эм тариаг импортлож байв. Монгол Улс Ирантай хүнсний бүтээгдэхүүний худалдаа хийдэг ба хэмжээ нь 2013 оноос эхлэн буурч байна.

### Санхүүгийн сектор

33. 2015 оны 12 дугаар сард Монгол улсын санхүүгийн секторын хэмжээ (нийт актив) 21.83 их наяд төгрөг (9.6 тэрбум ам.доллар) буюу ДНБ-ий 76.7%-тай тэнцүү байв. 2010 оноос хойш санхүүгийн секторын активын өсөлт жилд дунджаар 40%-иар өссөн бол 2015 онд 2.9%-иар өсчээ. Санхүүгийн секторын өсөлт ийнхүү хурдацтай саарсан нь ГШХО бууралт, уул уурхайн томоохон төслүүд болон нүүрсний экспортын тодорхойгүй байдлаас шалтгаалав<sup>23</sup>.

34. Өмнө нь дурьдсанчлан, Монгол улсын санхүүгийн секторыг үндсэндээ банкны сектор тодорхойлж байгаа ба нийт 1482 салбар бүхий 14 банк нь санхүүгийн секторын активын 95.7%-ийг бүрдүүлж байна. 3 том банк нь банкны секторын активын 70%-ийг буюу 14.56 их наяд төгрөгийг (6.05 тэрбум ам.доллар) бүрдүүлж байна. Монгол Улсад гадаадын банкууд үйл ажиллагаа явуулдаггүй байна. 2010 оноос хойш банкны секторын актив жилд 30 орчим хувиар өсч байсан бол 2015 онд 3.2%-иар буурчээ.

35. Монгол Улсын банкны бус секторын бүтцийг задлан харвал санхүүгийн нийт активын 2.77%-ийг (258.2 сая ам.доллар) бүрдүүлж буй 450 банк бус санхүүгийн байгууллагууд (ББСБ), 0.77%-ийг (71.1 сая ам.доллар) бүрдүүлж буй 17 даатгалын компаниуд, 0.30%-ийг (28 сая ам.доллар) бүрдүүлж буй 61 үнэт цаасны захын компаниуд, 0.25%-ийг (24 сая ам.доллар) бүрдүүлж буй 17 хөрөнгө оруулалтын сангууд, 0.43%-ийг (40 сая ам.доллар) бүрдүүлж буй 253 хадгаламж, зээлийн хоршоод зэрэг болно.

36. Монголын хөрөнгийн бирж дээр 226 компани бүртгэлтэй байдаг ба 2015 оны 12 дугаар сарын байдлаар зах зээлийн нийт үнэлгээ нь 1.2 тэрбум төгрөг (608 сая ам.доллар) байв.

37. Монгол Улс томоохон сүүдрийн эдийн засагтай улс юм. Монгол Улс сүүдрийн эдийн засгийг бууруулах эрх зүйн өөрчлөлтүүдийг сүүлийн жилүүдэд хийсэн байна. ҮЭҮ-нд Монгол Улсын албан бус секторын хэмжээг тооцсон хэд хэдэн тайланг дурьджээ. Эдгээр тооцоо нь харилцан адилгүй аргачлалд суурилсан тул сүүдрийн эдийн засгийн хэмжээ ДНБ-ний 8-13%-иас 50%-ийн хооронд хэлбэлзэж байна. Санхүүгийн хүртээмжийн хувьд Монголчуудын 92% нь санхүүгийн байгууллагад данс эзэмшдэг байна. Гэсэн хэдий ч харилцагчдын ердөө 25% нь дансаа цалин буюу засгийн газрын шилжүүлэг авахад; 6% нь хэрэглээний төлбөр төлөхөд ашигладаг ажээ<sup>24</sup>.

### СББМҮҮ-д

38. Хуульчид, нотариатчид болон ня-бо нарыг эс тооцвол СББМҮҮ секторын хөгжил сул дорой байгаа бөгөөд секторыг үнэлж болох тоо мэдээлэл, судалгаа хомс байна. Тус

<sup>23</sup> IMF Country Report No. 15/109

<sup>24</sup> <http://datatopics.worldbank.org/financialinclusion/country/mongolia>

## БҮЛЭГ 1. МУТСТ ЭРСДЭЛ БОЛОН ОРЧИН НӨХЦӨЛ

сектор нь үл хөдлөх хөрөнгийн агентууд, үнэт металл болон чулууны диллер, ня-бо нар, хуульчид болон нотариатчдаас бүрдэж байна (Хүснэгт 3).

39. 2005-2012 оны хооронд Монгол Улсын үл хөдлөх хөрөнгийн сектор маш хурдацтай тэлж орон сууцны үнэ жил бүр 10 гаруй хувиар өсч байв<sup>25</sup>. Харин сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлт удааширснаар тус секторын өсөлт саарчээ. 2015 оны байдлаар үл хөдлөх хөрөнгийн сектор ДНБ-ий 6.9%-тай (~814.2 сая ам.доллар) тэнцэж байв.

40. Үнэт металл, чулууны салбар хөгжөөгүй байна. Диллерүүд лиценз авах шаардлагатай ч Монгол Улсын диллерийн тоо, тэдний үзүүлдэг үйлчилгээ нь тодорхойгүй байна (Монгол Улс дахь алт олборлолттой хэсгийг дор үзнэ үү).

41. Монгол Улсад казиногийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглосон байдаг.

42. Монгол Улс экспресс траст, түүнтэй адил төстэй бүтэц, чиг үүрэг бүхий гэрээ, бусад зохицуулалт бүхий этгээд байгуулахыг хуулиар хориглосон байдаг<sup>26</sup>. Гадаадын трастуудыг Монгол Улсад үүсгэх, гадаадын эрх зүйн үйлчлэлийн хүрээнд үүсгэх эсхүл гадаадад үүсгэсэн трастуудыг Монгол Улсад үйл ажиллагааг явуулахыг илтэд хориглосон зүйл анги Монгол Улсын хууль тогтоомжид байхгүй ч Монголын эрх баригчид болон хувийн секторын зүгээс өгч буй мэдээллээр гадаадын трастууд нь Монголын эдийн засгийн онцлог шинж биш бөгөөд Монгол Улсад гадаадын трастуудыг үүсгэх, аль эсхүл удирдахад СББМҮҮ-чид оролцдоггүй ажээ. Гэсэн хэдий ч Монгол Улсад үйлчилж буй гадаадын эрх зүйн гэрээ, бусад зохицуулалт бүхий этгээдтэй холбоотой аливаа үнэлгээ, судалгаа байхгүй байна.

### *Бүтцийн хүчин зүйлс*

43. МУТСТ тогтолцооны бүтцийн хүчин зүйлс Монгол Улсад бүрдсэн ч стратегийн түвшинд хүлээсэн үүрэг, зорилт дутмаг байна. Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан Өршөөл үзүүлэх тухай хууль баталжээ. Энэ үйл явдал нь Монгол Улс гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой тэмцэх чинхүү сонирхол байгаа эсэхэд эргэлзэхэд хүргэж байна.

44. Монгол Улсын МУТСТ үүрэг, зорилт стратегийн түвшинд дутмаг байгааг МУТСТ үндэсний стратеги байхгүйгээс харж болно. Түүнчлэн Монгол улсад авлигын эсрэг үндэсний стратеги үгүйлэгдэж байна. Харилцан үнэлгээний баг Монгол Улсад ажиллаж байх үеэр АТГ шинэ стратегийн төслийг боловсруулан 2015 оны хавар УИХ-д өргөн барьсан ч батлагдаагүй ажээ. Энэ нь АТГ-ын эрх мэдэл нэмэгдэхээс болгоомжилсон явдал байсан гэх тайлбар ч байна<sup>27</sup>. Стратегийн түвшний үүрэг, зорилт дутмаг байгаа нь Монгол Улсын МУТСТ ойлголтыг бүдэгрүүлж АТГ-ын авлига, МУ-тай тэмцэх чадварт сөргөөр нөлөөж байна. Гэтэл авлига бол Монгол Улсын өндөр эрсдэлтэй суурь гэмт хэргийн нэг билээ.

<sup>25</sup> <http://www.globalpropertyguide.com/Asia/Mongolia>

<sup>26</sup> Монгол Улс Иргэний хуулийн 406-р зүйлийн дагуу итгэлцлийн трастыг “траст гэрээ” хэлбэрээр зохицуулсан хууль тогтоомжтой. 2008 онд Банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээний журам батлагдсанаар “траст гэрээ”-ний бүтэц, чиг үүрэг тодорхой болжээ. Эндээс үнэлгээний баг энэхүү механизм нь экспресс траст буюу түүнтэй адил төстэй бүтэц, чиг үүрэгтэй хуулийн механизм биш гэдгийг тогтоосон болно.

<sup>27</sup> ЭЗХАХБ Монгол Улс дахь авилгын эсрэг реформ тайлан, 2015

## БҮЛЭГ 1. МУТСТ ЭРСДЭЛ БОЛОН ОРЧИН НӨХЦӨЛ

45. Монгол Улс Өршөөл үзүүлэх тухай хуулийг 2015 оны 8 дугаар сард баталж, 10 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулжээ. Тус хуулийн 4 дүгээр зүйлийн дагуу 2015 оны 7 дугаар сарын 2-ны өдрөөс өмнө тус хуульд ялаас өршөөн хасах болон өршөөлд хамааруулахгүйгээр зааснаас (өршөөлд үндэсний аюулгүй байдалтай холбоотой гэмт хэргүүд хамаарахгүй, тухайлбал терроризм, терроризмыг санхүүжүүлэх, хар тамхи, мансууруулах бодисыг хэрэглэх, тээвэрлэх, авлига<sup>28</sup>) бусад гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн ялтныг шүүхээс оногдуулсан болон биечлэн эдэлсэн ялын хугацааг үл харгалзан эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялаас өршөөн хэлтрүүлэхээр заажээ. Түүнчлэн тус хуулийн 7 дугаар зүйлийн дагуу 2015 оны 7 дугаар сарын 2-ны өдрөөс өмнө ялаас өршөөн хасах болон өршөөлд хамааруулахгүйгээр зааснаас бусад гэмт хэрэг (тухайлбал, МУ) үйлдсэн хүний хэрэг бүртгэх, мөрдөн шалгах болон шүүхээр хянан шийдвэрлэх шатанд байгаа эрүүгийн хэргийг тус тус хэрэгсэхгүй болгожээ. Өршөөлд онц аюултай болон давтан үйлдэлтэй гэмт хэрэгтнүүдийг хамруулахгүй байх зарим зохицуулалт байгаа ч (10 дугаар зүйлийг үз) үнэлгээний багийн үзэж байгаагаар тус хууль нь Монгол Улсын МУТСТ тогтолцоог, тухайлбал мөнгө угаасан хэрэгтнүүдийг шийтгэх, гэмт хэрэг үйлдэж олсон орлогод хориг тавих Монгол Улсын үүрэг амлалтыг сулруулж байна. Хүснэгт 1-д ялын хөнгөлөлт буюу өршөөлд хамрагдсан хүний тоо, хэрэгсэхгүй болгосон хэргийн тоог үзүүлэв.

### Хүснэгт 1: Өршөөлийн хуулиар ялын хөнгөлөлт/чөлөөлөлт эдэлсэн хүний болон хэрэгсэхгүй болгосон хэргийн тоо

| Гэмт хэргийн төрөл                           | Тоо   |
|--|-------|
| <i>Ялын хугацааг нь бууруулсан хүний тоо</i> |       |
| Эдийн засгийн бус гэмт хэрэг                 | 1,103 |
| Эдийн засгийн гэмт хэрэг                     | 657   |
| Бүлгийн дүн                                  | 1,760 |
| <i>Ялаас чөлөөлөгдсөн хүний тоо</i>          |       |
| Эдийн засгийн бус гэмт хэрэг                 | 435   |

<sup>28</sup> Эрүүгийн хуулийн дараахь зүйл ангид хамаарах гэмт хэрэг өршөөлд хамрагдаагүй болно: Эх орноосоо урвах /79 дүгээр зүйл/, Тагнуул хийх /80 дугаар зүйл/, Төр, нийгмийн зүтгэлтний амь биед халдах /81 дүгээр зүйл/, Зэвсэгт үймээн дэгдээх /83 дугаар зүйл/, Хорлон сүйтгэх /84 дүгээр зүйл/, Хорлон саатуулах /85 дугаар зүйл/, Хүнийг санаатай алах /91 дүгээр зүйл/, Хүний цус, эд, эрхтэнг хууль бусаар авах /101 дүгээр зүйлийн 101.2 дахь хэсэг/, Хүн хулгайлах /108 дугаар зүйлийн 108.3 дахь хэсэг/, Хүнийг барьцаалах /112 дугаар зүйлийн 112.2 дахь хэсэг/, Хүн худалдаалах /113 дугаар зүйлийн 113.2, 113.3 дахь хэсэг/, Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах /125 дугаар зүйлийн 125.2 дахь хэсэг/, Хүчиндэх /126 дугаар зүйлийн 126.2, 126.3 дахь хэсэг/, Гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомж зөрчих /133 дугаар зүйл/, Бусдын эд хөрөнгийг хулгайлах /145 дугаар зүйлийн 145.4 дэх хэсэг/, Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх /147 дугаар зүйлийн 147.3 дахь хэсэг/, Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах /148 дугаар зүйлийн 148.4 дэх хэсэг/, Зандалчлах /177 дугаар зүйлийн 177.2 дахь хэсэг/, Терроризм /178<sup>1</sup> дүгээр зүйл/, Терроризмыг санхүүжүүлэх /178<sup>2</sup> дугаар зүйл/, Тэсэрч дэлбэрэх болон түргэн шатамхай бодисыг агаарын хөлөгт хууль бусаар авч явах /184 дүгээр зүйл/, Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах буюу хордуулах, цацраг идэвхт, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлэх /188 дугаар зүйлийн 188.4 дэх хэсэг/, Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах /192 дугаар зүйлийн 192.3 дахь хэсэг/, Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх бодисыг хэрэглэх газар зохион байгуулах /196 дугаар зүйл/, Агаарын хөлөг авч зугтаах /225 дугаар зүйл/, Илт гэм буруугүй хүнийг сэжигтнээр тооцох, яллагдагчаар татах, ял шийтгэх /248 дугаар зүйлийн 248.2 дахь хэсэг/, Эрүү шүүлт тулгах /251 дүгээр зүйлийн 251.3 дахь хэсэг/, Прокурорын хяналт, шүүх, цагдан хорих, хорих ангиас оргох /261 дүгээр зүйлийн 261.2 дахь хэсэг/, Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах /263 дугаар зүйл/, Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх /264 дүгээр зүйл/, Хээл хахууль авах /268 дугаар зүйл/, Хууль бусаар хөрөнгөжих /270<sup>1</sup> дүгээр зүйл/, Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах /273 дугаар зүйл/.

## БҮЛЭГ 1. МУТСТ ЭРСДЭЛ БОЛОН ОРЧИН НӨХЦӨЛ

|  |       |
|--|-------|
| Эдийн засгийн гэмт хэрэг   | 243   |
| Бүлгийн дүн  | 678   |
| <i>Хэргийг хэрэгсэхгүй болгосон тохиолдол (хэрэг бүртгэх, мөрдөн шалгах болон шүүхээр хянан хэлэлцэх шатанд)</i> |       |
| Эдийн засгийн бус гэмт хэрэг   | 1,665 |
| Эдийн засгийн гэмт хэрэг   | 80    |
| Бүлгийн дүн  | 1,745 |
| Бүгд   | 4,183 |

46. Дараахь мэдээллийн нээлттэй эх сурвалжууд нь Монгол Улсын МУТСТ тогтолцооны бүтцийн хүчин зүйлс ямар байгааг харуулж байна.

47. Хууль дээдлэх зарчмын индекс 0-ээс 1 хүртэл утга авах ба 1 рүү ойртох тусам хууль дээдлэх зарчим сайжирч буйг илтгэнэ. Монгол Улсын хууль дээдлэх зарчмын индекс 2016 онд 0.54 байв /The World Justice Project’s 2016 Rule of Law Index/. Тус үзүүлэлтээр Монгол Улс 113 орноос 55-т жагссан байна. Өмнөх тайлантай харьцуулахад Эрүүгийн эрх зүйн үзүүлэлт дээшилсэн боловч бусад үзүүлэлтүүд хэвээрээ байна.

48. Доорхи хүснэгтэд засаглалын индексүүд 2010-2015 онд хэрхэн өөрчлөгдсөнийг харуулна /World Bank World Wide Governance Indicators Country Snapshots/. Монгол Улсын Дуу хоолой ба Хариуцлага, Улс төрийн тогтвортой байдал ба Терроризм/Хүчирхийллээс ангид байдал, Засгийн газрын үр нөлөө ба Авлигын хяналтын индексүүд 2010 оноос хойш сайжирчээ. Харин Зохицуулагчийн чанар ба Хууль дээдлэх зарчмын үзүүлэлтүүд 2015 оны хувьд бага зэрэг буурсан байна.

### Хүснэгт 2: Дэлхийн банк: Монгол Улсын засаглалын үзүүлэлтүүд

| Үзүүлэлт  | Засаглалын<br>оноо<br>2010 онд<br>(-2.5-аас +2.5) <sup>29</sup> | Перцентиль<br>2010 оны<br>ранг<br>(0-100) <sup>30</sup> | Засаглалын<br>оноо<br>2015 онд<br>(-2.5-аас +2.5) | Перцентиль<br>2015 оны ранг<br>(0-100) |
|---|---|---|---|--|
| Дуу хоолой болон Хариуцлага   | 0.04  | 50.24   | 0.24  | 56.65                                  |
| Улс төрийн тогтвортой байдал,<br>Терроризмаас/Хүчирхийллээс<br>ангид байдал | 0.59  | 67.30   | 0.65  | 67.14                                  |
| Засгийн газрын үр нөлөө   | -0.57   | 34.93   | 0.40  | 40.38                                  |

49. Нийтийн албан дахь авлига бол төсөөлөгдөж буй хүндрэлтэй асуудлын нэг юм. Хамгийн сүүлийн Transparency International Global Corruption Barometer Report (2013) тайланд дурдсанаар монголчуудын 65% нь улс төрийн намуудыг “авлигад өртсөн буюу

<sup>29</sup> Засаглалын үзүүлэлтийг -2.5 to +2.5 хооронд хэмжинэ. Үзүүлэлтийн утга нэмэгдэх тусам засаглалын чанар сайжирч буйг илтгэнэ.

<sup>30</sup> Тухайн улсыг бусад улс оронтой харьцуулсан байдлаар харуулна. 0-перцентиль нь хамгийн бага рангийг харуулж байгаа бол 100-р перцентиль нь хамгийн өндөр рангийг харуулна.

## БҮЛЭГ 1. МУТСТ ЭРСДЭЛ БОЛОН ОРЧИН НӨХЦӨЛ

маш их өртсөн”, 63% нь парламент/хууль тогтоох засаглал “авлигад өртсөн буюу маш их өртсөн”, 66% нь цагдаа нарыг “авлигад өртсөн буюу маш их өртсөн”, 77% нь төрийн болон нийтийн албан хаагчдыг “авлигад өртсөн буюу маш их өртсөн” хэмээн хариулжээ<sup>31</sup>. Түүнчлэн санал асуулгад оролцогсдын 45% нь авлига өгч байсан хэмээн хариулжээ.

50. Монгол Улсын авлигын төсөөллийн индекс /Transparency International corruption perception index/ сүүлийн жилүүдэд сайжирч 2015 онд 168 улс орноос 72-г оржээ.

### *Суурь болон бусад хүчин зүйлс*

51. 2015 оны 8 дугаар сард Монгол Улс Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль баталжээ. Бид энэ хуулийг сайн дурын үндсэн дээр татварыг дагаж мөрдөх схем /voluntary tax compliance (VTC) scheme<sup>32</sup>/-тэй адилтган авч үзэж байна. Учир нь тус хуулийн зорилго нь хувь хүн, хуулийн этгээд хөрөнгө орлогоо сайн дурын үндсэн дээр ил тод болгосон нөхцөлд НӨАТ, Татварын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Гаалийн тухай болон Захиргааны ерөнхий хуульд заасан хариуцлага болон албан татвар, хүү, торгуулиас нэг удаа чөлөөлөхөөр заажээ.

52. Монгол Улс алтны үлэмж нөөцтэй. Алтны сектор нь томоохон олборлогчид, бичил уурхайчид болон хууль бус олборлогчдоос бүрдэнэ. Бичил уурхайн үйл ажиллагааг Засгийн газрын 308 тоот тогтоолоор баталсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын дагуу зохицуулна. 100 мянга орчим бичил уурхайчид 4-7 тонн алт олборлодог гэсэн тооцоо бий<sup>33</sup>. Харин хууль бус олборлолтын секторт 60 мянган хүн 5 тонн алт олборлодог гэсэн баримжаа тооцоо байна<sup>34</sup>. Алтыг Үнэт металлын сорьцын хяналтын газраар дамжуулан Монголбанкинд худалдах тогтолцоо байгаа ч Улаанбаатар хотоос алс хол байрших хууль бус болон бичил уурхайчид цэвэршүүлээгүй алтыг албан бус диллерүүд/”ченжүүд”-эд зарах замаар сүүдрийн эдийн засгийг хөөргөж, контрабанд, нэр усгүй гүйлгээг нэмэгдүүлж байж болзошгүй юм.

53. Монгол Улс Чөлөөт бүсийн тухай хуулийн дагуу чөлөөт худалдааны 3 бүс байгуулжээ. Нэг бүс нь Алтанбулагт, нөгөөх нь Замын-Үүдэд, гуравдах нь Баян-Өлгийн аймгийн Цагааннуурын боомтод байрладаг. Чөлөөт худалдааны бус (ЧХБ)-эд татвар, гааль, шалган нэвтрүүлэх, хуулийн этгээдийн болон иргэний бүртгэл, хөдөлмөр эрхлэлтийн тусгай дэглэм мөрдөгдөх ажээ<sup>35</sup>. Гэхдээ бидэнд өгсөн мэдээллээр бол ЧХБ-үүд дорвитой хөгжөөгүй бөгөөд 3 бүсийн жилийн эргэлт 10 сая ам.доллар давдаггүй аж. Эдгээр бүсэд үйл ажиллагаа явуулдаг СБ байхгүй ба Замын-Үүдэд ердөө ганц нотариатын үйлчилгээтэй ажээ.

54. Монгол Улс казиногийн үйл ажиллагааг хориглосон байдаг. Гэхдээ казиногийн талаарх хуулийн төсөл УИХ-аас 2017 онд хэлэлцэх асуудлыг жагсаалтад байгаа аж.

<sup>31</sup> <http://www.transparency.org/gcb2013/country/?country=mongolia>

<sup>32</sup> АНДББ нь 2017 оны 7 дугаар сард уг хууль нь АНДББ-ын VTC бодлоготой нийцэж буйг тогтоосон болно.

<sup>33</sup> [http://www.bgr.bund.de/EN/Themen/Zusammenarbeit/TechnZusammenarb/Downloads/mongolei\\_MRAM\\_GoldMongolia.pdf?\\_\\_blob=publicationFile&v=4](http://www.bgr.bund.de/EN/Themen/Zusammenarbeit/TechnZusammenarb/Downloads/mongolei_MRAM_GoldMongolia.pdf?__blob=publicationFile&v=4)

<sup>34</sup> [https://www.khanbank.com/uploads/users/28-khanbank/IBD\\_Daily\\_Report\\_2014\\_03\\_07.pdf](https://www.khanbank.com/uploads/users/28-khanbank/IBD_Daily_Report_2014_03_07.pdf)

<sup>35</sup> Doing Business Guide in Mongolia, PWC, 2015

## БҮЛЭГ 1. МУТСТ ЭРСДЭЛ БОЛОН ОРЧИН НӨХЦӨЛ

55. Монгол Улсын албан ёсны хэл нь монгол хэл билээ. Монгол Улс хууль тогтоомж, албан баримт бичгээ англи хэлээр хэвлэдэггүй, англи хэл рүү албан ёсоор хөрвүүлдэггүй ажээ. Иймээс энэхүү тайланд ашиглаж буй баримт бичгүүдийн орчуулга нь СМА болон бусад байгууллагын албан бус орчуулга болно.

56. Харилцан үнэлгээнд шаардлагатай тоо мэдээ, нотлох баримт бичгийг гаргаж өгөх нь Монгол Улсын хувьд хүндрэл, бэрхшээлтэй асуудал байсан болно.

### *(a) МУТСТ стратеги*

57. Монгол Улс Үндэсний Стратеги болон Үйл ажиллагааны төлөвлөгөөний төслөө харахан батлаагүй байв. Бидний ойлгосноор Монгол Улс МУТСТ бодлого боловсруулж хэрэгжүүлэх асуудалд тэргүүн зэргийн ач холбогдол өгч байна. Энэхүү үйл ажиллагааг ХАЗ хэрэгжүүлж байгаа бол ТТАЗЗ нь Терроризмтой тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлж хянах үүрэгтэй. Терроризмтой тэмцэх тухай хуульд зорилтот санхүүгийн хориг арга хэмжээг тусгасан ч ТТАЗЗ-ийн үндсэн үйл ажиллагаа нь ТС бус харин терроризмтой тэмцэх үйл ажиллагааг зохицуулахад орших ажээ.

58. Монголбанкийг эс тооцвол бусад эрх бүхий байгууллагаас МУТСТ ач холбогдол, эрэмбийг авч үзсэн дотоод баримт бичиг, удирдамж заавар зэргийг бидэнд гаргаж өгөөгүй болно. Ийм баримт бичиг, удирдамж заавар байдаг эсэх нь тодорхойгүй байна.

### *(b) Хууль эрх зүй болон институтийн орчин*

59. Монгол Улс Ром-Германы уламжлалт иргэний эрх зүйтэй улс билээ. Монгол Улсын 1992 оны Үндсэн хууль нь эх хууль бөгөөд түүнийг дагалдах хуулиудыг УИХ батална. Үндсэн хуульд зааснаар Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.

60. Монгол Улсын МУТСТ тогтолцоо нь дараахь хууль тогтоомжоор зохицуулагддаг:

- 2002 оны Эрүүгийн хуулийн дагуу МУ болон ТС-ийг гэмт хэрэгт тооцно. Харин Эрүүгийн байцаан шийтгэх хууль нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг явуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
- НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1267 болон 1373 дугаар тогтоолын дагуу авах зорилтот санхүүгийн хориг арга хэмжээ нь Терроризмтой тэмцэх (ТТ) хууль болон Террорист этгээдийн жагсаалтад оруулах, жагсаалтад орсон этгээдийн хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох, хянах журам (ТЭЖО)-д тусгагджээ. Гэхдээ бидний үзэж байгаагаар Монгол Улсын хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох механизм (Шалгуур 6.5) дараахь шалтгааны улмаас хэрэгжихгүй байна: (i) ТТ хууль болон ТЭЖО журамд хөрөнгө зогсоох үүргийн зөрчилд хүлээлгэх хариуцлага байхгүй, хөрөнгө мөнгө зориулан гаргахыг хориглосон зүйл байхгүй, СБ-ууд болон СББМҮҮ-ид царцаасан хөрөнгө буюу авсан арга хэмжээгээ тайлагнах шаардлага байхгүй, (ii) хууль журмын зөрчилд шууд бус/өргөн хүрээтэй шийтгэл оногдуулах талаар харилцан иш татсан заалтууд ТТ хууль болон ТЭЖО журамд байхгүй, шууд бус/өргөн хүрээтэй шийтгэлийг хуулийн этгээд болон хувь хүнд оногдуулсан гэх баримт алга.

## БҮЛЭГ 1. МУТСТ ЭРСДЭЛ БОЛОН ОРЧИН НӨХЦӨЛ

- НҮБАЗ-ийн 1718, 1737, 1803, 1874 болон 1929 дүгээр тогтоолын дагуу БНАСАУ, Ираны эсрэг зорилтот санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх хууль эрх зүйн тогтолцоо Монгол улсад байхгүй байна.
  - МҮЭ-ийн МУТСТ урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах үүрэг хариуцлагыг банкуудын хувьд МУТСТ хуульд, УСЖ, Банкнаас СМА-нд мэдээлэл ирүүлэх журамд тусгасан байдаг бол банк бус этгээдүүдийн хувьд тусгайлсан хуулиудад тус тус тусгасан байдаг. СББМҮҮ-ийн хамрах хүрээний хувьд ноцтой дутагдлууд байгаа бөгөөд зөвхөн нотариатчид МУТСТ хууль тогтоомжийг мөрдөх үүрэгтэй аж.
  - Хуулийн этгээд болон хуулийн бусад зохицуулалт бүхий этгээдийн ил тод байдал, эцсийн өмчлөлийг 2002 оны Иргэний тухай хууль, 2012 оны Компанийн тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд тус тус тусгажээ.
  - Зохицуулагчдын эрх үүргийг Монголбанк /Төв банк/-ны тухай (1996) болон Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд (2005) тусгажээ.
  - ХСБ-уудын эрх үүргийг ЭБШХ болон ХСБ-уудын тухай хууль тогтоомжид тусгасан байдаг.
  - Олон улсын хамтын ажиллагааг ЭБШХ-д заасны дагуу болон гадаад улс орнуудтай байгуулсан гэрээний дагуу хэрэгжүүлнэ.
61. Монгол Улсын МУТСТ тогтолцоог дараахь яам, агентлаг хэрэгжүүлнэ:
- *Монголбанк* нь Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн дагуу банкуудад зөвшөөрөл олгох, хяналт шалгалт хийх үүрэгтэй төв банк билээ. СМА нь Монголбанкны дэргэд ажилладаг. Төв банкны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн дагуу Хяналт, шалгалтын газар нь банкны зохистой харьцаа, үйл ажиллагаанд хяналт тавих бол МУТСТ хуулийн 19 дүгээр зүйлийн дагуу банкууд МУТСТ хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавина.
  - *СМА* нь МУТСТ хуулийн 16 дугаар зүйлийн дагуу МҮЭ-ээс сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээний тайлан, бусад тайлан мэдээ хүлээн авах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, дүн шинжилгээний үр дүнд МУТСТ-тэй холбоотой гэж сэжиглэсэн гүйлгээ, гүйлгээний оролдлогын талаарх мэдээллийг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлэх чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан байгууллага билээ. МУТСТ хуулийн 19 дүгээр зүйлийн дагуу СМА нь банк бус сектор болон үл хөдлөх хөрөнгийн зуучлагчид МУТСТ хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад СЗХ-той хамтран хяналт тавина.
  - *СЗХ* нь банк бус салбарын тогтвортой байдлыг хангах, банк бус байгууллагыг бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох чиг үүрэг бүхий төрийн байгууллага билээ. СЗХ нь банк бус байгууллагуудын зохистой харьцаа, үйл ажиллагаанд хяналт тавих бол МУТСТ хуулийн 19 дүгээр зүйлийн дагуу ББСБ-ууд, ХЗХ-оод, хөрөнгө оруулалтын сангууд, үнэт цаас, даатгал, үл хөдлөх хөрөнгийн компаниуд МУТСТ хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад СМА-тай хамтран хяналт тавина.

## БҮЛЭГ 1. МУТСТ ЭРСДЭЛ БОЛОН ОРЧИН НӨХЦӨЛ

- *ЦЕГ* нь Хууль зүй, дотоод хэргийн яаманд харьяалагдах бөгөөд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүрэгтэй. ЭБШХ-ийн дагуу ЦЕГ нь Эрүүгийн хуульд заасан ТЕГ болон АТГ-г хамаарахаас бусад гэмт хэргийг мөрдөн шалгах эрхтэй.
- *ТЕГ* нь Монгол Улсын Ерөнхий сайдад харьяалагдах үндэсний аюулгүй байдлыг хариуцсан байгууллага билээ. ЭБШХ-ийн дагуу ТЕГ нь өөрийн эрх мэдлийн хүрээнд хамаарах МУТС гэмт хэргийг (ихэвчлэн хил, үндэсний аюулгүй байдалтай холбоотой) мөрдөн шалгах эрхтэй. ТЕГ нь Монгол Улсын зорилтот санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх ТТАЗЗ-д тэргүүлэх үүрэгтэй байгууллага билээ.
- *АТГ* нь 2006 оны Авлигын эсрэг хуулийн дагуу (2012 онд нэмэлт, өөрчлөлт орсон) авлигатай тэмцэх үйл ажиллагаа хариуцсан хараат бус, бие даасан, төрийн тусгай байгууллага билээ. АТГ нь ЭБШХ-ийн дагуу нийтийн албан хаагчдад хамаарах МУ хэргийг мөрдөн шалгах эрхтэй.
- *Гаалийн Ерөнхий газар (ГЕГ)* нь Монгол Улсын 2008 оны Гаалийн тухай хуулийн дагуу Монгол Улсын гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт хэрэгжүүлэх үүрэгтэй. МУТСТ тогтолцооны хувьд ГЕГ нь гаалийн деклараци болон мэдээлэх холимог системийг хариуцна. ГЕГ нь мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах эрхгүй.
- *УЕПГ* нь төрийн нэрийн өмнөөс эрүүгийн эрх зүйн хууль тогтоомжийг хэрэгжүүлэгч байгууллага билээ. УЕПГ-ын үйл ажиллагаа нь хоёр хэсгээс бүрдэнэ: нэг нь мөрдөн шалгах ажиллагаа, гүйцэтгэлд (тухайлбал, МУТС) хяналт тавих бол нөгөө нь шүүхэд төрийг төлөөлөх явдал болно. УЕПГ нь МУТС-тэй холбоотой эрх зүйн харилцан туслалцааг мөн хариуцна.
- *Гадаад харилцааны яам (ГХЯ)* нь Монгол Улсын гадаад бодлого, дипломат болон консулын үйлчилгээг хэрэгжүүлнэ. МУТСТ тогтолцооны хувьд ГХЯ нь олон улсын байгууллагууд (тухайлбал, НҮБ)-тай харилцах анхдагч байгууллага билээ.
- *ОӨУБЕГ* нь Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хуулийн дагуу хуулийн этгээдийг, үүний дотор ашгийн бус байгууллагыг бүртгэх үүрэгтэй.

### (с) Санхүүгийн сектор болон СББМҮҮ-ид

62. Монгол Улсын санхүүгийн сектор нь 14 банк, 450 ББСБ-ууд, 253 ХЗХ-д, 17 хөрөнгө оруулалтын компани, 61 үнэт цаасны компани болон 17 даатгалын компаниас бүрдэж байна.

## БҮЛЭГ 1. МУТСТ ЭРСДЭЛ БОЛОН ОРЧИН НӨХЦӨЛ

### Хүснэгт 3: СБ-ууд, СББМҮҮ-ид, МУТСТ зохицуулагчид, хяналт тавих этгээд

| Сектор                                   | Тоо               | Зохицуулагч                     | Урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй эсэх | МУСТ Зохицуулагч | Нийт хөрөнгө                            | Санхүүгийн секторын активт эзлэх жин |
|--|-------------------|---------------------------------|--|------------------|---|--------------------------------------|
| <i>Санхүүгийн байгууллагууд</i>          |                   |                                 |  |                  |   |                                      |
| Арилжааны банк                           | 14                | МБ                              | Тийм   | МБ               | 20.8 их наяд төг (8.6 тэрбум ам.доллар) | 95.7%                                |
| <i>Банк бус</i>                          |                   |                                 |  |                  |   |                                      |
| ББСБ-ууд <sup>36</sup>                   | 450               | СЗХ                             | Тийм   | СЗХ/СМА          | 623.2 тэрбум төг (258.2 сая ам.доллар)  | 2.77%                                |
| ХЗХ-д                                    | 253               | СЗХ                             | Тийм   | СЗХ/СМА          | 97.6 тэрбум төг (40 сая ам.доллар)      | 0.43%                                |
| Хөрөнгө оруулалтын сангууд               | 17                | СЗХ                             | Тийм   | СЗХ/СМА          | 58.0 тэрбум төг (24 сая USD)            | 0.25%                                |
| Үнэт цаасны компаниуд                    | 61                | СЗХ                             | Тийм   | СЗХ/СМА          | 67.9 тэрбум төг (28.1 сая ам.доллар)    | 0.30%                                |
| Даатгалын компаниуд                      | 17                | СЗХ                             | Тийм   | СЗХ/СМА          | 173.2 тэрбум төг (71.7 сая ам.доллар)   | 0.77%                                |
| Улсын тэтгэврийн болон даатгалын сангууд | 2(аль аль нь)     | -                               | Үгүй   | Байхгүй          | -                                       | -                                    |
| <i>СББМҮҮ</i>                            |                   |                                 |  |                  |   |                                      |
| Казино                                   | -                 | -                               | -  | -                | -                                       | Мэдээлэл байхгүй                     |
| Үл хөдлөх хөрөнгийн агент                | 8                 | ОӨУБЕГ <sup>37</sup>            | Тийм <sup>38</sup>   | СМА/СЗХ          | -                                       | Мэдээлэл байхгүй                     |
| Үл хөдлөх хөрөнгийн компани              | 3,475             | ОӨУБЕГ <sup>37</sup>            | Үгүй   | Байхгүй          | -                                       | Мэдээлэл байхгүй                     |
| Үнэт чулуу, мегаллын дилерүүд            | -                 | УУХҮЯ                           | Үгүй   | Байхгүй          | -                                       | Мэдээлэл байхгүй                     |
| Хуульчид                                 | 5,507             | Өмгөөлөгчдийн холбоо            | Үгүй   | Байхгүй          | -                                       | Мэдээлэл байхгүй                     |
| Ня-бо нар                                | 3,941             | Мэргэшсэн ня-бодогчдын институт | Үгүй   | Байхгүй          | -                                       | Мэдээлэл байхгүй                     |
| Нотариатчид                              | 304 <sup>39</sup> | Нотариатчдын танхим             | Тийм   | Байхгүй          | -                                       | Мэдээлэл байхгүй                     |
| Компаний/Траст үйлчилгээ үзүүлэгчид      | Мэдээлэл байхгүй  | Мэдээлэл байхгүй                | Мэдээлэл байхгүй   | Мэдээлэл байхгүй | Мэдээлэл байхгүй                        | Мэдээлэл байхгүй                     |

<sup>36</sup> Валют солилцооны үйлчилгээ эрхэлдэг зочид буудал болон бусад компани орно

<sup>37</sup> ОӨУБЕГ нь үл хөдлөх хөрөнгийн компаниудыг хуулийн этгээдээр бүртгэнэ

<sup>38</sup> Үл хөдлөх хөрөнгийн компаниудын хувьд МУТСТ хууль болон УСЖ үйлчлэхгүй

<sup>39</sup> Хуулийн этгээдийн тоо, нотариатчдын тоо биш.

## БҮЛЭГ 1. МУТСТ ЭРСДЭЛ БОЛОН ОРЧИН НӨХЦӨЛ

Жич: - = Монгол Улс мэдээлэл гаргаж өгөөгүй буюу мэдээлэл тодорхойгүй

Санхүүгийн сектор

63. Хүснэгт 3-т харуулсанчлан, Монголбанк нь банкуудад зохистой харьцааны болон МУТСТ хяналт тавина. Монгол Улсын санхүүгийн секторт 1482 салбартай, санхүүгийн салбарын хөрөнгийн 95.7%-ийг эзэмшиж буй 14 банкны үүрэг чухал гэдгийг дээр дурьдсан билээ. Биднийг Монголд ажиллах үеэр нийт хөрөнгийн 4%-ийг эзэмшиж буй 4 банкны үйл ажиллагаа хязгаарлагдмал байсан бол 1 банк үйл ажиллагаагаа зогсоосон байв. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй гадны банк байхгүй бөгөөд гадаадад үйл ажиллагаа явуулж буй Монголын банк байхгүй аж.

64. Хүснэгт 3-т харуулсанчлан, СЗХ нь банкны бус секторт тусгай зөвшөөрөл олгох, зохицуулах, зохистой харьцаанд хяналт тавих бөгөөд МУТСТ хяналтыг СМА-тай хамтран тавина. 2015 оны 12 дугаар сарын байдлаар 450 ББУСБ, 253 ХЗХ, 17 хөрөнгө оруулалтын сан, 61 үнэт цаасны компани, 17 даатгалын компани үйл ажиллагаа явуулж байв. Тэд нийлээд санхүүгийн секторын хөрөнгийн 3 хүрэхгүй хувийг бүрдүүлж байна.

65. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн дагуу ББСБ-ыг зохицуулж, тусгай зөвшөөрөл олгоно. ББСБ-ууд нь зээл олгох, санхүүгийн лизинг, төлбөрийн хэрэгсэл гаргах, цахим төлбөр, шилжүүлгийн үйлчилгээ, гадаад валютын солилцоо, богино хугацаат санхүүгийн хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийх зэрэг үйл ажиллагаа эрхэлж байна. ББСБ-уудыг үйл ажиллагаагаар ангилсныг Хүснэгт 4-т үзүүлэв.

### Хүснэгт 4: Санхүүгийн үйлчилгээ эрхэлж буй ББСБ-ууд

| Үйл ажиллагааны төрөл   | 2016 оны 10-р сарын байдлаар |
|---|------------------------------|
| Зээлийн үйл ажиллагаа   | 45                           |
| Факторингийн үйлчилгээ  | 22                           |
| Төлбөрийн баталгаа гаргах                                     | 16                           |
| Өр барагдуулах хэрэгсэл гаргах                                | 1                            |
| Цахим гүйлгээ, шилжүүлгийн үйлчилгээ                          | 12                           |
| Гадаад валютын солилцоо                                       | 142                          |
| Итгэлцлийн үйлчилгээ  | 28                           |
| Богино хугацаат санхүүгийн хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийх | 2                            |
| Хөрөнгө оруулалт, санхүүгийн мэдээлэл, заавар өгөх            | 33                           |
| <b>БҮГД</b>   | <b>301<sup>40</sup></b>      |

66. Хадгаламж, зээлийн хорошооны тухай хуулийн дагуу СЗХ нь ХЗХ-дыг зохицуулж, тусгай зөвшөөрөл олгоно. ХЗХ-ын үндсэн үйл ажиллагаа нь хадгаламж татах, зээл олгох юм. ХЗХ-ын бусад үйл ажиллагаанд: (i) санхүүгийн лизингийн үйлчилгээ, (ii) төслийн санхүүжилт, (iii) цахим төлбөр тооцооны төлөөлөгч болон ажиллах, (iv) даатгалын завсрын үйл ажиллагаа, (v) мөнгөн шилжүүлгийн үйлчилгээ, (vi) хуримтлалын санг үүсгэж удирдах. ҮЭҮ-нд ХЗХ-ын эрсдэлийг тогтоосон зүйл байхгүй аж.

67. Хүснэгт 3-т харуулсанчлан, хөрөнгө оруулалтын сангуудыг Хөрөнгө оруулалтын сангийн хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу зохицуулна. Тус

<sup>40</sup> Зарим байгууллага нэгээс дээш төрлийн санхүүгийн үйлчилгээ эрхлэх тул тухайн төрлийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээдийн тоо нь банк бус санхүүгийн байгууллагын нийт тоотой тэнцэхгүй.

## БҮЛЭГ 1. МУТСТ ЭРСДЭЛ БОЛОН ОРЧИН НӨХЦӨЛ

сангууд нь хөрөнгө оруулалтын чиглэлээр, тухайлбал даатгалын сангийн хөрөнгийг удирдах, хөрөнгө оруулалтын сангийн эсвэл тэтгэврийн сангийн гүйлгээ хийх зэрэг СЗХ-ноос зөвшөөрсөн үйл ажиллагааг эрхэлдэг аж. ҮЭҮ-нд хөрөнгө оруулалтын сангуудын эрсдэлийг тогтоосон зүйл байхгүй аж.

68. Хүснэгт 3-т харуулсанчлан, үнэт цаасны компаниудыг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай зарим үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэх журмын дагуу зохицуулна. Эдгээр компани нь брокер, дилер, хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа, үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх, үнэт цаасны трастын үйл ажиллагаа, андеррайтер, үнэт цаасны эзэмшлийн эрхийг бүртгэх, үнэт цаасны худалдаа, клиринг, үнэт цаасны арилжааны төлбөр тооцоо, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйлчилгээ, үнэт цаасны кастодиан үйлчилгээ, үнэт цаасны арилжаа зэрэг үйл ажиллагаа эрхэлдэг байна. ҮЭҮ-нд үнэт цаасны компаниудын эрсдэлийг бага хэмээн тогтоожээ.

69. Хүснэгт 3-т харуулсанчлан, даатгалын компаниудыг Даатгалын тухай хуулийн дагуу зохицуулна. Даатгалын компаниуд нь урт хугацаат<sup>41</sup> даатгал болон ерөнхий даатгалын<sup>42</sup> (тухайлбал, амь насны) бүтээгдэхүүнийг санал болгодог байна. Даатгалын зуучлагчдыг Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн дагуу зохицуулах ба тэд даатгалын төлөөлөгчийн эсвэл брокерын алдагдлыг зохицуулах үйлчилгээ эрхэлдэг аж. ҮЭҮ-нд үнэт даатгалын компаниудын эрсдэлийг бага хэмээн тогтоожээ.

### *СББМҮҮ-ид*

70. СББМҮҮ-дийн сектор нь үл хөдлөх хөрөнгийн зуучлагч/ААН, үнэт металл, чулууны диллерүүд, ня-бо нар, хуульчид болон нотариатчдаас бүрдэнэ (Хүснэгт 3). Монгол Улсад казино хориотой, компаний үйлчилгээ/траст үйлчилгээ үзүүлэгч компани байхгүй ажээ (нотариатчид зарим компаний үйлчилгээ үзүүлдэг байж магадгүй). МУТСТ тогтолцоонд ББМҮҮ-дээс зөвхөн үл хөдлөх хөрөнгийн зуучлагчид болон нотариатчид хамрагдаж байгаагийн дээр хуулийн шаардлагыг биелүүлэх үүрэг зөвхөн нотариатчдад ногддог ажээ.

71. Үл хөдлөх хөрөнгийн бизнес хийдэг 3475 этгээд ОӨУБЕГ-т бүртгүүлснийг Хүснэгт 3-аас харж болно. Тэдний үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээллийг бидэнд гаргаж өгөөгүй болно. МУТСТ хуулийн хүрээнд үл хөдлөх хөрөнгийн 8 зуучлагчийг хамруулжээ. Үл хөдлөх хөрөнгийн зуучлагчдын хувьд МУТСТ хууль үйлчлэхгүй аж.

72. Үл хөдлөх зуучлагч эдгээр 8 компани нь үйлчлүүлэгчдийнхээ өмнөөс хэлцэл хийх бус харин борлуулагч, худалдан авагчдыг тохируулан зуучилдаг байна. Үл хөдлөх хөрөнгийн секторын зуучлагчид зөвшөөрөл авах шаардлагагүй, тэдний эрхлэх үйл ажиллагаа, үзүүлэх үйлчилгээг зохицуулсан хууль эрх зүйн акт байхгүй аж. Үл хөдлөх хөрөнгийн төрөл бүрийн үйлчилгээ үзүүлдэг нэлээдгүй тооны компани (барилгын компаниуд энд багтана) байгааг ҮЭҮ-нд дурджээ. ҮЭҮ-нд үл хөдлөх хөрөнгийн секторын МУТС эрсдэлийг өндөр хэмээн тодорхойлжээ.

<sup>41</sup> Үүнд: Хугацаатай амь насны даатгал, Амь насны даатгал, Хадгаламжийн даатгал, Тэтгэврийн даатгал, Эрүүл мэндийн даатгал, аннуитетийн даатгал орно

<sup>42</sup> Үүнд: осол болон эрүүл мэнд, өмч, автомашин, карго, барилга, ХАА, онгоц, жолоочийн хариуцлага, хариуцлага, санхүү, зээл, траст, усан болон төмөр замын тээвэр орно.

## БҮЛЭГ 1. МУТСТ ЭРСДЭЛ БОЛОН ОРЧИН НӨХЦӨЛ

73. Үл хөдлөх хөрөнгийн зуучлагчид Үл хөдлөх хөрөнгө зуучлагчдын нэгдсэн холбоог байгуулжээ. Гэсэн хэдий ч холбогдох хууль тогтоомж байхгүй тул тус холбоо нь хуулийн чадамжгүй ба МУТСТ үйл ажиллагаа эрхэлдэггүй аж.

74. Хүснэгт 3-т харуулсанчлан, 304 хуулийн этгээд, тодорхойгүй тооны хувь хүн нотариатын үйлчилгээ эрхэлж байна. Нотариатчдыг Нотариатын хуулийн дагуу зохицуулна. Нотариатчид биеийн байцаалтыг баталгаажуулах, өмчлөлийн эрхийг бүртгэх зэрэг үйлчилгээ эрхэлнэ. Нотариатын үйл ажиллагааг Нотариатын тухай хуульд зааж өгсөн ба түүнд үйлчлүүлэгчдийн өмнөөс хэлцэл гүйлгээ хийх заалт байхгүй ажээ. ҮЭҮ-нд нотариатын МУТС эрсдэлийг дундаж хэмээн тодорхойлжээ.

75. Нотариатчдын танхим Нотариатын тухай хуулийн хэрэгжилтийг хянана; тус танхим МУТС хяналт шалгалтын үйл ажиллагаанд оролцдоггүй аж.

76. Доорхи СББМҮҮ-дийг Монгол Улсын МУТСТ тогтолцоонд хамруулдаггүй бөгөөд тэднийг эрсдэл багатай гэдгийг нотлох баримт алга:

- Хүснэгт 3-т харуулсанчлан, Мэргэшсэн нягтлан бодогчдын институтаас Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу 3941 ня-бо нарт зөвшөөрөл олгожээ. ҮЭҮ-нд ня-бо нарын МУТС эрсдэлийг өндөр хэмээн тодорхойлжээ.
- Хүснэгт 3-т харуулсанчлан, Өмгөөлөгчдийн холбооноос Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу 5507 хуульчид зөвшөөрөл олгожээ. ҮЭҮ-нд хуульчдын МУТС эрсдэлийг тогтоосон зүйл байхгүй аж.
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу үнэт металл, чулууны бизнес эрхлэх зөвшөөрөл авсан этгээдийн тоо тодорхойгүй байна. Эдгээр этгээдийг зохицуулсан тусгайлсан хууль тогтоомж бий эсэх нь ч тодорхойгүй ажээ. ҮЭҮ-нд уул уурхайн секторыг байгаль орчны эсрэг гэмт хэргийн хамт (эрдэс баялгийг эрж хайх, олборлох журмыг зөрчих) авч үзэн тус салбарыг МУТС хамгийн өндөр эрсдэлтэй суурь гэмт хэргээр тодорхойлсон бол хууль бусаар хил давуулах гэмт хэргийг удаах эрсдэлтэй суурь гэмт хэргээр нэрлэжээ. Тэгсэн атлаа ҮЭҮ-нд үнэт металл, чулууны дилеруудын МУТС эрсдэлийг авч үзээгүй ажээ. Бичил болон хууль бус уурхайчдын талаар дээрээс үзнэ үү.
- Үнэ хаялцуулах /аукцион/ компани, автомашин, урлагийн болон эртний үнэт эдлэлийн дилерүүдийн мэдээллийг Монгол Улс гаргаж өгөөгүй болно. Эдгээр этгээдийг ҮЭҮ-нд авч үзээгүй болно.

### *(d) Урьдчилан сэргийлэх арга хэмжээ*

77. МУТСТ хуулийн үндсэн арга хэрэгсэл нь МУТСТ тухай хууль билээ. Мэдээлэх үүрэгтэй СБ-ууд болон СББМҮҮ-ийг хуульд заасан жагсаалтаар тодорхойлж байгаагаас бус үзүүлж буй үйлчилгээгээр нь тодорхойлоогүй аж. МУТСТ хуулийн дагуу банк, ББСБ, даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч, хөрөнгө оруулалтын сан, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага, ХЗХ, үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллага, нотариатч нь МҮЭ болно. МУТСТ урьдчилан сэргийлэх арга хэмжээг МУТСТ хууль, ТТ тухай хууль, УСЖ, ТЭЖО, Банкнаас СМА-нд мэдээлэл ирүүлэх

## БҮЛЭГ 1. МУТСТ ЭРСДЭЛ БОЛОН ОРЧИН НӨХЦӨЛ

журамд (эдгээр нь банкуудад хамаарна) болон олон тооны мөрдвөл зохих болон хэрэгжилтэд хяналт тавих боломжгүй журам, зааварт тусгаж өгчээ.

78. Монгол Улсын МУТСТ тогтолцоонд улсын тэтгэврийн болон даатгалын сан, үнэт металл, чулууны дилерүүд, хуульчид, нягтлан бодогчдыг хамруулаагүй байна. Тэдний эрсдэл МУТСТ тогтолцооноос хасагдахуйц бага хэмээн тогтоосон зүйл алга.

79. Монгол Улсын МУТСТ урьдчилан сэргийлэх арга хэмжээний цөм нь ХТМ болон сэжигтэй гүйлгээг тайлагнах МУТСТ хуулийн шаардлагад оршино. 2016 оны 6 дугаар сарын 30-нд УСЖ батлагджээ. Тус журамд МУТСТ хуулийн шаардлагыг дэлгэрүүлэхийн сацуу ФАТФ-ын зарим үндсэн стандартыг, тухайлбал эрсдэлийн үнэлгээ, цахим шилжүүлэх, шинэ технологи, гуравдагч этгээдэд тулгуурлах зэрэг асуудлыг авч үзжээ. ТТ хуульд зорилтот санхүүгийн хориг арга хэмжээг тусгасан байна. Түүнчлэн Монгол Улс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх талаар зарим удирдамж гаргажээ.

80. МУТС зөрчилд хүлээлгэх хариуцлагыг тухайн МҮЭ-ийг зохицуулсан хууль тогтоомжид заасан байдаг. Төв банкны тухай хуулийн дагуу хянан шалгагч нь банкинд хэд хэдэн төрлийн шийтгэл ногдуулж болно. СЗХ-ны хувьд хянан шалгагчид нь холбогдох хуулиудын дагуу зарим шийтгэлийг ногдуулж болох боловч захиргааны хариуцлагыг бүх МҮЭ-д хүлээлгэж чадахгүй ажээ.

81. Үл хөдлөх хөрөнгийн агентууд МУТСТ эсвэл УСЖ-ыг зөрчлөө гэхэд СМА эсвэл СЗХ-ны зүгээс тэдэнд арга хэмжээ авч чадахааргүй байна. Харин Нотариатын тухай хуулийн дагуу нотариатчдад хариуцлага хүлээлгэх боломжтой аж.

*(e) Хуулийн этгээд болон хуулийн бусад зохицуулалт бүхий этгээд*

82. Дараахь төрлийн хуулийн этгээд Монгол Улсад бүртгэлтэй байна:

### Хүснэгт 5: Бүртгэлтэй хуулийн этгээд

| Хуулийн этгээдийн төрөл   | 2016.Х            |
|---|-------------------|
| <i>Ашигийн төлөөх хуулийн этгээд</i>  |                   |
| Нөхөрлөл <sup>43</sup>  | 3,957             |
| Компани – Хувьцаат  | 298               |
| Компани – Хязгаарлагдмал хариуцлагатай  | 112,480           |
| Компани – Гадаадын хөрөнгө оруулалттай ХХК                                    | 9,417             |
| Компани – Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар | 465               |
| <i>Бүлгийн дүн</i>  |                   |
| <i>126,617</i>  |                   |
| <i>Ашигийн бус хуулийн этгээд</i>   |                   |
| Хоршоо  | 4,093             |
| ХЗХ   | 475 <sup>44</sup> |
| Төрийн бус байгууллага  | 23,027            |
| Шашны байгууллага   | 746               |
| Сан   | 1,119             |
| Үйлдвэрчний эвлэлийн байгууллага  | 2,676             |
| Хэвлэл мэдээллийн хэрэгсэл  | 3,561             |

<sup>43</sup> Нөхөрлөлийн ангиллыг гаргаж өгөөгүй болно

<sup>44</sup> Зарим ОӨУБЕГ-т бүртгэлтэй ХЗХ нь СЗХ-ноос зөвшөөрөл аваагүй, үйл ажиллагаа явуулдаггүй байж болно

## БҮЛЭГ 1. МУТСТ ЭРСДЭЛ БОЛОН ОРЧИН НӨХЦӨЛ

|  |         |
|--|---------|
| Нийтийн хуулийн этгээд <sup>45</sup>                           | 1       |
| Соёл, боловсрол, судалгаа шинжилгээ, эрүүл мэндийн байгууллага | 331     |
| <i>Бүлгийн дүн</i>   | 36,029  |
| <i>Ашгийн болон ашгийн бус хуулийн этгээд</i>                  |         |
| Соёл, боловсрол, судалгаа шинжилгээ, эрүүл мэндийн байгууллага | 331     |
| БҮГД   | 162,977 |

83. Иргэний хуульд Монгол Улсад үүсгэж болох хуулийн этгээдийг заажээ. Тус хуулийн 33 дугаар зүйлд зааснаар хуулийн этгээд нь ашгийн төлөө болон ашгийн төлөө бус байна. Ашгийн төлөө хуулийн этгээдийг нөхөрлөл, компанийн хэлбэрээр байгуулна. Иргэний хуулийн 35 дугаар зүйлд “гишүүдийн оруулсан хувь хөрөнгөөс бүрдэх эд хөрөнгөтэй, хүлээсэн үүргээ уг эд хөрөнгө болон гишүүдийн хувийн өмчийн эд хөрөнгөөр хуульд заасны дагуу хариуцдаг хуулийн этгээдийг нөхөрлөл гэнэ” гэсэн бол мөн хуулийн 34 дүгээр зүйлд “хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан хөрөнгөтэй, ашгийн төлөө үндсэн зорилготой хуулийн этгээдийг компани гэнэ” хэмээн заажээ.

84. Компанийн тухай хуулиар компанийг зохицуулна. Тус хуулийн дагуу хувьцаат (4 дүгээр зүйл) болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийг (5 дугаар зүйл) үүсгэж болно.

85. Нөхөрлөлийн тухай хуулиар нөхөрлөлийг зохицуулна. Нөхөрлөл дор дурьдсан хэлбэрээр зохион байгуулагдаж болно: бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай (нөхөрлөлийн хүлээсэн үүргийг гишүүд нь нөхөрлөлд оруулсан эд хөрөнгө болон хувийн өмчийн эд хөрөнгөөрөө хамтран хариуцна); зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай (нөхөрлөлийн хүлээсэн үүргийг наад зах нь нэг гишүүн нөхөрлөлд оруулсан хөрөнгө болон хувийн өмчийн эд хөрөнгөөрөө бүрэн хариуцна, бусад гишүүд нь гагцхүү нөхөрлөлд оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр хариуцна); хязгаарлагдмал хариуцлагатай (нөхөрлөлийн үүргийг гишүүд нь нөхөрлөлд оруулсан хөрөнгийн хэмжээгээр, нөхөх хариуцлагыг буруутай үйл ажиллагаа явуулсан гишүүн нөхөрлөлд оруулсан хөрөнгө болон хувийн өмчийн хөрөнгийн хэмжээгээр бүрэн хариуцна).

86. Ашгийн бус хуулийн этгээдийг холбоо, сан хоршоо хэлбэрээр байгуулж болно. Иргэний хуулийн 36-р зүйлийн дагуу (i) нэгдмэл, тодорхой зорилго тавьсан хэд хэдэн этгээд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгуулсан, гишүүнчлэл бүхий хуулийн этгээдийг холбоо гэнэ, (ii) нэг буюу хэд хэдэн үүсгэн байгуулагч нийгэмд ашиг тустай, нэгдмэл зорилгод хүрэхийн тулд эд хөрөнгө төвлөрүүлэх замаар байгуулсан гишүүнчлэлгүй хуулийн этгээдийг сан гэнэ, (iii) эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, хамтын удирдлага, хяналт бүхий дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэнэ. Холбоо, сан, хоршоог ОӨУБЕГ-т бүртгүүлэх ба эрх зүйн байдлыг нь хуулиар тогтооно.

87. Монгол Улсад экспресс траст, түүнтэй адил төстэй бүтэц, чиг үүрэг бүхий хууль эрх зүйн зохицуулалт бүхий этгээдийг хуулиар<sup>46</sup> хориглосон байдаг. Гадаадын трастууд

<sup>45</sup> Монголын Өмгөөлөгчдийн холбоо

## БҮЛЭГ 1. МУТСТ ЭРСДЭЛ БОЛОН ОРЧИН НӨХЦӨЛ

нь Монголын эдийн засагт онцгой хамаарах зүйл биш болох нь Монгол Улсад ажиллах үеэр тодорхой болсон билээ. Монгол Улсад гадаадын трастуудыг бий болгох, аль эсхүл удирдахад СББМҮҮ-ид оролцдог гэх баримт алга. Гэсэн хэдий ч Монгол Улс эрх зүйн зохицуулалт бүхий этгээдтэй холбоотой МУТС эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгээгүй байна.

*(f) Хяналт шалгалтын арга хэмжээ*

88. МУТСТ хуулийн дагуу МУТСТ 3 төрлийн зохицуулагч Монгол Улсад байна:
  - Банкуудыг Монголбанк шалгана.
  - Банк бус сектор буюу ББСБ, ХЗХ, хөрөнгө оруулалтын сан, үнэт цаасны болон даатгалын компаниуд, үл хөдлөх хөрөнгийн зуучлагчдыг СЗХ, СМА нар шалгана.
  - Нотариатчид хяналт шалгалтад хамрагддаггүй ажээ.
89. Төв банкнаас банкуудыг зохицуулах ба Банкны тухай хууль болон Банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журмын дагуу зөвшөөрөл олгоно.
90. СЗХ-наас ББСБ-ууд, ХЗД-д, хөрөнгө оруулалтын сангууд, үнэт цаасны компаниуд болон даатгалын компаниудыг зохицуулах ба ББСБ-ын тухай, ХЗХ-ны тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай, Үнэт цаасны тухай, Даатгалын тухай хуулийн дагуу тус тус зөвшөөрөл олгоно.
91. Үл хөдлөх хөрөнгийн компаниуд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай болон Компанийн тухай хуулийн дагуу бүртгүүлнэ. Үл хөдлөх хөрөнгийн секторыг зохицуулж буй өөр хууль тогтоомж байхгүй ажээ.
92. Нотариатын танхимаас нотариатчдад Нотариатын тухай хуулийн дагуу зөвшөөрөл олгоно. МУТСТ тухай хуульд нотариатчдыг зохицуулах этгээдийг заагаагүй аж.

---

<sup>46</sup> Монгол Улс Иргэний хуулийн 406-р зүйлийн дагуу итгэлцлийн трастыг “траст гэрээ” хэлбэрээр зохицуулсан хууль тогтоомжтой. 2008 онд Банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээний журам батлагдсанаар “траст гэрээ”-ний бүтэц, чиг үүрэг тодорхой болжээ. Эндээс үнэлгээний баг энэхүү механизм нь экспресс траст буюу түүнтэй адил төстэй бүтэц, чиг үүрэгтэй хуулийн механизм биш гэдгийг тогтоосон болно.

## БҮЛЭГ 2. ҮНДЭСНИЙ МУТСТ БОДЛОГО БА ЗОХИЦУУЛАЛТ

### *Дүгнэлт ба авах арга хэмжээний зөвлөмж*

#### **Дүгнэлт**

- Монгол Улс анхны ҮЭҮ-г 2016 онд гүйцэтгэж, үнэлгээний баг Монголд ажиллах үеэр хэвлүүлжээ. Хянан шалгагчдын банкны МУТСТ эрсдэлийг үнэлэхдээ ашигладаг мэдээлэл болон ТЕГ-ын терроризмын эрсдэлийн жилийн үнэлгээнээс өөр МУТС секторын эрсдэлийн үнэлгээг харуулах тайлан мэдээ Үнэлгээний багт ирээгүй болно.
- ҮЭҮ-нд МУ эрсдэлийг тодорхойлохыг чухалчилжээ. Харамсалтай нь ҮЭҮ нь аюул занал, үр дагавар, эмзэг байдлын дүн шинжилгээ, ойлголтыг багтаасан Монгол Улсын МУТС эрсдэлийн цогц үнэлгээ болж чадаагүй байна. ҮЭҮ-г боловсруулахад оролцоогүй төрийн яам, агентлагуудын МУ эрсдэлийн талаарх ойлголтыг эрс дээшлүүлэх шаардлагатай.
- ҮЭҮ-ний зорилго, үйл явцыг тайлбарлах сургалт семинарыг эс тооцвол хувийн секторын зүгээс ҮЭҮ-г боловсруулахад үндсэндээ оролцоогүй ажээ. ҮЭҮ-ний төсөл дээр хувийн секторын саналыг аваагүй аж. Томоохон банкуудыг эс тооцвол хувийн секторын Монгол Улсын МУТС эрсдэлийн талаарх ойлголт хангалтгүй байна.
- ҮЭҮ-нд өндөр эрсдэлтэй дараахь гэмт хэргийг тодорхойлжээ (ач холбогдлын эрэмбээр): (i) залилан, (ii) байгаль орчны эсрэг гэмт хэрэг, (iii) татвараас зайлсхийх, (iv) авлига.
- ҮЭҮ-нд мөн өндөр эрсдэлтэй дараахь салбарыг тодорхойлжээ: (i) банкны салбар, (ii) үл хөдлөх хөрөнгийн салбар, (iii) нягтлан бодогчид, (iv) үнэт чулуу, металлын дилерүүд. Харин дундаж эрсдэлтэй салбарт нотариатчдыг тодорхойлсон бол бага эрсдэлтэй бүлэгт үнэт цаасны зах зээл, даатгалын салбарыг багтаажээ. Санхүүгийн секторын бүтээгдэхүүн, үйлчилгээ дотроос шилжүүлгийг хамгийн өндөр эрсдэлтэй үйлчилгээгээр нэрлэжээ.
- ҮЭҮ-нд ТС-ийг тодорхойлж, дүн шинжилгээ хийсэн дорвитой зүйл алга. Яам, агентлагууд болон хувийн секторын ТС талаарх ойлголт, мэдлэгийг эрс дээшлүүлэх шаардлагатай.
- Монгол Улсын МУТСТ стратегийн төсөл хараахан бэлэн болоогүй байв. Эрх бүхий байгууллагууд МУТС эрсдэлийг эн тэргүүнд тавих нь ховор аж.
- Зохицуулагчид ҮЭҮ-нд үндэслэн МУТСТ өргөтгөсөн эсвэл хялбаршуулсан арга хэмжээг (эсвэл эрсдэл бага үе МУТСТ шаардлагаас чөлөөлөх) боловсруулаагүй аж.
- Монгол Улсад МУТСТ арга хэмжээг уялдуулж зохицуулах хоёр төрлийн механизм бий. ХАЗ нь МУТСТ хуулийн хэрэгжилтийг хангах үүрэгтэй билээ. ХАЗ нь сүүлийн үеийн МУ-тэй тэмцэх бодлого болон ҮЭҮ боловсруулахад хувь нэмрээ оруулсан ч түүний үйл ажиллагааны түвшинд зохицуулалт хийх чадвар хангалтгүй байна. ТТАЗЗ нь зорилтот санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлж хянах үүрэгтэй билээ. Гэвч ТТАЗЗ-ын үндсэн зорилт нь терроризмтой тэмцэх явдал болохоос биш ТС асуудлыг бодлого, үйл ажиллагааны түвшинд зохицуулахад оршихгүй билээ.
- Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг

## БҮЛЭГ 2. ҮНДЭСНИЙ МУТСТ БОДЛОГО БА ЗОХИЦУУЛАЛТ

уялдуулж зохицуулсан зүйл алга.

### **Авах арга хэмжээний зөвлөмж**

- Эрх бүхий байгууллагууд Монгол Улсын МУ эрсдэлийн талаарх ойлголтоо ахиулж ҮЭҮ-г салбаруудын эрсдэлийн үнэлгээгээр баяжуулбал зохино. Аливаа салбарын онцлог эмзэг тал, үр дагаварыг тодорхойлж байж гэмээнэ МУ эрсдэлийг иж бүрэн, цогцоор нь танин мэдэх боломж бүрдэнэ.
- Монгол Улс ТС эрсдэлийг зохих түвшинд тодорхойлж, үнэлж, ойлгосон байвал зохино.
- Монгол Улс Үндэсний стратеги болон Үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, секторуудын онцлогт тохирсон (илрүүлсэн эрсдэлд суурилсан) бодлого боловсруулбал зохино. Секторыг зангидсан бодлого нь улмаар холбогдох этгээдүүдийн дотоод бодлого, дүрэм журамд тусгалаа олох учиртай.
- Монгол Улс МУТС эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулахын тулд эрсдэлд суурилсан аргачлалыг гүйцэтгэвэл зохино. Иймд холбогдох чадавхийг бий болгох, сургалт семинар хийх, нөөц хуваарилахад анхаарвал зохино.
- Монгол Улс МҮЭ-тэй, үүний дотор СББМҮҮ-идтэй улам идэвхтэй ажиллаж МУТС эрсдэлийн талаарх ойлголтоо сайжруулбал зохино.
- ҮОХЗДС-тэй тэмцэх үйл ажиллагааг зохицуулах механизмыг бий болговол зохино.

93. Энэхүү бүлэгт хамаарах Шууд Хэрэгжилт нь ШХ1 болно. Энэхүү хэсэг дэх үр дүнтэй байдлын үнэлгээнд хамаарах зөвлөмж нь Зөвлөмж 1-2 болно.

### **Шууд Хэрэгжилт 1 (Эрсдэл, Бодлого ба Зохицуулалт)**

#### *Монгол Улсын МУТС эрсдэлийн талаарх ойлголт*

94. Монгол Улс анхны ҮЭҮ-г 2016 онд гүйцэтгэж, үнэлгээний баг Монголд ажиллах үеэр (2016 оны 24.X-4.XI) Монголбанкны цахим хуудас дээр байршуулжээ. Үнэлгээний багтай уулзах хуваарьтай хувийн секторын 30 төлөөлөгч ҮЭҮ-тэй урьдчилан танилцсан байв.

95. Зарим байгууллага (тухайлбал, АТГ) эрсдэлийн үнэлгээг ҮЭҮ-нээс өмнө өөрсдөө хийдэг байсан гэж байв. Гэвч банкны хянан шалгагчдын банкны МУТСТ эрсдэлийг үнэлэхдээ ашигладаг мэдээлэл болон ТЕГ-ын терроризмын эрсдэлийн жилийн үнэлгээнээс өөр МУТС секторын эрсдэлийн үнэлгээтэй холбоотой мэдээлэл Үнэлгээний багт ирээгүй болно.

#### *Монгол Улсын ҮЭҮ*

96. СМА нь 12 байгууллагын (гол төлөв ХАЗ-ийн гишүүд) төлөөллөөс бүрдсэн Ажлын хэсгийг толгойлон ҮЭҮ-г боловсруулах ажлыг манлайлав. ҮЭҮ-ний явцыг Бүлэг 1-д дэлгэрэнгүй авч үзсэн болно. ҮЭҮ-г боловсруулах ажил дараахь 3 үе шаттайгаар 2015 оны 10 дугаар сараас 2016 оны 8 дугаар сар хүртэл хэрэгжсэн байна:

- *1 дүгээр үе шат* – Ажлын хэсэг нь мэдээлэл цуглуулах маягт боловсруулахдаа Европын Аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (OSCE)-ын

## БҮЛЭГ 2. ҮНДЭСНИЙ МУТСТ БОДЛОГО БА ЗОХИЦУУЛАЛТ

туршлагад тулгуурласан ба холбогдох байгууллагууд, хувийн секторын төлөөлөгчдөд ҮЭҮ-ний талаар сургалт хийв. Монголбанкны хянан шалгагч нар ОУВС-гийн тусламжтайгаар боловсруулсан эрсдэлд суурилсан хэрэгслүүдийг ашиглан банкны секторын талаарх мэдээллийг боловсруулав.

- *2 дугаар үе шат* – цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, мэдээллийн дутууг төсөөллөөр нөхөв. Төсөөлөл мэдээлэл гэдэг нь эрх бүхий байгууллагуудын төлөөлөлтэй хийсэн ярилцлага, нөхүүлж авсан судалгаа юм. Түүнчлэн төсөөлөл мэдээллийг асуулгын тусламжтайгаар банкны 30 ажилтан, банк бус санхүүгийн 30 байгууллага, үл хөдлөх хөрөнгийн 5 агент, хөрөнгийн биржийн 5 брокер, 60 нягтлан бодогч (ня-бо) болон 22 нотариатчдаас авчээ.
- *3 дугаар үе шат, 2016 оны 8 дугаар сард эхэлсэн* – эрсдэл, эмзэг сул талын магадлалыг тооцож, холбогдох секторууд болон иргэдийн гэмт хэрэгтэй холбоотой МУТС эрсдэлийг тогтоохын тулд эрсдэлийн үнэлгээний маягтыг ашиглав. Энэ шатанд ҮЭҮ-ний төсөлд ХАЗ-ийн гишүүд санал өгчээ.

97. Дүгнэн хэлэхэд Ажлын хэсгийн хүрээнд засгийн газрын яам, агентлагууд зохих түвшинд хамтран ажиллаж хувь нэмрээ оруулжээ. Харин ҮЭҮ-г боловсруулах явцад хувийн сектортой ярьж зөвлөлдсөн, саналыг нь авч сонссон зүйл байхгүй ажээ (хувийн секторын МУТС эрсдэлийн талаарх ойлголтыг дор үзнэ үү).

98. Ажлын хэсэг нь ҮЭҮ-г хоёр хувилбараар боловсруулжээ: (i) үнэлгээний баг болон эрх бүхий байгууллагуудад зориулсан дэлгэрэнгүй хувилбар, (ii) Монголбанкны цахим хуудас дээр байршуулсан олон нийтэд зориулсан хувилбартай төрийн бүх яам, агентлаг, хувийн сектор танилцах боломжтой. ҮЭҮ-ний дэлгэрэнгүй хувилбарыг ҮЭҮ-ний Ажлын хэсэг, ХАЗ, ТТАЗЗ-ийн гишүүн бус төрийн байгууллагуудад хүргүүлсэн эсэх нь тодорхойгүй байна. ҮЭҮ-г Монголбанкны цахим хуудас дээр байршуулж, үр дүнг нэг удаа танилцуулснаас өөр олон нийтийн хүртээл болгох ажил хийгдээгүй ажээ.

99. Дор яригдах зүйлс нь үнэлгээний багт өгсөн ҮЭҮ-ний хувилбар, эрх бүхий байгууллага болон хувийн секторын төлөөлөлтэй хийсэн уулзалтад тулгуурлаж байгаа болно.

100. ҮЭҮ-нд МУ эрсдэлийг таньж мэдэх сэдвийг онцгойлон авч үзсэнээс биш эмзэг байдал, үр дагаварт төдийлөн анхаараагүй ажээ. Бүлэг 1-д дурьдсанчлан, МУ өндөр эрсдэлтэй дараахь гэмт хэргийг тодорхойлсонтой бид ерөнхийдөө санал нэг байна (ҮЭҮ-нд ач холбогдол өгсөн эрэмбээр): (i) залилан, (ii) байгаль орчны эсрэг гэмт хэрэг, (iii) татвараас зайлсхийх, (iv) авлига. Гагцхүү бид авлигыг ҮЭҮ-нд авч үзсэнээс илүү өндөр эрсдэлтэй гэж бодож байна. Мэдээ тайлангаас харахад Монгол Улсын хувьд авлигын асуудал, ялангуяа уул уурхайн салбартай холбоотойгоор (ДНБ-д хамгийн өндөр жинтэй салбар) хурцаар тавигдаж байгаа бол авлигын эсрэг тэмцэл (Монгол Улсын авлигын тайлангийн талаар Бүлэг 1-ээс үзнэ үү) төдийлөн үр дүнд хүрэхгүй байгаа аж.

101. ҮЭҮ-нд дундаж эрсдэлтэй гэмт хэрэгт хар тамхи, контрабанд (тухайлбал, хүний наймаа), зохион байгуулалттай гэмт хэрэг, терроризм ба ТС, хулгай, гадаадад үйлдсэн гэмт хэргийн хөрөнгө мөнгөтэй холбоотой хэрэг багтаж байна. Эрсдэлийг ийнхүү ангилахад (өндөр, дундаж) суурь гэмт хэргийн статистик тоо, учруулсан хохирол, хурааж

## БҮЛЭГ 2. ҮНДЭСНИЙ МУТСТ БОДЛОГО БА ЗОХИЦУУЛАЛТ

битүүмжилсэн хөрөнгө, мэргэжилтнүүдийн санаа бодол зэргийг харгалзан үзжээ. МУ дундаж эрсдэлтэй гэмт хэргийн дээрх ангилалтай бид ерөнхийдөө санал нэг байна. Гагцхүү терроризм, ТС-ийг яагаад энэхүү ангилалд авч үзсэн нь тодорхойгүй байна (ТС-ийн талаар дор үзнэ үү).

102. ҮЭҮ-ний МУ-ын хэсэгтэй бид ерөнхийдөө санал нэг байгаа ч дүн шинжилгээ хийх, ойлгох тал дээр учир дутагдалтай байна гэж үзэж байна. Угтаа бол Монгол Улсын МУТС-ын эрсдэлийн үнэлгээг цогц байдлаар буюу аюул занал, үр дагавар, эмзэг сул талтай нь авч үзэх шаардлагатай. Гэтэл ҮЭҮ-нд МУ-тай холбоотой тагнуулын мэдээ, мэргэжилтнүүдийн судалгаа шинжилгээ, тайлан, стратегийн дүн шинжилгээ болон хандлага, типологийг авч үзсэн зүйл алга. Салбарын болон байгууллагын түвшин (тухайлбал, банкуудын өөрсдийнх нь үнэлгээ) дэх эрсдэлийн үнэлгээ ч ҮЭҮ-нд тусгагдаагүй ажээ.

103. ҮЭҮ-нд банкны сектор, үл хөдлөх хөрөнгийн сектор, ня-бо нарыг өндөр эрсдэлтэй, нотариатчдыг дундаж эрсдэлтэй, үнэт цаасны болон даатгалын компаниудыг бага эрсдэлтэй хэмээн тодорхойлжээ. ББСБ-ууд тооны хувьд олон, газар зүйн байршлын хувьд өргөн тархсан тул МУТС эрсдэлийг илүү өндөр хэмээн дүгнэжээ. Эдгээр дүгнэлт нь мэргэжилтнүүдийн эргэцүүлэл, секторын хэмжээ томрох тусам МУТС эрсдэл нэмэгдэнэ гэх байр суурьд тулгуурласан бөгөөд статистик мэдээлэлд төдийлөн үндэслээгүй ажээ. Монгол Улс ҮЭҮ болон Монголбанкны банкуудын эрсдэлийн үнэлгээнээс өөр төрлийн үнэлгээ бидэнд гаргаж өгөөгүй болно.

104. ҮЭҮ-нд МУ холбоотой дараахь асуудлыг лавшруулан авч үзвэл зохино. Үүнд: (i) хуулийн этгээд, гадаадын хууль эрх зүйн механизм, (ii) өндөр эрсдэлтэй МУ суурь гэмт хэргээс үүдэлтэй хууль бус орлогыг угааж буй арга хэлбэр (үүнд авлига орохгүй), (iii) хөрөнгийн хууль бус дотогшлох, гадагшлах урсгал (бэлэн мөнгөний болон худалдаанд суурилсан МУ), (iv) банк бус секторын МУ эрсдэл, (v) СББМҮҮ-ид, ялангуяа үл хөдлөх хөрөнгийн сектор болон үнэт чулуу, металлын диллерүүдтэй холбоотой МУ эрсдэл, (vi) сүүдрийн эдийн засагтай холбоотой эрсдэлүүд, ялангуяа түүний хэмжээг багасгах арга хэмжээний дараахь нөхцөл байдал (Бүлэг 1-ийг үзнэ үү).

105. ТС холбоотойгоор ҮЭҮ-нд зарчмын өөрчлөлт оруулах шаардлагатай. ҮЭҮ-нд ТС асуудалд ердөө нэг нүүрний  $\frac{3}{4}$ -ыг зориулжээ. ҮЭҮ-нд ТС эрсдэл, үр дагаварт маш бага анхаарчээ. ҮЭҮ-нд дараахь дүгнэлтэд хэрхэн хүрсэн нь ойлгомжгүй байна: (i) Монгол Улсын дамжин өнгөрүүлэхтэй холбоотой ТС-ийн эрсдэл өндөр байна, (ii) терроризм/ТС нь МУ дунд зэргийн эрсдэлтэй суурь гэмт хэрэг болно. Мэдээллийн нээлттэй эх сурвалжаас харсан ч, Монголын бүс нутгийн эрсдэлийг авч үзсэн ч Монгол Улсын ТС эрсдэлд өртөх магадлал бага байхаар байна. Аль Каида, Талибан эсхүл Исламын улстай холбоотой үйл ажиллагаа Монгол Улсад бүртгэгдээгүй бөгөөд алан хядагчдыг<sup>47</sup> бэлтгэдэг буюу нутгаараа дамжин өнгөрүүлдэг улс орны тоонд Монгол Улс багтдаггүй аж. Монгол Улсад террорист халдлага гарсан эсхүл террорист бүлэглэлүүд үйл ажиллагаа явуулсан гэх тохиолдол бүртгэгдээгүй аж.

106. Террорист этгээдээс АББ-уудад учруулж буй эрсдэлийг таньж мэдэх талаар ҮЭҮ-нд тусгаагүй байна.

<sup>47</sup> [http://soufangroup.com/wp-content/uploads/2015/12/TSG\\_ForeignFightersUpdate3.pdf](http://soufangroup.com/wp-content/uploads/2015/12/TSG_ForeignFightersUpdate3.pdf)

## БҮЛЭГ 2. ҮНДЭСНИЙ МУТС БОДЛОГО БА ЗОХИЦУУЛАЛТ

Эрх бүхий байгууллагуудын МУТС эрсдэлийн талаарх ойлголт

107. Бидэнтэй уулзсан эрх бүхий байгууллагуудын МУ эрсдэлийн талаарх ойлголт бүрэн бус, харилцан адилгүй байна. СМА болон ЦЕГ МУ гэмт хэргийг мөрдөн шалгахад оролцох (ҮЭҮ-г боловсруулахад мөн идэвхтэй оролцсон) тул МУ эрсдэлийн талаар арай дөнгүүр ойлголттой байна. ЦЕГ нь МУ 27 гэмт хэрэг мөрдөн шалгасны хувьд Монгол Улсад үл хөдлөх хөрөнгийн сектор болон хуулийн этгээдээр дамжуулан хэрхэн мөнгө угаадаг талаар зарим нэг ойлголттой ажээ.

108. Бусад ХСБ (тухайлбал, ТЕГ болон АТГ)-уудын МУ эрсдэлийн талаарх ойлголт бүр ч нимгэн байгаагийн дээр Монгол Улсын суурь гэмт хэргийг хэрхэн эрэмбэлж буйтай санал нийлэхгүй байгаа аж. Бидний үзэж байгаагаар МУ эрсдэлийн талаарх мэдлэг ийнхүү нимгэн байгаа нь ҮЭҮ-г саяхан гүйцэтгэсэн, байгууллагууд МУ тэмцэх асуудлыг бодлогын түвшинд авч үздэггүй, шалгасан МУ гэмт хэргийг тоо цөөн зэрэг хүчин зүйлстэй холбоотой.

109. Монголбанкны хянан шалгагчид банкны секторын болон тухайн банкны МУ эрсдэлийн талаар тодорхой хэмжээний ойлголттой аж. Харин СЗХ-ны хянан шалгачдын МУ эрсдэлийн талаарх ойлголт эхлэл төдий байна. СББМҮҮ-дийн салбар дахь МУ эрсдэлийн талаарх ойлголт эрх бүхий байгууллагуудад үндсэндээ алга.

110. Эрх бүхий байгууллагуудын МУ эрсдэлийн талаарх ойлголт ийнхүү дутуу дулимаг байгаад ҮЭҮ-г саяхан гүйцэтгэсэн явдал, ҮЭҮ-н дэх сул тал, дутагдал (дээр авч үзсэн), нэгжийн болон салбарын түвшинд МУ эрсдэлийн үнэлгээ төдийлөн хийгдээгүй зэрэг хүчин зүйлс бүгд нөлөөлж байна. Иймд Монгол Улс МУ эрсдэлийн талаарх ойлголтоо эрс сайжруулбал зохино.

111. Эрх бүхий байгууллагууд ТС эрсдэлийн талаар үндсэндээ ойлголтгүй байна. ТЕГ нь Монгол Улсын терроризмын үнэлгээг гүйцэтгэдгийн хувьд терроризмын эрсдэлийн талаар боломжийн ойлголттой байна. Гэвч энэ нь ТС-ийн эрсдэлд хамаарахгүй ажээ. Монгол Улсын ТС эрсдэлийн талаарх ойлголт ийнхүү нимгэн байгаа нь тус асуудлыг ҮЭҮ-нд зохих түвшинд авч үзээгүй, ТЕГ-аас ТС-ий мөрдөн шалгалт хийж байгаагүйтэй холбоотой аж.

112. Ийнхүү ҮЭҮ нь МУ эрсдэлийг тодорхойлоход анхаарч харин Монгол Улсын МУТС эрсдэлийг цогцоор нь үнэлэх асуудлыг орхигдуулжээ. Төрийн байгууллагууд, тэр дундаа хууль сахиулах болох хяналт шалгалтын байгууллагууд МУ эрсдэлийн талаарх ойлголтоо эрс дээшлүүлбэл зохино. Мөн ТС-ийн талаарх ойлголтоо ахиулахад онцгой анхаарах шаардлагатай болжээ.

*МУТС эрсдэлийг бууруулах үндэсний бодлого*

113. Илрүүлсэн эрсдэлд суурилан МУТС тэмцэх үндэсний стратегийг боловсруулах талаар ҮЭҮ-нд дурджээ. Одоогоор Үндэсний Стратеги болон Үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдаагүй байна. МУТС тэмцэх хууль тогтоомж, бодлогыг боловсруулахад ХАЗ-ийн үүрэг оролцоо шийдвэрлэх нөлөөтэй юм. Гэсэн хэдий ч ХАЗ нь тулгамдсан эрсдэл, аюул занал, эмзэг сул талыг зохих түвшинд шийдвэрлэж чадахгүй байсаар өдий хүрлээ.

## БҮЛЭГ 2. ҮНДЭСНИЙ МУТСТ БОДЛОГО БА ЗОХИЦУУЛАЛТ

114. ШХ.3, ШХ.4, ШХ.5, ШХ.6, ШХ.7, ШХ.9, ШХ.10 болон ШХ.11-д авч үзсэнчлэн, эрх бүхий байгууллагуудын үйл ажиллагаа МУТС эрсдэлийг шийдвэрлэхэд чиглэгдэхгүй байна.

*Шаардлагаас чөлөөлөх, өргөтгөсөн болон хялбаршуулсан арга хэмжээ*

115. ҮЭҮ нь МУТС тэмцэх өргөтгөсөн буюу хялбаршуулсан арга хэмжээ авах буюу эрсдэл бага тохиолдолд МУТС шаардлагаас чөлөөлөх арга хэмжээг дагуулаагүй ажээ.

116. МУТСТ тухай хуулийн МУТСТ шаардлага нь бүх СББМҮҮ-дийг хамардаггүй аж. Тухайлбал, энд хуульчид, ня-бо нар, үнэт чулуу, металлын дилерүүдийг дурдаж болно. Тэднийг ийнхүү хасах болсон нь эрсдэлийн үнэлгээний үр дүнд суурилсан хэрэг биш аж.

*Эрх бүхий байгууллагуудын зорилго, үйл ажиллагаа*

117. Монгол Улс МУТС эрсдэлийг бууруулах ажлыг (арга хэмжээ, нөөцийн хуваарилалт) цогц, эрсдэлд суурилсан байдлаар гүйцэтгэж чадахгүй байна. Монгол Улсад үндэсний түвшний МУТСТ бодлого, түүнийг байгууллагын түвшинд зорилгоо болгон томъёолох явдал ихээхэн үгүйлэгдэж байна. Гэхдээ зарим эрх бүхий байгууллагын зорилтод Монгол Улсын МУТС эрсдэл дараахь байдлаар тусгагджээ:

- МУ - ЦЕГ, ТЕГ, АТГ нь МУ болон суурь гэмт хэргийг мөрдөн шалгах эрх бүхий байгууллагууд билээ. Тайлант үед Монгол Улс МУ 46 тохиолдлыг шалгажээ. Эдгээр нь гол төлөв залилан, авлигатай холбоотой байв. ҮЭҮ-нд эрсдэл бүхий суурь гэмт хэргийн нэгд залилан, харин дөрөвт авлига жагсжээ. Хэдий тийм ч: (i) мөрдөн шалгасан МУ тохиолдлын тоо нь Монгол Улсын МУ эрсдэл, тэр дундаа авлигын эрсдэлийг төлөөлж чадахгүй байна, (ii) бусад өндөр эрсдэлтэй суурь гэмт хэргийг (тухайлбал байгаль орчны эсрэг) шалгасан зүйл бараг алга, (iii) Монгол Улсад МУ гэмт хэргээр ялласан тохиолдол алга (Дээд шүүхээс хэрэгсэхгүй болгосон).

- ТС – ТЕГ нь ТС-ийг мөрдөн шалгах эрх бүхий байгууллага билээ. ТЕГ нь СМА-наас шилжүүлсэн ТС-тэй холбоотой байж магадгүй 3 тохиолдлыг шалгаж үзжээ. ТЕГ-аас эдгээрийн 2 нь ТС-ийн шинжийг агуулахгүй байна гэж үзжээ. Үлдсэн нэг тохиолдлыг шалгах ажиллагаа үргэлжилж байна. ТЕГ-ын үйл ажиллагаа нь терроризм дээр төвлөрөх ажээ.

- *Хяналт, шалгалт* – Монголбанк банкуудын, СЗХ банк бус санхүүгийн салбарын, харин СМА нь СББМҮҮ-дийн хяналт, шалгалтыг тус тус хэрэгжүүлэх үүрэгтэй. Банкуудын хяналт шалгалтад зориулан нөөцийн хуваарилалтыг хийсэн бөгөөд бөгөөд саяхан эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлсэн. Биднийг Монголд айлчлахаас өмнө өндөр эрсдэлтэй 2 банкны МУТСТ газар дээрх шалгалт, айлчлалын үеэр 2 шалгалт тус бүр явагдсан ба шалгалтын тайлан эцэслэгдээгүй байв.

- СЗХ нь өөрийн хяналт шалгалтын хүрээнд МУТСТ асуудлыг хамруулах нь бага бөгөөд МУТСТ зарим хяналт шалгалтыг СМА-тай хамтран гүйцэтгэжээ. СЗХ-ын хяналт шалгалт нь эрсдэлд суурилагагүй бөгөөд хамрах хүрээ нь ББСБ-ууд, даатгалын компаниуд, үнэт цаасны захын оролцогчид болон ХЗХ-доор хязгаарлагдаж байна. СЗХ нь эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлэх шатандаа байна. СББМҮҮ-ийн хувьд МУТСТ хяналт шалгалт хийгдээгүй аж.

*Үндэсний хамтын ажиллагаа, зохицуулалт*

## БҮЛЭГ 2. ҮНДЭСНИЙ МУТСТ БОДЛОГО БА ЗОХИЦУУЛАЛТ

118. МУТСТ үндэсний хэмжээний бодлого боловсруулах, МУТСТ арга хэмжээг бодлогын болон үйл ажиллагааны түвшинд зохицуулах институтийн бүтэц байгаа боловч түүний үр ашгийг дээшлүүлэх шаардлагатай байна. МУТСТ хуулийн дагуу байгуулагдсан ХАЗ-ын гишүүд нь МУТСТ үйл ажиллагаанд оролцогч үндсэн байгууллагууд юм. ХАЗ нь тэргүүлэх үүрэгтэй СМА, хяналт шалгалт хэрэгжүүлэгч, хууль сахиулах болон бусад байгуулагаас бүрдэнэ.

119. ХАЗ нь (i) МУТСТ тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, (ii) мэдээлэл солилцох, (iii) МУТС Монгол Улсын эрсдэлийг үнэлэх, түүнийг бууруулах, (iv) МУТС-хээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх талаар бодлого, зөвлөмж, чиглэл гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл болно. Тайлант хугацаанд ХАЗ нь МУТСТ хууль тогтоомжийг (тухайлбал, УСЖ болон ҮЭҮ) боловсруулж, хэрэгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэв. Харин ХАЗ-ийн МУ-тай тэмцэх үйл ажиллагааг зохицуулах чадвар доголдож байна. ХАЗ-ийн зохицуулах чадварыг илтгэх нэг ч баримт, жишээ бидэнд алга.

120. ТЕГ-аар дэргэдэх ТТАЗЗ нь Терроризмтой тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж хянах эрх бүхий субъект билээ. Гагцхүү ТТАЗЗ-ийн ТС-эй тэмцэх үйл ажиллагааг зохицуулах чадвар сул байна. ТТАЗЗ-ийн бодлогын болон үйл ажиллагааны түвшинд зохицуулах чадварыг илтгэх нэг ч баримт, жишээ бидэнд алга. Гэтэл ТТАЗЗ-ийн үндсэн зорилт нь терроризмтой тэмцэх үйл ажиллагааг зохицуулах явдал билээ.

121. ХАЗ болон ТТАЗЗ хоёрын үйл ажиллагааг албан ёсоор уялдуулж зохицуулсан механизм байхгүй аж. Гэхдээ үндсэн агентлагууд хоёр зөвлөлийн аль алинд гишүүнчлэлтэй аж.

122. Монгол Улсын тайлбарлаж байгаагаар үйл олноор хөнөөх зэвсгийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг ТТАЗЗ зохицуулдаг аж. Гэсэн хэдий ч ТТАЗЗ энэ асуудлыг бодлогын болон үйл ажиллагааны түвшинд зохицуулж буйг илтгэх нэг ч баримт, жишээ бидэнд алга.

### *Хувийн секторын эрсдэлийн талаарх ойлголт*

123. ҮЭҮ-г боловсруулах шатанд хувийн сектортой ярилцсан, зөвлөлдсөн зүйл нь ҮЭҮ-ний зорилго, үйл явцыг тайлбарлах сургалт семинараар хязгаарлагджээ. Эдгээр семинарын үеэр хувийн сектороос төсөөллийн мэдээл авсан байна. ХҮБ Монголд айлчлахын өмнөхөн (i) ҮЭҮ-ний хэвлүүлэлтийн өмнөх хувилбарыг үндсэн СБ-уудад хүргүүлж, (ii) СМА-наас ҮЭҮ-г танилцуулах брифинг хийжээ, (iii) ҮЭҮ-ний нийтэд зориулсан хувилбарыг Монголбанкны цахим хуудаст байршуулсан байна. Бидэнтэй уулзсан СБ-ууд ҮЭҮ-тэй танилцаж байна, ҮЭҮ-ний үр дүнг эрсдэлийн үнэлгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тусгаж хараахан амжаагүйг хэлж байв.

124. Санхүүгийн сектор дахь ҮЭҮ, МУ эрсдэлийн талаарх ойлголт харилцан адилгүй байна. Банкууд ҮЭҮ-г мэдэж байсан бөгөөд тэдний МУ эрсдэлийн талаарх ойлголт нь дотоод эрсдэлийн үнэлгээ, ХТМ-эд суурилсан харилцагчийн МУ эрсдэлээр хязгаарлагдаж байна. ҮЭҮ-г саяхан гүйцэтгэсэн тул банкууд Монгол Улсын МУ эрсдэл, үр дагавар, эмзэг тал, МУ типологийн талаар гүн гүнзгий ойлголттой болж амжаагүй байна.

125. ББСБ-ууд ҮЭҮ-ний талаар сонссон ч банкуудтай харьцуулахад ойлголт тааруу байна. Даатгалын компаниуд, үнэт цаасны зах зээлд оролцогчид, хөрөнгө оруулалтын

## **БҮЛЭГ 2. ҮНДЭСНИЙ МУТСТ БОДЛОГО БА ЗОХИЦУУЛАЛТ**

сангууд болон ХЗХ-оод ҮЭҮ-ний талаар сонссон ч МУ эрсдэлийн талаар ойлголт үндсэндээ алга байна. СББМҮҮ-ид ҮЭҮ-ний талаар огт ойлголтгүй байв. Хувийн секторын Монгол Улсын ТС эрсдэлийн талаарх ойлголт туйлын чамлалттай байна.

*Шууд Хэрэгжилт 1-ийн Ерөнхий Дүгнэлт*

**126. Монгол Улсын Шууд Хэрэгжилт 1-ийн үр дүнтэй байдал доогуур түвшинд байна.**

## БҮЛЭГ 3. ЭРХ ЗҮЙН СИСТЕМ БА ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АСУУДАЛ

### *Дүгнэлт ба авах арга хэмжээний зөвлөмж*

#### *Дүгнэлт*

##### *ШХ.6*

- Монгол Улсын МУ эрсдэл СГТ-нд тусгалаа олж чадахгүй байна. СМА цөөн тооны СГТ хүлээн авч байна. Эдгээрийн дийлэнхийг банкуудаас, ганц хоёрыг банк бусаас хүлээн авч байгаа бол СБМҮҮ-дээс огт аваагүй байна. СГТ-ийн нэлээдгүй хэсэг нь БНАСАУ-тай холбоотой ажээ.
- СМА-ны дүн шинжилгээнд тулгуурлан МУ болон суурь гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлсэн тохиолдол цөөн аж. СМА-наас шалгуулахаар шилжүүлсэн мэдээ, материалын дийлэнхийг ТЕГ хүлээн авсан ба гол төлөв БНАСАУ-тай холбоотой ажээ – эдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээлэл бидэнд алга. Харин ЦЕГ нь СМА-ны мэдээлэлд тулгуурлан МУ мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлдэг ажээ. Тухайлбал, ял оногдуулахад хүргэсэн МИАТ-ын хэрэг нь СМА-наас шилжүүлсэн мэдээлэлд тулгуурлажээ. Харин анхан шатны шүүхээс оногдуулсан ялыг Дээд шүүхээс хэрэгсэхгүй болгожээ.
- СМА-ны үндсэн үйл ажиллагаа нь ХСБ-уудын хэрэгцээг мэдээллийг гаргаж өгөхөд чиглэгдэж байна.
- ТЕГ-аас ТС мөрдөн шалгалтыг эхлүүлэхдээ СМА-ны үйл ажиллагааны шинжилгээг ашиглаж байна.
- СМА нь стратегийн дүн шинжилгээ гүйцэтгэдэггүй, шилжүүлдэггүй болно.
- СМА нь ХСБ-уудтай санамж бичиг байгуулан мэдээлэл солилцож байна. СМА нь хэд хэдэн эрх бүхий байгууллагын мэдээллийн санд нэвтрэх эрхтэй ч энэхүү боломжийг СГТ-ийн дүн шинжилгээнд бараг ашиглахгүй байна.
- Хууль сахиулах болон эрх бүхий байгууллагуудын Санхүүгийн мэдээлэл, дүн шинжилгээг ашиглах ойлголт, чадвар бүрдэж төлөвших шатандаа байна.

##### *ШХ.7*

- Монгол Улсад үндэсний МУТСТ бодлого, МУ гэмт хэргийг чухалчлан авч үзэх дотоод заавар, удирдамж, механизм дутагдаж байна.
- ХСБ-уудын хувьд мөнгө угаасан байж болзошгүй тохиолдлуудыг шалгадаг байна. Харин мөрдөн шалгах шатанд эсвэл шийтгэл оногдуулах шатанд шилжиж буй нь цөөн ажээ. Тухайлбал ХСБ-ууд 4345 хүнийг мөнгө угаасан байж болзошгүй асуудлаар шалгаснаас 46 хүний хэрэг мөрдөн шалгах шатанд шилжжээ. Улмаар 20 хүнийг хэргийг УПЕГ-т шилжүүлснээс 2 хүнд ял оногдуулсан аж.
- УПЕГ-аас МУ гэмт хэрэгт 2011 болон 2013 онд ял оногдуулж байжээ. Гэвч Дээд шүүхийн шатанд эдгээр хоёр хэргийг хэрэгсэхгүй болгосон байна.
- МУ мөрдөн шалгах үйл ажиллагаа нь Монгол Улсын өндөр эрсдэлтэй суурь гэмт хэрэг болох залилан болон авлигатай гол төлөв холбоотой байна. Харин бидний үзэж

### БҮЛЭГ 3. ЭРХ ЗҮЙН СИСТЕМ БА ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АСУУДАЛ

байгаагаар МУ мөрдөн шалгалтын тоо, төрөл нь Монгол Улсын МУ эрсдэлийг тусгаж чадахгүй байна – бусад суурь гэмт хэргийг, тухайлбал байгаль орчны эсрэг гэмт хэрэг, татвараас зайлсхийх хэргийг шалгасан тохиолдол маш цөөн эсвэл бүр байхгүй байна.

- Монголд айлчлах үеэр өрнөсөн хэлэлцүүлэг болон ҮЭҮ-нээс харахад ХСБ-ууд суурь гэмт хэргийг мөрдөх замаар МУ эрсдэлтэй тэмцдэг ажээ.

#### III.8

- ЭХ болон ЭБШХ дахь хөрөнгө хураах тухай заалтууд ФАТФ-ын стандартыг хангахуйц байгаа ч үүнийг ХСБ-ын бодлогын зорилтын түвшинд авч үзэх явдал Монгол Улсад дутмаг байна.
- МУ хэргүүдийн заалтыг Дээд шүүх хэрэгсэхгүй болгосны улмаас хөрөнгө хураагдаагүй ч анхан шатны шүүхээс хураахаар тогтоосон хөрөнгийн хэмжээг Дээд шүүхээс өөрчлөөгүй ажээ.
- Монгол Улс залилан, байгаль орчны эсрэг гэмт хэрэг, татвараас зайлсхийх болон авлигын гэмт хэрэгтэй холбоотойгоор хөрөнгө битүүмжлэх, хураах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг ажээ. Гэхдээ эдгээр өндөр эрсдэлтэй суурь гэмт хэрэгтэй холбоотойгоор улсын хураасан хөрөнгийн статистикийн мэдээ өгөөгүй.
- Гадаадад байрших хөрөнгийг Монгол Улс хураасан тохиолдол алга, харин БНСУ болон Чех улс руу хөрөнгө буцааж байжээ.
- Монгол Улс ТС холбоотойгоор хөрөнгө хурааж байгаагүй аж. Энэ Монгол Улсын ТС-ийн төсөөлж буй эрсдэлтэй нийцтэй байна.
- Монгол Улс гаалийн декларацид мэдүүлээгүй валют, үнэт чулууг хураасан тохиолдол бүртгэгдсэн аж. Гэхдээ мэдүүлээгүй буюу худал мэдүүлэн хилээр нэвтрүүлэх мөнгөн хөрөнгийг илрүүлж хураах Монгол Улсын чадавхи сул байна.

#### *Авах арга хэмжээний зөвлөмж*

#### III.6

- СМА нь үйл ажиллагааны дүн шинжилгээг дараахь байдлаар сайжруулбал зохино: (i) тайлагнах үүрэг хариуцлагын талаар МҮЭ-дэд дараа дараагийн удирдамж, чиглэл өгөх, (ii) авч болох болон бэлэн хууль сахиулах болон бусад мэдээллийн ашиглалтыг нэмэгдүүлэх, (iii) шалгуулахаар шилжүүлж буй дүн шинжилгээг ХСБ-уудын хэрэгцээ шаардлагад нийцүүлэх.
- СМА нь Монгол Улсын МУТСТ хуулийн дагуу ХСБ-уудын хэрэгцээ шаардлагыг хангахуйц стратегийн дүн шинжилгээ хийдэг байвал зохино.
- Дотоодын эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагааг тэлснээр тэдний санхүүгийн мэдээллийн чадавхийг нэмэгдүүлэх, МУТСТ хуулийн дагуу мэдээлэл солилцоог өргөжүүлбэл зохино.
- Үйл ажиллагааны болон стратегийн дүн шинжилгээг ХСБ-уудын мөрдөн шалгах хэрэгцээнд нийцүүлбэл зохино. Ингэхдээ СМА-нд нэмж мэргэжилтэн авах эсвэл ХСБ-аас хүн түр ажиллуулах, тэдэнд байнгын сургалт зохион байгуулах шаардлагатай. Ингэснээр шалгуулахаар шилжүүлэх материалын чиглэлийг онилох боломж бүрдэнэ.

### БҮЛЭГ 3. ЭРХ ЗҮЙН СИСТЕМ БА ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АСУУДАЛ

#### *ШХ.7*

- Үндэсний МУТСТ бодлогод маш тодорхой удирдамж чиглэлийг суулгаж өгөх замаар МУ гэмт хэргийг мөрдөн шалгаж, шийтгэнэ гэдэг үүрэг амлалтаа ахиулбал зохино.
- Хууль сахиулах, шүүх прокурорын байгууллагын ажилтнуудыг онилсон сургалт зохион байгуулж тэдний МУ мөрдөн шалгах болон шийтгэх ажиллагааны талаарх ойлголтыг нэмэгдүүлбэл зохино.

#### *ШХ.8*

- МУТСТ стратегийн хүрээнд гэмт хэрэг үйлдэж олсон орлого, түүнтэй дүйцэхүйц өмч, гэмт хэргийн хэрэгслийг Монгол Улсын МУТС эрсдэлийн түвшинтэй уялдуулан хуулийн дагуу хураах болон гэмт хэргийг шалган шийдвэрлэх ажилд тэргүүн зэргийн ач холбогдол өгч хууль шүүхийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн дэмжвэл зохино.
- Хөрөнгө хураахад баримтлах дотоод бодлого, гарын авлага болон процедурыг үргэлжлүүлэн боловсруулж хөрөнгө хураах ажлыг сайжруулбал зохино.
- Хууль бус хөрөнгийг хил гааль дээр хураах ажлыг стратегийн бодлогын түвшинд авч үзэн, үйл ажиллагааны уялдааг хангавал зохино. Ингэхдээ холбогдох байгууллагуудын чадавхи, тагнуулын мэдээний чанарыг сайжруулж байгууллага хоорондын уялдааг хангахад анхаарна.

127. Энэхүү бүлэгт авч үзсэн Шууд Хэрэгжилтүүд нь ШХ6-8 болно. Энэ хэсэг дэх үр дүнтэй байдлын үнэлгээнд хамаарах зөвлөмжүүд нь Зөвлөмж 3, Зөвлөмж 4 болон Зөвлөмж 29-32 болно.

#### *Шууд Хэрэгжилт 6 (МУТСТ Санхүүгийн мэдээлэл)*

128. МУТСТ хуулийн дагуу СМА нь 2006 оны 11 дүгээр сарын 29-нд Монголбанкны дэргэд байгуулагджээ. Монгол Улсын СМА нь мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах эрхгүй аж. СМА нь мэдээллийг хүлээн авах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, дүн шинжилгээний үр дүнд МУТС-тэй холбоотой гэж сэжиглэсэн гүйлгээ, гүйлгээний оролдлогын талаарх мэдээллийг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлэх чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан байгууллага юм.

129. СМА Монголбанкны дэргэд ажилладаг ч үүрэг функц, систем, нэвтрэх хяналт тусдаа нэгж билээ. Харин мэдээллийн технологийн дэд бүтцийн хувьд СМА нь Монголбанкны системийг ашигладаг ажээ. СМА-ны техник функц нь бүрэн бие даасан, хараат бус байдлаар, гадны нөлөө, саадгүй хэрэгждэг байна. Тухайн үед СМА нь дарга, 8 шинжээч, 1 хянан шалгагч буюу нийт 10 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байв.

130. СМА нь Дэлхийн Санхүүгийн мэдээллийн албадын олон улсын нийгэмлэг /EGMONT буюу Эгмонт/-т 2009 онд элсжээ.

#### *Эрх бүхий байгууллагуудын хүлээн авсан/хүссэн СГТ*

Хүлээн авсан тайлан

### БҮЛЭГ 3. ЭРХ ЗҮЙН СИСТЕМ БА ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АСУУДАЛ

131. МУТСТ хуулийн дагуу СМА нь МҮЭ-үүдээс гүйлгээний тайлан хүлээн авдаг. Эдгээрт 20 сая төгрөгөөс (8000 ам.доллар) дээш дүнтэй сэжигтэй, бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны тайлан орно. Түүнчлэн СМА нь Хилээр нэвтрүүлсэн бэлэн мөнгөний мэдүүлгийн тайлан (ХНБММТ)-г ГЕГ-аас хүлээн авдаг байна. Тус тайланд 15 сая төгрөгөөс дээш (6000 ам.доллар) дүн тусгагддаг ажээ. Өнөөдрийн байдлаар санхүүгийн хэрэгслүүд /BNI/-тэй холбоотой ХНБММТ-г СМА хүлээн аваагүй ажээ. Хүснэгт 6-д СМА-ны хүлээн авсан гүйлгээний тайлангийн статистикийг харуулав.

**Хүснэгт 6: СМА-ны хүлээн авсан тайлан**

| Тайлан      | Гүйлгээний тайлангийн тоо |                |                |                  |                  |                |                  |
|-------------|---------------------------|----------------|----------------|------------------|------------------|----------------|------------------|
|             | 2011                      | 2012           | 2013           | 2014             | 2015             | 2016.Х         | Бүгд             |
| СГТ         | 71                        | 158            | 285            | 212              | 113              | 174            | <b>1 013</b>     |
| БМГТ        | 474 880                   | 557 513        | 755 499        | 1 962 408        | 1 223 984        | 553 362        | <b>5 527 646</b> |
| ГТГТ        | 49 221                    | 98 657         | 60 274         | 149 682          | 86 329           | 65 653         | <b>509 816</b>   |
| ХНБММТ      | 2 376                     | 2 796          | 3 259          | 2 347            | 1 917            | 1 099          | <b>13 794</b>    |
| <b>БҮГД</b> | <b>526 548</b>            | <b>659 124</b> | <b>819 317</b> | <b>2 114 649</b> | <b>1 312 343</b> | <b>620 288</b> | <b>6 052 269</b> |

**Хүснэгт 7: СМА-ны хүлээн авсан СГТ**

| МҮЭ                 | 2011      | 2012       | СГТ-ийн тоо |            | 10 сар     |            | Бүгд         |
|---------------------|-----------|------------|-------------|------------|------------|------------|--------------|
|                     |           |            | 2013        | 2014       | 2015       | 2016       |              |
| Банк                | 71        | 156        | 283         | 210        | 111        | 171        | <b>1,002</b> |
| ББСБ                | 0         | 1          | 2           | 0          | 0          | 0          | <b>3</b>     |
| Даатгалын компани   | 0         | 0          | 0           | 0          | 0          | 0          | <b>0</b>     |
| Үнэт цаасны компани | 0         | 1          | 0           | 0          | 0          | 0          | <b>1</b>     |
| ХЗХ                 | 0         | 0          | 0           | 0          | 0          | 0          | <b>0</b>     |
| ББМҮҮ-ид            | 0         | 0          | 0           | 0          | 0          | 0          | <b>0</b>     |
| Бусад <sup>48</sup> | 0         | 0          | 0           | 2          | 2          | 3          | <b>7</b>     |
| <b>Бүгд</b>         | <b>71</b> | <b>158</b> | <b>285</b>  | <b>212</b> | <b>113</b> | <b>174</b> | <b>1,013</b> |

132. Хүснэгт 7-д МҮЭ болон бусад холбогдох байгууллагаас мэдүүлсэн СГТ-н 2011 оноос 2016 оны 10 дугаар сар хүртэл харуулав. Бидний үзэж байгаагаар СГТ-г мэдүүлж буй байдал нь Монгол Улсын МУ эрсдэлийн илэрхийлэл болж чадахгүй байна:

- СГТ-ийн 99% буюу 1002-ыг банкуудаас мэдүүлсэн бол банк бус сектороос ганц хоёрыг, харин ББМҮҮ-ид огт мэдүүлээгүй ажээ. Банкны сектор Монгол Улсын санхүүгийн секторын үлэмж хэсгийг бүрдүүлдэг нь үнэн ч банк бус болон ББМҮҮ-дээс СГТ огт мэдүүлэхгүй байгаа нь ҮЭҮ-нд тодорхойлсон МУ эрсдэлтэй нийцгүй байна гэж бид үзэж байна.
- ҮЭҮ-нээс харахад 2011-2016 онд банкуудаас мэдүүлсэн 1002 СГТ-гийн 42% буюу 423 СГТ-г өндөр эрсдэлтэй улс оронтой холбоотойгоор (гол төлөв БНАСАУ)

<sup>48</sup> Үүнд хувийн компаниуд, дотоодын эрх баригчид, гадаадын ХСБ-ууд болон СМА өөрөө орно

### БҮЛЭГ 3. ЭРХ ЗҮЙН СИСТЕМ БА ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АСУУДАЛ

мэдүүлсэн бол зөвхөн 435 СГТ-г гэмт хэргээс үүдэлтэй хөрөнгө байж болзошгүй хэмээн мэдүүлжээ. Өндөр эрсдэлтэй улс оронтой холбоогүйгээр мэдүүлсэн СГТ-ийн тоо нь Монгол Улсын МУ эрсдэлийг төлөөлж чадахааргүй байна.

- Мэдүүлсэн СГТ нь Монгол Улсын МУ эрсдэлтэй уялдахгүй байгааг ҮЭҮ-нээс харж болно. Тухайлбал, Монгол Улсын хувьд авлига өндөр эрсдэлтэй суурь гэмт хэргийн нэгд тооцогддог атал 2010-2015 оны хооронд УТНБЭ-тэй холбоотой хоёрхон СГТ-г мэдүүлсэн байх жишээтэй.

133. Мэдүүлсэн СГТ-ийн тоо 2012 онд эрс нэмэгдсэнийг Хүснэгт 6 харуулж байна. Энэ нь өндөр эрсдэлтэй улс оронтой холбоотой бүх гүйлгээг СГТ-аар мэдээлэх шаардлагыг нэвтрүүлсэнтэй холбоотой аж. Түүнчлэн 2014-2015 онд СГТ үлэмж буурчээ. Үүнд Монгол Улс дараахь тайлбар хийж байна: (i) ФАТФ-ын жагсаалтад орсон өндөр эрсдэлтэй орны тоо буурсан, (ii) СГТ болон БМГТ-г мэдүүлэх заавар, Банкнаас СМА-нд мэдээлэл ирүүлэх журам, ХТМ болон сэжигтэй ба бэлэн мөнгөний гүйлгээг тайлагнах удирдамж гарсантай холбоотойгоор 2014-2015 онд СГТ-гийн чанар сайжирсан аж.

134. 2011-2015 онд 2 СГТ-г ТС-тэй холбоотойгоор, 3 СГТ-г НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан Нэгдсэн жагсаалтад бүртгэгдсэн этгээдтэй нэр таарсан гэх үндэслэлээр мэдүүлжээ.

135. МУТСТ хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотойгоор БМГТ 2013-2014 онд нэмэгджээ. Тус өөрчлөлтийн дагуу банк нь тухайн данс/ААН-ийн гүйлгээний өдрийн дүн 20 сая төгрөг давбал (8000 ам.доллар) БМГТ-аар мэдээлэх болжээ. 2014 онд гарсан удирдамж БМГТ мэдүүлэх шаардлагыг тодотгосноор алдаатай БМГТ мэдүүлэх явдал багасчээ.

#### *СБ/СББМҮҮ-дээс авах мэдээлэл*

136. СМА нь СГТ-ийн дүн шинжилгээ хийх стандарт процедурын хүрээнд СБ болон СББМҮҮ-ээс нэмэлт мэдээлэл гаргуулан авах эрхтэй. Энэхүү үйл явц ихэвчлэн цахим шуудангаар эсвэл СМА-ны даргын албан ёсны хүсэлтийн дагуу хэрэгжих ажээ. Мэдээллийн хэмжээнээс шалтгаалан ажлын 1-5 хоног зарцуулагддаг байна. Банкуудас хүргүүлсэн хүсэлтийн тоог Хүснэгт 8-д харуулав. Банк бус сектор эсвэл СББМҮҮ-ээс мэдээлэл хүссэн тухай баримт бидэнд алга.

#### Хүснэгт 8: СМА-ны банкуудаас хүссэн мэдээлэл

| МҮЭ                                  | 2011 | 2012             | 2013 | 2014 | 2015 | 2016.X | Бүгд       |
|--------------------------------------|------|------------------|------|------|------|--------|------------|
| Хүсэлтийн тоо                        | 6    | 23 <sup>49</sup> | 50   | 4    | 5    | 18     | <b>106</b> |
| Хүсэлтэд хамаарах иргэн, ААН-ийн тоо | 18   | 229              | 439  | 15   | 89   | 127    | <b>917</b> |

137. ЭБШХ-ийн дагуу ХСБ-ууд СБ-ууд болон СББМҮҮ-ээс мэдээлэл гаргуулан авах эрхтэй. Үүнтэй холбоотой тоо мэдээ бидэнд алга. Бидэнтэй уулзсан ЦЕГ-ын төлөөлөл МУ болон суурь гэмт хэргүүдийг шалгах явцад банкуудаас мэдээлэл хүсэх тохиолдол олонтаа гардгийг хэлж байв.

<sup>49</sup> 2012-2013 онд СМА ХСБ-ын өмнөөс мэдээлэл хүсдэг байсан. Энэ үйл ажиллагаа 2013 онд зогссон.

### БҮЛЭГ 3. ЭРХ ЗҮЙН СИСТЕМ БА ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АСУУДАЛ

Үйл ажиллагааны хэрэгцээнд зориулан санхүүгийн мэдээлэл ашиглах нь (6.1 болон 6.3 хамтдаа)

138. СМА-ны дүн шинжилгээ, шалгуулахаар шилжүүлж буй материал нь эрх бүхий байгууллага (ЦЕГ, ТЕГ, АТГ)-ын хэрэгцээ шаардлагыг хангах нь ховор байна. Эдгээр ХСБ нь мөрдөн шалгах чиглэлээ тодорхойлох, баримт нотолгоо цуглуулах, МУТС болон суурь гэмт хэргийн хөрөнгийн хөдөлгөөнийг тогтоохдоо зарим нэг санхүүгийн мэдээллийг ашиглах ажээ.

*СМА-наас шалгуулахаар шилжүүлсэн мэдээ тайлан*

139. МУТС болон бусад суурь гэмт хэрэгтэй холбоотой байж болох мэдээллийн талаар СМА нь СГТ-д журмын дагуу дүн шинжилгээ хийдэг ажээ. СМА нь СГТ, төрийн байгууллагуудаас гаргуулан авсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, улмаар ХСБ-уудад шалгуулахаар шилжүүлдэг ажээ.

#### Хүснэгт 9: ХСБ-уудад шилжүүлсэн СГТ болон тайлангийн ангилал

|   | 2011      | 2012      | 2013      | 2014     | 2015      | 2016<br>Хсар | Бүгд         |
|---|-----------|-----------|-----------|----------|-----------|--------------|--------------|
| СМА-ны хүлээн авсан СГТ   | 71        | 158       | 285       | 212      | 113       | 174          | <b>1,013</b> |
| Дүн шинжилгээ хийсэн СГТ  | 57        | 110       | 180       | 275      | 209       | 114          | <b>945</b>   |
| <i>ХСБ-уудад шилжүүлсэн тайлан</i>  |           |           |           |          |           |              |              |
| <b>ТЕГ</b><br>Нийгмийн аюулгүй байдал, хилийн гэмт хэрэг, өндөр эрсдэлтэй орны СГТ-гийн шинжилгээтэй холбоотой ЭХ-д хамаарах болзошгүй зөрчлүүд | 16        | 86        | 7         | 3        | 6         | 6            | <b>124</b>   |
| <b>АТГ</b><br>Нийтийн албан хаагчидтай холбоотой ЭХ-д хамаарах болзошгүй зөрчлүүд   | 0         | 1         | 0         | 0        | 0         | 0            | <b>1</b>     |
| <b>ЦЕГ</b><br>ТЕГ буюу АТГ-ын мэдэлд үл харъяалагдах гэмт хэрэгтэй холбоотой ЭХ-д хамаарах болзошгүй зөрчлүүд                                   | 3         | 7         | 7         | 3        | 21        | 29           | <b>70</b>    |
| <b>Бусад</b> <sup>50</sup>  | 2         | 0         | 0         | 0        | 0         | 0            | <b>2</b>     |
| <b>Бүгд</b>   | <b>21</b> | <b>94</b> | <b>14</b> | <b>6</b> | <b>27</b> | <b>35</b>    | <b>197</b>   |

140. Нэгэнт СМА цөөн тооны СГТ хүлээн авдаг тул ХСБ-уудад шалгуулахаар шилжүүлсэн тайлан ч цөөн ажээ. Гэтэл энэ нь Монгол Улсын МУТС эрсдэлийг огт төлөөлөхөөргүй байгаа юм. ҮЭҮ-нд авлигыг Монгол Улсын хамгийн өндөр эрсдэл бүхий суурь гэмт хэргээр нэрлэсэн атал СМА-наас АТГ-т тус асуудлаар ганцхан тайлан хүргүүлсэн байх жишээтэй.

141. СМА нь шалгуулахаар шилжүүлэх мэдээ тайланд зөвхөн СГТ-г ойлгож харин бусад тайлан мэдээг орхигдуулж буй сэтгэгдэл төрөхөөр байна.

<sup>50</sup> Банкны эзэмшлийг тайланг Монголбанкны ХШГ-т хүргүүлдэг. Үүнтэй холбоотойгоор ХШГ-аас ямар арга хэмжээ авсан нь тодорхойгүй байна.

### БҮЛЭГ 3. ЭРХ ЗҮЙН СИСТЕМ БА ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АСУУДАЛ

142. СМА-наас шалгуулахаар шилжүүлсэн мэдээ тайланг ТЕГ бараг ашиглахгүй байна. Тухайлбал, ТЕГ-т 124 тайлан хүргүүлснээс ердөө 2 нь МУ мөрдөн шалгах шатанд шилжсэн бол ТС-тэй холбоотойгоор 3 тайланг магадласан ажээ (Хүснэгт 11). Шилжүүлсэн мэдээ тайлан нь мөрдөн шалгах шатанд ийнхүү шилжихгүй байгаа нь СГТ-ийн дийлэнх нь өндөр эрсдэлтэй улс орон (гол төлөв БНАСАУ)-той хийсэн гүйлгээтэй зарим талаараа холбоотой байхаар байна. СМА-наас ирүүлсэн мэдээллийг хэрхэн ашиглаж буйг ТЕГ бидэнд тайлбарлаагүй болно.

143. Харин ЦЕГ-аас бидэнд өгсөн мэдээллээр бол тэд СМА-наас шилжүүлсэн мэдээллийг МУ болон суурь гэмт хэргийг шалгахад ашигладаг гээд СМА-ны дүн шинжилгээний чанарыг сайн гэж үнэлж байв. 2011 оноос хойш СМА-наас ЦЕГ-т 70 тайлан шилжүүлснээс зарим нь МУ мөрдөн шалгах буюу магадлах шатанд шилжсэн байна. Тухайлбал, МИАТ-ын хэрэг дээр доод шатны шүүх яллах дүгнэлт гаргасан ч Дээд шүүхээс хэрэгсэхгүй болгожээ (ШХ7-г үзнэ үү).

144. СМА нь стратегийн дүн шинжилгээ хийдэггүй ажээ. Гэтэл үүнийг гүйцэтгэх 1 ажилтны орон тоо СМА-нд байдаг төдийгүй СМА-ны зүгээс стратегийн дүн шинжилгээ хийх дотоод зааварчилгаа гаргажээ. Стратегийн шинжээч шууд хариуцсан ажлаа бус харин өөр зүйл хийж байгаагаас СМА нь мэргэшсэн хүний нөөцийн хомсдолд орсныг харж болно.

*СМА-наас хүсэлтийн дагуу гаргаж өгсөн мэдээлэл*

145. СМА нь ХСБ-уудын хүссэн мэдээллийг гаргаж өгөх замаар тэдний үйл ажиллагааны хэрэгцээг идэвхтэй ханган ажиллаж байна (Хүснэгт 10). Гэхдээ энэхүү мэдээллийг МУ болон суурь гэмт хэргийг мөрдөн шалгахад чухам хэрхэн ашигласан талаар бидэнд мэдээлэл алга.

**Хүснэгт 10: ХСБ хүсэлтийн дагуу СМА-наас гаргаж өгсөн мэдээлэл**

| ХСБ   | 2011   |          | 2012   |          | 2013   |          | 2014   |          | 2015   |          | 2016.X |          |
|-------|--------|----------|--------|----------|--------|----------|--------|----------|--------|----------|--------|----------|
|       | Хүссэн | Хангасан |
| ТТГ   | 6      | 5        | 15     | 15       | 211    | 211      | 38     | 29       | 157    | 155      | 6      | 6        |
| ЦЕГ   | 93     | 87       | 190    | 199      | 888    | 776      | 331    | 334      | 1081   | 1076     | 762    | 800      |
| АТГ   | 30     | 29       | 285    | 282      | 68     | 63       | 265    | 268      | 10     | 10       | 0      | 0        |
| ШШГЕГ | 16     | 16       | 1      | 0        | 27     | 13       | 0      | 0        | 0      | 0        | 0      | 0        |
| УПЕГ  | 0      | 0        | 10     | 10       | 0      | 0        | 0      | 0        | 0      | 0        | 0      | 0        |
| Бусад | 5      | 0        | 0      | 5        | 3      | 3        | 0      | 0        | 0      | 0        | 0      | 0        |
| Бүгд  | 150    | 137      | 501    | 511      | 1197   | 1066     | 634    | 631      | 1248   | 1241     | 768    | 806      |

### БҮЛЭГ 3. ЭРХ ЗҮЙН СИСТЕМ БА ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АСУУДАЛ

146. ХСБ-ууд нь СМА-наас мэдээлэл хүсэхээс гадна (Хүснэгт 10) өөрийн гэсэн санхүүгийн мэдээллийн тогтолцоог бүрдүүлж суурь гэмт хэргийг шалгах/мөрдөх, МУ болон ТС-ийг магадлахад ашиглаж буйг бидэнд ярьсан. Гэхдээ үүнийг нотлох бодит жишээ, баримтыг бидэнд гаргаж өгөөгүй болно.

147. Дүгнэн хэлэхэд СМА-ны үйл ажиллагаа нь ХСБ-уудад хүссэн мэдээллийг нь гаргаж өгөхөд чиглэгдэж байна. МУТСТ болон суурь гэмт хэргийг мөрдөн шалгахад СМА болон ХСБ-уудын зүгээс найдвартай, үнэн зөв, бодитой санхүүгийн мэдээллийг боловсруулж буйг нотлох хангалттай баримт бидэнд алга. СМА-ны бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэхийн тулд юуны түрүүнд СГТ-ийн тоо, чанарт анхаарах, стратегийн дүн шинжилгээ хийдэг болох, ХСБ-ын тусгайлсан хэрэгцээг хангахуйц, МУТС-ийн эрсдэл дээр төвлөрсөн шинэ бүтээгдэхүүн боловсруулах шаардлагатай юм.

*Хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоо*

148. МУ-тай тэмцэх үйл ажиллагаанд СМА голлох үүрэг гүйцэтгэнэ. ХАЗ-ийн ажлын албаны чиг үүргийг хэрэгжүүлэгчийн хувьд СМА нь МУТСТ бодлогыг боловсруулахад шийдвэрлэх үүрэгтэй ажээ. СМА нь ХАЗ-өөр дамжуулан үндсэн эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллана. СМА нь санамж бичгийн хүрээнд ЦЕГ, ТЕГ, АТГ, ГЕГ, УПЕГ-тай мэдээлэл солилцдог ажээ. ЦЕГ болон ТЕГ нь өөрийн зориулалтын терминалаар дамжин СМА-ны мэдээллийн санд аюулгүй, шууд нэвтрэх эрхтэй.

149. СМА нь дараахь мэдээллийн санд шууд буюу хүсэлт гарган нэвтрэх эрхтэй:

- Шууд нэвтрэх эрхтэй мэдээллийн сан:
  - Монголбанкны удирдлагын мэдээллийн сан, тус сан нь гүйцэтгэх захирлууд болон хувь эзэмшигчдийн талаарх мэдээллийг агуулна.
  - Монголбанкны зээлийн мэдээллийн сан.
  - Монголбанкны банк хоорондын бага болон өндөр дүнтэй гүйлгээний мэдээллийн сан.
- Албан хүсэлтээр нэвтрэх мэдээллийн сан:
  - АТГ-ын хөрөнгө, орлогын мэдүүлгийн сан.
  - ГЕГ-ын гаалийн декларацийн мэдээллийн сан.
  - ТЕГ-ын далд үйл ажиллагааны мэдээлэл.
  - ОӨУБЕГ-ын иргэд, өмч, хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сан.
  - НДЕГ-ын тэтгэвэр, тэтгэмжийн мэдээлэл.
  - ТаЕГ-ын татварын бүртгэлийн мэдээллийн сан.
  - ЭЦГ-ын далд үйл ажиллагааны мэдээлэл.
  - Хил хамгаалалтын газрын хил нэвтрүүлэлтийн талаарх мэдээллийн сан.
  - ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны төвийн шүүхээр ял шийтгүүлсэн хүмүүсийн архив.

150. СМА нь эрх бүхий 5 байгууллагатай хамтран ажиллах санамж бичиг байгуулжээ. Харин бусад байгууллагатай хамтран ажиллаж мэдээлэл солилцож буй зүйл алга. Мөн

### БҮЛЭГ 3. ЭРХ ЗҮЙН СИСТЕМ БА ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АСУУДАЛ

СМА нь зарим нэр бүхий мэдээллийн санг ашиглах боломжгүй байгаа нь түүний дүн шинжилгээг түргэн шуурхай, цогц байдлаар хийх чадварт сөргөөр нөлөөлж байна.

151. СМА нь мэдээллийн нууцлалыг хамгаалахдаа дотоод журам, үйл ажиллагааны зааврыг мөрдөж ажилладаг ажээ. Энэхүү заавар нь СГТ-г хүлээн авах, дүн шинжилгээ хийх, шалгуулахаар шилжүүлэх үйл явцыг хамрахаас гадна СГТ-гийн нууцлалыг хангахыг зоридог байна. СМА дүн шинжилгээгээ цаасаар холбогдох ХСБ-д шууд шилжүүлнэ. Цахим мэдээлэл шилжүүлж буй тохиолдолд нууц үгээр хамгаалагдсан байна. СМА-наас мэдээллийг чандлан хадгалж, гуравдагч этгээдэд задлахгүй байхыг ХСБ-д анхааруулдаг байна.

*Шууд Хэрэгжилт 6: Ерөнхий Дүгнэлт*

152. **Монгол Улс Шууд Хэрэгжилт 6-ийн үр дүнтэй байдлыг хангаж чадаагүй байна.**

### БҮЛЭГ 3. ЭРХ ЗҮЙН СИСТЕМ БА ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АСУУДАЛ

#### Шууд Хэрэгжилт 7 (МУ мөрдөн шалгах ба шийдвэрлэх)

153. Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон Улсын Ерөнхий Прокурорын 2015 оны А/67 тушаалын дагуу МУ гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүрэг ЦЕГ, ТЕГ, АТГ гэсэн ХСБ-ад оногдоно. МУ-сан байж болзошгүй тохиолдлыг ХСБ шалгаж үзээд шаардлагатай бол УПЕГ-т шилжүүлнэ. УПЕГ нь 2015 оны А/67 тоот тушаалын дагуу хяналт тавих харьяаллыг тогтоож, мөрдөн шалгах үйл ажиллагаанд хяналт тавина. Үүнд:

- АТГ - Нийтийн албан хаагчидтай холбоотой МУ хэргийг АТГ шалгана. АТГ-ын МУ болон суурь гэмт хэргийг мөрдөн шалгах нэгж 13 хүнтэй ба эдгээрээс 6 нь МУ гэмт хэрэг дээр ажилладаг ажээ.
- ТЕГ –нийгмийн аюулгүй байдал, хилийн гэмт хэрэгт хамаарах МУ тохиолдлыг ТЕГ шалгана. ТЕГ-ын мөрдөн шалгах нэгжид МУ гэмт хэрэг дээр 7 хүн ажиллаж байна.
- ЦЕГ – МУ-тай холбоотой бусад суурь гэмт хэргийг ЦЕГ-ын харьяа Улсын мөрдөн байцаах газрын Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс шалгана. Тус хэлтэст МУ гэмт хэрэг дээр 50 хүн ажиллаж байна.

#### МУ гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах

154. Монгол Улс МУ-тай тэмцэх асуудалд тэргүүн зэргийн ач холбогдол өгөхгүй байна. Дээр өгүүлсэнчлэн, ХСБ-уудын түвшинд МУ-тай тэмцэх дотоод удирдамж, чиглэл байдаггүй бол үндэсний түвшинд МУТСТ бодлого байхгүй ажээ. Монгол Улс олон хүнийг шалгасныг Хүснэгт 11 харуулж байна. МУ 46 хэргээс ЦЕГ 27, АТГ 17, ТЕГ 2 тохиолдлыг тус тус шалгажээ. Эдгээр 46 хэргийг хэрхэн шийдвэрлэснийг дор харуулав. Үүнд:

- Прокурорт шилжсэн 20 хэргийн 2-т анхан шатны шүүхээс яллах дүгнэлт үйлдсэн ч Дээд шүүхээс хэрэгсэхгүй болгожээ (Баримт 1, 2). Үлдсэн 18 хэргийн хувьд: (i) өөр зүйл ангиар шийдвэрлэсэн - 6, (ii) түдгэлзүүлсэн - 3, (iii) хэрэгсэхгүй болгосон - 4, (iv) шалгаж байгаа - 5 (үүнд 2014 оны 2 хэрэг орно) хэрэг тус тус байна.
- 26 хэрэг прокурорт шилжээгүй үлджээ. Эдгээрээс: (i) түдгэлзүүлсэн - 4, (ii) шалгаж байгаа - 10 (2014 оны 1 хэрэг үүнд орно), (iii) хэрэгсэхгүй болсон - 12 хэрэг тус тус байна.

#### Хүснэгт 11: МУ хэргийг шалгаж шийдвэрлэсэн байдал

| Он   | ХСБ-ууд | Шалгасан (хүний тоогоор) | Эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан /хэргийн тоо/ | Прокурорт шилжүүлсэн | Ял оногдуулсан /хэргийн тоо/ |
|------|---------|--------------------------|--|----------------------|------------------------------|
| 2011 | ЦЕГ     | 87                       | 1  | 1                    | 1 <sup>51</sup>              |
|      | АТГ     | 29                       | 0  | 0                    | 0                            |
|      | ТЕГ     | 5                        | 0  | 0                    | 0                            |
| 2012 | ЦЕГ     | 199                      | 0  | 0                    | 0                            |
|      | АТГ     | 282                      | 0  | 0                    | 0                            |

<sup>51</sup> МУ зүйл ангиар анхан шатны шүүхээс ял оногдуулсан ч Дээд шүүх хэрэгсэхгүй болгосон.

### БҮЛЭГ 3. ЭРХ ЗҮЙН СИСТЕМ БА ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АСУУДАЛ

|              |     |              |           |                |          |
|--------------|-----|--------------|-----------|----------------|----------|
|              | ТЕГ | 15           | 0         | 0              | 0        |
| 2013         | ЦЕГ | 776          | 5         | 2              | 0        |
|              | АТГ | 63           | 3         | 2              | 1        |
|              | ТЕГ | 211          | 0         | 0              | 0        |
| 2014         | ЦЕГ | 334          | 8         | 8              | 0        |
|              | АТГ | 268          | 4         | 2              | 0        |
|              | ТЕГ | 29           | 1         | 1 <sup>s</sup> | 0        |
| 2015         | ЦЕГ | 1,076        | 4         | 1              | 0        |
|              | АТГ | 10           | 4         | 0              | 0        |
|              | ТЕГ | 155          | 0         | 0              | 0        |
| 2016         | ЦЕГ | 800          | 9         | 4              | 0        |
|              | АТГ | 0            | 6         | 0              | 0        |
|              | ТЕГ | 6            | 1         | 0              | 0        |
| <b>Total</b> |     | <b>4,345</b> | <b>46</b> | <b>20</b>      | <b>2</b> |

155. МУ санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааг гол төлөв ХСБ-ууд (ялангуяа ЦЕГ) эхлүүлэх нь нийтлэг ажээ. ХСБ-ууд СМА (Хүснэгт 10) болон бусад СБ-уудаас лавлагаа гаргуулан авдаг талаар бидэнд танилцуулж байсан. Лавлагааны үр дүнд МУ эрүүгийн мөрдөн шалгах үйл ажиллагаа эхэлсэн нь ховор ч цуглуулсан тоо баримтыг суурь гэмт хэргийг мөрдөхөд ашигладаг ажээ. СМА-ны мэдээлэлд тулгуурлан мөрдөн шалгах ажиллагаа эхэлсэн тохиолдол ховор аж.

156. Лавлагаа нь ийнхүү мөрдөн шалгах, яллах шат руу шилжихгүй байгаа нь дараахь шалтгаантай: (i) МУТСТ асуудлыг улс орны бодлогын түвшинд авч үзэхгүй, МУ-тай тэмцэх стратеги, чин эрмэлзэл дутуу дулимаг байгаа нь МУ мөрдөн шалгалтын ач холбогдлыг сулруулж байна, (ii) МУ мөрдөн шалгах дотоод удирдамж, чиглэл байхгүй, (iii) МУ мөрдөн шалгах мэргэшсэн боловсон хүчин, хүчин чадал дутмаг (Монголд шүүхийн шинжээч-нягтлан бодогч/forensic accountant байхгүй), (iv) МУ гэмт хэргийн талаарх ойлголт сул, (v) өнөөгийн нөөц бололцоо нь суурь гэмт хэргийг илүү түргэн, хүндрэл багатай шийдвэрлэх боломж олгох тул МУ гэмт хэргийг дараагийн ээлжинд тавьж байна.

*МУ мөрдөн шалгах ба шийдвэрлэх үйл ажиллагаа нь МУ эрсдэл, МУ-тай тэмцэх үндэсний бодлогыг илэрхийлж буй эсэх*

157. Монгол Улсын МУТС эрсдэл болон ХСБ-уудын дотоод бодлогоос улбаатай МУТСТ үндэсний стратегигүй байна. ЦЕГ-ийн МУ мөрдөн шалгалт нь юуны түрүүнд залилан (МУ хамгийн өндөр эрсдэлтэй суурь гэмт хэрэг)-тай холбоотой байна (Хүснэгт 12). АТГ нь МУ-тай холбоотой 17 авлигын хэрэг шалгажээ (мөн өндөр эрсдэлтэй суурь гэмт хэрэгт тооцогддог). Бидний үзэж байгаагаар Монгол Улсын МУ эрсдэл нь МУ мөрдөн шалгалтын тоо, төрөлд тусгалаа олохгүй байна. Бусад өндөр эрсдэлтэй МУ гэмт хэргийн (тухайлбал, байгаль орчны эсрэг гэмт хэрэг, татвараас зайлсхийх) мөрдөн шалгалт байхгүй буюу үндсэндээ байхгүй ажээ.

### БҮЛЭГ 3. ЭРХ ЗҮЙН СИСТЕМ БА ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АСУУДАЛ

158. ҮЭҮ болон холбогдох хүмүүсийн ярианаас харахад ХСБ-ууд суурь гэмт хэрэг мөрдөх замаар МУ аюултай тэмцэж байна. Гэхдээ Бүлэг 1-д дурьдсанчлан Монгол Улс Өршөөлийн тухай хуулийг 2015 онд баталсан. Тус хуулийн үйлчлэлд МУ мөрдөн шалгалт хамрагдаагүй ч шалгах, мөрдөх, шүүх шатанд байсан эдийн засгийн шинжтэй 80 хэрэг хэрэгсэхгүй болжээ (Хүснэгт 1).

**Хүснэгт 12: МУ мөрдөн шалгалтын суурь гэмт хэргийн төрөл<sup>52</sup>**

| Суурь гэмт хэрээ  | Мөрдөн шалгалтын тоо | Гэмт хэргийн эрсдэл (ҮЭҮ) |
|---|----------------------|---------------------------|
| ЭХ-ийн 148-р зүйл: Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах  | 18                   | Өндөр                     |
| ЭХ-ийн 150-р зүйл: Бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх   | 4                    | Өндөр                     |
| ЭХ-ийн 156-р зүйл: Банкны тухай хууль тогтоомж зөрчих   | 2                    | Дунд зэрэг                |
| ЭХ-ийн 157-р зүйл: Банкны үйл ажиллагаанд албан тушаалын байдлаа урвуулж буюу эрх мэдлээ хэтрүүлж оролцох | 1                    | Дунд зэрэг                |
| ЭХ-ийн 266-р зүйл: Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх          | 1                    | Өндөр                     |
| ЭХ-ийн 166-1-р зүйл: МУ   | 3                    | Өндөр                     |

159. Түүнчлэн МУ гэмт хэрэгт ял шийтгэл оногдуулахгүй байна. УПЕГ-аас МУ 2 хэрэгт яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлэн шийдвэрлүүлсэн ч Дээд шүүхээс МУ зүйл ангийг хэрэгсэхгүй болгожээ. (Баримт 1, 2)<sup>53</sup>.

160.

#### Баримт 1: МИАТ-ын хэрэг

Төрийн өмчит МИАТ компаний 3 өндөр албан тушаалтанд байгууллагын хөрөнгө шамшигдуулж завшсан, мөнгө угаасан хэргээр анхан шатны болон давж заалдах шатны шүүхээс ял шийтгэл ногдуулжээ. Эдгээр албан тушаалтнууд 2 онгоцыг 2 өөр компанид давхар даатгуулах замаар 7.2 сая америк доллар завшсан хэрэгт буруутгагдсан юм. 2007-2010 оны хооронд тус албан хаагчид гадаадад байрлах хэд хэдэн банкны өөрсдийн дансаар нэг компанид төлбөр төлж, төлсөн мөнгийг эргүүлээд Монголын банкууд руу шилжүүлсэн байна. Дээд шүүх нь доод шатны шүүхийн оноосон 166<sup>1</sup> зүйл ангийг буруу ашигласан гэж дүгнэн МУ зүйл ангийг хүчингүй болгожээ.

#### Баримт 2: Дээд шүүх хүчингүй болгосон Е-системийн хэрэг

Иргэний нисэхийн ерөнхий газрын 4 албан хаагч эрх мэдлээ урвуулан ашиглаж, тендерийн үйл ажиллагааг будлиантуулах замаар 426,904 ам.доллар (1,062,959,200 төг) завшжээ.

<sup>52</sup> АТГ-ын 17 хэрэг ба ТЕГ-ын 2 хэргийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг гаргаж өгөөгүй болно.

<sup>53</sup> Шууд Хэрэгжилт 2-ын тэмдэглэгээг харна уу

### БҮЛЭГ 3. ЭРХ ЗҮЙН СИСТЕМ БА ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АСУУДАЛ

Албан хаагчид үйлчилгээний төлбөрийн зарим хэсгийг 2 албан хаагчийн гадаад дахь хамтарсан компани руу шилжүүлсэн. Анхан шатны болон давж заалдах шатны шүүхээс тэдэнд ЭХ-ийн 150.3 буюу МУ, завшиж үрэгдүүлэх зүйл ангиар нийт 7 жил хорих ял оноожээ. Гэсэн ч Дээд шүүх Монгол Улсын банкны дансанд мөнгө хүлээн авсан албан хаагчдын үйлдэл нь ЭХ-ийн 166<sup>1</sup>-р зүйл буюу “хууль бус эх үүсвэрийг нь нуух, далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах” хэмээн заасны дагуу үйлдэгдээгүй гэж үзэн доод шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгожээ.

#### *МУ гэмт хэргийн төрөл*

161. Монгол Улсад МУ гэмт хэргээр шийдвэрлэсэн тохиолдол байхгүй ажээ. ХСБ-ууд гол төлөв өөрийн (гуравдагч этгээдийн мөнгө угаасан хэргээс бусад) мөнгийг угаасан хэргийг шалгадаг байна. Гэхдээ ЦЕГ-аас 2013 онд гуравдагч этгээдтэй холбоотой 3 хэргийг шалгажээ. Нэг хэргийг АТГ-т шилжүүлсэн бол нөгөө хоёр нь гадаадын суурь гэмт хэрэгтэй холбоотой хэргийг шийдвэрлээгүй байна. Монгол Улс МУ хэргүүдтэй холбоотойгоор ЭЗХТ үзүүлжээ (Шууд Хэрэгжилт 2).

162. Авлигатай холбоотой МУ-аар ялласан хоёр хэрэг нь компанийн бүтэц, олон улсын гүйлгээг ашигласан, гадаад, дотоодын хууль тогтоомжийг зөрчсөн үйлдэл байсныг тэмдэглэх нь зүйтэй. Эдгээр хэрэг дээр Монгол Улс олон улсын хамтын ажиллагааны хүрээнд гадны тусламж авч нотлох баримт болон гүйлгээний мэдээлэл цуглуулсан байна.

#### *Шийтгэл нь зөрчилтэй нь дүйцэхүйц, гэмт хэрэг дахин үйлдэхээс сэргийлэхүйц үр дүнтэй байгаа эсэх*

163. Эрүүгийн хуулийн 166<sup>1</sup> -д хувь хүн, хуулийн этгээдэд ногдуулах хэд хэдэн төрлийн шийтгэлийг тусгажээ. Гэвч эдгээр шийтгэл нь хуулийн этгээд, зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлийн гишүүн бус хувь хүн, албан тушаалаа урвуулан ашигласан хувь хүний хувьд зөрчилтэй нь дүйцэхүйц, гэмт хэрэг давтан үйлдэхээс сэргийлэхүйц байж чадахгүй байгааг Зөвлөмж 3-т өгүүлсэн.

164. Дээд шүүхийн хэрэгсэхгүй болгосон МУ 2 хэрэгт анхан шатны шүүхээс МУ болон суурь гэмт хэргээр давхар ял ногдуулсан. Иймд МУ гэмт хэрэгт ногдуулах ял шийтгэл гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, гэмт хэрэг давтан үйлдэхээс сэргийлэхүйц эсэхийг тогтоох боломжгүй байна.

165. Бүлэг 1-д дурьдсанчлан Монгол Улс Өршөөлийн тухай хуулийг 2015 онд баталсан. Тус хуулиар МУ гэмт хэргийг өршөөгөөгүй ч эдийн засгийн гэмт хэрэгтэй 900 хүний ялыг хөнгөрүүлэх буюу хэрэгсэхгүй болгожээ.

#### *Эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ*

166. Монгол Улс эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.

#### *Шууд Хэрэгжилт 7-ийн ерөнхий дүгнэлт*

167. **Монгол Улсын Шууд хэрэгжилт 7-ийн үр дүнтэй байдал доогуур түвшинд байна.**

### БҮЛЭГ 3. ЭРХ ЗҮЙН СИСТЕМ БА ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АСУУДАЛ

#### Шууд хэрэгжилт 8 (Хөрөнгө хураах)

*Орлого, гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн хэрэгсэл, дүйцэхүйц өртөгтэй хөрөнгө хураах бодлого*

168. Монгол Улс хөрөнгө битүүмжилж хураадаг (Хүснэгт 13, 14) ч хууль сахиулах болон шүүх байгууллагуудад мөнгөний хөдөлгөөнийг хянах, хөрөнгийг илрүүлж царцаахад дагаж мөрдөх бодлого байхгүй аж. УЕПГ-аас албан хаагчиддаа зориулан мөрдөн шалгах, шийдвэрлэх шатанд ЭБШХ, ЭХ-ийн дагуу хөрөнгө хураах дотоод удирдамж, чиглэл гаргажээ.

169. Хөрөнгө хураах Монгол Улсын хууль тогтоомж нь ФАТФ-ийн стандарттай нийцтэй байна. ЭБШХ нь ХСБ-уудад гэмт хэрэг үйлдэж олсон орлого, хэрэглэсэн хэрэгсэл, үнийн хувьд дүйцэхүйц хөрөнгө хураах боломж олгож байна. Гэхдээ тэр болгон дүйцэхүйц өртөгтэй хөрөнгө хураагдаггүйг Баримт 3-аас харж болно.

*Гадаад, дотоод гэмт хэргийн гаралтай орлогыг хураах, хилийн чанад дахь орлогыг хураах*

170. Холбогдох тоо мэдээ, статистикийг хэрхэн гарган өгч байсан нь Монгол Улсын үр дүнтэй байдлын ерөнхий үнэлгээнд шууд нөлөөлсөн болно. Гэхдээ Хүснэгт 13, 14-өөс УЕПГ нь МУ болон суурь гэмт хэргийг мөрдөн шалгаж шийдвэрлэх явцад хөрөнгө битүүмжилдэг; шүүх хөрөнгө хураадаг; ШШГЕГ нь хохирогч, улсын төсөв, төрийн өмчит аж ахуйн нэгжийн хохирлыг барагдуулах шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлдэг нь харагдаж байна.

171. УЕПГ нь 2012-2015 оны хооронд 110 сая ам.долларын хөрөнгө битүүмжилсний дийлэнхи нь өндөр эрсдэлтэй суурь гэмт хэрэгтэй холбоотой байв (Хүснэгт 13). Нийт битүүмжилсэн хөрөнгийн 79 сая ам.долларыг анхан шатны шүүх хураажээ. ШШГЕГ-ын мэдээллээс харахад мөн хугацаанд 8.79 сая ам.долларыг улсын төсөв болон төрийн өмчит байгууллагуудад, 4.35 сая ам.долларыг иргэдэд нөхөн төлбөр болгон хуваарилжээ. 2016 онд 2.66 сая ам.долларыг улсын төсөв болон төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд хуваарилсан бол 1.67 сая ам.долларыг иргэдэд шилжүүлжээ. Баримт 1 болон 2 нь хөрөнгө хураах ажиллагаа тодорхой түвшинд явагдаж буйг харуулна.

#### Хүснэгт 13: 2012-2015 онд битүүмжилсэн, хураасан хөрөнгө<sup>54</sup>

| Гэмт хэргийн төрөл                  | УЕПГ-аас битүүмжилсэн хөрөнгө |                  |              | Анхан шатны шүүхийн шийдвэрээр хураасан хөрөнгө |                 |              |
|-------------------------------------|-------------------------------|------------------|--------------|---|-----------------|--------------|
|                                     | Хэргийн тоо                   | Сая төгрөг       | Сая ам.долл  | Хэргийн тоо                                     | Сая төгрөг      | Сая ам.долл  |
| Өндөр эрсдэлтэй суурь гэмт хэргүүд  |                               |                  |              |   |                 |              |
| Залилан                             | 598                           | 203,083.8        | 83.26        | 681   | 52,934.80       | 21.70        |
| Байгаль орчны эсрэг гэмт хэрэг      | 407                           | 5,182.2          | 2.12         | 447   | 1,559.70        | 0.64         |
| Татвараас зайлсхийх                 | 23                            | 8,731.5          | 3.58         | 18  | 1,375.00        | 0.56         |
| Авлига                              | 195                           | 16,078.5         | 6.59         | 72  | 20,918.10       | 8.58         |
| <b>Бүлгийн дүн</b>                  | <b>1,223</b>                  | <b>233,076.0</b> | <b>95.56</b> | <b>1,218</b>                                    | <b>76,787.6</b> | <b>31.48</b> |
| Дундаж эрсдэлтэй суурь гэмт хэргүүд |                               |                  |              |   |                 |              |

<sup>54</sup> ҮЭҮ-нээс авав.

### БҮЛЭГ 3. ЭРХ ЗҮЙН СИСТЕМ БА ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АСУУДАЛ

|   |              |                  |               |              |                 |              |
|---|--------------|------------------|---------------|--------------|-----------------|--------------|
| Мансууруулах эм,<br>сэтгэцэд нөлөөт бодисыг<br>хууль бусаар ашиглах | 142          | 284.2            | 0.12          | 167          | 1.50            | 0.00         |
| Улсын хилээр хууль<br>бусаар нэвтрүүлэх,<br>нэвтрэх                 | 159          | 4,910.1          | 2.01          | 179          | 14,364.30       | 5.89         |
| Банкны зөрчил   | 18           | 80.9             | 0.03          | 21           | 72,658.00       | 29.79        |
| Хулгай/дээрэм   | 5139         | 8,640.3          | 3.54          | 5186         | 15,572.20       | 6.38         |
| <b>Бүлгийн дүн</b>  | <b>5,457</b> | <b>13,915.5</b>  | <b>5.71</b>   | <b>5,553</b> | <b>102,596.</b> | <b>42.06</b> |
| МУ  | 6            | 7,855.6          | 3.1           | 1            | 19,009.92       | 7.6          |
| Бусад суурь гэмт хэрэг  | 860          | 13,545.2         | 5.67          | 1,410        | 17,475.88       | 7.36         |
| <b>Бүгд</b>   | <b>7,546</b> | <b>268,392.0</b> | <b>110.04</b> | <b>8,182</b> | <b>215,869</b>  | <b>87.90</b> |

#### Хүснэгт 14: Эрүүгийн гэмт хэрэгтэй холбоотой улсын орлого болгосон хөрөнгийн үнэлгээ<sup>55</sup>

| Он   |                               | Иргэдэд<br>олгосон | Улсын<br>төсөвт<br>шилжүүлсэ<br>н | Нийт,<br>ам.долла<br>р |
|------|-------------------------------|--------------------|-----------------------------------|------------------------|
| 2012 | Хөрөнгө хураах шийдвэрийн тоо | 1,733              | 799                               | 2,532                  |
|      | дүн (ам.доллар)               | 1,125,446          | 688,107                           | 1,813,554              |
| 2013 | Хөрөнгө хураах шийдвэрийн тоо | 2,234              | 966                               | 3,200                  |
|      | дүн (ам.доллар)               | 756,020            | 547,713                           | 1,303,733              |
| 2014 | Хөрөнгө хураах шийдвэрийн тоо | 2,041              | 628                               | 2,669                  |
|      | дүн (ам.доллар)               | 699,330            | 2,083,175                         | 2,782,506              |
| 2015 | Хөрөнгө хураах шийдвэрийн тоо | 3,464              | 728                               | 4,192                  |
|      | дүн (ам.доллар)               | 1,774,819          | 5,479,753                         | 7,254,571              |
|      | Хөрөнгө хураах шийдвэр, бүгд  | 9,472              | 3,121                             | 12,593                 |
|      | Нийт дүн (ам.доллар)          | 4.35               | 8.79                              | 13.15                  |
| 2016 | Хөрөнгө хураах шийдвэрийн тоо | 2,268              | 614                               | 2,882                  |
|      | дүн (ам.доллар)               | 1,669,857          | 2,675,214                         | 4,345,070              |
|      | Хөрөнгө хураах шийдвэр, бүгд  | 9,472              | 3,121                             | 12,593                 |
|      | Нийт дүн (ам.доллар)          | 6.02               | 11.46                             | 17.48                  |

172. Монгол Улсад МУ гэмт хэрэгтэй холбоотойгоор хөрөнгө хураагдсан тохиолдол алга. Дээд шүүх хэрэг хэрэгсэхгүй болгосон ч (Баримт 1, 2 болон Шууд Хэрэгжилт 7) анхан шатны шүүхийн хураахаар шийдвэрлэсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөөгүй байна.

173. Монгол Улс хилийн чанадад байрших хөрөнгө мөнгийг хураагаагүй ч МУ хэрэгтэй холбоотой хөрөнгийг Чех, БНСУ руу буцаасан байна (Баримт 3).

174. Монгол Улс ТС гэмт хэрэгтэй холбогдуулан хөрөнгө хураагаагүй ч энэ нь тус улсын ТС эрсдэлийн төсөөлөлтэй нийцгүй гэсэн үг биш юм.

<sup>55</sup> Статистикийг ШШГЕГ-аас авав.

## БҮЛЭГ 3. ЭРХ ЗҮЙН СИСТЕМ БА ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АСУУДАЛ

### Баримт 1: Хөрөнгө хураах

Төрийн албан хаагчид болох ноён Т. болон ноён Т.Б. нарт 265-р зүйл (Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах), 150-р зүйл (Бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх), 166-р зүйл (Татвараас зайлсхийх)-ээр хэрэг үүсгэн гэм буруутайг тогтоосон. Тэд 2.84 тэрбум төгрөг (1,143,781 ам.доллар)-ийн хохирол учруулснаас 560 сая төгрөг (225,534 ам/доллар)-ийг хурааж улсын орлого болгожээ.

### Баримт 2: Хөрөнгө хураах (МИАТ-тын хэрэг)

МИАТ-ын захирал асан ноён Б., ерөнхий нягтлан бодогч хатагтай Н. нар их хэмжээний мөнгийг эрсдэлийн даатгал нэрийдлээр хэд хэдэн даатгалын компанид шилжүүлсэн. Тэднийг 263-р зүйл (Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах), 150-р зүйл (Бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх) ангиар гэм буруутайд тооцжээ. Энэхүү хэргийн хохирлын хэмжээг 1.06 тэрбум төгрөг (426,904 ам.доллар) гэж тооцоолж, 2 тэрбум төгрөг (805,480 ам.доллар)-ийн үнэ өртөг бүхий хөрөнгө хураажээ.

### Баримт 3: БНСУ руу буцаасан хөрөнгө

2013 онд Монголд зочид буудлын бизнес эрхэлж буй Солонгосын иргэнтэй холбоотой хүсэлтийг БНСУ-аас Интерполын шугамаар хүлээн авсан. Тус иргэн нь хууль бус мөрийтэй тоглоомноос олсон мөнгөөр Улаанбаатар хотод зочид буудал барьсан байна. 2009 онд Сөүлийн шүүхээс түүнд МУ хэргээр шийтгэл ногдуулж 4.5 сая ам.долларыг (10 тэрбум төгрөг) хураах шийдвэр гаргажээ. Тус иргэн зочид буудлынхаа 65%-ийг 2 Солонгосын иргэнд шилжүүлснийг Монголын тал тогтоож үлдсэн 35% буюу 210,000 ам.долларыг хураан авч БНСУ руу шилжүүлжээ.

### *Мөнгөн хөрөнгө хууль бусаар хил давуулах*

175. Хил дамнасан бэлэн мөнгөний урсгал эрсдэл учруулж буйг 2016 оны ҮЭҮ-д тэмдэглэжээ. Монгол Улсын эдийн засаг бэлэн бус төлбөр тооцоонд төдийлөн тулгуурлаагүй билээ. Түүнчлэн алт хууль бусаар хил давуулах нь томоохон эрсдэл болохыг Бүлэг 1-д дурьдсан.

176. Улсын хилээр худал мэдүүлсэн эсхүл мэдүүлээгүй алт болон мөнгөн хөрөнгийг ГЕГ-аас хураасан тохиолдол цөөн аж (Хүснэгт 15, 16). Гаалийн бүх цэг рентген болон бусад төхөөрөмжөөр тоноглогдсон ажээ. Гэхдээ тагнуулын мэдээллийг түргэн шуурхай авах боломж хомс; ГЕГ, ХХГ, ЦЕГ, СМА зэрэг байгууллагын ажлын уялдаа сул байгаа нь хил дамнасан хууль бус мөнгөн хөрөнгийг илрүүлж хураахаад сөргөөр нөлөөлж байна. Илрүүлэлтийг сайжруулах зарим арга хэмжээ авагдаж (анхааруулга тэмдэглэгээг ахиулах, их хэмжээний бэлэн мөнгийг илрүүлэх рентген төхөөрөмж суурилуулах г.м.), төлөвлөгдөж байгаа ч (сургуультай нохой ашиглах г.м.) тагнуулын мэдээлэл хомс байгаа нь урьдчилан мэдэх боломжийг хязгаарлаж, гаалийн ажилтан зөвхөн өөрийн мэдрэмж, сэжигт найдахад хүргэж байна.

### БҮЛЭГ 3. ЭРХ ЗҮЙН СИСТЕМ БА ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АСУУДАЛ

#### Хүснэгт 15. 2011-2015 онд хураагдсан мөнгө

| Мөнгөн дэвсгэрт      | Дүн          | Ам/доллар      |
|----------------------|--------------|----------------|
| <b>Юань</b>          | 2,419,000.00 | 355,897        |
| <b>Америк доллар</b> | 20,000.00    | 20,000         |
| <b>Евро</b>          | 48,620.00    | 54,432         |
| <b>Рубль</b>         | 100,000.00   | 1,740          |
| <b>Вон</b>           | 6,000,000.00 | 5,347          |
| Нийт                 |              | <b>437,416</b> |

#### Хүснэгт 16. 2010-2016 онд хураагдсан алт, мөнгө

| Алтны үнэлгээ               | Мөнгөний үнэлгээ | Улсын төсөвт шилжүүлсэн дүн |
|-----------------------------|------------------|-----------------------------|
| <b>2,822,898,803 төгрөг</b> | 5,010,079 төгрөг | 2,827,908,883 төгрөг        |
| <b>1,138,983 ам.доллар</b>  | 2,021 ам.доллар  | 1,141,004 ам.доллар         |

177. Гаалийн алба хаагчдын ярьснаар зорчигчид бэлэн мөнгө хууль бусаар зөөвөрлөх нь харьцангуй гайгүй, харин каргоны хувьд нөхцөл байдал өөр гэж байв.

*Хөрөнгө хураалт нь МУТС эрсдэл, МУТСТ бодлоготой нийцтэй эсэх нь*

178. Монгол Улсад МУТСТ үндэсний стратеги байхгүйг дээр өгүүлсэн. Монгол Улсад МУ холбоотой хөрөнгө хураасан тохиолдол байхгүй ч УЕПГ нь МУ болон суурь гэмт хэрэг шалгах, шийдвэрлэх шатанд хөрөнгө битүүмжилж байсан бол шүүхийн байгууллага нь хөрөнгө хурааж байжээ. Суурь гэмт хэрэгтэй (ялангуяа өндөр эрсдэлтэй) холбоотойгоор улсын орлого болгосон хөрөнгийн дэлгэрэнгүй тоо мэдээллийг бидэнд гаргаж өгч чадаагүй нь Монгол Улсын үр дүнтэй байдлын үнэлгээнд шууд нөлөөлснийг онцлох хэрэгтэй.

179. Үнэлгээний багийн үзэж байгаагаар ТС холбоотой хөрөнгө хурааж байгаагүй нь тус улсын эрсдэлийн төсөөлөлтэй зөрчилдөхөөргүй байна.

180. Хууль бусаар хил давуулж буй мөнгийг хурааж буй байдал нь Үнэлгээний багийн Монгол Улсын эрсдэлийн төсөөлөлтэй нийцэхгүй байна.

*Шууд Хэрэгжилт 8-ын ерөнхий дүгнэлт*

181. **Монгол Улс Шууд хэрэгжилт 8-ын үр дүнтэй байдлыг дундаж түвшинд хангаж байна.**

## БҮЛЭГ 4. ТЕРРОРИЗМЫГ БОЛОН ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ

### *Дүгнэлт ба авах арга хэмжээний зөвлөмж*

#### *Дүгнэлт*

##### *Шууд хэрэгжилт 9*

- Монгол Улс ТС эрсдэлд өртөх магадлал харьцангуй бага ажээ. Аль Каида, Талибан эсхүл Исламын улстай холбоотой үйл ажиллагаа Монгол Улсад бүртгэгдээгүй бөгөөд алан хядагчдыг бэлтгэх, хөлслөх, нутгаараа дамжин өнгөрүүлдэг улс орны тоонд Монгол Улс багтдаггүй байна. Монгол Улсад террорист халдлага буюу үйл ажиллагаа явуулж буй алан хядах бүлэг бүртгэгдээгүй ажээ.
- Монгол Улсын эрх бүхий байгууллагууд ТС эрсдэлийн талаар төдийлөн сайн ойлголтгүй ажээ. ҮЭҮ-нд ТС аюул занал, эрсдэлийг тодорхойлж шинжилсэн зүйл бараг байхгүй аж.
- Монгол Улс Терроризмтэй тэмцэх стратегийн хүрээнд ТС асуудлыг бодлогын түвшинд авч үзсэн зүйл алга. ТЕГ нь СМА-наас ирүүлсэн ТС холбоотой байж магадгүй 2 тохиолдлыг шалгажээ. Өөр шалгаж магадласан талаар буюу ТЕГ-ын ТС-ийг илрүүлэх хүчин чадлыг илтгэх мэдээ баримт бидэнд байхгүй болно.
- Монгол Улсад ТС-ийн зүйл ангиар ялласан тохиолдол байхгүй аж. ТС-ийн зүйл ангиар ял оногдуулах боломжгүй тохиолдолд ТС-ийг таслан зогсоох эрүүгийн, захиргааны, эрх зүйн бусад арга хэмжээ авагдсан зүйл байхгүй. Гэхдээ энэ нь улсын ТС эрсдэлийн төсөөлөлтэй нийцтэй байна.

##### *Шууд Хэрэгжилт 10*

- Монгол Улсын СЗХАХ-тэй холбоотой хууль тогтоомжид дунд зэргийн доголдол илэрч байна. Терроризмтой тэмцэх тухай хууль болон “Террорист этгээдийн жагсаалтад оруулах, жагсаалтад орсон этгээдийн хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох, хянах журам”-д хөрөнгө царцаах, хөрөнгө мөнгө ашиглуулахгүй байх, ББСБ болон СББМҮҮ нар битүүмжилсэн хөрөнгө, авсан арга хэмжээг тайлагнах шаардлагыг зөрчсөн этгээдийг шийтгэх заалт алга.
- СЗХАХ-ний хэрэгжилт санхүүгийн секторт харилцан адилгүй байгаа бол СББМҮҮ-ид үүнийг огт хэрэгжүүлдэггүй аж. Томоохон банкууд бүх хэрэглэгч болон гүйлгээг НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн террорист этгээдийн жагсаалттай автомат тулгалт хийдэг аж. Жижиг банкууд, томоохон ББСБ-ууд гараар хянадаг байна. Харин бусад МҮЭ-үүд ямар ч хяналт тавьдаггүй аж.
- Жагсаалттай таарсан тохиолдол гараагүй тул данс буюу гүйлгээ царцаасан тохиолдол бүртгэгдээгүй байна. Гэхдээ энэ нь СБ-уудын (томоохон банкуудыг эс тооцвол) хяналт султай холбоотой байж мэднэ.
- НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1267 эсхүл 1373 тогтоолын хоригийн жагсаалтад Монгол Улсаас оруулсан хувь хүн, хуулийн этгээд байхгүй аж. Гэхдээ энэ нь тус улсын ТС эрсдэлийн талаарх төсөөлөлтэй нийцтэй байна.

## БҮЛЭГ 4. ТЕРРОРИЗМЫГ БОЛОН ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ

- Ашгийн бус байгууллага (АББ)-ад хамаарах ТС эрсдэлийн талаарх Монгол Улсын ойлголт сул байна. АББ секторын эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй аж. АББ секторын хувьд засаглалтай холбоотой зохицуулалтын ерөнхий дэглэм үйлчилж байна.

### *Шууд хэрэгжилт 11*

- ҮОХЗДС-тэй холбоотой хориг арга хэмжээ нь Монгол Улсад нөлөөлж болох талтай. Учир нь Монголд БНАСАУ-ын иргэд хөдөлмөр эрхэлж байгаагаас гадна БНАСАУ-тай шууд холбоотой хэд хэдэн хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж байна. Монголын компаниуд БНАСАУ-ын төрийн өмчит компаниудад хувь эзэмшиж байсан буюу эзэмшиж байна. Монгол Улс сүүлийн үед БНАСАУ-ын хөлөг онгоцуудыг Монголын далбаан дор сэлэхийг хоригложээ.
- Иран, БНАСАУ-тай холбоотой СЗХАХ-г хэрэгжүүлэх хууль эрх зүйн тогтолцоо Монголд байхгүй байна.
- Монгол Улс ҮОХЗДС-тэй холбоотой хөрөнгө, мөнгө тодорхойлох зарим арга хэмжээ авчээ.
- ҮОХЗДС-тэй холбоотой хориг арга хэмжээ Монгол Улсад нөлөөлж болзошгүйг (тухайлбал, БНАСАУ-ын ажилчидтай холбоотойгоор) МҮЭ-үүд тодорхой түвшинд ухамсарлаж байна. Томоохон банкууд БНАСАУ-ын иргэдийн гүйлгээг СГТ-аар мэдээлдэг ажээ.

### *Хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж*

#### *Шууд хэрэгжилт 9*

- Монгол Улс ТС эрсдэлийг иж бүрнээр үнэлбэл зохино. Энэхүү үнэлгээг гүйцэтгэснээр МҮЭ болон төрийн байгууллагуудын ТС эрсдэлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх шаардлагатай.
- ТС эрсдэлийн үнэлгээг гүйцэтгэсний үндсэн дээр ТС тэмцэх үндэсний стратеги боловсруулбал зохино. Улмаар уг стратегийг холбогдох байгууллагуудын дотоод бодлого, сургалт, тэргүүлэх зорилго, үйл ажиллагаанд тусгаж, ТС-тэй тэмцэх хамтын ажиллагаа, уялдааг хангахад ашиглавал зохино.
- Хүний нөөц, хүчин чадлаа бэхжүүлж ТС-ийн үйл ажиллагааг таньж мэдэх, санхүүгийн мөрдөн шалгалтыг зохих түвшинд гүйцэтгэдэг болоход анхаарах хэрэгтэй.

#### *Шууд Хэрэгжилт 10*

- НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1267 ба 1373 тогтоолттой холбоотой хууль эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна. Ялангуяа хөрөнгө царцаах, хөрөнгө мөнгө ашиглуулахгүй байх, ББСБ болон СББМҮҮ нар битүүмжилсэн хөрөнгө, авсан арга хэмжээг тайлагнах шаардлагыг зөрчигсдөд гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, гэмт хэрэг давтан үйлдэхээс сэргийлэхүйц шийтгэл оногдуулах нь зүйтэй<sup>56</sup>.

<sup>56</sup> ХҮБ-ийн ажлын айлчлалын дараа Монгол Улс эдгээр дутагдлыг арилгах хууль тогтоомж баталсан болно.

## БҮЛЭГ 4. ТЕРРОРИЗМЫГ БОЛОН ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ

- ББСБ, СББМҮҮ нарт СЗХАХ-г танилцуулж, чиглэл өгөх нь зүйтэй. Ялангуяа, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1267 тогтоолын шинэчилсэн жагсаалтыг хаанаас олж авахыг зөвлөх нь зүйтэй.
- Шууд Хэрэгжилт 3-т дурьдсанчлан, хянан шалгагч нар СЗХАХ-тэй холбоотой зөрчил, дутагдал давтагдахгүй байх үр дүнтэй арга боловсруулж хориг арга хэмжээний биелэлтийг хангавал зохино.
- АББ-ын террорист үйл ажиллагаанд өртөж болзошгүй эрсдэл, эмзэг байдалд иж бүрэн дүн шинжилгээ хийвэл зохино. Энэхүү дүн шинжилгээнд үндэслэн АББ-уудад эрсдэлийг нь тайлбарлан ухуулахын сацуу эрсдэлтэй АББ-ын үйл ажиллагаанд хяналт тавибал зохино.

### *Шууд хэрэгжилт 11*

- Зөвлөмж 7-г бүрэн хэрэгжүүлэхүйц хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна. Ийм орчныг бүрдүүлмэгц Монгол Улс СЗХАХ-г хэрэгжүүлэх институт, үйл ажиллагаа, арга хэрэгсэл бүхий иж бүрэн тогтолцоог бий болгох шаардлагатай.
- ҮОХЗДС-тэй холбоотой асуудлыг тодорхой танилцуулж, чиглэл өгөх нь зүйтэй. СБ-ууд болон СББМҮҮ-дийн зүгээс хориг арга хэмжээг хэрэгжүүлэхэд нь бүх талын дэмжлэг үзүүлэх шаардлагатай.

182. Энэхүү бүлэгт үнэлэгдэж буй Шууд Хэрэгжилт нь ШХ 9-11 болно. Үр дүнтэй байдлын үнэлэлтэд хамаарах зөвлөмж нь 3.5-8 болно.

### *Шууд хэрэгжилт 9 (ТС мөрдөн шалгах ба шийдвэрлэх)*

*Улс орны эрсдэлийн онцлогийг харгалзан ТС үйл ажиллагааг шалган шийдвэрлэх нь*

183. ТЕГ нь ТС болон нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг (тухайлбал, терроризм)-ийг мөрдөн шалгах эрх бүхий байгууллага билээ. ТЕГ жил бүр Терроризмын аюул заналын үнэлгээг боловсруулдаг. Иймээс Монгол Улс терроризмын эрсдэлийн талаар тодорхой ойлголттой ажээ. Нөгөө талаас эрх бүхий байгууллагууд ТС талаар сайн мэдэхгүй байгааг Шууд хэрэгжилт 1-д дурьдсан. ҮЭҮ-нд ТС эрсдэл, эмзэг байдлыг тодорхойлж шинжилсэн зүйл бараг алга. Үүгээр зогсохгүй ҮЭҮ- д ТС-тэй холбоотой зарим дүгнэлтэд хэрхэн хүрсэн нь ойлгомжгүй байна (Шууд Хэрэгжилт 1).

184. Мэдээллийн эх сурвалж болон бүс нутгийн эрсдэлийг харгалзан үзвэл Монгол Улс ТС эрсдэлд өртөх магадлал харьцангуй бага байж болох талтай. Аль Каида, Талибан эсхүл Исламын улстай холбоотой үйл ажиллагаа Монгол Улсад бүртгэгдээгүй бөгөөд алан хядагчдыг бэлтгэх, хөлслөх, нутгаараа дамжин өнгөрүүлдэг улс орны тоонд Монгол Улс багтдаггүй байна. Монгол Улсад террорист халдлага буюу үйл ажиллагаа явуулж буй алан хядах бүлэг бүртгэгдээгүй ажээ.

185. Монгол Улсын хууль тогтоомжоор терроризмыг гэмт хэрэгт тооцно. ТС хэргээр хувь хүн, хуулийн этгээдийг яллан шийтгээгүй нь тус улсын талаарх эрсдэлийн төсөөлөлтэй нийцтэй байна.

## БҮЛЭГ 4. ТЕРРОРИЗМЫГ БОЛОН ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ

*ТС илрүүлж мөрдөн шалгах нь*

186. Тайлант хугацаанд, ТЕГ нь СМА-аас ирүүлсэн ТС холбоотой байж магадгүй 5 холбогдогчтой хоёр тохиолдлыг шалгажээ. Үүнээс, 2-ыг хэргийн бүрэлдэхүүнгүй хэмээн хаасан бол 3 дахь СГТ-г шалгах ажил үргэлжилж байна. Эдгээрээс өөр ТС-тэй холбоотой тохиолдол Монголд байхгүй гэх ойлголтыг бидэнд өгсөн. Дээрх СГТ-тай холбоотой эсвэл одоо шалгаж буй талаар ямар нэгэн мэдээлэл Монгол Улс гаргаж өгөөгүй болно.

187. Хуулийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагааны түвшинд ТС-ийг илрүүлж мөрдөн шалгаж буй зүйл алга. ТС хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах хүний нөөц Монголд байгааг илтгэх баримт бидэнд алга. Дүгнэн хэлэхэд, ТС болон түүнийг хэрхэн илрүүлж шалгах талаар Монгол Улс ойлголтгүй байна.

*ТС-ийг үндэсний стратеги, бодлогын салиггүй хэсэг болгох нь*

188. Монгол Улс Терроризмтэй тэмцэх стратегийн хүрээнд ТС-ийн асуудлыг авч үзэхгүй байна. ТЕГ нь терроризм, ТС-тэй тэмцэхэд тэргүүлэх үүрэгтэй ХАЗ-ийн гишүүн, ТГАЗЗ-ийг даргалагч байгууллага юм.

189. ТЕГ-ын төлөөлөлтэй хийсэн уулзалтаас терроризмтэй тэмцэх мөрдөн шалгалт нь ТС-ийг хамардаггүй болох нь тогтоогдсон билээ.

*Ял шийтгэл нь үр дүнтэй, зөрчилд нь дүйцэхүйц, урьдчилан сэргийлэхүйц эсэх нь*

190. Эрүүгийн хуулийн 178<sup>2</sup>-т хувь хүн ТС гэмт хэрэг үйлдэж гэм буруутай нь тогтоогдсон тохиолдолд эд хөрөнгийг хурааж, 5-12 жил хүртэл хугацаагаар хорихоор, харин хуулийн этгээд үйлдсэн бол тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх эрх хасаж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурван зуугаас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төгрөгөөр (29,000-48,500 ам. доллар) торгохоор заажээ.

191. Монгол Улсад ТС-ийн зүйл ангиар ялласан тохиолдол байхгүй аж.

*ТС гэмт хэргээр ял оногдуулах боломжгүй тохиолдолд өөр төрлийн арга хэрэглэх нь*

192. ТС-ийн зүйл ангиар ял оногдуулах боломжгүй тохиолдолд Монгол Улс Шууд Хэрэгжилт 9-ийг хангах үүднээс ТС-ийг таслан зогсоох эрүүгийн, захиргааны, эрх зүйн бусад арга хэрэгсэл ашигласан зүйл байхгүй аж. Гэхдээ энэ нь Монгол Улсын ТС эрсдэлийн төсөөлөлтэй зөрчилдөхгүй байна.

*Шууд хэрэгжилт 9-ийн ерөнхий дүгнэлт*

**193. Монгол Улс Шууд хэрэгжилт 9-ийн үр дүнтэй байдлыг доогуур түвшинд хангасан байна.**

## БҮЛЭГ 4. ТЕРРОРИЗМЫГ БОЛОН ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ

### *Шууд хэрэгжилт 10 (ТС- ээс урьдчилан сэргийлэх болон санхүүгийн хориг арга хэмжээ)*

*ТС эсрэг санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлэх нь*

194. Монгол Улсын терроризмын эсрэг авах СЗХАХ-ний хууль тогтоомжид буй доголдлыг дунд зэргийн гэж ангилж болох юм. СЗХАХ-г ТТ тухай хууль болон ТЭЖО журамд тусгасан байдаг. Гэвч хөрөнгө царцаах, хөрөнгө мөнгө ашиглуулахгүй байх, ББСБ болон СББМҮҮ нар битүүмжилсэн хөрөнгө, авсан арга хэмжээг тайлагнах шаардлага мөрдөгдөхгүй байна. Түүнчлэн террорист жагсаалтаас хасах, царцаасан хөрөнгийг чөлөөлөх процедурыг зохицуулсан зүйл алга. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1267 эсхүл 1373 тогтоолын хоригийн жагсаалтад Монгол Улсаас орсон хувь хүн, хуулийн этгээд байхгүй аж. Гэхдээ энэ нь тус улсын ТС эрсдэлийн талаарх төсөөлөлтэй нийцэхгүй гэсэн үг биш юм.

195. Монгол Улс СЗХАХ дараах байдлаар хэрэгжүүлдэг: НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1267 тогтоолын жагсаалтыг Монгол Улс дахь НҮБ-ын суурин төлөөлөгчийн газраас ГХЯ-аар дамжуулан ТЕГ-т хүргүүлнэ, ТЕГ-аас СМА-нд, СМА-наас холбогдох хянан шалгагч нарт болон МҮЭ-үүдэд хүргэнэ. Энэхүү үйл явцад 5-8 хоног зарцуулна. 2014 оны 5 дугаар сард ТЕГ нь СМА-аар дамжуулан бүх банкинд бичгээр хүргүүлсэн зөвлөмжид НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн жагсаалтыг шинэчлэгдсэн эсэхийг ТЕГ-ын цахим хуудаснаас байнга хянаж байхыг үүрэг болгожээ. Гэтэл СЗХ-оос өөрийн МҮЭ-үүдэд ийм үүрэг өгсөн зүйл байхгүй ажээ. Томоохон ББСБ-ууд ТЕГ-ын цахим хуудсанд хандаж тус жагсаалттай танилцдаг ажээ (дор үзнэ үү).

196. СБ-уудын НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1267 тогтоолын биелэлт харилцан адилгүй байна. Томоохон банкууд бүх хэрэглэгч болон гүйлгээг НҮБ-ын жагсаалттай автомат тулгалт хийж, жагсаалт шинэчлэгдсэн эсэхийг өдөр бүр хянадаг аж. Жижиг банкууд, томоохон ББСБ-ууд үүргээ тодорхой хэмжээнд ухамсарлаж шинэ харилцагчдыг жагсаалттай гар аргаар тулган шалгадаг аж. Харин бусад МҮЭ-ийн хувьд ойлголт сул, харилцагчид болон гүйлгээг хянадаггүй ажээ.

197. Монголбанк СЗХАХ-тэй холбоотой хэдэн зөрчил илрүүлсэн нь тодорхойгүй байна. Монголбанк 2016 онд гүйлгээ/данстай холбоотой үүрэг даалгавар 9 удаа өгсөн бол НҮБ-ын жагсаалттай тохирсон байж болзошгүй нэг СГТ ирүүлээгүй гэсэн үндэслэлээр 1 банкинд зөрчил арилгах үүрэг өгчээ. СЗХ-ны хувьд МУТСТ хяналт шалгалт төдийлөн хийдэггүй бөгөөд СЗХАХ-тэй холбоотой зөрчил илрүүлсэн эсэх нь тодорхойгүй байна. МУТСТ үүргийн зөрчилд Монголбанк, СЗХ хариуцлага тооцож мөнгөн торгууль оногдуулсан зүйл байхгүй аж (Шууд Хэрэгжилт 3-ыг үз).

*ТС холбоотой хөрөнгө болон хэрэгслийг хураах нь*

198. Томоохон банкуудын хувьд НҮБ-ын жагсаалттай тохирч данс, гүйлгээг царцаасан тохиолдол одоогоор гараагүй байна. Гэхдээ Шууд Хэрэгжилт 6-д дурьдсанчлан, үүнтэй холбоотой байж болзошгүй 3 СГТ-г мэдүүлсэн аж.

199. Бусад МҮЭ-ийн хувьд жагсаалттай таарч данс буюу гүйлгээ царцаасан тохиолдол гараагүй байна. Гэхдээ энэ нь ийм тохиолдол байхгүйтэй бус харин СБ-уудын хяналт сул байгаатай холбоотой байж мэднэ.

#### БҮЛЭГ 4. ТЕРРОРИЗМЫГ БОЛОН ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ

200. ТС мөрдөн шалгах, яллахтай холбоотой хөрөнгө царцаах, хураах явдлыг Шууд хэрэгжилт 8-д авч үзэв.

*Өндөр эрсдэлтэй АББ-уудыг хянах болон хамрах хүрээ*

201. Монголын АББ-ууд холбоо, сан, хоршоодын хэлбэртэй байна. Тухайн үед бүртгэлтэй 23,029, бүртгэлгүй тодорхойгүй тооны АББ байв. Бүртгэлтэй АББ-ын 10 хувь нь л үйл ажиллагаа явуулдаг мэдээ байна.

202. АББ-ын салбарт хамаарах ТС эрсдэлийн талаар Монгол Улс ойлголтгүй байна. Монгол Улс ФАТФ-ын тодорхойлолтод хамаарах АББ-уудыг тогтоогоогүй, эрсдэлтэй АББ-уудад эрсдэлийн үнэлгээ хийгээгүй, МУТС-тэй тэмцэх асуудлаар тэдний дунд сургалт зохиогоогүй аж.

203. АББ-уудын хувьд засаглалтай холбоотой зохицуулалтын энгийн дэглэм үйлчилж байна. Харин тэдэнд хяналт тавьж терроризм, ТС-ээс хол байлгах тогтолцоо алга. ОӨУБЕГ нь АББ-ын бүртгэлийн, харин ТаЕГ нь АББ-ын татварын асуудлыг зохицуулах ажээ. ОӨУБЕГ нь АББ-ын захирал, үүсгэн байгуулагч, ТУЗ, гүйцэтгэх удирдлага, актив хөрөнгө, үйл ажиллагаа, холбоо барих мэдээллийг бүртгэж АББ-ын үйл ажиллагааны тайланг жил бүр авдаг байна. Нөгөө талаас АББ хөрөнгөө хэрхэн босгож байгаа болон АББ-ыг хэн хянаж буйд хяналт тавьж буй зүйл алга. Түүнчлэн ОӨУБЕГ нь АББ-уудаас авч буй мэдээллийг байнга хянан магадлах тогтолцоо байхгүй аж.

204. ТЕГ, ЦЕГ нь зарим АББ-ад хяналт тавьдаг гэж байгаа ч ямар нэгэн мэдээ, баримт бидэнд гаргаж өгөөгүй болно.

205. Ерөнхийдөө, Монгол Улс эрсдэлтэй АББ-ыг тогтоож, тэдэнтэй тулж ажиллаж, хяналт тавьж чадахгүй байна. Монгол Улс АББ-уудаа терроризм, ТС-ээс ангид байлгаж, тэднийг ийм үйл ажиллагааны золиос болохоос сэргийлж чадаж буйг нотлох зүйл алга. АББ-ууд ТС эрсдэлд өртөж болзошгүйг ойлгож ухамсарлахгүй байна.

*Арга хэмжээ нь улс орны ТС эрсдэлтэй уялдаж буй эсэх*

206. Томоохон банкуудын НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1267 дугаар тогтоолын СЗХАХ-ний хэрэгжилт Монголын ТС эрсдэлийн төсөөлөлтэй нийцтэй байна. Харин санхүүгийн салбарын маш бага хувийг бүрдүүлэх бусад МҮЭ-үүдийн хувьд СЗХАХ-ний хэрэгжилт Монголын ТС эрсдэлийн төсөөлөлтэй нийцэхгүй байна.

207. Жагсаалттай таарсан тохиолдол гараагүй тул данс буюу гүйлгээ царцаасан тохиолдол бүртгэгдээгүй байна. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1267 эсхүл 1373 тогтоолын хоригийн жагсаалтад Монгол Улсаас оруулсан хувь хүн, хуулийн этгээд байхгүй аж. Гэхдээ энэ нь тус улсын ТС эрсдэлийн талаарх төсөөлөлтэй нийцгүй гэсэн үг биш юм.

208. АББ-ын секторын ТС эрсдэлийн талаарх ойлголт муу, хяналт шалгалт байхгүй, техник нөхцөл сул дорой байгаа нь эрсдэлтэй АББ-уудад санаа зовниход хүргэж байна.

*Шууд хэрэгжилт 10-ын ерөнхий дүгнэлт*

**209. Монгол Улс Шууд хэрэгжилт 10-ын үр дүнтэй байдлыг доогуур түвшинд хангаж байна.**

## БҮЛЭГ 4. ТЕРРОРИЗМЫГ БОЛОН ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ

### *Шууд хэрэгжилт 11 (ҮОХЗДС эсрэг хориг арга хэмжээ)*

*ҮОХЗДС эсрэг СЗХАХ-г нэн яаралтай хэрэгжүүлэх нь*

210. ҮОХЗДС эсрэг хориг арга хэмжээ нь Монгол Улсад нөлөөлж болзошгүйг Бүлэг 1-д өгүүлсэн. Монголд хөдөлмөрлөж байгаа 1,500 БНАСАУ-ын иргэд хоёр улсын хооронд байгуулсан гэрээ хэлцлийн дагуу цалинждаг ажээ. Гадаадад ажиллаж буй БНАСАУ-ын иргэдийн цалингийн тодорхой хувийг засгийн газар нь суутгадаг судалгаа байна<sup>57</sup>. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй хэд хэдэн хуулийн этгээд нь БНАСАУ-тай шууд холбоотой ба Монголын компаниуд БНАСАУ-ын төрийн өмчит компаниудад хувь эзэмшиж байсан буюу эзэмшиж байна<sup>58</sup>. Энэхүү нөхцөл байдал нь дараахь байдлаар илэрч байна: (i) 2010-2015 оны хооронд 177 СГТ БНАСАУ-ын иргэдтэй холбоотой байв, (ii) 2012 оны 2 дугаар сард СМА-наас банкуудад албан тоот хүргүүлж олон улсын анхаарлын төвд байгаа улс орнууд (тухайлбал, БНАСАУ)-ын зүгээс Монгол Улсын үл хөдлөх эд хөрөнгө, уул уурхай, банкны секторт мөнгө угааж болзошгүйг анхааруулжээ. Түүнчлэн, Монгол Улс сүүлийн үед БНАСАУ-ын хөлөг онгоцуудыг Монголын далбаан дор сэлэхийг хоригложээ.

211. Монгол Улс НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1267 тогтоолыг хэрэгжүүлж буй хүрээнд ҮОХЗДС-тэй тэмцэх асуудлыг авч үзэх боломжтой гэж байв. Гэвч энэ бол бүтэшгүй зүйл юм. Иймээс Монгол Улс Иран ба БНАСАУ-ын эсрэг СЗХАХ-тэй холбоотой НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1718, 1737, 1803, 1874 ба 1929 тогтоолыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн тогтолцоогүй гэж бид дүгнэж байна.

212. Ямартаа ч Монгол Улс ҮОХЗДС-ийн эсрэг хатуу байр суурьтай байна. Монгол Улс Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээ (1969), Бактериологийн болон хорт зэвсэг нөөцлөх, үйлдвэрлэх, хөгжүүлэхийг хориглох болон тэднийг устгах конвенц (1972), Химийн зэвсэг хэрэглэх, нөөцлөх, үйлдвэрлэх, хөгжүүлэхийг хориглох болон тэднийг устгах конвенц (1995), Цөмийн туршилтыг бүрэн хориглох гэрээ (1997), Цөмийн материалын биет хамгаалалтын тухай конвенцид (1987) нэгдэн орсон билээ. ҮОХЗД-ийг үйлдвэрлэх, эзэмших, баяжуулах, тээвэрлэх, санхүүжүүлэхийг хориглохын тулд Монгол Улс Химийн хорт бодисоос хамгаалах тухай хууль (1995), Цөмийн зэвсгээс ангид байх тухай хууль (2000), Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль (2006), Цөмийн энергийн тухай хууль (2009), Эрүүгийн хууль (2002)-ийг тус тус баталжээ. Эрүүгийн хуулийн дагуу Монгол Улсын нэгдэн орсон химийн, биологийн болон бусад үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг олон улсын гэрээ хэлэлцээрээр хориглосон үйл ажиллагааг эрүүгийн гэмт хэрэгт тооцно. ҮОХЗД-тэй холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг хөрөнгө босгох, шилжүүлэх, ашиглах явдлаас ангид байлгах зорилгоор дээрх хуулиудыг хэрэглэж ирснийг нотлох баримт Монгол Улс гаргаж өгөөгүй болно.

*Жагсаалтад бүртгэлтэй хувь хүн, хуулийн этгээдийн хөрөнгө, мөнгийг илрүүлэх, хориглох*

213. Монгол Улсад ҮОХЗДС-ийн эсрэг НҮБ-ийн Аюулгүйн Зөвлөлийн тогтоолыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн тогтолцоо дутагдаж байгаа ч томоохон банкууд НҮБ-ын

<sup>57</sup><http://www.wsj.com/articles/north-koreas-lucrative-labor-exports-come-under-pressure-1467916815>;

<https://www.nknews.org/pro/mongolia-enforces-latest-sanctions-on-north-korean-ships/>

<sup>58</sup> <http://koreajoongangdaily.joins.com/news/article/article.aspx?aid=3016554>

#### БҮЛЭГ 4. ТЕРРОРИЗМЫГ БОЛОН ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ

нэгдсэн жагсаалттай тулгалт хийдэг байна. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1718 тогтоолын жагсаалтад хамаарах хувь хүн, хуулийн этгээдийн хөрөнгө мөнгө илэрсэн тохиолдол одоогоор бүртгэгдээгүй байна. Гэхдээ илэрлээ гэхэд банкууд ийм хөрөнгө, мөнгийг царцаах хуулийн заалт байхгүй аж.

214. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1718, 1874 тогтоолыг хэрхэн мөрдөж, хэрэгжүүлж буйг Монгол Улс тайлагнах үүрэг хүлээсний дагуу Монголбанк 2010 онд банкуудад албан тоот хүргүүлэн тэдний БНАСАУ-тай холбогдох эдийн засаг, банк, санхүүгийн харилцааны талаар мэдээлэл ирүүлэхийг хүсчээ. Энэхүү ажлын үр дүнг бидэнд танилцуулаагүй болно.

215. Түүнчлэн 2012 онд СМА нь БНАСАУ-ын иргэд, хуулийн этгээдтэй холбоотой гүйлгээг хянаж, сар бүр СМА-д тайлагнаж байхыг банкуудаас хүсчээ. Энэхүү хүсэлтийг банкууд хэрхэн биелүүлсэн нь тодорхойгүй байна. Гэхдээ банкууд өндөр эрсдэлтэй улс орнууд (тухайлбал, БНАСАУ)-ын СГТ-г мэдүүлж байгаа аж. 2010 оноос хойш БНАСАУ-ын иргэдтэй холбоотой 177 СГТ байна. Шууд хэрэгжилт 6-д дурьдсанчлан, эдгээр тайланг ТЕГ-т шилжүүлжээ. Харамсалтай нь ТЕГ-аас үүнийг хэрхсэн талаар тайлбарлаагүй болно.

216. Дээр жагсаалтад бүртгэлтэй хувь хүн, хуулийн этгээдийн хөрөнгө, мөнгийг илрүүлэх зохицуулалтын талаар дурьдсан. Тэгвэл Монгол Улс НҮБ-ын жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдийг (эсхүл тэдний нэрийн өмнөөс ажиллаж буй хүмүүс) гүйлгээ хийх шатанд илрүүлж чадахыг илтгэх баримт бидэнд алга байна.

*СБ-ууд, СББМҮҮ нарын үүргээ ухамсарлаж, биелүүлж буй байдал*

217. Монгол Улс ҮОХЗДС-тэй холбоотойгоор СЗХАХ-г хэрэгжүүлэх хууль тогтоомжгүй ажээ. Гэсэн ч томоохон банкууд, ББСБ-ууд хориг арга хэмжээ нь Монгол Улсад нөлөөлж болзошгүйг гадарлаж байгаа (ялангуяа, БНАСАУ-ын ажилчидтай холбоотойгоор) бөгөөд томоохон банкууд БНАСАУ-ын иргэдтэй холбоотой СГТ мэдүүлж байна. Бусад СБ, СББМҮҮ-ид энэ асуудлаар ойлголтгүй ажээ.

*Хэрэгжилтэд хяналт тавьж буй эрх бүхий байгууллагууд*

218. Монголбанк, СЗХ, СМА нар газар дээрх болон зайны МУТСТ хяналт шалгалт хэрэгжүүлдэг ч (Шууд Хэрэгжилт 3) Монгол Улсад ҮОХЗДС-хтэй холбоотой СЗХАХ хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдээгүй байна.

*Шууд хэрэгжилт 11-ийн ерөнхий дүгнэлт*

**219. Монгол Улс Шууд Хэрэгжилт 11-ийн үр дүнтэй байдлыг доогуур түвшинд хангаж байна.**

## БҮЛЭГ 5. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

### *Дүгнэлт ба хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж*

#### **Дүгнэлт**

- МУТСТ үүрэг хариуцлага, МУТС-ийн эрсдэл, түүнийг бууруулах арга замын талаарх ойлголт санхүүгийн салбарт харилцан адилгүй түвшинд байна. Томоохон банкуудын МУ эрсдэлийн талаарх ойлголт жижиг банкуудтай харьцуулахад боломжийн түвшинд байна. Харин томоохон ББСБ-уудын ойлголт томоохон банкуудтай харьцуулахад арай дутуу байх жишээтэй. Жижиг ББСБ-ууд, даатгалын компаниуд, үнэт цаасны зах зээлд оролцогчид, хөрөнгө оруулалтын сангууд, ХЗХ-дын МУ эрсдэлийн талаарх ойлголт чамлалттай түвшинд байна. Тэгвэл СБ-уудад ТС эрсдэлийн тухай ойлголт үндсэндээ байхгүй ажээ.
- СБ-ууд Монгол Улсын МУТС эрсдэлийг бүрэн ухаарч түүнийг удирдах дотоод хяналтын системийг бүрдүүлж амжаагүй байна. Энэ нь дараахь шалтгаантай: (i) эрсдэлийн үнэлгээ хийх шаардлагыг тусгасан УСЖ дөнгөж 2016 оны 6 дугаар сард батлагдсан, (ii) биднийг Монголд ажиллах үеэр л ҮЭҮ-г эцэслэж МҮЭ-үүдэд түгээсэн, (iii) МУТСТ хяналт, шалгалт хангалттай түвшинд хийгдэхгүй байгаа явдал.
- СБМҮҮ-ид болох үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллагууд болон нотариатууд ҮЭҮ, МУТС эрсдэлийн талаар ойлголтгүй, МУТСТ тухай хууль болон УСЖ-аар хүлээх үүрэг үүрэг хариуцлагаа ухамсарлаж буй зүйл алга. Иймээс тэд МУТС эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаггүй ажээ. Зөвхөн нотариатчдад л МУТС-тэй тэмцэх үүрэг хариуцлага хүлээлгэх боломжтой байна.
- 2011 оноос 2016 оны 10 дугаар сарын хүртэл МҮЭ-үүдээс ердөө 1,006 СГТ мэдүүлсэн бол СБМҮҮ-ид нэг ч СГТ мэдүүлээгүй байна. СГТ мэдүүлж буй байдал ҮЭҮ-д өгүүлсэн МУТС-ийн эрсдэлийг төлөөлж чадахгүй байна.

#### ***Хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж***

- Хянан шалгагч нар МҮЭ-үүдийн МУТС эрсдэлийн талаарх ойлголтыг нэн даруй нэмэгдүүлбэл зохино. МУТСТ хууль тогтоомжийг мөрдөж, эрсдэлийг бууруулахын тулд дараахь арга хэмжээ авах: (i) салбарын ассоциациуд болон салбарын журам, стандартыг боловсруулж, мөрдүүлэх байгууллагуудын дэмжлэгийг авах, (ii) салбар салбараар тусгайлсан удирдамж чиглэл дараах чиглэлээр гаргах: (a) ЭСА, ҮЭҮ-тэй холбоотойгоор МҮЭ-дээс хүлээгдэж буй зүйлс, (b) ЭӨ-ийн үүрэг хариуцлага, (c) УТНБЭ-ийн үүрэг хариуцлага, (d) ТС эрсдэлийг тодорхойлж бууруулах.
- МҮЭ-үүд МУТСТ эрсдэл, үүрэг хариуцлагаа ухаарч илүү идэвхи санаачилгатай байвал зохино. МҮЭ-үүд харилцагчидтай тулж ажиллаж буй ажилтнууд, комплаенс хариуцсан удирдлага болон ажилтнууддаа тогтмол сургалт зохион байгуулвал зохино.
- СБМҮҮ-дийн МУТС эрсдэлийг харгалзан үзэж МУТСТ хууль тогтоомжид үл хөдлөх хөрөнгийн зуучлагч, үнэт металл арилжаалагчид, нягтлан бодогч, хуульч нарыг хамруулбал зохино.
- СМА-наас МҮЭ-үүдэд СГТ мэдүүлэхэд нь дэмжлэг, чиглэл өгвөл зохино. Тухайлбал, СМА нь банкнаас бусад СБ-ууд, СБМҮҮ нарт СГТ-ийн жишээ хүргүүлж, ямар

## БҮЛЭГ 5. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

тохиолдолд сонор сэрэмжтэй байж СГТ-аар мэдээлэхийг зөвлөж болох юм.

■ МУТСТ хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулахын тулд зохицуулагчдын зүгээс МҮЭ-дэд хүлээлгэх хариуцлагыг үр дүнтэй, гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, зөрчил давтагдахаас сэргийлэхүйц байлгахад анхаарвал зохино (Шууд Хэрэгжил 3).

220. Энэхүү бүлэгт Шууд хэрэгжилт 4-ийг авч үзэж үнэлэв. Энэ хэсгийн үр дүнтэй байдлын үнэлгээнд Зөвлөмж 9-23 хамаарна.

### *Шууд хэрэгжилт 4 (Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа)*

221. СБ-ууд, СББМҮҮ, МУТСТ хууль тогтоомжийг Бүлэг 1-д авч үзсэн тул энэхүү бүлэгт эдгээр асуудлыг давтахгүй болно.

222. Монголын санхүүгийн салбарт банкууд нийт активын 95.7%-ийг бүрдүүлэн давамгайлж байна. Түүнчлэн 450 ББСБ, 253 ХЗХ, 17 хөрөнгө оруулалтын сан, үнэт цаасны зах зээлд оролцогчид, 17 даатгалын компани үйл ажиллагаа явуулж байна. 14 арилжааны банкны хамгийн том 3 банк нь банкны салбарын 70%-ийг буюу 20.8 их наяд төгрөг (11.8 тэрбум ам/доллар)-ийг бүрдүүлж байна. 2016 оны 10 дугаар сарын байдлаар активын 4%-ийг бүрдүүлдэг 4 банк хязгаарлагдмал үйл ажиллагаа явуулж, харин нэг банк үйл ажиллагаагаа зогсоогоод байгаа тухай Монголбанк мэдэгдсэн.

223. Монгол Улсад гадаадын банк үйл ажиллагаа явуулдаггүй ажээ.

224. 2016 оны 6 дугаар сард УСЖ баталж ЭСА нэвтрүүлснээр Монгол Улсын урьдчилан сэргийлэх тогтолцоог ФАТФ-ын стандартад дөхүүлэх алхам болов. Ингэснээр Монгол Улс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 1 зөвлөмжийг бүрэн биелүүлсэн, 8 зөвлөмжийн дийлэнхийг биелүүлсэн гэсэн үнэлгээ авч байна.

*МУТС эрсдэл, түүнтэй тэмцэх үүрэг хариуцлагыг ойлгож эрсдэл бууруулах арга хэмжээ авах*

### *Санхүүгийн салбар*

225. МУТС-ийн эрсдэл, түүнтэй тэмцэх үүрэг хариуцлага, эрсдэлийг бууруулах арга замын тухай ойлголт санхүүгийн салбарт харилцан адилгүй түвшинд байна. Үүнд дараах хүчин зүйлс нөлөөлөв: (i) МУТСТ хуульд урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн тусгаагүй, (ii) эрсдэлийн үнэлгээ хийх үүргийг тусгасан УСЖ-ыг дөнгөж 2016 оны 6 дугаар сард батлав, (iii) МУТСТ хяналт шалгалт тэр болгон хийгдэхгүй байна, (iv) биднийг Монголд ажиллах үеэр л ҮЭҮ-г эцэслэж СБ-ад хүргүүлсэн.

226. Томоохон банкууд жижиг банкуудыг бодвол МУ эрсдэлийн талаар илүү ойлголттой ажээ. Гэвч энэхүү ойлголт нь харилцагчдын МУ эрсдэлээр хязгаарлагдаж байна. Угтаа бол МУ эрсдэлд байгууллагын хэмжээ, бүтэц, засаглал, бүтээгдэхүүн, үйлчилгээ, гүйлгээ, түгээлтийн суваг, ҮЭҮ-ний үр дүн болон бусад эрсдэлийн үнэлгээг авч үзсэн байх ёстой. 2016 онд Монголбанкны газар дээрх хяналт шалгалтаар нэг том банк МУТС-ийн эрсдэлийн үнэлгээг хэсэгчлэн биелүүлсэн нь дээрх дүгнэлтийн нотолгоо юм. Томоохон банкууд Монгол Улсын МУТС аюул занал, эзмэг байдал эргээд тэдний МУТС эрсдэлийн үнэлгээнд хэрхэн нөлөөлснийг тэр болгон ойлгохгүй байгаа нь ҮЭҮ саяхан гарсантай мөн холбоотой.

## БҮЛЭГ 5. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

227. 450 ББСБ-ууд нийт санхүүгийн активын ердөө 2.77% буюу 623.2 тэрбум төгрөгийг (258 сая ам.доллар) бүрдүүлж буй ч зээл, валютын арилжаа, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга зэрэг олон төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг ажээ. Ерөнхийдөө, ББСБ-ууд МУ эрсдэлийн талаар үндсэндээ ойлголтгүй байна. Томоохон ББСБ-уудын МУ эрсдэлийн талаарх бага сага ойлголт нь ААН-ийн түвшинд бус харин харилцагчдын түвшинд байна.

228. Жижиг ББСБ-ууд, даатгалын компаниуд, үнэт цаасны зах зээлд оролцогчид, хөрөнгө оруулалтын сангууд, ХЗХ-д ҮЭҮ-ний талаар сонссон ч МУ эрсдэлийнхээ талаар ойлголтгүй байна.

229. Томоохон банкууд СЗХАХ-ний талаар боломжийн ойлголттой байгаа ч (дор үз) бусад СБ-ууд ТС-ийн эрсдэлээ ухаарахгүй байна. Энэ нь ҮЭҮ-нд Монгол Улсын ТС-ийн аюул занал, эмзэг байдлыг бараг авч үзээгүй (Шууд хэрэгжилт 1), ТС-ийн асуудлыг санхүүгийн салбарынханд ойлгуулж тайлбарлахгүй байгаатай мөн холбоотой.

230. МУТСТ үүрэг хариуцлага, эрсдэлийг бууруулах арга замын талаарх ойлголт санхүүгийн салбарт харилцан адилгүй байна. Жижиг банкуудыг бодвол томоохон банкууд МУТСТ үүрэг хариуцлага, УСЖ-ын шинэ шаардлагын талаар илүү ойлголттой аж. Томоохон банкуудын МУ эрсдэлийг бууруулах арга хэмжээ нь харилцагчдын МУ эрсдэлтэй нийцтэй байна. Нөгөө талаас эдгээр банк нь Монгол Улсын өндөр эрсдэлтэй суурь гэмт хэргүүдтэй тэмцэхүйц арга хэрэглэж чадахгүй байна. Банкууд СББМҮҮ-дийн “харуулын” үүрэг гүйцэтгэдгийн хувьд СББМҮҮ-дийн зүгээс (ялангуяа үл хөдлөх хөрөнгийн зуучлагч) үүсч болох МУ эрсдэлийг бууруулах арга хэрэгсэлгүй байна.

231. ББСБ-ууд, даатгалын компаниуд, үнэт цаасны зах зээлд ороцогчид, хөрөнгө оруулалтын сангууд болон ХЗХ-оод МУТСТ үүрэг хариуцлагаа ойлгохгүй байгаагийн дээр эрсдэлээ бууруулахад анхаарч буй зүйл алга.

### *СББМҮҮ-ид*

232. СББМҮҮ-ид (ялангуяа үл хөдлөх хөрөнгийн зуучлагчид, нотариатууд) ҮЭҮ-ний талаар сонсоогүй, МУТС эрсдэлээ ойлгохгүй, МУТСТ хууль, УСЖ-аар хүлээсэн үүрэг хариуцлагаа ухамсарлахгүй байна. Иймээс тэдэнд МУ эрсдэлээ бууруулахад анхаарч буй зүйл алга. МУТСТ хариуцлагыг зөвхөн нотариатуудад хүлээлгэх боломжтой аж. СББМҮҮ нарыг хянаж шалгасан зүйл байхгүй тул тэдний МУТСТ үүрэг хариуцлагаа ухамсарлаж, эрсдэлээ бууруулж буй нь тодорхойгүй байна.

### *Харилцагчийг таньж мэдэх, мэдээлэл хадгалах*

233. МҮЭ-үүд ХТМ, мэдээлэл хадгалах үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлж буйг илтгэх тоо статистикийг Монгол Улс гаргаж өгөөгүй болно.

### *Санхүүгийн салбар*

234. ХТМ үйл ажиллагаа санхүүгийн салбарт харилцан адилгүй байна. Банкууд болон томоохон ББСБ-ууд ХТМ талаар ойлголттой ажээ. Гэхдээ зөвхөн томоохон банкууд, ББСБ-ууд шинэ харилцагчдыг эрсдэлээр нь ангилах ажээ. Томоохон банкууд болон ББСБ-ууд харилцагчийн данс нээлгүүлэхдээ өгсөн мэдээлэлд (тухайлбал хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчид, УТНБЭ болон хөрөнгийн эх үүсвэр) тулгуурлан бага, дунд, өндөр эрсдэлтэй харилцагч гэж ангилдаг байна. Улмаар өндөр эрсдэлтэй харилцагчдын хувьд ХТМ үйл ажиллагааг өргөтгөсөн байдлаар хийдэг ажээ. Харин ХТМ-

## БҮЛЭГ 5. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

дээ олж авсан мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг баталгаажуулдаг нь тодорхойгүй байна.

235. Харилцагчдын үргэлжлүүлэн хянах үйл явц банкууд болон томоохон ББСБ-уудын дунд харилцан адилгүй байна. Үргэлжлүүлэн хянах үйл явц 0.5-2 жилийн зайтай хэрэгжих тул банкууд болон ББСБ-ууд эрсдэлд суурилсан ХТМ үйл ажиллагааг хэрэгжүүлж буй нь тодорхойгүй байна.

236. Монголбанк газар дээрх шалгалтаар ХТМ зөрчлүүдийг илрүүлж засах үүрэг даалгавар өгчээ (Хүснэгт 17). Харин СЗХ-ноос СБ-уудын ХТМ зөрчилтэй холбоотой ямар нэгэн мэдээллийг гаргаж өгөөгүй болно.

### Хүснэгт 17: ХТМ зөрчлийг арилгах үүрэг даалгавар

| Үүрэг даалгаврын төрөл     | 2014 | 2015 | 2016 |
|----------------------------|------|------|------|
| ХТМ ерөнхий шаардлага      | 1    | 0    | 2    |
| ЭӨ-ийг таньж мэдэх, шалгах | 0    | 2    | 9    |
| ХТМ өргөтгөсөн процедур    | 10   | 2    | 0    |

237. Жижиг ББСБ, даатгалын компаниуд, үнэт цаасны захын компаниуд, хөрөнгө оруулалтын сангууд болон ХЗХ-оод өөрийн гэсэн ХТМ процедурыг дагадаг ба цуглуулсан мэдээлэл нь шаардлага хангахааргүй байна. Эдгээр СБ нь хувь хүн, хуулийн этгээд болон гадаадын эрх зүйн зохицуулалтын<sup>59</sup> хувьд өргөтгөсөн ХТМ ажлыг гүйцэтгэдэг эсэх нь тодорхойгүй байна. Түүнчлэн хөрөнгийн эх үүсвэр, бизнесийн хамаарлын зорилго мөн чанарыг шалгадаггүй ажээ. Хувь хүний хувьд иргэний үнэмлэх нь таньж мэдэх, шалгах чухал хэрэгсэл болно. Эдгээр СБ-ууд арилжааны банкуудад найддаг, банкууд тэдний хувьд “харуулын” үүрэг гүйцэтгэдэг, банкны дансаар дамжсан мөнгөний гарал үүслийг нягтлаад байдаггүйг бидэнд хэлж байв. Эдгээр СБ-ууд харилцагчдын эрсдэлийг ангилдаггүй, үргэлжилсэн хяналт тавьдаггүй ажээ.

238. Хуулийн этгээд, гадаадын эрх зүйн зохицуулалт болох харилцагчдын хувьд СБ-ууд ОӨУБЕГ-ын мэдээлэлд (тухайлбал бүртгэлийн сертификат, компаний дүрэм) найдлага тавьдаг аж. Салбаруудын ЭӨ-ийн талаарх ойлголт харилцан адилгүй байна. Томоохон банкууд болон ББСБ-уудын хувьд хуулийн этгээд нь өөр хуулийн этгээдийг эзэмшдэг аль эсвэл нэг хувь хүн нөгөө хувь хүнийг төлөөлж буй тохиолдолд ЭӨ-ийг таньж мэдэх нь хүндрэлтэй байдаг ажээ.

239. Зарим СБ биечлэн данс нээхийг шаардаг бол заримынх нь хувьд нотариатаар баталгаажуулсан иргэний үнэмлэхийн хуулбар байхад хангалттай аж. Өөрөөр хэлбэл, СБ-ууд харилцагчийг таньж мэдэхдээ нотариатчдад найддаг нь харагдаж байна. Харин нотариатчид ХТМ үүргийг бүрэн хэрэгжүүлдэггүй, хяналт шалгалтад хамрагддаггүй тул СБ-ууд эрсдэлийг бууруулах зохих аргууд хэрэглэж буй нь эргэлзээтэй ажээ.

<sup>59</sup> Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу экспресс траст, аль эсвэл үүнтэй адил бүтэц, чиг үүрэгтэй хуулийн зохицуулалтыг байгуулах боломжгүй (нэгдүгээр бүлгийг үз).

## БҮЛЭГ 5. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

240. Бүх СБ-ууд хуулийн дагуу мэдээллийг 5 жилийн турш хадгалах үүрэгтэй. Хянан шалгагч болон ХСБ-уудаас авсан мэдээллээр бол тус үүргийн биелэлт сайн байгаа бөгөөд мөрдөн шалгах ажлын шаардлагыг хангадаг аж.

241. ХТМ явц дутуу байснаас шинэ бизнестэй харилцаа үүсгэхээс татгалзсан, аль эсвэл хуучин харилцагчтай хамтран ажиллахаас татгалзсан жишээг Монгол Улс гаргаж өгөөгүй болно. Тэгсэн хэрнээ ҮЭҮ-нд өгүүлснээр 2010-2015 онд мэдээлэл дутуу, үнэн бус буюу гаргаж өгөөгүй гэсэн шалтгаанаар СБ-ууд 14 СГТ мэдүүлсэн ажээ.

### *СББМҮҮ-ид*

242. СББМҮҮ-ид МУТСТ хяналт, шалгалтад хамрагддаггүй тул ХТМ, мэдээлэл хадгалах шаардлага хэрэгждэг эсэх нь тодорхойгүй аж. Үл хөдлөх хөрөнгийн зуучлагчид болон нотариатчид МУТСТ хуулийн талаар сонссон ч ХТМ үүргийг бүрэн хэрэгжүүлдэггүй, банкуудад найддаг тухайгаа ярьж байв. Тэд МУТСТ үүрэг, МУТС-ийн эрсдэлээ ухаарсны үндсэн дээр бус харин ёс төдий байдлаар ХТМ үйл ажиллагааг хэрэгжүүлдэг ажээ.

### *ХТМ өргөтгөсөн арга хэмжээ*

#### *Санхүүгийн сектор*

243. Санхүүгийн салбар дахь өргөтгөсөн ХТМ процедурын хэрэгжилт харилцан адилгүй байна. Томоохон банкууд, ББСБ-ууд ямар нэгэн байдлаар өргөтгөсөн ХТМ процедурыг ашиглаж байхад бусад СБ-ын хувьд нөхцөл байдал өөр ажээ:

- *УТНБЭ* –УТНБЭ-тэй холбоотой удирдамж, чиглэл МҮЭ-үүдэд хүрээгүй болно. Банкууд болон томоохон ББСБ-ууд УТНБЭ-үүдийн жагсаалтыг өөрсдөө боловсруулсан, харин гадаадын УТНБЭ-ийн мэдээллийг арилжааны мэдээллийн сангаас авдаг гэж байв. Гэтэл СБ-ууд УТНБЭ-ийг ямар түвшинд таньж мэдэж буйг дараахь баримт өгүүлнэ: (i) ҮЭҮ-нд дурдсанаар 5 банк УТНБЭ-ийг таньж мэдэх ажлыг гүйцэтгээгүй аж; (ii) 2016 онд Монголбанк УТНБЭ-тэй холбоотой ХТМ зөрчлийг арилгах 9 удаагийн шаардах хуудас хүргүүлжээ.
- Хянан шалгагч нар УТНБЭ, тэдний гэр бүлийн гишүүд, хамааралтай этгээдүүдийг бүгдийг таньж мэдэх нь хүндрэлтэй гэж байв.
- *Корреспондент банкны харилцаа* – корреспондент банкны харилцаанд тавигдах шаардлагын талаарх мэдлэг хангалттай түвшинд байна. Корреспондент банкны харилцаа нь МУТСТ хатуу чанд шаардлагатай гадаад улс орнуудыг хамарч байна. Корреспондент банкны харилцааг тогтоохдоо Монголын банкууд тухайн банкны МУТСТ бодлого, дүрэм, хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээллийг хүсдэг ажээ. Томоохон банкууд корреспондент банкны харилцааг тогтоох зорилгоор мэдээллийн сан буюу системд нэвтрэх эрхийг захиалдаг ажээ.
- *Шинэ технологи* – зарим банк интернет банкны үйлчилгээ зэрэг шинэ технологийг хөгжүүлж байгаа ч МУТС эрсдэлийн үнэлгээг эхлээд хийсэн эсэх, хийсэн бол илрүүлсэн эрсдэлийг бууруулах арга хэмжээ боловсруулсан эсэх нь тодорхойгүй байна. 2015 онд Монголбанк шинэ бүтээгдэхүүн, технологитой холбоотой зөрчлийг арилгах 12 үүрэг даалгавар гаргажээ.

## БҮЛЭГ 5. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- *Мөнгөн гуйвуулга* – томоохон банкууд мөнгөн гуйвуулгад тавих шаардлагыг мэдэж байна. Гуйвуулга шилжүүлэгч болон хүлээн авагчийн талаарх мэдээллийг автоматжуулсан системийн тусламжтайгаар авч байгаа бөгөөд эс бөгөөс гүйлгээ хийгдэхгүй болно.
- Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ явуулдаг 12 ББСБ-ын хувьд өргөтгөсөн ХТМ арга хэмжээ хэрэгжүүлэх зохицуулалтууд байгаа эсэх нь тодорхойгүй байна.
- *ТС-тэй холбоотой СЗХАХ* – Шууд Хэрэгжилт 10-т өгүүлсэнчлэн, томоохон банкууд бүх хэрэглэгч болон гүйлгээг НҮБ-ын жагсаалттай автомат тулгалт хийж, жагсаалт шинэчлэгдсэн эсэхэд өдөр бүр хяналт тавьдаг аж. Жижиг банкууд, томоохон ББСБ-ууд үүргээ тодорхой хэмжээнд ухамсарлаж шинэ харилцагчдыг жагсаалттай гар аргаар тулган шалгадаг аж. Харин бусад МҮЭ-ийн хувьд ойлголт сул, харилцагчид болон гүйлгээг хянадаггүй ажээ.
- *ФАТФ-аас өндөр эрсдэлтэй хэмээн тодорхойлсон улс орнууд* – Томоохон банкууд болон ББСБ-ууд эрсдэл өндөр улс орнуудыг, тухайлбал Иран, БНАСАУ-ын талаар сайн мэдэж байв. Шууд хэрэгжилт 11-д авч үзсэнчлэн 2010-2015 онд банкууд БНАСАУ-ын иргэдтэй холбоотой 177 СГТ мэдүүлжээ. Гэхдээ өргөтгөсөн ХТМ зарим арга хэмжээг (тухайлбал, зарим бүтээгдэхүүн, үйлчилгээг хязгаарлах, данс нээлгэхэд удирдлагын шийдвэр гаргуулах, хөрөнгийн эх үүсвэрийн мэдээллийг шаардах) эс тооцвол өөр тусгайлсан арга хэрэглэдэг эсэх нь тодорхойгүй байна.

244. Дүгнэн хэлэхэд СБМҮҮ-ид МУТСТ хууль, УСЖ-аар хүлээсэн үүрэг хариуцлагаа ойлгохгүй байна. СБМҮҮ хяналт шалгалтад хамрагддаггүй тул тэд ХТМ өргөтгөсөн үйл ажиллагаа хэрэгжүүлдэг эсэх нь тодорхойгүй байна.

*Мэдээлэх үүрэг болон мэдээлэл задруулах*

245. МҮЭ-үүдээс СГТ цөөн мэдүүлж байна. Харин СБМҮҮ-ид нэг ч СГТ мэдүүлэгүй аж. СМА нь 2011 оноос 2016 оны 10 сарын хооронд СБ-даас нийт 1,006 СГТ хүлээн авсны 99.5%-ийг банкууд мэдүүлжээ (Хүснэгт 18).

**Хүснэгт 18: СБ болон СБМҮҮ-дээс мэдүүлсэн СГТ**

| Сектор                       | 2011 | 2012 | 2013 | 2014-2016 | 2015 | Oct | Бүгд         |
|------------------------------|------|------|------|-----------|------|-----|--------------|
| Банк                         | 71   | 156  | 283  | 210       | 111  | 171 | <b>1,002</b> |
| ББСБ                         | 0    | 1    | 2    | 0         | 0    | 0   | <b>3</b>     |
| Үнэт цаас                    | 0    | 1    | 0    | 0         | 0    | 0   | <b>1</b>     |
| Даатгал                      | 0    | 0    | 0    | 0         | 0    | 0   | <b>0</b>     |
| Хөрөнгө оруулалтын сан       | 0    | 0    | 0    | 0         | 0    | 0   | <b>0</b>     |
| ХЗХ                          | 0    | 0    | 0    | 0         | 0    | 0   | <b>0</b>     |
| СБМҮҮ                        | 0    | 0    | 0    | 0         | 0    | 0   | <b>0</b>     |
| <b>Бүгд хүлээн авсан СГТ</b> |      |      |      |           |      |     | <b>1,006</b> |

## БҮЛЭГ 5. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

246. ББСБ, даатгалын компаниуд, үнэт цаасны зах зээлд оролцогчид, хөрөнгө оруулалтын сангууд, ХЗХ-д, СББМҮҮ нар СГТ мэдээлэх үүргээ биелүүлэхгүй байна. Энэ нь МУТС эрсдэл, МУТСТ үүрэг хариуцлагаа ойлгохгүй, СЗХ болон СМА энэ талаар зохих түвшинд ажиллахгүй байгаатай холбоотой.

247. Монголбанк 2016 онд банкны гүйлгээ болон дансны хяналттай холбоотой зөрчлийг арилгах 9 үүрэг даалгавар гаргасан байхад СЗХ-ноос ийм төрлийн мэдээллийг гаргаж өгөөгүй болно.

248. 2011-2015 онд ТС-тэй холбоотой 2 СГТ, НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн Нэгдсэн жагсаалт (ОFАС жагсаалт)-тай нэр тохирсон байж болзошгүй 3 СГТ-г мэдүүлжээ. СМА-наас эдгээр 3 СГТ нотлогдоогүйг баталсан болно. Бидний үзэж байгаагаар ТС-тэй холбоотойгоор мэдүүлж буй СГТ нь Монгол Улсын ТС-ийн эрсдэлтэй төсөөлөлтэй нийцэж байна.

249. Банкуудаас мэдүүлж буй СГТ-гийн тоо нь Монгол Улсын МУТС эрсдэл, банкны секторын хэмжээг төлөөлөхгүй байна гэж бид үзэж байна. 2011 оноос хойш СМА 1002-хон СГТ бүрдүүлжээ. Гэтэл банкууд (i) 20.8 их наяд төгрөгийн (~11.8 тэрбум ам.доллар) хөрөнгөтэй, (ii) Монгол Улсын гүйлгээний үлэмж хэсэг нь банкаар дамждаг, (iii) 2015 оны 12 дугаар сарын байдлаар банкны секторт 6,045,491 харилцах болон хадгаламжийн данс байгаа юм.

250. ҮЭҮ-ээс харахад мэдүүлж буй СГТ нь Монгол Улсын МУ өндөр эрсдэлтэй аюул заналын тусгал нь болж чадахгүй байна:

- Банкуудаас мэдүүлсэн 1002 СГТ-ийн хувьд, 2010-2015 онд 423 СГТ (нийт СГТ-ийн 42%)-г өндөр эрсдэлтэй улс орнуудтай холбоотойгоор (ихэвчлэн БНАСАУ), ердөө 435 СГТ-г гэмт хэрэг үйлдэж олсон орлоготой холбоотой байж болзошгүй үндэслэлээр мэдүүлснийг ҮЭҮ харуулж байна. Өндөр эрсдэлтэй улс орнуудад хамаарахгүй СГТ-ийн тоо нь Монгол Улсын МУ эрсдэлийг төлөөлж чадахгүй байна.

- Авлига Монгол Улсын өндөр эрсдэлтэй суурь гэмт хэргийн нэг ч ҮЭҮ-нээс харахад 2010-2015 оны хооронд УТНБЭ-тэй холбоотойгоор зөвхөн 2 СГТ-г мэдүүлжээ.

- ҮЭҮ-нд ББСБ-уудын МУТС эрсдэл өндөр гэсэн ч тус сектор сүүлийн 7 жилд зөвхөн 3 СГТ-г мэдүүлжээ.

- ҮЭҮ-нд нотариатчдыг дундаж эрсдэлтэй, үл хөдлөх хөрөнгийн секторыг өндөр эрсдэлтэй хэмээн тодорхойлсон ч эдгээр сектор СГТ мэдүүлээгүй байна.

251. СБ-ууд БМГТ-г мэдүүлэг үүргээ боломжийн түвшинд ойлгож буй Хүснэгт 19 харуулж байна. Харин СББМҮҮ-ид нэг ч БМГТ мэдүүлээгүй ажээ.

**Хүснэгт 19: СБ-ууд болон СББМҮҮ-дийн мэдүүлсэн БМГТ**

| Сектор            | 2010    | 2011    | 2012    | 2013    | 2014      | 2015      | Oct 2016 |
|-------------------|---------|---------|---------|---------|-----------|-----------|----------|
| Банк              | 462,847 | 474,876 | 555,390 | 712,582 | 1,949,920 | 1,214,476 | 539,769  |
| Банкны бус сектор | 0       | 4       | 2,123   | 42,917  | 12,488    | 9,508     | 13,593   |
| СББМҮҮ-ид         | 0       | 0       | 0       | 0       | 0         | 0         | 0        |

## БҮЛЭГ 5. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

252. Мэдээлэл задруулахгүй байх үүргээ СБ-ууд ерөнхийдөө мэдэх ажээ. Томоохон банкууд болон ББСБ-ууд мэдээлэл задруулахгүй байх үүргийг ёс зүйн дүрэмдээ тусгасан гэж байв. Мэдээлэл задруулахгүй байх асуудал нь СБ-уудын хувьд онцгой сорилт болдоггүйг хянан шалгагч, ХСБ-уудын зүгээс хэлж байв.

Монгол Улсын хувьд мэдээлэл задруулсан тохиолдол бүртгэгдээгүй байна. Гагцхүү СББМҮҮ-ид мэдээлэл задруулахгүй байх үүрэг хариуцлагаа ухамсарлаж буй эсэх нь тодорхойгүй ажээ.

*Дотоод хяналт болон хэрэгжилтэд саад тотгор болж буй хууль эрх зүйн зохицуулалтууд*

253. МУТСТ хууль болон УСЖ-ын дагуу МҮЭ нь МУТСТ дотоод хяналтын хөтөлбөртэй байх ёстой. Гэтэл ҮЭҮ-нээс харахад 14 банк бүгд үр дүнтэй дотоод хяналттай гэвэл үгүй аж. Монголбанк дотоод хяналтын зөрчилтэй холбоотойгоор гаргасан үүрэг даалгаврыг Хүснэгт 20-т харуулав. Үүрэг даалгаврын тоо ийнхүү цөөрөх нь коплаенсийн ажилд ахиц гарч буйг илтгэнэ. Нөгөө талаас УСЖ-аар шинэ шаардлагыг 2016 оны 6 дугаар сард нэвтрүүлсэн тул банкуудын МУТСТ бодлого, зохицуулалтаа шинэчлэх ажил замын дунд байгаа нь дамжиггүй.

**Хүснэгт 20: Дотоод хяналтын зөрчлийг залруулах үүрэг даалгавар**

| Дотоод хяналтаа сайжруулах талаар гаргасан үүрэг даалгаврын тоо | 2014 | 2015 | 2016 оны 9-р сар |
|---|------|------|------------------|
| МУТСТ дотоод бодлого, зохицуулалт                               | 10   | 2    | 6                |
| МУТСТ бүтэц болон коплаенсийн ажилтан                           | 10   | 2    | 0                |
| Дотоод аудит болон хяналт                                       | 0    | 12   | 0                |
| Боловсон хүчний сургалт   | 10   | 12   | 9                |

254. СЗХ-ны мэдлийн СБ-уудын хувьд МУТСТ дотоод хяналт сул байгааг Хүснэгт 23 харуулж байна. Монголд санхүүгийн хоёр бүлэг үйл ажиллагаа явуулж байна. СЗХ-ноос МҮЭ-д МУТСТ шаардлагыг биелүүлж дотоод хяналт, үйл явцыг хэрэгжүүлдэг гэж байгаа боловч нотлох мэдээ баримтыг гаргаж өгөөгүй болно. Дүгнэн хэлэхэд, банкуудаас бусад СБ-уудын хувьд дотоод хяналт сул байгаа нь нөөцийн хязгаарлалттай холбоотой байгаа бол СББМҮҮ-дэд ийм хяналт огт байдаггүй ажээ.

255. Монгол Улс МУТСТ урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд харшлах хуулийн эсвэл зохицуулалтын зүйл байхгүй болно.

*Шууд хэрэгжилт 4-ийн Ерөнхий дүгнэлт*

256. **Монгол Улс Шууд Хэрэгжилт 4-ийн үр дүнтэй байдлыг доогуур түвшинд хангаж байна.**

## БҮЛЭГ 6. ХЯНАЛТ ШАЛГАЛТ

### *Дүгнэлт ба авах арга хэмжээний зөвлөмж*

#### *Дүгнэлт*

- Монголбанкны тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих механизмууд нь банкны зах зээлийг гэмт хэрэгтнүүдээс хамгаалахад зохих хувь нэмэр оруулж байна. Монголбанк нь гэмт хэргийн түүх, дүрмийн сангийн эх үүсвэр, аудитаар баталгаажсан тайлан тэнцэл зэргийг магадлах замаар үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх удирдлагыг шалгадаг аж. Банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэх, зөвшөөрлийг сунгах, шалгалт явуулах, удирдах албан тушаалтнууд өөрчлөгдөх үед бүх төрлийн мэдээллийг шалгадаг байна. Гэхдээ ҮЭҮ-нд дурьдсанчлан банкны эцсийн өмчлөгчдийг бүрэн шалгадаггүй ажээ.
- Монгол Улсын МУТС эрсдэлийн талаарх Монголбанкны ойлголт хязгаарлагдмал байгаа нь ҮЭҮ-г гүйцэтгээд удаагүй байгаатай холбоотой. Нөгөө талаас Монголбанк эрсдэлд суурилсан хяналт, шалгалт хийдэг болсноор салбарын болон банкуудын түвшин дэх МУ эрсдэлийн талаарх ойлголт ахисан байна.
- 2016 оны 6 сард Монголбанк МУТС-ийн зайнаас тавих хяналтын хүрээнд бүх банкны МУТС эрсдэлийн үнэлгээг дуусган 3 банкиг өндөр эрсдэлтэй, 5 банкиг дунд зэргийн эрсдэлтэй, 3 банкиг бага эрсдэлтэй, 3 банкиг маш бага эрсдэлтэй хэмээн тодорхойлжээ. 2015 оны 12 дугаар сараас өмнө Монголбанк нь МУТСТ дүрэмд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлдэг байв. ХҮБ-ийг Монголд ажиллах үед Монголбанк харьцангуй өндөр эрсдэлтэй 4 банкинд МУТС-ийн газар дээрх хяналт, шалгалтыг гүйцэтгэсэн ч шалгалтын тайлан эцэслэгдээгүй байв.
- Монголбанк албадлагын шинжтэй арга хэмжээг шат дараатай авах боломжтой. Эдгээрээс Монголбанк зөвхөн МУТС-ийн зөрчлөө арилгах хугацаатай үүрэг даалгавар өгч иржээ. Хяналт шалгалтын энэхүү арга хэмжээ нь банкны секторын МУТСТ талаарх ойлголт, хууль, журмын биелэлтэд төдийлөн нөлөөлөөгүй байна. (ШХ.4-ийг үзнэ үү).
- Банк бус санхүүгийн салбарын хувьд СЗХ нь хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирлуудын гэмт хэргийн түүхийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шалгадаг ажээ. СЗХ нь СБ-уудын эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг холбогдох агентлагуудаас гаргуулан авдаг байна. СЗХ-ны зүгээс СБ-уудын эцсийн өмчлөгчийг тодорхойлох, тэдний зах зээлд ажиллах шалгуур хангаж буй эсэхийг магадлах чадвар ямар түвшинд байгаа нь тодорхойгүй байна.
- СЗХ-ны МУТС, тэр дундаа хариуцсан салбарын болон байгууллагуудын түвшин дэх МУ эрсдэлийн талаарх ойлголт сул байна. ҮЭҮ-г тэргүүлсний хувьд СМА-ны МУТС эрсдэлийн талаарх ойлголт харьцангуй сайн байв.
- СЗХ нь эрсдэлд суурилсан МУТС-ийн хяналт шалгалтыг нэвтрүүлэхээр ажиллаж байна. СЗХ-ны хяналт шалгалт нь тоо болон хамрах хүрээний хувьд хязгаарлагдмал байна. СЗХ-ноос торгууль шийтгэл оногдуулж байгаагүй ба үйл ажиллагаа нь МЭҮЭ-үүдийн МУТСТ тухай ойлголт, хууль, журмыг биелэлтийг сайжруулсан гэх баримтыг бидэнд гаргаж өгч чадаагүй болно.
- Монгол Улсын МУТСТ хууль тогтоомжийн дагуу мэдээлэх үүрэгтэй СББМҮҮ-ийн

хүрээг зөвхөн үл хөдлөх хөрөнгийн агентууд болон нотариатчдаар хязгаарласны дээр хууль сахиx үүрэг зөвхөн нотариатчдад оногддог байна. СМА болон СЗХ нь үл хөдлөх хөрөнгийн зуучлагчдыг хянах үүрэгтэй ч хяналт шалгалтыг хэрэгжүүлж байгаагүй байна. Нотариатын болон хуулийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах шатанд зах зээлд ажиллах зарим нэг шалгуур тавьдаг байна.

- Монгол улс МУТСТ талаар зарим нэг заавар удирдамж гаргасан ч МУТС урьдчилан сэргийлэх шинэчилсэн журмыг санхүүгийн байгууллагууд (СБ) болон СББМҮҮ нарын зүгээс хэрэгжүүлэхэд дөхөм болохуйц зөвлөмж үгүйлэгдэж байна. СБ-ууд нь хянан шалгагчдын үйл ажиллагаа (тухайлбал, сургалт) чухал гэдгийг тэмдэглэж байна.

### *Хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж*

- Хянан шалгагчид МУТС-ийн эрсдэлийн үнэлгээг гүйцэтгэх, МҮЭ-үүдийг эрэмбэлэх бодлого журмыг нэвтрүүлж, тэдний МУТС эрсдэлийн талаарх ойлголтыг дээшлүүлбэл зохино.

- СББМҮҮ-ийн МУТС эрсдэлийн талаарх цогц ойлголтыг бүрдүүлснээр СББМҮҮ-ийг МУТСТ тогтолцоонд хамруулбал зохино. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг үл хөдлөх эд хөрөнгийн компаниуд, нотариат, үнэт металл болон үнэт чулууны арилжаа эрхлэгчид (ФАТФ-ын стандартын дагуу хамрагдах ёстой) хувьд яаралтай гүйцэтгэвэл зохино.

- Монголбанк нь эрсдэлд суурилсан банкны хяналт шалгалтыг нэвтрүүлэх нь зүйтэй. Үүний хүрээнд торгууль шийтгэл нь зөрчилд нь тохирохуйц, давтан үйлдэхээс сэргийлэхүйц байвал зохино. Монголбанк МУТСТ хяналт шалгалтыг хэрэгжүүлэх хүн хүч, хөрөнгө мөнгөний асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

- СЗХ нь эрсдэлд суурилсан банкны хяналт шалгалтыг нэвтрүүлэх нь зүйтэй. Үүний хүрээнд торгууль шийтгэл нь зөрчилд нь тохирохуйц, давтан үйлдэхээс сэргийлэхүйц байвал зохино. СЗХ МУТСТ хяналт шалгалтыг хэрэгжүүлэх хүн хүч, хөрөнгө мөнгөний асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

- Хянан шалгагчид цаашид ч МэҮЭ-үүдтэй хамтран ажиллаж, тэднийг МУТСТ эрсдэл, үүрэг хариуцлагын талаар (ялангуяа УТНБЭ-ын шинэ шаардлага, ЭӨ-ийг таньж мэдэх) чиглүүлэх нь зүйтэй.

257. Энэхүү бүлэгт авч үзсэн Шууд хэрэгжилт нь ШХЗ болно. Энэхүү хэсэг дэх үнэлгээнд зөвлөмж 3.26-28, 3.34 болон 35 хамааралтай болно.

### **ШУУД ХЭРЭГЖИЛТ 3 (ХЯНАЛТ, ШАЛГАЛТ)**

*Зах зээлд гэмт хэрэгтэн болон түүний хамсаатнууд нэвтрэхээс урьдчилан сэргийлэх тогтолцоо: тусгай зөвшөөрөл, бүртгэл, хяналтын механизмууд*

#### *Санхүүгийн салбар*

258. Монголбанк нь “Төв банкны тухай”, “Банкны тухай” болон “МУТС тэмцэх тухай” хуулийн дагуу банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, банкны үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх эрх бүхий байгууллага юм.

## БҮЛЭГ 6. ХЯНАЛТ ШАЛГАЛТ

259. СЗХ нь “СЗХ-ны эрх зүйн байдлын тухай” болон бусад хууль тогтоомжийн дагуу банк бус санхүүгийн салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллага юм. Банкны бус салбар нь 450 ББСБ, 17 даатгалын компани, 17 хөрөнгө оруулалтын сан, 61 үнэт цаасны компаниуд, 253 ХЗХ-доос бүрдэнэ. СЗХ нь МУТСТ хяналт шалгалтыг МУТС тэмцэх тухай хуулийн дагуу СМА-тай хамтран хэрэгжүүлнэ.

260. Монголбанкны тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих механизмууд нь банкны зах зээлийг гэмт хэрэгтнүүдээс хамгаалахад зохих хувь нэмэр оруулна. Монголбанк нь гэмт хэргийн түүх, дүрмийн сангийн эх үүсвэр, аудитаар баталгаажсан тайлан тэнцэл зэргийг магадлах замаар үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх удирдлагыг шалгадаг. Банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэх, зөвшөөрлийг сунгах, шалгалт явуулах, удирдах албан тушаалтнууд өөрчлөгдөх үед бүх төрлийн мэдээллийг шалгадаг байна. Гэхдээ ҮЭҮ-нд дурьдсанчлан банкны эцсийн өмчлөгчдийг бүрэн шалгадаггүй ажээ. Зайнаас гүйцэтгэсэн эрсдэлд суурилсан банкны хяналт шалгалтад банкны хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх удирдлага, МУТСТ комплаенсийн ажилтан нар (дор үзнэ үү) хамрагджээ. ХҮ-ний баг Монголд ажиллах үеэр Монголбанк харьцангуй өндөр эрсдэлтэй 4 банкинд МУТСТ эрсдэлд суурилсан газар дээрх шалгалтыг хийсэн бөгөөд шалгалтын тайлан эцэслэгдээгүй байв.

261. Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, захирал, гүйцэтгэх захирлууд нь гадаадын иргэн байх тохиолдолд Монголбанк нь эрх бүхий дотоод гадаадын байгууллагуудаас тодорхойлолт, албан бичиг хүсэх боломжтой боловч гадаадын гэмт хэрэгт холбогдсон лавлагааг гадаадын эрх бүхий байгууллагаас тодруулж шалгадаггүй байна.

262. Зах зээлд ажиллах шалгуур хангаагүйн улмаас банкны зөвшөөрөл олгогдоогүй тохиолдол гараагүй ажээ. Харин бүрдүүлсэн баримт бичиг дутуу, мэдээллийг шалгах боломжгүй гэдэг үндэслэлээр 2010 оноос хойш банкны зөвшөөрөл хүссэн хоёр хүсэлтэд татгалзсан хариу өгчээ.

263. Банк бус санхүүгийн салбарт гэмт хэрэгтнүүд орж ирэх үүд хаалгыг хаахын тулд СЗХ-ноос дүрмийн сангийн хөрөнгө, бизнесийн үйл ажиллагаа нь хууль ёсны эсэхийг магадлахын сацуу дүрмийн сангийн хөрөнгийг банкны дансанд бэлнээр байршуулахыг шаарддаг байна. Хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирлуудын гэмт хэрэгт холбогдож байсан эсэхийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шалгадаг ажээ.

264. 2011-2016 оны хооронд СЗХ нь дараах үндэслэлээр 26 компанид ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоос татгалзжээ. Үүнд: (1) 24 компани нь хөрөнгийн гарал үүслийн талаар хангалттай баримт бүрдүүлээгүй, (2) 2 компаний бизнес төлөвлөгөө шаардлага хангаагүй байна. СЗХ нь өөрийн мэдлийн бусад салбарт зөвшөөрөл олгоогүй тохиолдлын талаар мэдээлэл гаргаж өгөөгүй болно. СЗХ нь зохистой харьцааг хангаагүй, үйл ажиллагаа явуулаагүй болон/эсвэл дүрмийн сангийн доод хэмжээг бүрдүүлээгүй гэсэн үндэслэлээр 2015 оны 8 сараас хойш 4 ББСБ, 4 ХЗХ-ны зөвшөөрлийг, 2012 оноос хойш 30 үнэт цаасны компаний зөвшөөрлийг тус тус цуцалжээ.

265. СЗХ нь СБ-уудын эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг холбогдох агентлагуудаас гаргуулан авдаг байна. СЗХ-ны зүгээс СБ-уудын эцсийн өмчлөгчийг тодорхойлох, эцсийн өмчлөгч зах зээлд ажиллах шалгуур хангаж буй эсэхийг магадлах чадвар ямар түвшинд байгаа нь тодорхойгүй байна (банкны салбарын адил). Тухайлбал,

## БҮЛЭГ 6. ХЯНАЛТ ШАЛГАЛТ

СЗХ-ноос үнэлгээний багт танилцуулсан 2 энгийн жишээ нь тус ажил зохих түвшинд хийгдэж буй гэх сэтгэгдэл төрүүлээгүй болно. Үүгээр зогсохгүй СЗХ нь гадаад түншүүдтэй хамтран мэдээлэл шалгадаг гэх баримт алга. Албан тушаал буюу хувь нийлүүлсэн хөрөнгөнд өөрчлөлт орсон тохиолдолд СЗХ нь ЦЕГ-тай хамтран ажиллах боломжтой аж.

266. Монголбанк болон СЗХ нь ЦЕГ-аас гэмт хэргийн мэдээллийг хүсч хариу авахад ойролцоогоор 1 долоо хоног зарцуулдаг ажээ. Монголбанк болон СЗХ ОӨУБЕГ-ын цахим хуудсаар дамжуулан тухайн хуулийн этгээдийн талаар мэдээлэл авах боломжтой. Гэхдээ ШХ 5-д дурьдсанчлан энэхүү мэдээллийн үнэн зөв байдал эргэлзээтэй ажээ. Гэмт хэрэгтэн бусдын (хуулийн этгээд, түүнийг төлөөлж буй хүн) далбаан дор зах зээлд нэвтрэх явдлыг таслан зогсоох чадвар хянан шалгагч нарт хангалтгүй байгааг ҮЭҮ-нээс харж болно.

### *СББМҮҮ-ид*

267. Монгол Улсын МУТСТ хууль тогтоомжийн дагуу мэдээлэх үүрэгтэй СББМҮҮ-ийн хүрээг зөвхөн үл хөдлөх хөрөнгийн агентууд болон нотариатчдаар хязгаарласны дээр хууль хэрэгжүүлэх үүрэг зөвхөн нотариатчдад оногддог байна. СМА болон СЗХ нь үл хөдлөх хөрөнгийн зуучлагчдыг хянах үүрэгтэй.

268. СББМҮҮ-дийн хувьд дараахь зөвшөөрөл, бүртгэл, хяналтын механизм үйлчилнэ:

- Монгол Улсад казиног хориглодог.
- Монгол Улсад үл хөдлөх хөрөнгийн салбарыг зохицуулдаггүй. Үл хөдлөх хөрөнгийн компаниуд ОӨУБЕГ-т бүртгүүлсэн байхад л хангалттай. Энэхүү бүртгэл нь тухайн зах зээлд ажиллах шалгуурыг хамардаггүй болно.
- Аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.10.2 дахь заалтын дагуу үнэт металл, чулууны арилжаа эрхлэгчид Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас зөвшөөрөл авах ёстой. Гэвч зөвшөөрөл авах шатанд үүсгэн байгуулагч, удирдах менежерүүдэд зах зээлд ажиллах шалгуур тавьдаг гэх баримт байхгүй байв.
- Нотариатын зөвшөөрлийг Хууль зүйн яамнаас олгох ба гэмт хэргийн түүхийг өргөдөл гаргах үед шалгадаг байна. Нотариатын тухай хуулийн дагуу нотариатчид мэргэжлийн чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй. Зах зээлд ажиллах шалгуур хангаагүйн улмаас зөвшөөрөл олгоогүй эсхүл зөвшөөрлийг түдгэлзүүлсэн буюу цуцалсан талаарх мэдээлэл үнэлгээний багт ирээгүй болно.
- Монголын хуульчдын холбооноос хуулийн мэргэжилтнүүдэд тусгай зөвшөөрөл олгох ба ингэхдээ зах зээлд ажиллах шалгуур тавьдаг. Зөвшөөрөл хүсэгч нь гэмт хэрэг үйлдэж байгаагүй, эрүүл мэндийн хувьд тэнцэхээ баримт бичгээр баталгаажуулах ба хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй. Түүнчлэн, хуульч ажил мэргэжлийн зөрчил гаргасан аваас Монголын хуульчдын холбоонд мэдэгдэх үүрэгтэй. Зах зээлд ажиллах шалгуур хангаагүйн улмаас зөвшөөрөл олгоогүй эсхүл зөвшөөрлийг түдгэлзүүлсэн буюу цуцалсан талаарх мэдээлэл үнэлгээний багт ирээгүй болно.

## БҮЛЭГ 6. ХЯНАЛТ ШАЛГАЛТ

- Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт нь мэргэшсэн нягтлан бодогч (МНБ) болон аудитын байгууллагуудын ёс зүйн дүрмийг мөрдүүлэх, МНБ-д зөвшөөрөл олгох асуудлыг хариуцдаг. Гэхдээ зөвшөөрөл нь зах зээлд ажиллах шалгуурыг хамардаггүйн дээр МНБ-ын мэргэжлийн ёс зүйн дүрэм боловсруулагдсан эсэх нь тодорхойгүй байна.

### *Хянан шалгагчдын МУТС-ийн эрсдэлийн талаарх ойлголт*

#### *Санхүүгийн салбар*

269. Монголбанк болон бусад эрх бүхий байгууллагуудын Монгол Улсын МУТС эрсдэлийн талаарх ойлголт хязгаарлагдмал байгаа нь ҮЭҮ-г гүйцэтгээд удаагүй байгаатай мөн холбоотой. Монголбанк нь тухайн салбарт хамаарах эрсдэлийн үнэлгээнүүдийг хийгээгүй ба ҮЭҮ-нд банкны бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой эрсдэлийн нарийвчилсан бөгөөд системтэй дүн шинжилгээ байхгүй байна. ҮЭҮ-нд оролцож, 2015 оны 12 сараас хойш банкуудад эрсдэлд суурилсан хяналт, шалгалт хийдэг болсноор Монголбанк салбарын болон байгууллагуудын түвшин дэх МУ эрсдэлийн талаар ойлголттой болсон байна.

270. 2016 оны 6 сард Монголбанк МУТС-ийн зайнаас тавих хяналтын хүрээнд бүх банкны МУТС эрсдэлийн үнэлгээг дуусган (дор үзнэ үү) 3 банкныг өндөр эрсдэлтэй, 5 банкныг дунд зэргийн эрсдэлтэй, 3 банкныг бага эрсдэлтэй, 3 банкныг маш бага эрсдэлтэй хэмээн тодорхойлжээ. Монголбанк банк тус бүрийн эрсдэлийг тооцохдоо эрсдэлийн матрицын аргыг хэвлэмэл асуулгатай хослуулжээ. Өгөгдлийн чанар харилцан адилгүй байсан нь шинэ аргачлал ашиглаж байсантай холбоотой байв. Хэрхэн хариулах болон эрсдэлийн үнэлгээг хэрхэн хийх удирдамж тус аргачлалыг дагалдаагүй тул хариултын үнэн зөвийг дахин шалгавал зохино. ҮЭҮ-нд хувийн хэвшлийг хангалттай түвшинд хамруулж, цаг хугацаа зарцуулж чадаагүй нь зохицуулагчдын МУТС эрсдэлийн талаарх ойлголт явцуу байгааг харуулна.

271. СЗХ-ны МУТС талаарх ойлголт эхлэл төдий шатанд байна. СЗХ нь ҮЭҮ-нд оролцсон ч өөрийн хяналт тавидаг байгууллагуудын МУТС эрсдэлийг зохих түвшинд тусгаагүй байна. СЗХ нь эрсдэлд суурилсан аргачлалыг нэвтрүүлэхээр ажиллаж байгаа боловч анхаарлаа гол төлөв зохистой үзүүлэлтүүдийн эрсдэлд хандуулж байгаа нь уулзалтын үеэр ил болсон юм. СЗХ-д салбаруудын болон байгууллагуудын МУТС эрсдэлийг таньж мэдэх, ойлголтоо ахиулах ажил хэвшиж тогтоогүй байна.

#### *СББМҮҮ*

272. СМА нь ҮЭҮ-ний ажлыг оройлж оролцсонтой холбоотойгоор МУТС эрсдэлийн талаар арай илүү ойлголттой байв. Гэсэн хэдий ч СМА-ны СББМҮҮ-ийн МУТС-ийн эрсдэлийн (байгууллагын болон салбаруудын түвшин дэх) талаарх ойлголт нимгэн байгаа нь СББМҮҮ-ийн хяналт шалгалт хангалтгүй байгаатай холбоотой юм.

### *Эрсдэлд суурилсан МУТСТ-ийн хяналт, шалгалт*

#### *Санхүүгийн салбар – Монголбанкнаас банкинд тавих хяналт*

273. ОУВС-гийн техник тусламжтайгаар Монголбанк нь 2015 оны 12 сард эрсдэлд суурилсан МУТСТ хяналт, шалгалтыг нэвтрүүлж холбогдох журмуудыг (зайнаас болон газар дээрх шалгалт) баталжээ. Үүнээс өмнө СМА нь Монголбанктай хамтран

## БҮЛЭГ 6. ХЯНАЛТ ШАЛГАЛТ

банкнуудын МУТСТ дүрэмд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлдэг байв. ХҮБ Монголд ажиллах үед Монголбанк харьцангуй өндөр эрсдэлтэй 4 банкинд МУТС-ийн газар дээрх хяналт, шалгалтыг гүйцэтгэсэн (2-ыг нь 2016 оны 9 дүгээр сард, 2-ыг нь ХҮБ Монголд ажиллах үеэр) ч шалгалтын тайлан эцэслэгдээгүй байв. ХҮБ Монголд ажиллах хугацаандаа тус шалгалттай холбоотой ямар нэгэн мэдээлэл аваагүй болно.

274. Монголбанк МУТСТ зайны хяналт, шалгалтыг жилд 2 удаа хийдэг ба 2016 оны эхний шалгалт 6 дугаар сард хийгджээ. Энэхүү шалгалтад дараахь зүйлс багтана: (1) банкнаас ирсэн Тоон мэдээлэл цуглуулах маягыг хянах, (2) банкаас ирсэн Мониторинг болон комплаенсийн үнэлгээний асуулгыг хянах, (3) МБ/СМА-наас өмнө өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, засч залруулсан байдлыг хянах, (4) банкны улирлын МУТСТ тайланг хянах, (5) банкны СМА-нд тайлагнах үүргийн биелэлтийг хянах, (6) өөрийн хөрөнгө эсхүл хоёрдогч зээлийн өсөлтийн гарал үүсэл, эх үүсвэрийг хянах, (7) банкны хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон комплаенсийн ажилтны өөрчлөлтийг хянах. Монголбанк эрсдэлийн матрицыг ашиглан дээрх мэдээлэлд шинжилгээ хийж банкнуудыг эрсдэлийн түвшингээр 5 хуваадаг (хамгийн багаас хамгийн их хүртэл) байна. 2016 оны 6 дугаар сард 14 банкнаас 3-ыг өндөр эрсдэлтэй хэмээн тодорхойлсон байна.

275. Монголбанк нь эрсдэлд суурилсан хяналтыг дэмжих үүднээс (1) Банкны мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд газар дээрх хяналт, шалгалт хийх журам болон, (2) Банкны мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих журамтай нийцүүлэн гарын авлага боловсруулжээ. Газар дээрх шалгалт хийх, банкуудын МУТС үйл ажиллагааг үнэлэх, МУТС урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх үед олон төрлийн аргыг (тухайлбал, ярилцлага) ашигладаг байна.

276. Банкны эрсдэлийн талаарх ойлголтыг лавшруулах үүдээс зайнаас тавих хяналтаар банкуудыг дараахь үзүүлэлтээр мөн эрэмбэлдэг байна: Эрсдэл үнэлэх хэрэгслүүдийн ашиглалт, гадаад дотоод аудитын тайлан, хэвлэл мэдээлэл болон зах зээлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж буй байдал.

277. Банкны газар дээрх МУТС шалгалтыг гүйцэтгэхдээ зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн хангалтыг давхар авч үздэг байна. Монголбанкны 60 хянан шалгагчдын 9 нь МУТСТ хяналт, шалгалтыг хариуцдаг. Сүүлийн үеийн газар дээрх шалгалтыг Монголбанк хоёр багийн хүчээр хэрэгжүүлэх болжээ. 3 хянан шалгагчтай нэг баг нь МУТСТ асуудал дээр, харин нөгөө баг нь зохистой харьцаан дээр төвлөрнө. Тухайн банкны МУТС эрсдэлийн талаарх төсөөллөөс хамаараад газар дээрх шалгалт нь 2 долоо хоногоос 1 сарын хугацаанд үргэлжлэх аж. Газар дээрх шалгалтыг Монголбанк тухайн банкны төв байран дээр явуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд мэдээллийг банкны салбаруудаас авч болно.

278. Монголбанкнаас банкуудад зориулан гаргасан МУТСТ гарын авлагад өндөр эрсдэлтэй банк хяналт, шалгалтад илүү эрчимтэй хамрагдахаар заажээ. Зайнаас тавих хяналтын давтамж банкны эрсдэлээс хамааран харилцан адилгүй байжээ гэх мэдээллийг ХҮБ аваагүй болно. Түүнчлэн дараа дараагийн зайны болон газар дээрх шалгалтын хуваарь ХҮБ Монголд ажиллаж байх үеэр эцэслэгдээгүй байв.

## БҮЛЭГ 6. ХЯНАЛТ ШАЛГАЛТ

279. МУТС болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн газар дээрх шалгалтын тоог Хүснэгт 21-д, зайнаас тавьсан хяналтыг Хүснэгт 22-т тус тус харуулав. Энэхүү хүснэгт нь гол төлөв дүрэмд суурилсан шалгалтыг харуулна (2016 оны 4 үнэлгээ нь эрсдэлд суурилсан).

### Хүснэгт 21: Банкны МУТСТ болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн газар дээрх шалгалт

|                                      |  | 2012 | 2013 <sup>60</sup> | 2014 | 2015 | 2016 |
|--------------------------------------|--|------|--------------------|------|------|------|
| Шалгасан банк<br>(дүрэмд суурилсан)  |  | 12   | 0                  | 10   | 12   | 5    |
| Шалгасан банк<br>(эрсдэлд суурилсан) |  | 0    | 0                  | 0    | 0    | 4    |

### Хүснэгт 22: Банкинд тавьсан зайны хяналт

|  |                  | 2012 | 2013 <sup>61</sup> | 2014 | 2015 | 2016 |
|--|------------------|------|--------------------|------|------|------|
| Хүлээн авсан МУТСТ<br>улирлын тайлан                 |                  | -    | -                  | 56   | 56   | 56   |
| Биелэлтгүй танилцах<br>уулзалт                       |                  | -    | -                  | 28   | 28   | 28   |
| Залруулах даалгавар<br>захиргааны хэмжээний мэдэгдэл | үүрэг болон арга | -    | -                  | 51   | 47   | 44   |

*Санхүүгийн салбар – СЗХ-ны банк бус санхүүгийн салбарын хяналт*

280. СЗХ нь Дэлхийн банк, АХБ-ны тусламжтайгаар эрсдэлд суурилсан хяналт, шалгалтыг нэвтрүүлэхээр ажиллаж байна. ХҮБ Монголд ажиллах үеэр газар дээрх болон зайны МУТСТ шалгалтын журмууд болон Эрсдэл үнэлэх хэрэгсэл болон Асуулгын төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан байв<sup>62</sup>.

281. Хүснэгт 23-т үзүүлсэнчлэн СЗХ нь 2013 оноос эхлэн дүрэмд суурилсан МУТСТ хяналт, шалгалтыг хэрэгжүүлж байна. СЗХ-ны шалгалтад гол төлөв ББСБ-ууд хамрагдах ба газар дээрх шалгалт нь МУТСТ тухай хуулийн энгийн шаардлага, тухайлбал (1) МУТСТ бодлого боловсруулсан эсэх, (2) комплаенсийн ажилтантай эсэх, (3) БМГТ болон СГТ-г хүргүүлдэг эсэх дээр төвлөрдөг байна.

282. СЗХ-ны мэдээлснээр 2013-2014 онд зөрчлийн тоо буурсан нь ББСБ-ууд 2014 онд алдаагаа залруулсан, бусад зөрчил гаргаагүйтэй холбоотой аж (Хүснэгт 23). Түүнчлэн ББСБ-аас бусад салбарт зөрчил бараг илрээгүй ажээ. ХҮБ энэхүү МУТСТ шалгалтыг учир дутагдалтай гэж үзэж байна. Ихэвчлэн 3 долоо хоног үргэлжлэх (заримдаа 1 долоо хоног) газар дээрх шалгалтаар өдөр тутмын гүйлгээг шалгадаг байна. Зайны шалгалт нь

<sup>60</sup> МУ/ТСТ тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбоотойгоор 2013 онд хяналт хийгдээгүй.

<sup>61</sup> МУ/ТСТ тухай хуулийг шинэчлэн найруулсантай холбоотойгоор 2013 онд хяналт, шалгалт хийгдээгүй.

<sup>62</sup> Тус журам нь 2016 оны 12 сард батлагдсан. Гэхдээ эрсдэлд суурилсан хяналт хэзээ эхлэх нь тодорхойгүй байна.

## БҮЛЭГ 6. ХЯНАЛТ ШАЛГАЛТ

улирлын үйл ажиллагааны тайлан болон жилийн санхүүгийн тайлан дээр төвлөрдөг байна. БМГТ болон СГТ-аас өөр мэдээлэл СЗХ-нд тайлагнах шаардлагагүй ажээ.

283. СЗХ-ноос бүх хяналт шалгалт МУТСТ асуудлыг хамардаг гэсэн боловч (Хүснэгт 23) зарим СБ-тай хийсэн уулзалтаас энэ нь тийм биш болох нь харагдсан.

284. СЗХ нь Хөрөнгө оруулалтын санд МУТСТ хяналт шалгалт хийж байгаагүй ажээ.

### Хүснэгт 23. СЗХ-ны МУТСТ болон зохистой харьцааны хяналт

|  | 2011             | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
|--|------------------|------|------|------|------|------|
| <b>ББСБ</b>                                    |                  |      |      |      |      |      |
| Хуулийн этгээдийн тоо                          | 195              | 212  | 263  | 378  | 450  | 518  |
| Газар дээрх шалгалтын тоо                      | 70               | 35   | 30   | 36   | 5    | 117  |
| Зайн шалгалтын тоо                             | 777              | 815  | 950  | 1332 | 1660 | 1867 |
| Илрүүлсэн зөрчлийн тоо                         | 0                | 0    | 35   | 3    | 2    | 0    |
| Захиргааны арга хэмжээний тоо                  | 31 <sup>63</sup> |      | 2    | 155  | 12   | 3    |
| <b>ХЗХ</b>                                     |                  |      |      |      |      |      |
| Хуулийн этгээдийн тоо                          | 162              | 148  | 141  | 159  | 253  | 280  |
| Газар дээрх шалгалтын тоо                      | 40               | 34   | 36   | 35   | 30   | 24   |
| Зайн шалгалтын тоо                             | 606              | 586  | 557  | 570  | 941  | 1039 |
| Илрүүлсэн зөрчлийн тоо                         | 0                | 0    | 0    | 0    | 3    | 0    |
| <i>Үнэт цаасны зах зээл дэх хуулийн этгээд</i> |                  |      |      |      |      |      |
| Хуулийн этгээдийн тоо                          | 94               | 97   | 93   | 70   | 61   | 62   |
| Газар дээрх шалгалтын тоо                      | 0                | 0    | 0    | 0    | 61   | 49   |
| Зайн шалгалтын тоо                             | 0                | 0    | 0    | 0    | 61   | 62   |
| Илрүүлсэн зөрчлийн тоо                         | 0                | 0    | 0    | 0    | 0    | 0    |
| <i>Даатгалын компаниуд</i>                     |                  |      |      |      |      |      |
| Хуулийн этгээдийн тоо                          | 17               | 18   | 17   | 17   | 17   | 17   |
| Газар дээрх шалгалтын тоо                      | 13               | 12   | 10   | 7    | 8    | 7    |
| Зайн шалгалтын тоо                             | 68               | 72   | 68   | 68   | 68   | 68   |
| Илрүүлсэн зөрчлийн тоо                         | 0                | 0    | 0    | 0    | 0    | 0    |
| Газар дээрх нийт шалгалт                       | 123              | 81   | 76   | 78   | 106  | 197  |
| Зайны нийт шалгалт                             | 1451             | 1473 | 1575 | 1970 | 2730 | 3036 |
| Илрүүлсэн нийт зөрчил                          | 0                | 0    | 35   | 3    | 5    | 0    |
| Нийт захиргааны арга хэмжээ <sup>64</sup>      | 31 <sup>65</sup> |      | 2    | 155  | 12   | 0    |

### СББМҮҮ

285. МУТСТ тухай хуулийн дагуу СМА болон СЗХ нь үл хөдлөх хөрөнгийн секторт хяналт тавих үүрэгтэй. Бусад СББМҮҮ-дийг хянах зохицуулагч байхгүй аж. СББМҮҮ нь МУТСТ хяналт шалгалтад хамрагдаж байгаагүй аж.

286. Нэгтгэн хэлэхэд, МУТСТ хяналт шалгалт хэрэгжүүлэх нөөц боломж, мэдлэг чадвар дутмаг байна. СМА нь 10 ажилтантай ба зөвхөн 1 хянан шалгагчтай аж. Монголбанкны 60 хянан шалгагчдын зөвхөн 9 нь МУТСТ хяналт тавих үүрэгтэй бол СЗХ-ны 28 ажилтан 700 гаруй СБ-ыг хянах үүрэгтэй аж. Түүнчлэн зарим банк бус СБ-ийн

<sup>63</sup> Эдгээр 31 захиргааны арга хэмжээг 2008-2012 онд авсан.

<sup>64</sup> Захиргааны арга хэмжээний тухай мэдээллийг зөвхөн ББСБ-ын хувьд ирүүлсэн.

<sup>65</sup> 2016 оны тушаалууд нь дүрэмд-суурилсан хяналт, шалгалтад хамаарна. Эрсдэлтэй дөрвөн банкинд хийсэн газар дээрх МУТСТ шалгалтын тайлан эцэслэгдээгүй байсан болно.

## БҮЛЭГ 6. ХЯНАЛТ ШАЛГАЛТ

мэдээлснээр СЗХ-ны хянан шалгагч нар ойр ойрхон өөрчлөгддөг нь хяналт, шалгалтын чанарт сөргөөр нөлөөлдөг ажээ.

*Гаргасан зөрчилд нь тохирсон, үр дүнтэй, давтан үйлдэхээс сэргийлсэн засч залруулах арга хэмжээ*

*Санхүүгийн салбар – Монголбанкны банкны хяналт, шалгалт*

287. Банкны тухай хуулиар Монголбанк нь бичгээр өгөх мэдэгдлээс өгсүүлээд тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл албадлагын арга хэмжээг шат дараатай авах эрхтэй. 2014 оноос хойш Монголбанк зөвхөн МУТСТ зөрчил дутагдлыг арилгах хугацаатай үүрэг даалгавар өгч иржээ. Хүснэгт 24-т үзүүлсэнчлэн хугацаатай үүрэг даалгавар, илэрсэн зөрчил болон түүнийг арилгах арга хэмжээний жагсаалтыг тусгадаг аж. Шаардлага биелүүлээгүй банкинд дараагийн шатны хариуцлага тооцох (тухайлбал, мөнгөн торгууль ногдуулах) боломжтой. Монголбанкнаас өгсөн мэдээллээр 2015 онд банкууд нийт зөрчлийн 91.4%-ийг тогтоосон хугацаанд арилгасан бөгөөд мөнгөн торгууль ногдуулсан тохиолдол гараагүй ажээ. Үйл ажиллагаа явуулдаггүй банкуудад хамаарах 4 тушаал л (МУТСТ-тэй холбоогүй) биелэгдээгүй үлджээ. Хувийн хэвшлийн урьдчилан сэргийлэх ажлын гүйцэтгэлийг харсан ч, бүх төрлийн зөрчилд нэг л төрлийн тушаал гарч байсныг харсан ч ийм хугацаатай үүрэг даалгавар нь зөрчилд тохирсон, давтан үйлдэхээс сэргийлсэн байсан гэхэд хүндрэлтэй юм.

288. Банкуудад хүргүүлсэн зөрчил арилгах зарим хугацаатай үүрэг даалгавар хэт ерөнхий шинжтэй байна. Зарим тушаалд “эцсийн өмчлөгчийг тодорхойлох” эсхүл “СГТ-г сайжруулах” үүрэг өгөгджээ. Бидний үзэж байгаагаар эдгээр үйл ажиллагааг хугацаатай үүрэг даалгавараар сайжруулах боломжгүй юм. Харин үүний оронд ямар арга хэмжээг яагаад авах ёстойг банкуудад сайтар тайлбарлаж ойлгуулах ёстой.

### Хүснэгт 24: Монголбанкнаас банкнуудад хүргүүлсэн хугацаатай үүрэг даалгавар

| Засч залруулах асуудал                              | 2014      | 2015      | 2016        |
|---|-----------|-----------|-------------|
| МУТСТ дотоод бодлого, журам                         | 10        | 2         | 6           |
| МУТСТ бүтэц болон комплаенсийн ажилтан              | 10        | 2         | 0           |
| Гүйлгээ болон дансны хяналт                         | 0         | 0         | 9           |
| Эрсдэлийн үнэлгээний тогтолцоо, журам               | 10        | 2         | 0           |
| ХТМ ерөнхий шаардлага                               | 1         | 0         | 2           |
| ЭӨ-ийг тогтоох, баталгаажуулах                      | 0         | 2         | 9           |
| Сайжруулсан МШ                                      | 10        | 2         | 0           |
| УТНБЭ-эд тавих шаардлага                            | 0         | 0         | 9           |
| Цахим шилжүүлэг                                     | 0         | 1         | 0           |
| Дотоод хяналт, аудит                                | 0         | 12        | 0           |
| Ажилтны сургалт                                     | 10        | 12        | 9           |
| Шинэ бүтээгдэхүүн, технологи                        | 0         | 12        | 0           |
| <b>Бүгд</b>   | <b>51</b> | <b>47</b> | <b>4465</b> |
| <i>Монголбанкны зайны болон газар дээрх шалгалт</i> | <i>10</i> | <i>12</i> | <i>23</i>   |

*Санхүүгийн салбар – СЗХ-ны банкны бус санхүүгийн салбарын хяналт шалгалт*

289. СЗХ-ноос тус салбар дахь зөрчил дутагдалд авах арга хэмжээ харилцан адилгүй ажээ. СЗХ-ноос хариуцлага тооцсон тохиолдол байхгүй ба СЗХ нь зөрчлийн эсрэг авах

## БҮЛЭГ 6. ХЯНАЛТ ШАЛГАЛТ

арга хэмжээний үр нөлөөг сайн ойлгохгүй байна гэх сэтгэгдэл төрсөн. СЗХ нь газар дээрх болон зайны хяналтаар илрүүлсэн бүх зөрчилд захиргааны арга хэмжээ авах мэдэгдэл хүргүүлсэн хэмээн бидэнд мэдэгдсэн. Гэвч ирүүлсэн мэдээллийг харахад зөвхөн ББСБ-тай холбоотой байв (Хүснэгт 25). Үүгээр зогсохгүй, зөрчил дутагдлын мөрөөр арга хэмжээ авсан эсэх нь тодорхойгүй байгаа бөгөөд энэ талаар ямар нэг баримтыг Монгол Улс гаргаж өгөөгүй болно.

290. Илрүүлсэн зөрчлийн төрөлтэй холбоотой мэдээлэл хангалтгүй байв. ББСБ-ын хувьд зөвхөн 2 төрлийн МУТС-ийн зөрчил тогтоогджээ: (1) МУТС тэмцэх бодлого, журам байхгүй, мөн (2) комплаенсийн ажилтан байхгүй. Бидний үзэж буйгаар, бодлого журмыг баталж, холбогдох ажилтныг томилох нь урьдчилан сэргийлэх тогтолцооны угтвар нөхцөл бөгөөд зөрчлийн мөрөөр авах арга хэмжээ гаргасан зөрчилд нь тохирсон, давтан үйлдэхээс сэргийлэхүйц байх баталгаа юм. СЗХ нь МУТС зөрчилтэй холбоотойгоор зөвшөөрөл цуцалсан тохиолдол байхгүй ажээ.

### Хүснэгт 25. ББСБ-ийн салбар дахь МУТСТ зөрчил

| Зөрчлийн төрөл                                       | 2013 | 2014 | 2015 | 2016 |
|--|------|------|------|------|
| МУТС тэмцэх батлагдсан дотоод бодлого, журам байхгүй | 215  | 116  | 72   | 63   |
| МУТСТ асуудлыг хариуцсан ажилтан байхгүй             | 137  | 117  | 72   | 63   |

### СББМҮҮ

291. Монгол Улс СББМҮҮ-ийн хувьд МУТСТ хяналт, шалгалтыг явуулж байгаагүй, зөрчил дутагдал арилгуулах арга хэмжээ авч байгаагүй болно. МУТСТ тухай хууль болон УТНБЭ нь үл хөдлөх хөрөнгийн секторт үйлчилдэггүй бол нотариатчдын оногдуулдаг торгууль шийтгэл нь зөрчилд тохирсон, урьдчилан сэргийлэгдэхүйц байж чадахгүй байна. Үл хөдлөх хөрөнгийн компани МУТСТ хуулийг зөрчвөл бүртгэлийн жагсаалтаас хасах хүсэлт ОӨУБЕГ-т хүргэдэг хэмээн СЗХ-ноос мэдэгдсэн ч үүнийг нотлох баримт алга байна.

*Хяналт, шалгалтын арга хэмжээний үр нөлөө*

### *Санхүүгийн салбар – Монголбанкны банкнуудын хяналт, шалгалт*

292. Хяналт шалгалтын арга хэмжээ (зөрчил дутагдлыг арилгах хугацаат үүрэг даалгавар) нь банкуудын ойлголт, комплаенсийн чанарт нөлөөлжээ. Банкнууд ЭСА болон газар дээрх шалгалтад мэдрэг байгаа нь ажиглагдав. Тухайлбал, томоохон банкнууд Монголбанкны газар дээрх шалгалтын мөрөөр харилцагчдаа эрсдэлээр нь эрэмбэлж, улс төрд нөлөө бүхий этгээдийн жагсаалтыг гаргаж, харилцагчаа таньж мэдэх ажлаа сайжруулж, ажилтнуудынхаа МУТСТ сургалтын чанар болон давтамжыг ахиулснаа бидэнд ярьж байв. Банкнууд УТНБЭ-ын шинэ шаардлагад нийцүүлэн бодлого, журмаа шинэчлэх тал дээр Монголбанкт хамтран ажиллахад бэлэн байгаа харагдсан. Гэсэн хэдий ч банкуудад хүргүүлсэн хугацаат үүрэг даалгавар тоо (ялангуяа, МУТСТ дотоод бодлого журам, ЭӨ-г тогтоож баталгаажуулах, ажилтныг сургахтай холбоотой) цөөрөх хандлага байхгүй байгааг Хүснэгт 24-өөс харж болно. Эрсдэлд суурилсан газар дээрх 4

## БҮЛЭГ 6. ХЯНАЛТ ШАЛГАЛТ

удаагийн шалгалтын тайлан үнэлгээний багт ирээгүй тул үр нөлөө нь тодорхойгүй үлдэж байна.

*Санхүүгийн салбар – СЗХ-ны банк бус санхүүгийн салбар дахь хяналт, шалгалт*

293. СЗХ-ны МУТСТ хяналт шалгалт тоо болон цар хүрээний хувьд хязгаарлагдмал байна. СЗХ-ны хяналт шалгалт МУТСТ талаарх ойлголт, комплаенсийг дорвитой ахиулсан гэх тоо, мэдээ бидэнд алга. СЗХ-ноос шалгадаг байгууллагуудын төлөөлөлтэй хийсэн уулзалт, ярилцлагаас СЗХ-ны үйл ажиллагаа МУТСТ комплаенсийг сайжруулсан гэх итгэл үнэмшил төрөхөөргүй байв.

294. СМА-ны хяналт шалгалт нь хэдий хязгаарлагдмал ч гэлээ МУТСТ комплаенст эерэгээр нөлөөлсөн байх магадлалтайг дорхи жишээ харуулна. Хэдий тийм ч үүнийг нотлох баримт бидэнд алга байна.

### Жишээ 1: СМА-ны хяналт шалгалт

СМА 2012 онд нэгэн ББСБ-д МУТСТ шалгалт хийж, шалгалтын мөрөөр тус байгууллагад 2 төрлийн зөвлөмж өгсөн байна. Нэг нь БМГТ болон СГТ-ний тайланг цаг тухайд нь ирүүлэх, нөгөөх нь иргэдийн хувийн мэдээллийг тодорхой маягтын дагуу цуглуулах талаар байв. Хяналт шалгалт хийгдсэний дараа СМА нь тухайн ББСБ-ын ажилтнуудад сургалт зохион байгуулснаар тэдний хандлагыг бүрмөсөн өөрчилж чаджээ. Тэд ХТМ болон ХМШ хэрэгжүүлэх, МУТСТ дүрэм журмыг мөрдөх ач холбогдлыг ухаарч ойлгосноор зөрчил дутагдлаа түргэн шуурхай арилгаж чаджээ. СМА-наас 3 сарын дараа давтан шалгахад үр дүн нь хангалттай гарсан байна.

*МУТСТ үүрэг хариуцлага, эрсдэлийн талаар бүрэн дүүрэн ойлголт өгөх нь*

295. Монголбанк, СМА-тай хамтран МУТСТ асуудлаар хэд хэдэн заавар, зөвлөмжийг (тухайлбал, сэжигтэй гүйлгээг хэрхэн таних болон тайлагнах) гаргажээ. Гэхдээ ихэнх зөвлөмж нь ФАТФ-ын Ил тод байдал болон эцсийн өмчлөгчийн талаарх удирдамж, УТНБЭ-ийн талаарх удирдамж зэрэг баримтын орчуулга учраас Монголын онцлог нөхцлийг тусгаж чадаагүй байна. Салбарын ХТМ/ХМШ шаардлагыг тайлбарласан удирдамж заавар байхгүй ажээ. УТНБЭ-тэй холбоотой удирдамжийг саяхан эцэслэж, тараасан байна. Сүүлийн үеийн сургалтаар УТНБЭ-ыг тодорхой хэмжээнд хамардаг болов.

296. СЗХ-ы зүгээс МУТСТ үүрэг хариуцлагыг ухамсарлуулах ямар нэгэн удирдамж заавар гаргаагүй аж. Иймд СЗХ-ноос зохицуулдаг байгууллагуудын хувьд МУТСТ хууль, СГТ болон БМГТ-г тайлагнах журам, УТНБЭ-аас өөр дагаж мөрдөх заавар журам байхгүй аж.

297. Хянан шалгагчдын ТС талаарх ойлголт сул байгаа төдийгүй ТС-ийн талаарх удирдамж байхгүй аж. Банкуудыг эс тооцвол бидэнтэй уулзсан МҮЭ-ийн ихэнх нь НҮБАЗ-ийн Нэгдсэн жагсаалтыг ашигладаггүй байна.

298. Хянан шалгагчид МУТСТ сургалтыг хийсээр иржээ (Хүснэгт 26). Хагас өдөр үргэлжлэх сургалтыг СМА нь дангаараа эсхүл МБ, СЗХ, ТЕГ, УПЕГ, Монголын Банкны

## БҮЛЭГ 6. ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Холбоо, ББСБ-ын холбоотой хамтран ОУВС, ЭЗХАХБ, АХБ-ны дэмжлэгтэйгээр явуулдаг. Сургалт гол төлөв МУТСТ талаарх ерөнхий ойлголтыг ахиулахад чиглэгдэнэ. Сургалтад теллер, дотоод аудитор, комплаенс ажилтнаас эхлээд банк болон банк бус СБ-ын ахлах менежерүүд, нотариат, хуульчид оролцдог аж. МУТСТ талаарх ойлголтыг гүнзгийрүүлэхэд сургалтын ач холбогдол өндөр байсныг СБ-ууд онцолж байсан ч бидэнд ирүүлсэн сургалтын төрөл болон чанарын талаарх мэдээлэл үүнийг нотлохооргүй байв.

### Хүснэгт 26. Хянан шалгагчдын зохион байгуулсан сургалт

|  | 2016 | 2015 | 2014 | 2013 |
|--|------|------|------|------|
| СМА-ны зохион байгуулсан сургалт/семинарын тоо   | 0    | 6    | 4    | 4    |
| Оролцогчдын тоо  | 0    | 239  | 164  | 229  |
| СМА-ны бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалт/семинарын тоо            | 5    | 20   | 10   | 5    |
| СМА-ны бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалт/семинарт оролцогчдын тоо | 260  | 738  | 428  | 421  |

299. СЗХ нь МУТСТ-тэй холбоотой ердөө 3 удаагийн сургалтыг зохион байгуулжээ. Үүнээс хоёрыг нь 2014 онд, нэгийг нь 2016 онд зохион байгуулсан байна. СЗХ-ноос тогтмол зохион байгуулдаг сургалт нь МУТСТ сэдвийг огт хамардаггүй аж. Үнэт цаасны дилерийн холбоо нь Үнэт заасны захад ажиллах зөвшөөрлийг олгох хүрээнд МУТСТ сургалтыг жилд дор хаяад 2 удаа зохион байгуулдаг байна.

300. Монгол Улсын МУТС эрсдэлийг хамрах хүрээ хязгаарлагдмал байна. Энэ нь ҮЭҮ хэвлэгдээд удаагүй байгаатай зарим талаараа холбоотой.

*Шууд хэрэгжилт 3: Ерөнхий дүгнэлт*

**301. Монгол Улсын Шууд хэрэгжилт 3-н хэрэгжилт доогуур түвшинд байна.**

## **БҮЛЭГ 7. ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛОН БУСАД ЗОХИЦУУЛАЛТ БҮХИЙ ЭТГЭЭДҮҮД**

### *Дүгнэлт болон хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж*

#### **Дүгнэлт**

- Монгол Улс хуулийн этгээдтэй холбоотой МУТС эрсдэл, сул талыг зохих ёсоор тодорхойлж, үнэлж чадаагүй байна (ҮЭҮ-нд мөн адил).
- ОӨУБЕГ-аас хуулийн этгээдийн талаарх мэдээллийг авах боломжтой. ТЕГ, УПЕГ болон АТГ нь хуулийн этгээдийн талаарх мэдээллийг ОӨУБЕГ-ын мэдээллийн сангаас тухай бүр авах боломжтой. Гэхдээ ОӨУБЕГ-аас мэдээллийг шалгах, үнэн зөв оруулахыг шаардах боломж байдаггүй байна.
- МҮЭ-үүд ХТМ ажлын хүрээнд ЭӨ-ийн талаар мэдээлэл авах үүрэгтэй. ХСБ-ууд болон СМА нь ЭӨ-ийн талаарх мэдээллийг тухай бүр авч чаддаг. Зөвхөн томоохон банк болон ББСБ ХТМ тусгайлсан шаардлагыг биелүүдэг тул санхүүгийн салбар дахь ЭӨ-ийг таних үүргийн хэрэгжилт харилцан адилгүй байдаг ажээ. Иймд ЭӨ-ийн талаарх мэдээлэл байхгүй, бодитой бус болон/эсвэл шинэчлэгдээгүй байж болно.
- Хуулийн этгээдийг МУТС зорилгоор урвуулан ашиглахаас сэргийлж Монгол Улсын дараахь арга хэмжээг мөн авчээ: (1) хувьцаа эзэмшигч болохыг нотлох дамжуулах хувьцааг бүртгэх, (2) нэрлэсэн хувьцаа, нэрлэсэн захирлуудыг томилохыг хориглох, (3) ОӨУБЕГ-ын хуулийн этгээдийн бүртгэлийг сайжруулах, шинэчлэх.
- Монгол Улс экспресс траст, түүнтэй адил төстэй бүтэц, чиг үүрэг бүхий гэрээ, бусад зохицуулалт бүхий этгээд байгуулахыг хуулиар хориглосон байдаг. Гадаадын трастууд нь Монголын эдийн засагт онцгой хамаарах зүйл биш болох нь бидэнд тодорхой болсон билээ. Монгол Улсад гадаадын трастуудыг бий болгох эсхүл удирдахад СББМҮҮ-д оролцдог гэх баримт алга. Гэсэн хэдий ч Монгол Улс эрх зүйн гэрээ, бусад зохицуулалт бүхий этгээдтэй холбоотой (тухайлбал, гадаадын эрх зүйн гэрээ, бусад зохицуулалт бүхий этгээд) МУТС эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгээгүй болно.

#### **Хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж**

- Монгол Улс хуулийн этгээдтэй холбоотойгоор үүсч болох эрсдэл, эмзэг байдлыг бүрэн ухамсарлаж, үнэлбэл зохино.
- Монгол Улс ОӨУБЕГ-т мэдээллийн үнэн зөв, бодитой байдлыг магадлах, сахих эрх үүргийг олгож нэмэгдүүлбэл зохино.
- ЭӨ-ийн мэдээллийг цуглуулах үүргээ ухамсарлаж буй МҮЭ-ийн (ялангуяа, СББМҮҮ) хүрээг тэлэх.
- Хуулийн этгээд нь ЭӨ-ийн мэдээллийн үнэн зөв байдлыг ханган, эрх бүхий байгууллагуудад хүргүүлдэг байх үүргийг Монгол Улс бий болговол зохино. Эрх бүхий байгууллагууд энэхүү мэдээллийг хуулийн ямар нэгэн хязгаарлалтгүйгээр шуурхай авч чаддаг байвал зохино.
- Монгол Улс торгууль шийтгэлийн тогтолцоогоо илүү үр дүнтэй, шийтгэл нь

## БҮЛЭГ 7. ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛОН БУСАД ЗОХИЦУУЛАЛТ БҮХИЙ ЭТГЭЭДҮҮД

зөрчилдөө тохирсон, давтан үйлдэхээс сэргийлэхүйц байлгахад анхаарах хэрэгтэй.

302. Энэхүү бүлэгт авч үзсэн Шууд хэрэгжилт нь ШХ5 болно. Энэхүү хэсэг дэх үр нөлөөний үнэлгээнд Зөвлөмж 24 болон 25 хамааралтай болно.

### *Шууд хэрэгжилт 5 (Хуулийн этгээд/бусад зохицуулалт бүхий этгээд)*

*Хуулийн этгээд/бусад зохицуулалт бүхий этгээдийн талаарх мэдээллийн нээлттэй байдал*

303. Иргэний болон ХУУБТХ-ийн дагуу Монгол Улсад дараах төрлийн хуулийн этгээд байгуулж, бүртгүүлж болно. Ашгийн төлөө ангилалд: хязгаарлагдмал нөхөрлөл, хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл болон компаниуд; ашгийн бус ангилалд: холбоо, сан болон хоршоо болно. Тухайн үед ОӨУБЕГ-т бүртгүүлсэн хуулийн этгээдийн тоог Хүснэгт 27-д харуулав.

### Хүснэгт 27: Хуулийн этгээдийн тоо

| Хуулийн этгээдийн төрөл   | Хуулийн этгээдийн тоо (2016 оны X сарын байдлаар) |
|---|---|
| <i>Ашгийн төлөөх хуулийн этгээд</i>   |   |
| Нөхөрлөл <sup>66</sup>  | 3,957   |
| Компани – Хувьцаат  | 298   |
| Компани – Хязгаарлагдмал хариуцлагатай  | 112,480   |
| Компани – Гадаадын хөрөнгө оруулалттай хязгаарлагдмал хариуцлагатай           | 9,417   |
| Компани – Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар | 465   |
| <b>Бүлгийн дүн</b>  | <b>126,617</b>                                    |
| <i>Ашгийн бус хуулийн этгээд</i>  |   |
| Хоршоо  | 4,093   |
| ХЗХ   | 475 <sup>67</sup>                                 |
| Төрийн бус байгууллага  | 23,027  |
| Шашны байгууллага   | 746   |
| Сан   | 1,119   |
| Үйлдвэрчний эвлэлийн байгууллага  | 2,676   |
| Хэвлэл мэдээлэл   | 3,561   |
| Нийтийн эрх зүйн хуулийн этгээд <sup>68</sup>                                 | 1   |
| Соёл, боловсрол сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн байгууллага           | 331   |
| <b>Бүлгийн дүн</b>  | <b>36,029</b>                                     |
| <i>Ашгийн болон ашгийн бус хуулийн этгээд</i>                                 |   |
| Соёл, боловсрол, сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн байгууллага          | 331   |
| <b>БҮГД</b>   | <b>162,977</b>                                    |

<sup>66</sup> Хязгаарлагдмал нөхөрлөл болон хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн задаргааг ирүүлээгүй болно.

<sup>67</sup> ОӨУБЕГ-т бүртгүүлсэн хадгаламж, зээлийн хоршоодын нэлээдгүй хэсэг нь үйл ажиллагаа явуулдаггүй эсвэл СЗХ-ноос зөвшөөрөл аваагүй байж болно

<sup>68</sup> Монголын хуульчдын холбоо

## **БҮЛЭГ 7. ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛОН БУСАД ЗОХИЦУУЛАЛТ БҮХИЙ ЭТГЭЭДҮҮД**

304. Монгол Улсад үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийн талаарх мэдээллийг Төрийн мэдээллээс авах боломжтой. ОӨУБЕГ нь бүх хуулийн этгээдийн мэдээллийг цаасан болон цахим хэлбэрээр хадгалах үүрэгтэй засгийн газрын агентлаг юм.

305. Эрх бүхий байгууллагууд ОӨУБЕГ-ын мэдээллийн санд шууд нэвтрэх эрхтэй бол хувь хүн хүсэлт гарган мэдээлэл авна.

306. Компанийн тухай хуулиар компаниуд үүсгэн байгуулах тухай баримт бичиг, тэдгээрт орсон өөрчлөлт болон ЭӨ-ийн мэдээллийг хадгалах үүрэгтэй.

307. Монгол Улсад экспресс траст, түүнтэй адил төстэй бүтэц, чиг үүрэг бүхий гэрээ, бусад зохицуулалт бүхий этгээд байгуулахыг хуулиар хориглосон байдаг<sup>69</sup>.

*Хуулийн этгээдийн МУТС эрсдэлийг тодорхойлж үнэлэх нь*

308. ҮЭҮ-нд хуулийн этгээдтэй холбоотой МУТС эрсдэлийг зохих түвшинд үнэлээгүй байна. Монгол Улс хуулийн этгээдийн төрөлтэй (тухайлбал, нийтийн болон Монгол Улсад бүртгэлтэй гадаадын компаниуд) холбоотой эрсдэлүүдийн талаар ойлголтгүй байна.

309. Суурь болон МУ гэмт хэрэгт хуулийн этгээдийг хэрхэн ашиглаж болохыг Монголын ХСБ-ууд (тухайлбал, УПЕГ) тодорхой хэмжээнд ойлгож мэдэрдэг. Харин бусад байгууллага (тухайлбал, ОӨУБЕГ)-ын энэ талаарх мэдлэг тааруухан байна. Хуулийн этгээдүүдийг хянах, эрсдэлийг хуулийн этгээдийн төрөлтэй нь уялдуулан таних нэгдсэн тогтолцоо алга байна.

310. Монгол Улсын хуулийн этгээдтэй холбоотой ТС эрсдэл, эмзэг байдлын талаарх ойлголт туйлын нимгэн байна.

311. Монгол Улс экспресс траст, түүнтэй адил төстэй бүтэц, чиг үүрэг бүхий гэрээ, бусад зохицуулалт бүхий этгээд байгуулахыг хуулиар хориглосон байдаг. Гадаадын трастууд нь Монголын эдийн засагт онцгой хамаарах зүйл биш болох нь Монгол Улсад ажиллах үеэр тодорхой болсон. Монгол Улсад гадаадын трастуудыг бий болгох эсхүл удирдахад СББМҮҮ-д оролцдог гэх баримт алга. Гэсэн хэдий ч Монгол Улс эрх зүйн гэрээ, бусад зохицуулалт бүхий этгээдтэй холбоотой (тухайлбал, гадаадын эрх зүйн гэрээ, бусад зохицуулалт бүхий этгээд) МУТС эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгээгүй болно.

*Хуулийн этгээдийг урвуулан ашиглахаас сэргийлэх арга хэмжээ*

312. Хуулийн этгээдийг урвуулан ашиглахаас сэргийлэх зарим арга хэрэгсэл Монгол Улсад байдаг. Хуулийн этгээдийн үүсгэн байгуулалт болон өөрчлөлттэй холбоотой баримт бичгүүд (Зөвлөмж 24-ийг үз) нь үндсэн мэдээлэл болж өгнө. Гэвч ОӨУБЕГ-т мэдээллийн үнэн зөвийг (тухайлбал, гадаадын хуулийн этгээдтэй холбоотой) шалгах боломж байхгүй аж.

---

<sup>69</sup> Монгол Улс Иргэний хуулийн 406-р зүйлийн дагуу итгэлцлийн трастыг “траст гэрээ” хэлбэрээр зохицуулсан хууль тогтоомжтой. 2008 онд Банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээний журам батлагдсанаар “траст гэрээ”-ний бүтэц, чиг үүрэг тодорхой болжээ. Эндээс үнэлгээний баг энэхүү механизм нь экспресс траст буюу түүнтэй адил төстэй бүтэц, чиг үүрэгтэй хуулийн механизм биш гэдгийг тогтоосон болно.

## **БҮЛЭГ 7. ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛОН БУСАД ЗОХИЦУУЛАЛТ БҮХИЙ ЭТГЭЭДҮҮД**

313. Баримт бичгийн бүрдүүлбэр дутуу, үүсгэн байгуулах баримт бичиг нь хуульд заасан шаардлага хангаагүй эсхүл хуурамч болох нь тогтоогдсон бол ОӨУБЕГ нь шинээр үүсгэн байгуулсан, өөрчлөн байгуулагдсан, татан буугдсан зэрэг өөрчлөлтийг бүртгэхээс татгалзаж болно.

314. Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн дагуу 2015 оны 8 дугаар сараас 2016 оны 2 дугаар сарын хооронд хуулийн этгээдэд бүртгэлийн мэдээллээ шинэчлэх боломжийг олгож, хариуцлагаас чөлөөлөхөөр заасан байна. Энэхүү арга хэмжээ хэр үр дүнтэй болсныг Монгол Улс мэдээлээгүй болно.

315. Компанийн тухай хуулийн 3.7 болон 4.2 дахь заалт нээлттэй хувьцаат компанийн гаргасан шилжүүлгийн хувьцааг нээлттэй зах зээлд арилжаалахаас өмнө үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлэхээр тодорхойлсон байдаг. Хувьцааг үүнээс өөр аргаар шилжүүлэх тохиолдолд шилжүүлгийг нэн даруй үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлэх ёстой.

316. МУТСТ хууль болон УТНБЭ-ын дагуу СБ-ууд болон СББМҮҮ-ид хуулийн этгээд харилцагчийг таньж мэдэхийг (үүний дотор ЭӨ) шаарддаг. Гэхдээ ШХ.4-т авч үзсэнчлэн: (1) санхүүгийн салбар дахь ХТМ үйл явц харилцан адилгүй байна. Тухайлбал, зөвхөн томоохон банк болон ББСБ-ууд үүнийг ойлгож, хэрэгжүүлж байна; (2) харин ХТМ өргөтгөсөн шаардлагыг томоохон банкууд хүртэл биелүүлэхэд хүндрэлтэй байгаа нь УТНБЭ батлагдаад удаагүй байгаатай холбоотой. СББМҮҮ-ид ХТМ ажлыг хийж гүйцэтгэдэг нь тодорхойгүй байна.

*Хуулийн этгээдийн болон эцсийн өмчлөгчийн талаар зохих, үнэн зөв, сүүлийн үеийн анхан шатны мэдээллийг тухай бүр авах боломж*

317. ТЕГ, УПЕГ, АТГ нь ОӨУБЕГ-ын мэдээллийн сангаас хуулийн этгээдийн мэдээллийг тухай бүр авах эрхтэй. ОӨУБЕГ-аас мэдээллийг шалгах боломжгүй нь мэдээллийн чанарын асуудлыг дагуулахаар байна. Мөн мэдээллийг шинэчлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлага хөнгөдөж байна. ЦЕГ-аас бидэнд өгсөн мэдээллээр бол МУ-тай холбоотой мөрдлөх үйл ажиллагааны 73%-д нь хуулийн этгээдийг урвуулан ашигласан асуудал хөндөгддөг ба ОӨУБЕГ-аас гаргуулан авсан холбогдох мэдээлэл нь бодитой бус, хуучирсан байдаг ажээ.

318. ХСБ-ууд, СМА нь харилцагчийн (тухайлбал, ЭӨ) талаарх мэдээллийг тухай бүр авах боломжтой. Гэхдээ ШХ.4-т авч үзсэнчлэн: (1) санхүүгийн салбар дахь ХТМ үйл явц харилцан адилгүй байна. Тухайлбал, зөвхөн томоохон банк болон ББСБ-ууд ХТМ өргөтгөсөн шаардлагыг хэрэгжүүлж байна; (2) СББМҮҮ-ид ХТМ ажлыг хийж гүйцэтгэдэг эсэх нь тодорхойгүй байна; (3) ХТМ үйл явцаас шалтгаалан МҮЭ-үүд бизнесийн саналаас татгалзсан эсхүл бизнесийн харилцаагаа тасалсан гэх баримтыг Монгол Улс гаргаж өгөөгүй болно, мөн (4) биднийг Монголд очихоос өмнөхөн УСҮАЖ батлагдсанаар ЭӨ-ийн өргөтгөсөн шаардлагыг тавьдаг болсон байна. Иймд ХСБ-ууд ЭӨ-ийн талаар мэдээлэл авах эрхтэй ч гэсэн мэдээлэл нь бодитой бус эсвэл хуучирсан байх боломжтой.

## **БҮЛЭГ 7. ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛОН БУСАД ЗОХИЦУУЛАЛТ БҮХИЙ ЭТГЭЭДҮҮД**

*Хуулийн бусад зохицуулалт бүхий этгээдийн эцсийн өмчлөгчийн талаар зохих, үнэн зөв, сүүлийн үеийн анхан шатны мэдээллийг тухай бүр авах боломж*

319. Дээр өгүүлсэнчлэн Монгол Улс экспресс траст, түүнтэй адил төстэй бүтэц, чиг үүрэг бүхий гэрээ, бусад зохицуулалт бүхий этгээд байгуулахыг хуулиар хориглосон байдаг. Гадаадын трастууд нь Монголын эдийн засагт онцгой хамаарах зүйл биш юм. Монгол Улсад гадаадын трастуудыг бий болгох эсхүл удирдахад СББМҮҮ-д оролцдог гэх баримт алга. Гадаадын эрх зүйн гэрээ, бусад зохицуулалт бүхий этгээд Монгол Улсад байлаа гэхэд ХСБ-ууд болон СМА нь МэҮЭ-ээс ЭӨ-ийн талаарх мэдээллийг шуурхай авч чадахаар байна. Гэхдээ дээр өгүүлсэнчлэн, санхүүгийн салбар дахь ХТМ үйл явц харилцан адилгүй байна. Тухайлбал, зөвхөн томоохон банк болон ББСБ-ууд ХТМ өргөтгөсөн шаардлагыг хэрэгжүүлж байгаагийн дээр Монгол улс хуулийн бусад зохицуулалт бүхий этгээд, гэрээтэй холбоотой МУТС эрсдэлийн үнэлгээг хийгээгүй байна.

*Торгууль шийтгэлийн үр нөлөө, тохирсон болон давтан үйлдэхээс сэргийлэхүйц байдал*

320. Бүртгэлийн шаардлагыг биелүүлээгүй хувь хүн, хуулийн этгээдтэй ОӨУБЕГ-аас хариуцлага тооцсон гэх баримт алга. Түүнчлэн 3.24-т дурьдсанчлан, шийтгэл нь давтан үйлдэхээс сэргийлэхүйц байж чадахгүй байна.

321. ШХ.3-т авч үзсэнчлэн, ХТМ үүргээ биелүүлээгүй МэҮЭ-эд давтан үйлдэхээс хариуцлага тооцсон тохиолдол алга байна.

*Шууд хэрэгжилт 5: Ерөнхий дүгнэлт*

**322. Монгол Улсын Шууд хэрэгжилт 5-н хэрэгжилт доогуур түвшинд байна.**

## БҮЛЭГ 8. ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

### *Дүгнэлт ба хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж*

#### **Дүгнэлт**

- Монгол Улс Эрүүгийн байцаан шийтгэх хууль, хоёр талын гэрээ, олон улсын бусад механизмын дагуу ЭЗХТ үзүүлэх, гэмт хэрэгтэн шилжүүлэх боломжтой. Албан ёсны гэрээ байхгүй байлаа ч Монгол Улс харилцан дэмжлэг үзүүлэх зарчмын дагуу туслалцаа үзүүлэх боломжтой.
- Монгол Улс нь суурь болон МУ гэмт хэрэгтэй холбоотой ЭЗХТ үзүүлэх, хэрэгтэн шилжүүлэх талаар улс хоорондын болон бус нутгийн хэмжээнд үр дүнтэй хамтран ажиллаж байна. Гагцхүү туслалцааг шуурхай үзүүлэх тал дээр саяхныг хүртэл асуудалтай байв.
- Монгол Улс суурь болон МУ нэлээдгүй олон гэмт хэрэг дээр ЭЗХТ эрэлхийлж байгаа бөгөөд гадагш нь явуулсан ЭЗХТ хүсэлт, тоо мэдээллийг үнэлгээний багт танилцуулсан болно.
- Монгол Улсад үндэсний түвшинд хамтран ажиллах албан ёсны механизм бий. Гэвч хамтын ажиллагааны дэгийг нарийвчлан заагаагүй нь олон улсын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоонд сөргөөр нөлөөлж байна.
- Монгол Улс ТС-тэй холбоотойгоор ЭЗХТ, хэрэгтэн шилжүүлэх хүсэлт гаргах буюу хүлээн авч байгаагүй болно.
- ХСБ-ууд болон СМА нь гадаад түншүүдтэй мэдээлэл солилцоходоо харилцан ойлголцлын санамж бичиг, Эгмонт Бүлгийн Secure Web болон Интерполын I-24/7 холболтыг ашиглаж байна. Хамтын ажиллагааны өөр арга хэлбэрүүдийг Монгол Улс төдийлөн ашигладаггүй байна.
- Хянан шалгагчдын олон улсын хамтын ажиллагаа нь гадны лавлагаанд хариу өгсөн СЗХ-ны 2 тохиолдлоор хязгаарлагдана. Хяналт шалгалт, эцсийн өмчлөгчтэй холбоотой мэдээллийг гадны байгууллагатай солилцсон тохиолдол байхгүй аж.

#### **Хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж**

- Эрх бүхий байгууллагууд (санхүүгийн хянан шалгагчид мөн) санамж бичиг болон бусад хоёр талт механизмыг ашиглан гадаад хамтын ажиллагааг бий болгох, бэхжүүлэх, чадавхи ахиулбал зохино.
- Монгол Улс ЭЗХТ-г тухай бүр, чанартай үзүүлэхийн тулд үндэсний хэмжээний зохицуулалтын механизм, түүний үйл ажиллагааны дэг журмыг бий болгон, олон улсын хамтын ажиллагааны статистикийг бүрдүүлбэл зохино.
- ЭӨ-ийн талаарх мэдээлэл солилцоог дөхөмтэй болгохын тулд Монгол Улс ОӨУБЕГ-т ЭӨ-ийн үнэ зөв, бодитой мэдээллийг олж авах нөхцөлийг бүрдүүлэх нь зүйтэй (ШХ.5 үзнэ үү).

## БҮЛЭГ 8. ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

323. Энэхүү бүлэгт хамаарах Шууд хэрэгжилт нь ШХ2 болно. Энэхүү хэсгийн үр дүнгийн үнэлгээнд хамаарах зөвлөмж нь 3.36-40 болно.

### *Шууд хэрэгжилт 2 (Олон улсын хамтын ажиллагаа)*

*ЭЗХТ, хэрэгтэн шилжүүлэх туслалцааг түргэн шуурхай, чанартай гүйцэтгэх*

324. Монгол Улс Эрүүгийн байцаан шийтгэх хууль, хоёр талын гэрээ, олон улсын бусад механизмын дагуу ЭЗХТ үзүүлэх, гэмт хэрэгтэн шилжүүлэх боломжтой. Албан ёсны гэрээ байхгүй байлаа ч Монгол Улс харилцан дэмжлэг үзүүлэх зарчмын дагуу туслалцаа үзүүлэх боломжтой. Харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулагдаагүйн улмаас ЭЗХТ үзүүлээгүй тохиолдол байхгүй аж.

325. Монгол Улс ЭЗХТ үзүүлэх 28 гэрээг 20 оронтой<sup>70</sup>, хэрэгтэн шилжүүлэх 15 гэрээг 15 улстай байгуулжээ<sup>71</sup>.

326. Эрүүгийн шинжтэй ЭЗХТ буюу хэрэгтэн шилжүүлэх хүсэлтийг ХЗДХЯ болон УПЕГ хүлээн авах үүрэгтэй боловч гол төлөв ГХЯ, элчин сайдын яамдын шугамаар ирдэг аж.

327. ЭЗХТ-ны талаарх тоо мэдээ зөрүүтэй байв. Тухайлбал, ҮЭҮ-нд тусгагдсан, АНДББ-ад хүргүүлсэн, Үнэлгээний багт танилцуулсан тоо мэдээлэл өөр хоорондоо зөрүүтэй байв<sup>72</sup>. Бидэнд ирүүлсэн мэдээллээс харахад 2014-2016 оны хооронд УПЕГ нийт 31 ЭЗХТ хүсэлт хүлээн авснаас (Хүснэгт 28) хулгай болон залилан тус бүр 20%, татвараас зайлсхийх болон хүн амины хэрэг тус бүр 10%-ийг эзэлж байна.

328. Дээрх хүсэлтийн дийлэнхийг Монгол Улс шийдвэрлэсэн байна (Хүснэгт 28). 4 тохиолдолд татгалзсан нь хамааралгүй буюу/болон албан бус мэдээлэл байсантай холбоотой ажээ. Хүсэлтийг нь нааштай шийдвэрлэсэн улс орны тоонд ОХУ, Казахстан, Польш, Солонгос, Турк, Унгар, АНУ, Беларусь орж байна.

### **Хүснэгт 28: УПЕГ -ын хүлээн авсан ЭЗХТ үзүүлэх, хэрэгтэн шилжүүлэх хүсэлт**

| Хүсэлтийн тоо, төрөл           | 2014 | 2015 | 2016 |
|--------------------------------|------|------|------|
| <b>ЭЗХТ</b>                    |      |      |      |
| Хүлээн авсан хүсэлтийн тоо     | 5    | 16   | 10   |
| Шийдвэрлэсэн хүсэлтийн тоо     | 4    | 14   | 6    |
| Хянагдаж буй хүсэлтийн тоо     | 0    | 0    | 3    |
| Татгалзсан хүсэлтийн тоо       | 1    | 2    | 1    |
| <i>Гэмт хэрэгтэн шилжүүлэх</i> |      |      |      |
| Хүлээн авсан хүсэлтийн тоо     | 1    | 2    | 2    |
| Шийдвэрлэсэн хүсэлтийн тоо     | 0    | 1    | 0    |
| Хянагдаж буй хүсэлтийн тоо     | 0    | 1    | 1    |
| Татгалзсан хүсэлтийн тоо       | 1    | 0    | 1    |

329. 2015 онд Монгол Улс 1 хүнийг хөрөнгө шамшигдуулсан хэргээр Солонгос Улсад шилжүүлжээ. 2 хүсэлт хянагдаж байгаа бол 2 хүсэлтийг хүлээн авахаас татгалзжээ. Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу Монгол Улсын иргэнийг өөр улсад шилжүүлэн

<sup>70</sup> Болгар, Канад, Хятад, Куба, Чех, БНАСАУ, Энэтхэг, Франц, Хонконг, Унгар, Казахстан, Киргизстан, Польш, Румын, ОХУ, Словак, Солонгос, Турк, Украин, Вьетнам.

<sup>71</sup> Эдгээрийн тав нь тусдаа гэрээ (Хятад, Энэтхэг, Хонконг, Казахстан, Солонгос) ба бусад улсын заалтууд нь ерөнхий ЭЗТХҮГ-г орсон

<sup>72</sup> Тухайлбал, нэг улс Монгол улсаас ХЭЗХТ-ны хүсэлтийг 5 удаа явуулсан гэсэн боловч УПЕГ тухайн улсаас ердөө 1 хүсэлт ирүүлсэн гэжээ.

## БҮЛЭГ 8. ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

өгөхийг хориглодог тул ийнхүү татгалзсан хариу өгсөн байна. Эдгээр хүсэлтийн аль нь ч МУТС-тэй холбоотой байгаагүй ажээ.

330. Бидэнд ЭЗХТ болон хэрэгтэн шилжүүлэх хүсэлтэд зарцуулсан хугацааны талаарх мэдээлэл ирээгүй ч Монгол Улс энэ тал дээр дорвитой ахисан нь ҮЭҮ-ээс харагдана. Тухайлбал, 2014 онд бүх хүсэлтийг шийдвэрлэхэд 2 сараас 2 жил, 2015 онд 14-90 хоног, 2016 онд 30-60 хоногийг тус тус зарцуулж байжээ. Энэ нь Монгол Улс хүсэлтийг дунджаар 90-300 хоногт хангалттай сайн шийдвэрлэдэг гэх түншүүдийн үнэлэмжтэй нийцтэй байгаа юм.

331. Монгол Улс ТС-тэй холбоотой ЭЗХТ болон хэрэгтэн шилжүүлэх хүсэлт хүлээн авч байгаагүй нь тус асуудлаарх үнэлгээний багийн төсөөлөлтэй нийцтэй байна.

332. Дүгнэн хэлэхэд Монгол Улс ЭЗХТ үзүүлэх, хэрэгтэн шилжүүлэх талаар (тухайлбал, МУ гэмт хэрэг) улс хоорондын болон бус нутгийн хэмжээнд үр дүнтэй хамтран ажиллаж байна. Туслалцааг түргэн шуурхай үзүүлэх тал дээр саяхныг хүртэл доголдолтой байжээ.

*Үндэстэн дамнасан шинжтэй дотоодын МУ, түүнтэй холбоотой суурь болон ТС хэргүүд дээр эрх зүйн туслалцаа эрэх*

333. Гадагш нь илгээсэн ЭЗХТ-ны хүсэлтийн статистик мэдээлэл үнэлгээний багт ирээгүй болно. УПЕГ-аас гадагш нь 74 ЭЗХТ авах хүсэлт, үүнээс 54-ийг 2015-2016 онд илгээжээ. Эдгээрээс 2015 онд 2 нь МУ-тай холбоотой байсан бөгөөд Герман, Польш улсад хаягласан хүсэлт байжээ (кейс судалгааг дор үзнэ үү).

### **Кейс 1. АНУ: Цахим шилжүүлгийн залилан, МУ**

2015 онд АНУ болон Монголд зэрэг мөрдөгдөж байсан цахим гүйлгээний залилан, МУ-тай холбоотойгоор Монгол Улс АНУ-д ЭЗХТ үзүүлжээ. Гэмт хэрэгтнүүд хуурамч баримт бичиг үйлдэн АНУ-ын банкуудыг ашиглан олон улс орны иргэдийг хууран мэхлэх ажиллагаа явуулж байжээ. Монгол Улс банк, жуулчдын бүртгэл, шүүхийн шинжилгээ, цахим төхөөрөмжийн хуулбар, хариуцагч болон гэрчийн мэдүүлгийг хүргүүлэх зэргээр туслалцаа үзүүлжээ. Монгол болон АНУ ЭЗХТ үзүүлэх гэрээ байгуулаагүй тул Монгол Улс эрх бүхий талаас албан ёсны хүсэлтийг хүлээн авмагцаа ЭЗХТ-ааг 3 сарын дотор шийдвэрлэжээ<sup>73</sup>.

### **Кейс 2: БНСУ: Залилан болон МУ-тай холбоотой ЭЗХТ**

2015 онд Монгол Улс залилан, МУ-тай холбоотойгоор ЭЗХТ-г Солонгос Улсад үзүүлсэн байна. Сэжигтний эхнэр Монголд боловсролын байгууллагын үйл ажиллагаа эрхэлдэг аж. Түүний данс руу тодорхойгүй эх үүсвэрээс хөрөнгө шилжсэн байв. Сэжигтэн гэмт хэргээ халхлахын тулд компанийн нэрийг барьдаг байжээ. Хөрөнгийн урсгалыг тогтоохын тулд тус компаний нэр дээр гадаадад нээсэн банкны дансны мэдээллийг Монгол Улсаас хүсчээ. ЦЕГ-аас анх шалгахад ямар нэгэн сэжигтэй гүйлгээг илрээгүй ба Солонгосын талаас нэмэлт хүсэлт тавиагүй аж. Монгол Улс туслалцааг 3 сарын дотор үзүүлсэн.

### **Кейс 3: Солонгос руу буцаан шилжүүлсэн хөрөнгө**

Монгол Улс 2013 онд БНСУ-аас Интерполоор дамжуулан Монголд зочид буудлын бизнес эрхэлдэг Солонгосын иргэнтэй холбоотой хүсэлт хүлээн авчээ. Тэрбээр хууль бус мөрийтэй тоглоомоос олсон мөнгөөрөө Улаанбаатарт зочид буудал барьсан байв. Сөүлийн шүүхийн 2009 онд түүнийг МУ хэргээр яллаж 4.5 сая ам.доллар (10 тэрбум төгрөг) хураах шийдвэр гаргажээ. Монголын ХСБ-ууд яллагдагч тус зочид буудлын 65%-ийг өөр 2 хүнд (мөн Солонгосын иргэд) шилжүүлснийг тогтоожээ. Иймд үлдэх 35%-ийг хураан авч 210,000 ам.долларыг Солонгос руу буцаасан байна. Хүсэлтийг 10 сарын дотор шийдвэрлэсэн байна.

334. ЭЗХТ хүсэлтийн дийлэнхийг залилан эзэлж байна (Монголын өндөр эрсдэлтэй суурь гэмт хэргийн нэг). Мөн өндөр эрсдэлтэй МУ гэмт хэрэг дээр Монгол Улс хүсэлт гаргаж байгаагүй аж. ЭЗХТ-ы газар зүй нь бүс нутгийн томоохон тоглогчдыг хамарч байна. Тухайлбал, 2015-2016 оны нийт ЭЗХТ-нд Хятад 18.5%, ОХУ 27%, Солонгос 15% тус тус эзэлж байна.

335. Монгол Улс МУ-тай холбоотойгоор хэрэгтэн шилжүүлж авах хүсэлт тавьж байгаагүй нь улс орны эрсдэлийн илрэл болохооргүй байна.

<sup>73</sup> 2017 оны 6 сард энэхүү залилан, МУ хэрэгтэй холбоотой гэмт хэрэгтнүүдийг анхан шатны шүүх 13-15 жил хорих ял оногдуулж эд хөрөнгийг хураах шийдвэр гаргасан.

## БҮЛЭГ 8. ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

### Кэйс 4: Хэд хэдэн улсаас хүссэн ЭЗХТ– МУ тохиолдол

АТГ нь УПЕГ-аар дамжуулан 2015 онд Герман, Солонгос, Сингапур, Хонгконг, АНУ болон Швейцар улсаас ноён Э-тэй холбоотой ЭЗХТ хүсчээ. Тэрбээр МУ, авлига өгсөн, төрийн албан тушаалтны эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашигласан, хөрөнгө завшиж шамшигдуулсан, гүйцэтгэх ажлын хууль тогтоомжийг зөрчсөн гэх хэргээр шалгагдаж байгаа аж. Монгол Улс зөвхөн 1 улсаас хариу авсан бөгөөд мөрдөн шалгах ажиллагаа үргэлжилж байгаа болно.

### Кэйс 5: Герман руу илгээсэн ЭЗХТ хүсэлт – МУ хэрэг

Ноён К Монгол Улсын иргэн хатагтай ММ-тэй хуйвалдан 2015 онд Монголд мөнгө угаасан. Герман руу гэрчийн мэдүүлэг авах болон эрүүгийн хэргээс материал авах хүсэлт явсан. Хэргийн явцтай холбоотой мэдээллийг талууд тогтмол солилцож байсан. Германы тал ЭЗХТ хүсэлтийг баталгаажуулахыг хүссэний дагуу Монголын УПЕГ-аас зохих хариуг өгсөн. Үүний дараагаар хүн амины хэрэг болон мөнгө угаахтай холбоотойгоор хэрэгтэн шилжүүлэх хүсэлт гаргасан. Мөрдөн шалгах үйл ажиллагаа үргэлжилж байна.

### Кэйс 6: Польш руу илгээсэн ЭЗХТ хүсэлт

Нигер улс дахь гэмт хэрэгтнүүд 2015 онд А компанийн нэрээр хуурамч цахим шуудангийн хаяг нээн тус хаягаас В.Т рүү цахим захидал илгээснээр В.Т нь 2015 оны 8 сарын 28-наас 9 сарын 22-ны хооронд Польшийн банк руу бүтээгдэхүүний төлбөр болгон 35,000 ам.доллар шилжүүлсэн байна. Монгол Улсаас банкны бүртгэл болон данс эзэмшигчийн мэдээлэл хуваалцахыг хүссэн. Эдгээр банкны дансан дахь залилагдсан нийт 35,000 ам.доллартай тэнцэх мөнгө эсхүл хөрөнгийг битүүмжлэх хүсэлтийг мөн тавьсан. Эрх бүхий байгууллагууд хүсэлтийг шийдвэрлэсэн байна.

336. ХСБ-ууд мөрдөн шалгах ажилд ЭЗХТ-ны ач холбогдлыг цохон тэмдэглэж, хариуг цаг тухайд нь авч чадахгүй байгааг үнэлгээний багт дурдаж байв. УПЕГ-аас хүсэлт явуулсны дараа хамтран ажиллах захиа явуулах буюу солилцох давтамжийг нэмэгдүүлэх замаар мөрдөн шалгах ажиллагааг идэвхжүүлэх шаардлага гарч байсныг сүүлийн 3 жилийн жишээнүүдээр тайлбарлаж байсан. Эдгээрт Хятад, Герман, ОХУ, Нидерланд, Хонгконг, Солонгос, Австрали, Казахстан, Канад, АНУ зэрэг улс орж байна. Гэхдээ дүгнэн хэлэхэд Монгол Улс ЭЗХТ-ийг бусад орноос эрэлхийлэхэд төдийлөн хүчин чармайлт гаргахгүй байна.

337. Монгол Улс ТС-тэй холбоотойгоор ЭЗХТ авах, хэрэгтэн шилжүүлэх хүсэлт гаргаж байгаагүй аж. Энэ нь Монгол Улсын ТС-ийн эрсдэлийн талаарх төсөөлөлтэй нийцэж байна.

*МУТСТ олон улсын хамтын ажиллагааны бусад арга хэлбэрийг эрэлхийлж ашиглах*

*СМА*

338. СМА нь олон улсын хамтын ажиллагаанд (ялангуяа, дүн шинжилгээний шатанд) идэвхтэй оролцдог. СМА нь 18 улс оронтой, үүний дотор бүс нутгийн түншүүдтэй

## БҮЛЭГ 8. ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

хамтран ажиллах санамж бичиг<sup>74</sup> байгуулжээ. СМА нь Эгмонт бүлгийн гишүүний хувьд бусад санхүүгийн мэдээллийн албадтай мэдээлэл солилцсоор иржээ (Хүснэгт 29, 30).

**Хүснэгт 29: СМА-ны Эгмонтын шугамаар хүлээн авсан хүсэлт**

|   | 2013   | 2014                   | 2015   | 2016   |
|---|--|------------------------|--|--|
| Хүлээн авсан хүсэлт, бүгд                                   | 11   | 6                      | 13   | 11   |
| Зөвхөн СМА руу илгээсэн хүсэлт                              | 4  | 2                      | 3  | 4  |
| Хэд хэдэн улсад илгээсэн хүсэлт                             | 7  | 4                      | 10   | 7  |
| Зөвхөн СМА-нд илгээсэн хүсэлтийн шалтгаан                   | Хөрөнгө шамшигдуулсан; ТС/МУ; Монголын УТНБЭ; МУ | МУ; мэдээлэл цуглуулах | Мэдээлэл цуглуулах; хөрөнгө завших болон МУ; Цахим залилан | Хөрөнгө оруулалтын залилан; Цахим залилан; МУ эрүүгийн ажиллагаа |
| <i>Зөвхөн СМА-нд хаягласан хүсэлтэд хариу өгсөн хугацаа</i> |  |                        |  |  |
| Хамгийн бага хугацаа  | 1 сар  | 13 өдөр                | 24 өдөр  | 6 өдөр   |
| Хамгийн урт хугацаа   | 6 сар  | 28 өдөр                | 1 сар  | 40 өдөр  |
| Дундаж хугацаа  | 2.75 сар   | 20.5 өдөр              | 28 өдөр  | 18.25 өдөр   |

**Хүснэгт 30: СМА-ны Эгмонтоор дамжин явсан хүсэлт**

|  | 2013   | 2014   | 2015  | 2016  |
|--|--|--|---|---|
| Илгээсэн хүсэлт, бүгд                  | 20   | 8  | 18  | 34  |
| Хүсэлт илгээсэн шалтгаан <sup>75</sup> | Нийтийн хөрөнгө шамшигдуулсан; МУ; Залилан болон МУ; | Нийтийн хөрөнгө шамшигдуулсан болон мөнгө угаасан (3); Залилан (2); Залилан болон МУ (1); Татвараас зайлсхийх болон МУ (2) | Цахим залилан (5); Нийтийн хөрөнгө шамшигдуулсан болон мөнгө угаасан (5); Залилан болон МУ (6); МУ (2); | Цахим залилан (7); Нийтийн хөрөнгө шамшигдуулсан болон мөнгө угаасан (2); Залилан болон МУ (15); МУ (10); |
| <i>Хариу өгсөн хугацаа</i>             |  |  |   |   |
| Хамгийн бага хугацаа                   | 1 өдөр   | 7 өдөр   | 2 өдөр  | 3 өдөр  |
| Хамгийн урт хугацаа                    | 4 сар  | 8 сар  | 5 сар   | 3 сар   |
| Дундаж хугацаа                         | 59 өдөр  | 50 өдөр  | 39 өдөр   | 40 өдөр   |

339. Гадаадын санхүүгийн тагнуулын албадыг хаягласан дээрх хүсэлтүүдийг дүн шинжилгээ хийх шатанд хүргүүлсэн, түүнээс биш СМА санамсаргүй байдлаар гэнэт хүргүүлсэн явдал биш болох нь тодорхой байна.

### *УПЕГ болон ЦЕГ*

340. УПЕГ нь ОХУ, Хятад, Солонгос зэрэг бүс нутгийн хэд хэдэн түнштэй харилцан ойлголцлын санамж бичиг буюу гэрээ байгуулжээ. Монгол Улс Интерполын гишүүний хувьд эл сүлжээг мэдээлэл өгч авахад идэвхтэй ашиглаж байна (Хүснэгт 31). Түүнчлэн 2013 онд Дорноговь аймгийн цагдаагийн газар Хятадын Эрээн хотын гааль, цагдаагийн газартай терроризм, МУ болон хууль бус мансууруулах бодисын наймааны талаар

<sup>74</sup> Афганистан, Бангладеш, Беларусь, Хятад, Япон, Казахстан, Малайз, Мексик, Молдав, Балба, Филиппин, ОХУ, Словени, Өмнөд Солонгос, Шри Ланка, Тайван, Турк, Украин.

<sup>75</sup> хүсэлтийн тоо хаалтан дотор

## БҮЛЭГ 8. ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

хамтран ажиллах санамж бичиг байгуулжээ. Үүний хүрээнд Монгол Улс нийт 17 хүсэлт хүлээн авч, 10 хүсэлтийг гаргажээ.

### Хүснэгт 31: Интерполоор МУ талаар солилцсон мэдээлэл

|                            | 2013 | 2014 | 2015 |
|----------------------------|------|------|------|
| <b>Хүлээн авсан хүсэлт</b> | 38   | 3    | 28   |
| <b>Илгээсэн хүсэлт</b>     | 0    | 0    | 0    |

#### *Гааль*

341. Гаалийн зүгээс олон улсын хамтын ажиллагааг илтгэх статистик эсхүл ямар нэгэн тоо баримт бидэнд өгөөгүй болно. Гааль нь мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулдаг байгууллага биш юм. Гааль нь ОХУ, Хятад зэрэг 16 улс оронтой хамтын ажиллагааны болон ЭЗХТ үзүүлэх гэрээтэй.

#### *ТЕГ*

342. ТЕГ нь МУ болон суурь гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны нэлээдгүй хувь нь олон улсын хамтын ажиллагаа хамардаг гэх мэдээллийг бидэнд өгсөн. Мэдээллийн нууцлалаас шалтгаалан бидэнд нарийвчилсан тоо мэдээлэл өгөх боломжгүй байв.

#### *АТГ*

343. АТГ нь Хятад, Солонгос, Тайландтай ХОСБ-тэй боловч үүний хүрээнд МУ болон суурь гэмт хэрэгтэй холбоотой мэдээлэл солилцсон эсэх нь тодорхойгүй байна.

344. Монголын ХСБ-ууд Интерпол болон ХОСБ-ээр дамжуулан олон улсын хамтын ажиллагаанд ямар нэгэн байдлаар оролцож байна хэмээн бид дүгнэж байна. Гагцхүү энэ ажлыг улам идэвхжүүлэхэд идэвх зүтгэл, санаачилга дутуу харагдаж байна.

#### *Хянан шалгагчид*

345. Монголбанк төв банкуудтай мэдээлэл солилцох бусад зохицуулалт бүхий этгээдтэй (тухайлбал, ХОСБ) хэрхэн мэдээлэл солилцож буйгаа бидэнд харуулаагүй болно. Санхүүгийн салбар дахь гадны оролцооны хувьд гэвэл дотоодын банкнуудын өөрийн хөрөнгийн тодорхой хэсгийг гадаадын хөрөнгө оруулалт бүрдүүлэх ажээ.

346. Сүүлийн 2 жилийн хугацаанд СЗХ гадны 2 хүсэлт (Хонгконг болон Мальт) хүлээн авч хоёуланд нь хариулжээ. СЗХ нь гадаадын түншүүдээс мэдээлэл хүсч байгаагүй аж. Гэтэл банкны бус салбарт охин компаниа ажиллуулж буй гадны аж ахуй нэгж хэд байгаа нь тодорхойгүй байгаа юм.

#### *Хуулийн этгээд/бусад зохицуулалт бүхий этгээдийн анхан шатны болон эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл солилцоо*

347. Монгол Улс анхан шатны эсхүл эцсийн өмчлөгчийн талаар мэдээлэл солилцож байгаагүй. Ийм мэдээллийг солилцохыг хязгаарласан хуулийн хязгаарлалт байхгүй ба тухайлбал, ГХЯ болон элчин сайдын яамдын шугамаар үүнийг гүйцэтгэх боломжтой. ОӨУБЕГ саяхан ОХУ дахь түнштэй хоёр талын гэрээнд гарын үсэг зурсан боловч одоогоор энэхүү бусад зохицуулалт бүхий этгээдийг ашиглаагүй байна.

348. **Монгол Улсын Шууд хэрэгжилт 2-ын хэрэгжилт дунд түвшинд байна.**

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

Энэхүү хавсралтад ФАТФ-ын 40 зөвлөмж тус бүрийн хэрэгжилтийг дэлгэрэнгүй байдлаар авч үзсэн болно. Тайланд Монгол Улсын нөхцөл байдал, эрсдэлийг бус, харин Зөвлөмж бүрийн техникийн шалгуурын дүн шинжилгээг багтаав. Хавсралтыг Харилцан үнэлгээний тайлан (ХҮТ)-тай зэрэгцүүлэн уншвал зохино.

ФАТФ-ын шаардлага, Монгол Улсын хууль тогтоомжийн аль аль нь өөрчлөгдөөгүй нөхцөлд эл хавсралт нь 2007 оны ХҮТ-ийн (АРГ-ын цахим хуудаснаас үзнэ үү) үр дүнг ашиглаж байгаа болно.

### *Зөвлөмж 1 – Эрсдэлийн үнэлгээ, эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх*

1. Эдгээр шаардлагыг 2012 онд ФАТФ-ын зөвлөмж болгон нэмсэн тул Монгол Улсын 2007 оны ХҮТ-д үнэлээгүй болно.
2. *Шалгуур 1.1* – Монгол улс Үндэсний эрсдэлийн үнэлгээ (ҮЭҮ)-г 2016 онд гүйцэтгэж биднийг Монголд ажиллах үеэр ( 2016 оны 10-р сарын 24-нөөс 11-р сарын 4-ний өдрийн хооронд) цахим хуудастаа байрлуулсан болно. Монголбанкнаас банкуудад хийсэн эрсдэлийн үнэлгээг эс тооцвол бусад секторын МУТС эрсдэлийн үнэлгээний мэдээлэл бидэнд ирээгүй болно.
3. ҮЭҮ-г боловсруулах ажлыг СМА тэргүүлж, ХАЗ-ийн гишүүдээс бүрдсэн Ажлын хэсэг оролцсон байна.
4. ҮЭҮ нь гол төлөв эрсдэлийг тодорхойлоход чиглэгджээ. Харин дүн шинжилгээ хийхэд дутуу анхаарсан ба Монгол Улсын МУТС аюул заналхийлэл, үр дагавар, сул талыг цогц байдлаар авч үзээгүй аж.
5. ҮЭҮ-нд өндөр эрсдэлтэй дараахь суурь гэмт хэргийг авч үзжээ (ач холбогдлын эрэмбээр). Үүнд: (i) залилан, (ii) байгаль орчны эсрэг гэмт хэрэг, (iii) татвараас зайлсхийх, (iv) авлига.
6. ҮЭҮ-нд дараах өндөр эрсдэлтэй салбарыг тодорхойлжээ: (i) банк, (ii) үл хөдлөх хөрөнгө, (iii) нягтлан бодох бүртгэл, (iv) үнэт чулуу, металлын диллер. Эдгээрийн араас нотариатыг дунд зэргийн эрсдэлтэй, үнэт цаасны зах зээл, даатгалын салбарыг бага эрсдэлтэй хэмээн ангилжээ. Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнээс мөнгөн гуйвуулгыг хамгийн өндөр эрсдэлтэй гэж үзжээ. Гэсэн хэдий ч банкуудыг эс тооцвол эдгээр салбарын МУ эрсдэлийг зохих түвшинд тодорхойлж чадаагүй байна. Түүнчлэн, ҮЭҮ-нд Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд, нийтийн болон гадаадын компаниуд, ашгийн бус секторын МУТС эрсдэлийг үнэлээгүй байна.
7. ҮЭҮ-нд Монгол Улсын ТС эрсдэлийг тодорхойлж шинжилгээ хийхэд маш бага анхаарчээ.
8. *Шалгуур 1.2* – МУТСТ хуулийн 22 дугаар зүйлийн дагуу байгуулагдсан ХАЗ нь Монгол Улсын МУТСТ бодлогыг боловсруулах, үүний дотор МУТСТ эрсдэлийг үнэлж бууруулах үүрэгтэй субъект билээ. ХАЗ-ийн журмын 3.1-р зүйлийн дагуу ХАЗ нь Монгол Улсын МУТС эрсдэлийг үнэлэх үйл ажиллагааг зохион байгуулах, ингэхдээ бусад төрийн

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

байгууллага, хувийн хэвшил, олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллах эрхтэй. ХАЗ-д Монголбанк, СМА нь тэргүүлэх агентлагууд юм.

9. *Шалгуур 1.3* – ХАЗ-ийн ажиллах журмын 3.2-р зүйлд ХАЗ нь жил бүр Монгол Улсын МУТС эрсдэлийг үнэлэх, дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулна гэж заасан байдаг.

10. *Шалгуур 1.4* – Ажлын хэсгээс ҮЭҮ-г (i) эрх бүхий байгууллагуудад зориулсан дэлгэрэнгүй, (ii) олон нийтэд гэсэн хоёр хувилбараар боловсруулжээ. Дэлгэрэнгүй хувилбарыг ҮЭҮ-ний ажлын хэсэг, ХАЗ, Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөл (ТТАЗЗ)-өөр дамжуулан эрх бүхий байгууллагуудад тараажээ. Нийтэд зориулсан хувилбарыг Монголбанк цахим хуудастаа байршуулснаас гадна хувийн хэвшлийн томоохон компаниудад танилцуулж ХҮТ-ийн хувийг өгчээ.

11. *Шалгуур 1.5* – ҮЭҮ-г саяхан буюу 2016 оны 10 дугаар сард гүйцэтгэсэн тул Монголын эрх баригчид ҮЭҮ-нд дурьдсан эрсдэлүүдийг шийдвэрлэхүйц нөөцийн хуваарилалтыг засгийн бүх түвшинд хийж эхлээгүй байна. Гэсэн хэдий ч, Монгол Улс ҮЭҮ-нд тулгуурлан Стратегийн төлөвлөгөө боловсруулж байгаа аж.

12. *Шалгуур 1.6* – МУТСТ шаардлагаас одоогоор чөлөөлөгдөх салбаруудыг эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан хасаагүй болно.

13. *Шалгуур 1.7* – Мөнгө угаах болон терроризмыг санхжүүлэхээс урьдчилан сэргийлэх журам (УСЖ)-ын 3, 4 дүгээр бүлэгт заасны дагуу МҮЭ нь МУТСТ эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан эрсдэлийг тодорхойлох, бууруулах нарийвчилсан арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүрэгтэй. Гэсэн хэдий ч, СББМҮҮ-ийг хамрах хүрээ хангалтгүй түвшинд байна (Зөвлөмж 22, 23).

14. *Шалгуур 1.8* – Бага эрсдэлтэй үед СБ болон СББМҮҮ-ид хялбаршуулсан энгийн арга хэмжээ авдаг байх зохицуулалт Монголд байхгүй байна.

15. *Шалгуур 1.9* – Зөвлөмж 26, 38-д дурьдсанчлан, СБ-ын хяналт шалгалт дунд зэргийн, харин СББМҮҮ-ийн хяналт шалгалт их хэмжээний доголдолтой байна. СБ, СББМҮҮ нарт хүргүүлсэн МУТСТ үүрэг хариуцлагын талаарх удирдамж, заавар нь Зөвлөмж 1-д тусгагдсан үүрэг хариуцлагын өчүүхэн хэсэг нь юм. СББМҮҮ-ийг хамрах хүрээ хангалтгүй түвшинд байна (Зөвлөмж 22, 23-ыг үзнэ үү).

16. *Шалгуур 1.10* – МУТСТ хуулийн 14.1-р зүйлд зааснаар МҮЭ нь өөрийн харилцагч, бүтээгдэхүүн, үйлчилгээний МУТС эрсдэлийг үнэлэх дотоод хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх үүрэгтэй. Үүнийг МУТС-ээс урьдчилсан сэргийлэх журмын 2 дугаар бүлэгт дараах үүргээр лавшруулан тодотгожээ: (i) бүтээгдэхүүн, үйлчилгээ, хэлцэл болон хүргэлтийн газарзүйн сувгийн эрсдэлийн үнэлгээ, (ii) 2.4-т зааснаар МҮЭ нь эрсдэлийн үнэлгээгээ тухай бүр шинэчлэн баримтжуулж хянан шалгагч нарт танилцуулахад бэлэн байх үүрэгтэй. Гэвч МУТСТ хуульд ч тэр, УСЖ-д ч тэр МҮЭ нь эрсдэлээ ойлгож ухаарах ёстой тухай зүйл, заалт байхгүй төдийгүй СББМҮҮ-ийг хамрах хүрээ хангалтгүй түвшинд байна (Зөвлөмж 22, 23).

17. *Шалгуур 1.11* – УСЖ-ын 3.2 болон 3.3-т заасны дагуу МҮЭ нь өөрийн хэмжээ, мөн чанар, эрсдэл, бүтцэд тохирсон, МУТСТ эрсдэлийг удирдахуйц дотоод бодлого, дүрэм журмыг ТУЗ-өөр батлуулсан байх ёстой. 3.5-р зүйлд зааснаар, МҮЭ-ийн ТУЗ эсвэл

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

Дотоод аудитын хороо нь дотоод бодлого, дүрэм журмын хэрэгжилтийг тогтмол хянах хэрэгтэй. УСЖ-ын 4.1-ийн дагуу МҮЭ-ийн ХТМ үйл явц өндөр эрсдэлтэй харилцагч, гүйлгээний хувьд илүү нарийн байх ёстой. Гэвч нөгөө талд нь эрсдэлийг удирдах, бууруулах нарийвчилсан арга хэмжээ тусгагдаагүй байна.

18. *Шалгуур 1.12* – Монгол Улс СБ болон СББМҮҮ-дэд хялбаршуулсан арга хэмжээ авахыг зөвшөөрдөггүй байна.

### *Дүгнэлт*

19. Монгол Улс анхны МУТС ҮЭҮ-г 2016 онд гүйцэтгэжээ. Тус баримт бичигт эрсдэлийг тодорхойлоход түлхүү анхаарч харин дүн шинжилгээ хийх, ойлголтоо ахиулах асуудлыг орхигдуулжээ. ҮЭҮ-нд ТС асуудал үндсэндээ тусгагдаагүй байна. Монгол Улс эрсдэлд суурилсан аргачлалыг нэвтрүүлээгүй байна. МҮЭ-үүд өөрийн МУТС эрсдэлийг үнэлж бууруулах цогц арга хэмжээ авсан байх шаардлагатай. Мэдээлэх үүрэгтэй СББМҮҮ-ийн хүрээг зөвхөн үл хөдлөх хөрөнгийн агентууд болон нотариатчдаар хязгаарласан байна. **Монгол Улс Зөвлөмж 1-ийг хэсэгчлэн биелүүлсэн байна.**

### *Зөвлөмж 2 – Үндэсний хамтын ажиллагаа, уялдаа холбоо*

20. 2007 оны Харилцан үнэлгээгээр Монгол Улс тэр үеийн Зөвлөмж 31-ийг хагас биелүүлж байв. Тэрхүү тайланд МУТСТ хуулийн 20 дугаар зүйлийн дагуу ХАЗ-ийг байгуулах эрх зүйн орчин бүрдсэн ч байгуулагдаагүйг тэмдэглэжээ. ТС хувьд Монгол Улс МУТСТ хуулийн 20-р зүйлийн дагуу ГТАЗЗ-ийг байгуулсан ч үйл ажиллагаанд нь хамааралтай бүх этгээд оролцож чадахгүй байгаагийн дээр НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1267-р тогтоолыг хэрэгжүүлж эхлээгүй байна.

21. *Шалгуур 2.1* – Монгол Улс Үндэсний стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулсан хэдий ч ХҮБ Монголд ажиллах үеэр уг баримт бичиг батлагдаагүй байв.

22. *Шалгуур 2.2* –МУТСТ хуулийн 22-р зүйлийн дагуу байгуулагдсан ХАЗ нь МУТСТ үндэсний бодлогыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага юм. Мөн Терроризмтой тэмцэх (ТТ) тухай хуулийн 3-р зүйлийн дагуу байгуулагдсан ГТАЗЗ нь үндэсний аюулгүй байдал, тухайлбал ТС-ийг хариуцсан эрх бүхий байгууллага юм.

23. *Шалгуур 2.3* – ХАЗ нь МУТСТ хуульд болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах; мэдээлэл солилцох; Монголбанкны Ерөнхийлөгчид санал хүргүүлж СМА-ны бүтэц, төсөв, стратегийг батлуулах; Монгол Улсын МУТС эрсдэлийг үнэлэх, бууруулах; МУТС тэмцэх, урьдчилан сэргийлэх зөвлөмж, бодлогыг боловсруулах үүрэгтэй байгууллага юм.

24. ХАЗ-ийн нарийн бичгийн даргын үүргийг СМА-ны дарга гүйцэтгэх ба ХАЗ нь дараах гишүүдээс бүрдэнэ:

- Хууль зүй, дотоод хэргийн яам (Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга).
- Гадаад хэргийн яам (Олон улсын гэрээ, эрхзүйн газрын захирал).

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

- Сангийн яам (Санхүүгийн бодлогын газрын дарга).
- Монголбанк (Тэргүүн дэд ерөнхийлөгч, Хууль, эрхзүйн газрын захирал, Хяналт шалгалтын газрын захирал).
- Санхүүгийн зохицуулах хороо (Захиргаа, удирдлагын газрын дарга).
- Улсын ерөнхий прокурорын газар (Улсын ерөнхий прокурорын орлогч).
- Цагдаагийн ерөнхий газар (Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга).
- Тагнуулын ерөнхий газар (Хоёрдугаар газрын дарга).
- Авлигатай тэмцэх газар (Гүйцэтгэх ажлын хэлтсийн дарга).
- Гаалийн ерөнхий газар (Гаалийн зөрчилтэй тэмцэх газрын дарга).
- Татварын ерөнхий газар (Эрсдэлийн удирдлагын хэлтсийн дарга).

25. ХАЗ-ийн журамд зааснаар СМА, хууль сахиулах байгууллагууд, хянан шалгагчид болон бусад эрх бүхий байгууллагууд МУТСТ бодлого боловсруулан үйл ажиллагаа явуулах зорилгоор хамтран ажилладаг. Гэвч МУТСТ үйл ажиллагааг зохицуулж уялдуулахад ХАЗ-ийг дутуу ашиглаж байна.

26. ТЕГ-ын тэргүүлсэн ТТАЗЗ нь ТТ тухай хуулийн дагуу ТС-тэй тэмцэх, хяналт тавих байгууллага юм. Гэвч ТС үйл ажиллагааг зохицуулж уялдуулахад ТТАЗЗ-ийг дутуу ашиглаж байна. Гэтэл ТТАЗЗ-ийн үндсэн зорилго нь терроризмтой тэмцэх үйл ажиллагааг зохицуулах явдал билээ.

27. *Шалгуур 2.4* –Үйл олноор хөнөөх зэвсгийн санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг зохицуулж уялдуулах субъект нь ТТАЗЗ гэх мэдээллийг бидэнд өгсөн боловч үүнийг нотлох баримт алга байна.

### *Дүгнэлт*

28. Монгол Улс тодорхойлсон эрсдэлдээ үндэслэн МУТСТ үндэсний стратегийг хэрэгжүүлэх ёстой. ХАЗ нь МУТСТ, харин ТТАЗЗ нь терроризмтой тэмцэх үүрэгтэй эрх бүхий байгууллагууд ч тэдний зохицуулж уялдуулах түвшин сул байна. Үй олноор хөнөөх зэвсгийг санхүүжүүлэхтэй тэмцэх ажлыг уялдуулж зохицуулах механизм бүр байхгүй аж. **Монгол Улс Зөвлөмж 2-ыг хэсэгчлэн биелүүлсэн байна.**

### *Зөвлөмж 3 – Мөнгө угаах гэмт хэрэг*

29. 2007 оны ХҮ-ээр Монгол Улс хуучин Зөвлөмж 1 болон Зөвлөмж 2-ын хэрэгжилтийг хагас биелүүлж байв. Тус тайланд Монгол Улс 2002 оны ЭХ-ийн 163-р зүйлийн дагуу МУ-ыг гэмт хэрэгт тооцдог болсон ч тус гэмт хэргийн хамрах цар хүрээ нь Палермогийн конвенцийн шаардлагад нийцэхгүй байгааг дурджээ. Гэмт хэрэг үйлдэх сэдлийг бодит обьектив нөхцөл байдлаас тогтоох боломжгүй, эрүүгийн хариуцлагыг хуулийн этгээдэд хүлээлгэх зохицуулалт байхгүй, шийтгэл нь үйлдсэн гэмт хэрэгт

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

тохирохуйц байж чадахгүй байв. Харин 2014 онд ЭХ-д нэмэлт өөрчлөлт оруулснаар Зөвлөмж 1-ийг “дийлэнхийг биелүүлсэн” үнэлгээтэй болсныг 2014 оны явцын тайланд дурджээ.

30. *Шалгуур 3.1* – Венийн болон Палермогийн конвенцийн шаардлагад нийцүүлэн МУ гэмт хэргийн биет болон үндсэн бүх элементийг Эрүүгийн хуулийн 166<sup>1-д</sup> заажээ.

31. *Шалгуур 3.2* –ЭХ-д заасан суурь бүх гэмт хэргийн орлого нь МУ гэмт хэрэгт тооцогдоно. Хууль бусаар хуулбарлах (ямар ч хэлбэрийн) эс тооцвол ФАТФ-ын ангиллын бүх төрлийн суурь гэмт хэргийг хамарсан байна.

32. *Шалгуур 3.3* – Монгол Улс “босго” эсвэл “нийлмэл” аргачлалыг бус харин “бүх гэмт хэрэг” аргачлалыг хэрэглэдэг.

33. *Шалгуур 3.4* – ЭХ-ийн 166<sup>1-р</sup> зүйлд зааснаар МУ гэмт хэрэг нь Иргэний хуулийн 83, 88-р зүйлд тодорхойлсон аливаа төрлийн өмч хөрөнгөнд хамаарна. ЭХ-ийн 83, 88-р зүйлд агуулагдаж буй тодорхойлолт, зарчмын нэлээдгүй хэсэг нь өмчийн талаарх олон улсын стандарттай нийцтэй аж.

34. *Шалгуур 3.5* – Хөрөнгө гэмт хэргийн гаралтай нь нотлогдвол иргэнийг суурь гэмт хэргээр яллана гэсэн шаардлага ЭХ-д байхгүй аж. ЭХ-ийн 166<sup>1-р</sup> зүйлд ЭХ-ийн Тусгай ангид хамаарах гэмт хэрэг үйлдэж олсон ямар ч хөрөнгийг мөнгө угаах гэмт хэрэг үйлдэж олсон гэж үздэг. Үйлдсэн хэрэг нь суурь гэмт хэрэг мөн эсэх, хөрөнгө нь суурь гэмт хэргийн гаралтайг нотлохыг шүүхээс шаарддаг ч суурь гэмт хэрэг үйлдсэн зүйл ангиар ял оноохыг шаарддаггүй аж. Гэвч амьдрал дээр үүнийг хэрэгжүүлсэн зүйл байхгүй бөгөөд анхан шатны шүүхээс ял оноосон МУ 2 хэрэг давж заалдах шатанд хэрэгсэхгүй болжээ.

35. *Шалгуур 3.6* – Тухайн иргэн ЭХ-д заасан гэмт хэргийг өөр улсад үйлдсэн бол Монгол Улсын хуулиар эрүүгийн хариуцлага хүлээхийг ЭХ-ийн 14-р зүйлд заажээ.

36. *Шалгуур 3.7* - 166<sup>1-р</sup> зүйл дэх МУ-ын тодорхойлолт нь өөрөө угаасан болон гуравдагч этгээдийн мөнгө угаасан үйлдэл аль алиныг хамарна.

37. *Шалгуур 3.8* – Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн (ЭБШХ) 79, 284-р зүйлүүд нь энэ шалгуурыг шууд хөндсөн болно.

38. *Шалгуур 3.9* – ЭХ-ийн 166<sup>1-р</sup> зүйлийн 1-ээс 3 дугаар хэсэгт МУ гэмт хэрэгтэй холбоотой шийтгэлийг тусгасан байдаг бөгөөд үүнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50-иас 100 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төгрөгөөр торгох эсвэл 6 сар хүртэлх хугацаагаар баривчлах, эсвэл 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заажээ. 166<sup>1-р</sup> зүйлийн 2 дугаар хэсэгт зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл эсхүл албан тушаалаа урвуулан ашигласан хувь хүн мөнгө угаах гэмт хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 300-аас 500 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 5 жилээс 12 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх талаар заасан байдаг.

39. 166<sup>1-р</sup> зүйлийн 2 дугаар хэсэгт заасан шийтгэл нь үйлдсэн гэмт үйлдэлд нь тохирсон, дахин үйлдэхээс сэргийлж чадахаар байна. Гэвч хорих ялын оронд мөнгөн торгууль оногдуулж болзошгүйг анхаарахгүй байх боломжгүй. Үнэхээр хорих ялын оронд мөнгөн торгууль оногдуулах боломжийг шүүгчид олговол шийтгэл нь тохирсон,

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

дахин үйлдэхээс сэргийлэхүйц байх утгаа алдаж, торгууль нь ердөө бизнесийн зардал болж хувирах юм.

40. 166<sup>1</sup>-р зүйлийн 1 дэх хэсэгт заасан мөнгөн торгуулийн шийтгэл эсвэл 6 сар хүртэлх хугацаагаар баривчлах эсвэл 5 жил хүртэлх хугацаагаар хорих зэрэг нь гэмт үйлдэлд нь тохирсон буюу дахин үйлдэхээс бүрэн сэргийлж чадахааргүй байна. 5 жилээр хорих ял нь тохирсон шийтгэл байж болох ч бусад шийтгэл нь хэт хөнгөдөхөөр байна. Дүгнэн хэлэхэд, МУ гэмт хэрэг үйлдсэн иргэнд ногдуулах шийтгэл нь гэмт үйлдэлд нь тохирсон, дахин үйлдэхээс бүрэн сэргийлж чадахааргүй байна.

41. *Шалгуур 3.10* –Хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг ЭХ-ийн 20.2, 8.3 дугаар зүйлд заасан байдаг. Хуулийн этгээдэд МУ гэмт хэргээр хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг 166<sup>1</sup>-р зүйлийн 3 дугаар хэсэгт дараахь байдлаар тусгажээ: (i) тодорхой төрлийн бизнес эрхлэх эрхийг хасах, (ii) хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 300-аас 500 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох. Эдгээр шийтгэл нь гэмт үйлдэлд тохирохуйц, дахин үйлдэхээс сэргийлэхүйц байж чадахгүй байна.

42. ЭХ-ийн 166<sup>1</sup>-д хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаар тусгажээ. Ингэхдээ хуулийн этгээдийг МУ гэмт хэргээр эрүүгийн хариуцлагад татлаа гэхэд тухайн хуулийн этгээдээр дамжуулан МУ гэмт хэрэг үйлдсэн хувь хүнийг мөн эрүүгийн хариуцлагад татах ажээ.

43. *Шалгуур 3.11* – ЭХ-ийн Ерөнхий ангид (30-аас 39 дүгээр зүйл) МУ-ад хамаарч болох олон төрлийн нэмэлт гэмт хэргийг тусган өгчээ.

### *Дүгнэлт*

44. Хуулийн этгээд болон иргэнд (зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлд хамаардаггүй эсвэл албан тушаалаа урвуулан ашигласан) оногдуулах шийтгэл нь гэмт үйлдэлд нь тохирсон, дахин үйлдэхээс сэргийлэхүйц байх тал дээр бага зэргийн доголдолтой байна. **Монгол Улс Зөвлөмж 3-ын дийлэнхийг биелүүлсэн байна.**

### *Зөвлөмж 4 – Хөрөнгө хураан авах болон түр зуурын арга хэмжээ*

45. 2007 оны Харилцан үнэлгээгээр Монгол Улс Зөвлөмж 3-ыг хэсэгчлэн биелүүлсэн үнэлгээтэй байв. Эл тайланд ЭХ болон ЭБШХ-ийн холбогдох зүйл заалт нь хэт ерөнхий, хөрөнгө хураах, битүүмжлэх, царцаах, тодорхойлох, мөрдөх эрхийг тодорхой зааж өгөөгүйг дурджээ. 2014 онд ЭБШХ-д нэмэлт өөрчлөлт оруулснаар Зөвлөмж 3 “дийлэнхдээ биелсэн” үнэлгээтэй болсныг 2014 оны явцын тайланд дурджээ.

46. Шалгуур 4.1 – ЭХ-ийн 49-р зүйлд энэхүү шалгуурыг тусгасан байдаг. ЭХ-ийн 49-р зүйлийн 1 дэх хэсэгт мөнгө угааж олсон орлогыг хураах хөрөнгөд хамруулжээ. Хөрөнгө хураах нь дотоод, гадаадад үйлдсэн аль ч гэмт хэрэгт хамаарахыг 49 болон 14-р зүйлээс ойлгож болно.

47. Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсэгт "...Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл буюу түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг болон бусад хэрэгслийг эд хөрөнгө хураах ялаас гадуур заавал хураана” гэж заажээ.

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

48. Үүнийг ЭХ-ийн ерөнхий ангид заасан тул эдгээр дүрэм нь тусгай ангид заасан бүх гэмт хэрэгт хамаарна. МУ гэмт хэргийг ЭХ-ийн тусгай ангийн 166 дугаар зүйлд тусгажээ.

49. *Шалгуур 4.2* – ЭБШХ-ийн 18 дугаар бүлгийн 132, 141 дүгээр зүйлд хөрөнгийг тодорхойлох, мөрдөх, битүүмжлэх арга хэмжээг тусгажээ. ЭБШХ-д гэмт хэргээс олсон орлогыг тодорхойлох, мөрдөх, битүүмжлэхээр заасан (2014 оны 1 дүгээр сард ЭБШХ-ийн 134/1-дэй холбоотойгоор орсон нэмэлт өөрчлөлт) бол 134/11 зүйлд “...тухайн гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг эзэмшигч нь тодорхойгүй, эсхүл эзэмшигчид мэдэгдэх нь тус үйл ажиллагааны зорилгод хор хохирол учруулахаар бол эзэмшигч, өмчлөгчид урьдчилан мэдэгдэхгүй байж болно” гэж заажээ.

50. *Дэд шалгуур 4.2(с)* –Иргэний хуулийн 59-р зүйлд тусгагдсан. 59-р зүйлд “Хэлцэл хийх зорилгоор бусдыг хууран мэхэлсэн бол мэхлэгдсэн этгээд уг хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар шаардах эрхтэй” гэж заажээ. Эд хөрөнгө битүүмжлэх, хураахаас зайлсхийх зорилгоор бусдыг хууран мэхэлж хэлцэл хийгдсэн тохиолдолд уг хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулах эрх хувь хүн болон хуулийн этгээдэд (тухайлбал, төрийн байгууллага) бий.

51. *Шалгуур 4.3* - Гуравдагч этгээдийн эрхийг хамгаалах талаар ЭБШХ-ийн 20, 43 дугаар зүйлд болон 2006 оны 2 дугаар сарын 20-ны Дээд шүүхийн тогтоолын зүйлд тусгагдсан. Тус тогтоолд “Гэм буруутай этгээд нь бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтанд байсан эд хөрөнгийг гэмт хэрэг үйлдэх явцдаа олж авсан, зэвсэг, тээврийн болон бусад хэрэгслийг хууль бусаар өөрийн эзэмшилд шилжүүлэн авч, улмаар гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан нь тогтоогдсон бол тэдгээрийг хурааж, жинхэнэ өмчлөгч, эзэмшигч, ашиглагчид нь шүүхийн шийтгэх тогтоолоор олгож байвал зохино. “гэж заажээ.

52. *Шалгуур 4.4* – ЭБШХ-ийн эд хөрөнгө битүүмжлэх тухай 134-р зүйл нь олон улсын стандартыг хангахгүй байна.

### *Дүгнэлт*

53. Монгол Улс МУТС болон суурь гэмт хэрэгтэй холбоотойгоор хөрөнгө хураах болон түр арга хэмжээ авах зэргийг хэрэгжүүлдэг ажээ. Монгол Улс царцаасан, битүүмжилсэн, хураасан хөрөнгийг удирдах, шаардлагатай үед захиран зарцуулах механизм байхгүй байгаа нь түүний бага зэргийн дутагдал болохоор байна. **Монгол Улс Зөвлөмж 4-ийн дийлэнхийг биелүүлсэн байна.**

### *Зөвлөмж 5 – Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг*

54. 2007 онд Монгол Улс Тусгай зөвлөмж 2-ыг биелүүлээгүй гэсэн үнэлгээтэй байв. НҮБ-ын ТС-ийг зогсоох тухай конвенцид ТС-ийг гэмт хэрэгт тооцохоор заасныг Монгол Улс хэрэгжүүлээгүйг ХҮТ-д дурьдсан байв. Харин 2014 онд ЭХ-д нэмэлт өөрчлөлт орсноор Монгол Улс Тусгай зөвлөмж 2-ыг дийлэнхийг хангах болсныг 2014 оны явцын тайланд дурджээ.

55. *Шалгуур 5.1* – ЭХ-ийн 178<sup>2</sup>-р зүйлд ТС гэмт хэргийг “Террорист хүн, террорист байгууллага болон террорист ажиллагаанд зарцуулагдахыг урьдчилан мэдсээр байж шууд

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

болон шууд бусаар, хууль бусаар болон санаатайгаар, бүхэлд нь болон хэсэгчлэн эд хөрөнгө хуримтлуулсан, шилжүүлсэн, зарцуулсан” гэж тодорхойлжээ.

56. *Шалгуур 5.2* – ЭХ-ийн 178<sup>2</sup>-р зүйл дэх ТС-ийн тодорхойлолт нь өргөн цар хүрээтэй бөгөөд ТС-ийн үндсэн бүх элементийг хамарчээ.

57. *Шалгуур 5.2<sup>bis</sup>* – ЭХ-ийн 178<sup>2</sup>-р зүйл дэх ТС-ийн тодорхойлолт нь өргөн цар хүрээтэй бөгөөд ТС-ийн үндсэн бүх элементийг хамарчээ. Гэхдээ шалгуурт заасан хувь хүмүүсийн терроризмтой холбоотой аяллыг санхүүжүүлэх үйлдлийг тусгайлсан заалт байхгүй ажээ.

58. *Шалгуур 5.3* – ЭХ-ийн 178<sup>2</sup>-р зүйлд ТС гэмт хэргийн хязгаарлалт байхгүй байгаа нь хууль ёсны болон хууль бус эх үүсвэрийн хөрөнгийн аль алиныг хамраагүй гэсэн үг юм.

59. *Шалгуур 5.4* – ЭХ-ийн 178<sup>2</sup>-р зүйлийн дагуу, ТС гэмт хэрэгт тооцохын тулд тухайн хөрөнгө алан хядах халдлага буюу оролдлогод бодитоор зарцуулагдсан; эсвэл тухайн алан хядах халдлагатай холбоотой байх шаардлагагүй.

60. *Шалгуур 5.5* – Гэмт хэргийг нотлоход шаардлагатай хүсэл зорилго, мэдлэгийг объектив, бодит нөхцөл байдлаас гарган авах боломжтойг ЭБШХ-ийн 11 дүгээр бүлгээс харж болно

61. *Шалгуур 5.6* – ТС гэмт хэрэг үйлдсэн хүний хөрөнгийг хураан авч 5-аас 12 жил хорих ял оноох шийтгэл нь гэмт хэрэгт нь тохирсон, дахин үйлдэхээс сэргийлэхүйц байна. Дагалдах гэмт хэрэг үйлдсэн хүнд ТС-тэй адил шийтгэл онооно.

62. *Шалгуур 5.7* - ЭХ-ийн 178<sup>2</sup> -р зүйлд гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасаж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 300-гаас 500 дахин нэмэгдүүлсэнтэй (21000-35000 ам.доллар) тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор заажээ. Шийтгэл нь үйлдсэн гэмт үйлдэлд нь тохирохуйц байгаа ч лицензийг цуцлах, хүчингүй болгох шийтгэл байхгүй тул дахин үйлдэхээс бүрэн сэргийлэхүйц байж чадахгүй байна.

63. *Шалгуур 5.8* – ЭХ-д заасан бүх гэмт хэрэгт (тухайлбал ТС) хамаарах олон тооны дагалдах гэмт хэргийг ЭХ-ийн 30-аас 39-р зүйлд заажээ (гэмт хэрэг үйлдэхээр завдах, хамтран оролцох, хамтран оролцогчийн хэлбэр).

64. *Шалгуур 5.9* – Монгол Улс МУ-ын хувьд “бүх гэмт хэргийг хамруулах аргачлал”-ыг ашиглах тул ТС нь МУ-ын суурь гэмт хэрэг болно.

65. *Шалгуур 5.10* – ЭХ-ийн 13, 14-р зүйлийн дагуу ТС гэмт хэрэг Монгол улсад, эсвэл гадаадад үйлдэгдсэн эсэхээс үл хамааран буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэнэ.

### *Дүгнэлт*

66. Монгол Улс ФАТФ-ын стандартын дагуу ТС-ийг эрүүгийн гэмт хэрэгт тооцож байна. Зарим бага зэргийн техник дутагдлыг нэрлэвэл: (i) гадны террорист болон хувь хүмүүс Монгол Улсаар алах хядах үйл ажиллагаа явуулах зорилгогүйгээр дамжин өнгөрөхийг гэмт хэрэгт тооцохгүй байгаа явдал; (ii) хуулийн этгээдэд тооцох ял шийтгэл нь гэмт хэргийг дахин үйлдэхээс сэргийлэхээргүй байна. Монгол Улсын онцлогт тохируулан Шалгуур 5.2<sup>bis</sup> -т бага жин өгсөн болно. **Монгол Улс Зөвлөмж 5-ын дийлэнхийг биелүүлсэн байна.**

### *Зөвлөмж 6 – Терроризм болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ*

67. 2007 онд Монгол Улс Тусгай зөвлөмж 3-ын хэрэгжилтийг биелүүлээгүй гэсэн үнэлгээтэй байв. Монгол улсад НҮБ-ын АЗ-ийн 1267-р тогтоолд заасан субъектуудын хөрөнгө болон бусад активыг шуурхай царцаах эрх зүйн орчин ч байхгүй, НҮБ-ын АЗ-ийн 1373-р тогтоолыг хэрэгжүүлэх зохицуулалт ч байхгүй байжээ. Харин 2013 онд ТТХ-д нэмэлт өөрчлөлт оруулж, “Террорист этгээдийн жагсаалтад оруулах, жагсаалтад орсон этгээдийн хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох, хянах журам”(ТЭЖО журам) -ыг баталснаар Монгол Улс Тусгай зөвлөмж 3-ыг дийлэнхийг хангах болсныг 2014 оны тайланд дурджээ.

68. *Дэд шалгуур 6.1(a)* – ТЕГ нь ТТХ-ийн 6-р зүйл, ТЭЖО журмын 2.2, 3.1-р зүйлийн дагуу 1267/1989 Хороонд тодорхой иргэн буюу хуулийн этгээдийг жагсаалтад оруулах санал тавих эрх үүрэг бүхий байгууллага юм.

69. *Дэд шалгуур 6.1(b)* – ТЕГ нь ГХЯ-аар дамжуулан НҮБ-ын холбогдох хороодод тусгай шалгуурт нийцсэн иргэн, хуулийн этгээдийг жагсаалтад оруулах санал тавьж болно. Ингэхдээ ТЭЖО журмын 3.1-ээс 3.5-р зүйлд заасан дүрмийг баримтална.

70. *Дэд шалгуур 6.1(c)* – ТЭЖО журмын 3.5-ын дагуу жагсаалтад оруулах санал гаргах эсэхийг тогтоохдоо “үндэслэлтэй” эсвэл “хангалтай үндэслэлтэй” гэдгийг баримтжуулан баталгаажуулах стандарт байх бөгөөд энэхүү үйл явц нь эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагаа явагдаж байгаа эсэхээс үл хамаарна.

71. *Дэд шалгуур 6.1(d)* – Хороодын жагсаалтад оруулах процедур, стандартыг Монгол Улс дагаж мөрдөх бүрэн боломжтой (ТЭЖО журмын 3.2-р зүйл).

72. *Дэд шалгуур 6.1(d)* – ТЭЖО журмын 3.2.2, 3.2.3-т жагсаалтад оруулах санал болгож буй этгээд, хэргийн талаар аль болох өргөн хэмжээний мэдээлэл, үндэслэл, шалтгааныг гаргаж өгөхөөр заажээ.

73. *Дэд шалгуур 6.2(a)* – ТЭЖО журмын 2.2-д зааснаар ТЕГ нь НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1373 дугаар тогтоолд заасан тусгай шаардлагад нийцсэн иргэн, хуулийн этгээдийг жагсаалтад оруулах эрх бүхий байгууллага юм.

74. *Дэд шалгуур 6.2(b)* – ТЭЖО журмын 2.2-2.5-д НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1373 дугаар тогтоолд заасан тусгай шаардлагад нийцсэн иргэн, хуулийн этгээдийг жагсаалтад оруулах эрх бүхий байгууллага болон хууль эрх зүйн үндэслэлийг заасан байдаг.

75. *Дэд шалгуур 6.2(c) - (d)* – ТЭЖО журмын 2.2-2.4-т ТЕГ нь НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1373 дугаар тогтоолд заасан тусгай шаардлагад нийцсэн иргэн, хуулийн этгээдийг гадаад улсын эрх бүхий байгууллагын хүсэлтийг хянан үзсэний үндсэн дээр тийнхүү жагсаалтад оруулах үндэслэл бүрдсэн гэж үзвэл жагсаалтад оруулахаар заажээ.

76. *Дэд шалгуур 6.2(e)* – ТЕГ нь ТЭЖО журмын 3.2.2-ын (НҮБ-ын АЗ-ийн 1267-р тогтоолтой холбоотой) дагуу санал болгож буй этгээдтэй холбоотой аль болох өргөн хэмжээний холбогдох мэдээллийг гаргаж өгөхөөр заажээ.

77. *Шалгуур 6.3* – ТЭЖО журмын 3.5-ын дагуу ТЕГ нь жагсаалтад оруулах шаардлагатай гэж тодорхой үндэслэлээр сэжиглэсэн эсхүл ингэж үзсэн иргэн, хуулийн этгээдийг таньж,

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

олох шаардлагатай мэдээллийг бүхий л эх сурвалжаас буюу эрх бүхий байгууллагаас өгсөн мэдээлэл зэргээс лавлаж шалгана.

78. *Дэд шалгуур 6.3(b)* – ТЭЖО журамд ТЕГ нь нэг талын санаачилгаар (ex parte) ажиллах тухай илт заалт байхгүй ба 2.5-т ТЕГ нь террорист этгээдийг жагсаалтад оруулснаас хойш ажлын 15 хоногийн дотор тухайн жагсаалтад орсон иргэн, хуулийн этгээдэд мэдэгдэхээр заажээ.

79. *Шалгуур 6.4* – Санхүүгийн хориг арга хэмжээг Монгол улс цаг алдалгүй хэрэгжүүлж байна (гаднын эрх бүхий байгууллагын хүсэлтээр мөн). Жагсаалтад орсон этгээд, эсхүл түүний удирдлагад хамаарах этгээд, түүнчлэн НҮБ-ын АЗ-өөс зөвшөөрөгдөөгүй этгээдийг шууд болон шууд бусаар санхүүжүүлэх, түүнд эдийн засгийн эх үүсвэр олгох, санхүүгийн болон бусад үйлчилгээ үзүүлэхийг хориглоно (ТТХ-ийн 7.1.7, 8.2 дугаар зүйл).

80. *Шалгуур 6.5.* – ТТХ-ийн дагуу ТЭЖО журамд ТЕГ-ыг Санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага гэж заасан байдаг.

81. *Дэд шалгуур 6.5(a)* – Хуулийн этгээдийн шууд болон шууд бус өмчлөлд байгаа хөрөнгө, ашиг орлогыг нэн даруй зогсоохыг ТТХ-ийн 7.1.7-д заажээ. ТЭЖО журмын 5.1-д дээрх үүргийн үйлчлэлийг өргөжүүлж Монгол Улсын бүх хувь хүн болон хуулийн этгээдэд хамруулсан байна. Харин хөрөнгө царцаах энэ үүрэг хэрэгжих боломжгүй гэж бид үзэж байгаа нь дараахь шалтгаантай: (i) ТТХ-ийн 7.1.7-ийн зөрчилд авах шийтгэлийн арга хэмжээг ТТХ-д тусгаагүй (гэтэл бусад заалтын зөрчилд шийтгэл бий), (ii) ТЭЖО журмын 5.1-ийн зөрчилд шийтгэлийн арга хэмжээ байхгүй, (iii) зөрчилд шууд бус/илүү өргөн хүрээтэй шийтгэлийн арга хэмжээ авах талаар ТТХ болон ТЭЖО журамд харилцан иш татсан заалт байхгүй, (iv) Монгол Улсад хувь хүн болон хуулийн этгээдэд шууд бус/илүү өргөн хүрээтэй шийтгэл оногдуулсан гэх баримт алга.

82. *Дэд шалгуур 6.5(b)* – ТЭЖО журмын 5-р зүйл болон ТТХ-ийн 7.1.7-р зүйл нь дэд шалгуур 6.5(b)-ын үг үсэгтэй нэгэн адил билээ. Гэсэн хэдий ч дээр дурьдсанчлан, ТТХ-ийн 7.1.7-ийн хэрэгжилтийг хангах боломжгүй.

83. *Дэд шалгуур 6.5(c)* – ТТХ-ийн 8.2-р зүйлд жагсаалтад орсон этгээд, эсхүл түүний удирдлагад хамаарах этгээд, түүнчлэн НҮБ-ын АЗ-өөс зөвшөөрөгдөөгүй этгээдийг шууд болон шууд бусаар санхүүжүүлэх, түүнд эдийн засгийн эх үүсвэр олгох, санхүүгийн болон бусад үйлчилгээ үзүүлэхийг хориглосон байдаг. Энэхүү хориг нь дараах зүйлст хамаарахгүй: (i) бусад хөрөнгө, (ii) Монгол Улсын нутаг дэвсгэр дээрх иргэдээс бусад хувь хүн болон этгээд (жагсаалтад орсон этгээдийн шууд/шууд бусаар өмчилж/хянаж буй, эсвэл жагсаалтад орсон иргэн буюу этгээдийн өмнөөс буюу өгсөн чиглэлийн дагуу). Гэсэн хэдий ч, үнэлгээний багийн үзэж байгаагаар санхүүжүүлэхийг хориглох заалт нь дараахь шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй юм: (i) ТТХ-ийн 8.2-ын зөрчилд шийтгэл байхгүй (гэтэл бусад заалтын зөрчилд шийтгэлийн арга хэмжээ бий), (ii) зөрчилд шууд бус/илүү өргөн хүрээтэй шийтгэлийн арга хэмжээ авах талаар ТТХ болон ТЭЖО журамд харилцан иш татсан заалт байхгүй, (iii) Монгол Улсад хувь хүн болон хуулийн этгээдэд шууд бус/илүү өргөн хүрээтэй шийтгэл оногдуулсан гэх баримт алга.

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

84. *Дэд шалгуур 6.5(d)* – ТЭЖО журмын 2.3-ын дагуу ТЕГ өөрийн цахим хуудсанд Нэгтгэсэн жагсаалтын холбоосыг байршуулдаг. ТТХ болон ТЭЖО журмын хөрөнгө царцаах удирдамж заавраар СБ-ууд болон СББМҮҮ-дийг хангаагүй байна.

85. *Дэд шалгуур 6.5(e)* – ТЭЖО журмын 5.2-ын дагуу царцаасан хөрөнгө болон авсан арга хэмжээний талаар мэдээллийг банкууд Монголбанкинд, СБ-ууд болон СББМҮҮ-ид СЗХ-д тус тус хүргүүлэх үүрэгтэй. Гэхдээ тус заалт хэрэгжих боломжгүй гэж бид үзэж байна (Дэд шалгуур 6.5(a) үзнэ үү).

86. *Дэд шалгуур 6.5(f)* – ТТХ болон ТЭЖО журам (ялангуяа ТЭЖО 4-р зүйл)-ын дагуу ТЕГ нь гуравдагч этгээдийн эрхийг хамгаалах журам боловсруулах үүрэгтэй ч ийм журам байхгүй байна.

87. *Дэд шалгуур 6.6* – ТЭЖО журмын 4-т ТЕГ нь жагсаалтаас хасах, жагсаалтад орсон этгээдийн хөрөнгийг чөлөөлөх тухай байдаг ч НҮБ-ын АЗ-ийн 1267, 1373-р тогтоолын жагсаалтаас хасах, хөрөнгийг чөлөөлөх, энэ талаар хувийн секторт мэдээлэл хүргэх процедур тодорхойгүй байна.

88. *Дэд шалгуур 6.7* – ТЭЖО журмын 4.8, 4.9-т жагсаалтад орсон этгээдийн мөнгөн хуримтлал, хөрөнгөөс төлж барагдуулах шаардлагатай эсэх асуудлыг ТЕГ нь НҮБ-ын АЗ-ийн 1452-р тогтоолд заасан журмын дагуу шийдвэрлэнэ хянаж, шийдвэрлэнэ.

### *Дүгнэлт*

89. Монгол Улс НҮБ-ын АЗ-ийн 1267, 1373-р тогтоолд нийцүүлэн санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авах тогтолцоотой ч хөрөнгө царцаах; санхүүжүүлэхийг хориглох; СБ-ууд болон СББМҮҮ-ид царцаасан хөрөнгө, авсан арга хэмжээгээ тайлагнах зэрэг үүрэг хэрэгжих боломжгүй байгаа нь Монгол Улсын сул тал байхаар байна. **Монгол Улс Зөвлөмж 6-г хэсэгчлэн биелүүлсэн байна.**

### ***Зөвлөмж 7 – Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ***

90. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ нь ФАТФ-ын 2012 онд шинээр нэмэгдсэн зөвлөмж юм.

91. *Шалгуур 7.1* – Үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэх, түүнийг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, хязгаарлах тухай НҮБ-ын АЗ-ийн тогтоолыг биелүүлж хориг арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлэх тогтолцоо Монгол Улсад байхгүй байна. ТТХ болон ТЭЖО журам нь Зөвлөмж 7-ийн шаардлагыг тусгаагүй аж.

92. *Шалгуур 7.2* – Хэд хэдэн төрийн байгууллага НҮБ-ын АЗ-ийн тогтоолуудыг хэрэгжүүлэх үүрэгтэй ч НҮБ-ын АЗ-ийн үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхтэй холбоотой тогтоолын хэрэгжилтийг хариуцсан байгууллага алга. ТЕГ нь цөмийн зэвсгийг дэлгэрүүлэх, үйлдвэрлэх, эзэмшихтэй холбоотой мөрдөн шалгах, СМА-тай хамтран хөрөнгө царцаах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Харин ГЕГ нь НҮБ-ын АЗ-ийн 2270 (2016), 1718 (2006), 1737 (2006) болон бусад тогтоолын дагуу барааг экспортлох, импортлох болон дамжин өнгөрүүлэхэд хязгаарлалт тавина. Түүнчлэн, Монгол Улсын

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

далбаан дор сэлж буй онгоц НҮБ-ын АЗ-ийн тогтоолыг мөрдөх нь Далайн захиргааны үүрэг юм. (a-f) Дэд шалгуур ТЭЖО журам нь үй олноор хөнөөх зэвсгийг хамардаггүй байна.

93. *Шалгуур 7.3* – Зөвлөмж 7-г СБ-ууд болон СББМҮҮ-ээр мөрдүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих механизм Монгол Улсад алга.

94. *Шалгуур 7.4* – ТЭЖО журам нь НҮБ-ын АЗ-ийн үй олноор хөнөөх зэвсгийн талаарх шаардлагыг тусгаагүй байна.

95. *Шалгуур 7.5* - Монгол Улсын хуулиар хориг арга хэмжээнд хамаарах гэрээ, хэлцэл, үүргүүд нь НҮБ-ын АЗ-ийн холбогдох тогтоолын шаардлагыг хамрахгүй байна.

### *Дүгнэлт*

96. Зөвлөмж 7-гийн дагуу хориг арга хэмжээг хэрэгжүүлэх хууль эрх зүйн зохицуулалт Монгол Улсад байхгүй байна. **Монгол Улс Зөвлөмж 7-г биелүүлээгүй байна.**

### *Зөвлөмж 8 – Ашгийн бус байгууллагууд*

#### *Оршил*

97. 1-р бүлэгт дурьдсанчлан, Монгол Улсын Иргэний хуулийн 33.2-ын дагуу ашгийн бус хуулийн этгээд нь холбоо, сан, хоршоо хэлбэртэй байж болох бөгөөд ОӨУБЕГ-т бүртгүүлсэн байх шаардлагатай. Ашгийн бус хуулийн этгээдийг зохицуулах хууль тогтоомжийг Хүснэгт 32-т харуулав.

**Table 32: Ашгийн бус хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах хуулиуд**

| Ашгийн бус хуулийн этгээдийн төрөл                     | 2016 оны 10 сарын байдлаарх этгээдийн тоо | Зохицуулах хууль                           |
|--|---|--|
| Хоршоо   | 4,093                                     | Хоршооны тухай хууль                       |
| ХЗХ  | 475 <sup>76</sup>                         | ХЗХ-ны тухай хууль                         |
| Төрийн бус байгууллага                                 | 23,027                                    | ТББ-ын тухай хууль                         |
| ашны байгууллага                                       | 746                                       | Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль    |
| Сан  | 1,119                                     | ТББ-ын тухай хууль                         |
| Үйлдвэрчний эвлэл                                      | 2,676                                     | Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль |
| Хэвлэл мэдээллийн холбоо                               | 3,561                                     | <sup>77</sup>                              |
| Төрийн өмчит хуулийн этгээд <sup>78</sup>              | 1   | Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль     |
| Соёл, боловсрол, судалгаа, эрүүл мэндийн байгууллагууд | 331                                       | Боловсролын тухай хууль                    |
| <b>Нийт</b>  | <b>36,029</b>                             |  |

<sup>76</sup> ОӨУБЕГ-т бүртгүүлсэн олон ХЗХ нь үйл ажиллагаа явуулдаггүй, СЗХ-оос тусгай зөвшөөрөл аваагүй байж болно.

<sup>77</sup> Ашгийн бус хэвлэл мэдээллийн хэрэгслийг зохицуулсан хууль тогтоомж байдаг эсэх нь тодорхойгүй байна.

<sup>78</sup> Өмгөөлөгчдийн холбоо

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

98. 2007 оны ХҮТ-д Монгол Улс Тусгай Зөвлөмж 8-г хэсэгчлэн биелүүлсэн үнэлгээтэй байв. Тухайн үед илэрсэн дутагдлыг нэрлэвэл: (i) дотоодын АББ-ын судалгаа байхгүй, (ii) МУТСТ-ийн асуудлыг АББ-ын хүрээнд авч үздэггүй, (iii) АББ-ыг бүртгэхдээ түүнийг эзэмшиж, хянаж, чиглүүлж буй этгээдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авдаггүй зэрэг байв.

99. *Шалгуур 8.1* – Монгол Улс дараахь зүйлийг хийгээгүй байна. Үүнд: (i) ФАТФ-ын АББ-ын тодорхойлолт аль байгууллагад хамаарахыг тогтоох; мэдээллийн бүх эх үүсвэрийг ашиглан АББ-ын онцлог, төрлийг тодорхойлох (ялангуяа үйл ажиллагаа, шинж чанарынхаа дагуу ТС эрсдэлд өртөж болох), (ii) террорист этгээдүүдийн ашгийн бус болон шашны байгууллагуудад учруулж болох эрсдэлийн мөн чанарыг тогтоох (тухайлбал, ҮЭҮ-д), (iii) эрсдэлтэй АББ-ын эрсдэлийг бууруулах арга хэмжээг судлах, (iv) тус салбарын эрсдэлийг тогтмол үнэлэх.

100. ҮЭҮ-нд ХЗХ-ын МУТС эрсдэлийг судлан үзжээ. ХЗХ-ыг мэдээлэх болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ (Зөвлөмж 9, 21) авах үүрэгтэй этгээд болгосон байна.

101. Шалгуур 8.2 – ТББ-ын тухай хуулийн 5-р бүлэгт ТББ-ын үйл ажиллагаа ил тод, олон нийтийн итгэлийг хүлээсэн байх талаар тусгажээ. ТББ нь ОӨУБЕГ-т бүртгүүлж жил бүр үйл ажиллагааны тайланг ОӨУБЕГ-т хүргүүлэх үүрэгтэй. ОӨУБЕГ нь ТББ-ын бүртгэлийг, үүний дотор бүтэц болон удирдлагад гарсан өөрчлөлтийг хөтлөх үүрэгтэй. ТББ нь жил бүр санхүүгийн тайланг гаргаж татварын тооцоо хийнэ. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хуулийн дагуу ТББ нь хөндлөнгийн аудит хийлгүүлнэ. Гэсэн хэдий ч Монгол Улс дараахь зүйлийг хийж гүйцэтгээгүй байна: (i) АББ-уудын ТС эрсдэлд өртөх магадлал, эмзэг байдлын талаарх ТББ болон шашны байгууллагуудын ойлголтыг нэмэгдүүлэх, (ii) ТББ болон шашны байгууллагатай хамтран ТС эрсдэлтэй тэмцэх сайн туршлагыг бий болгох, (iii) АББ-ууд санхүүгийн гүйлгээгээ хяналт, зохицуулалттай салбараар дамжуулан хийхийг өөгшүүлэн дэмжих.

102. ХЗХ-ны тухай хуульд ХЗХ-ын үйл ажиллагаа нь ил тод, олон нийтийн итгэлийг хүлээсэн байх талаар тусгажээ. ХЗХ нь СЗХ-ноос тусгай зөвшөөрөл авч аудитаар баталгаажсэн улирал, жилийн санхүүгийн тайланг СЗХ-нд хүргүүлнэ. ХЗХ нь МУТСТ хуульд, УСЖ-ын дагуу ХТМ арга хэмжээ авах үүрэгтэй. ХЗХ нь зохистой үзүүлэлт болон МУТСТ хяналт шалгалтад хамрагдана. Монгол Улс ХЗХ-ыг зохицуулахдаа АББ-ууд ТС-н эрсдэлд өртөх асуудлыг орхигдуулж байна. АББ-ыг буруугаах ашиглах үйл ажиллагаа нь хязгаарлагдмал байна. Монгол Улс ХЗХ-дтой хамтран ТС эрсдэлтэй тэмцэх сайн туршлагыг бий болгож чадаагүй байна.

103. *Шалгуур 8.3* – Монгол Улс хяналт, шалгалтаа сайжруулах зарим арга хэмжээ авчээ. ОӨУБЕГ нь ТББ-ын жилийн тайланг хүлээж авдаг ч тавих хяналт нь тодорхой бус ажээ. ЦЕГ-аас Монгол Улс дах олон улсын болон гадаадын АББ-ын салбар, суурин төлөөлөгчийн газарт тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагааг нь хянах зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

104. СЗХ нь ХЗХ-дын зохистой харьцааны болон МУТСТ хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ.

105. *Шалгуур 8.4* – ТББ хуулийн 8, 24-р зүйлийн дагуу шүүхээс хэд хэдэн төрлийн шийтгэл оногдуулах боломжтой. Гэхдээ эдгээр шийтгэл нь гэмт үйлдэлд нь тохирсон, дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэхүйц биш байна. Шийтгэлийн төрлийг нэрлэвэл: (i)

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

дүрмийнхээ зорилгод нийцээгүй үйл ажиллагаа явуулсан ТББ-ыг татан буулгах, (ii) орлогыг ногдол ашиг, төлбөр хэлбэрээр хууль бусаар хуваарилсан бол торгууль оногдуулах (иргэнийг 20-30 ам.доллар, байгууллагыг 50-75 ам.доллараар), (iii) байгууллагын хөрөнгө, мөнгийг хувийн ашиг хийх зорилгоор ашигласан бол орлогыг хураан авч торгууль ногдуулах (20-30 ам.доллар), (iv) улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчдэд хандив өгсөн бол торгууль оногдуулах (иргэнийг 50-75 ам.доллар, байгууллагыг 100-125 ам.доллараар), (v) жилийн тайлан хүргүүлээгүй бол торгууль оногдуулах (иргэнийг 5-10 ам.доллараар).

106. Зөвлөмж 35-д дурьдсанчлан, ХЗХ-ны тухай хуулийн 56-ийн дагуу ХЗХ нь хууль тогтоомж зөрчвөл (тухайлбал, МУТСТ хууль болон УСЖ) СЗХ-ноос зөрчил арилгахыг шаардах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох эрхтэй. Мөн хуулийн 57.1.4-ийн дагуу СЗХ-ноос тавьсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд ХЗХ-нд торгууль ногдуулах боломжтой. Хуулийн этгээдийг цалингийн доод хэмжээг 3-5 дахин нэмэгдүүлсэнтэй (375-625 ам.доллар), иргэнийг цалингийн доод хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэнтэй (375 ам.доллар) тэнцэх хэмжээгээр торгоно.

107. *Шалгуур 8.5* – ОӨУБЕГ нь мэдээллээ ЦЕГ, ТЕГ, АТГ, ГЕГ, ТаЕГ, ШШГЕГ, ХХЕГ зэрэг байгууллагатай хуваалцах боломжтой. Үүнд ТББ-ын захиргаа, удирдлагын мэдээлэл ч багтана. СЗХ нь ХЗХ-дын мэдээллийг хууль сахиулах болон бусад эрх бүхий байгууллагатай хуваалцах боломжтой.

108. ТЕГ нь терроризм болон ТС-ийг мөрдөн шалгах эрх бүхий байгууллага юм. Гэвч алан хядах үйл ажиллагаанд сэжиглэгдэж буй, оролцож буй, ашиглагдаж буй АББ-ыг мөрдөж шалгах ТЕГ-ын чадвар, чадавхи сул байна. АББ-ыг ТС-тэй холбоотойгоор шалгаж байсан баримт алга.

109. ТЕГ нь мөрдөн шалгах ажлын хүрээнд ТББ, ХЗХ-ын удирдлага, захиргааны талаарх мэдээллийг гаргуулан авах эрхтэй. Мөрдөн шалгах ажиллагаа нэгэнт эхэлбэл ТТАЗЗ нь мэдээллийг шуурхай хуваалцах үндсэн механизм болсноор урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах арга хэмжээ хэрэгжинэ.

110. *Шалгуур 8.6* –Терроризмтой холбоотойгоор АББ буюу ХЗХ-ны талаарх олон улсын лавлагааг ТЕГ хүлээн авна. Харин Интерполоос ирсэн хүсэлтэд ЦЕГ “Интерполоос мэдээлэл болон баримт бичиг хүлээн авах, дамжуулах журам”-ын дагуу хариу өгөх аж.

### *Дүгнэлт*

111. Монгол Улс эрсдэлтэй АББ-ыг тодорхойлоогүй байна. ТББ-ын тухай хуулийн дагуу ОӨУБЕГ нь ТББ-ыг бүртгэх, зарим төрлийн хяналт хэрэгжүүлснээр ТББ-ын ил тод байх, олон нийтийн итгэлийг хүлээх бодлого хэрэгждэг аж. ОӨУБЕГ нь эрх бүхий байгууллагуудтай мэдээлэл солилцох боломжтой. Терроризмтой холбоотойгоор АББ буюу ХЗХ-ны талаарх олон улсын лавлагааг ТЕГ хүлээн авна. Монгол Улсын хувьд хэд хэдэн ноцтой дутагдал байна. ҮЭҮ-нд АББ-уудын эрсдэлийг зохих түвшинд үнэлээгүй байна. Монгол Улс дараахь зүйлийг хийж гүйцэтгээгүй байна: (i) эрсдэлтэй ТББ-уудад хүрч ТС эрсдэлд өртөх магадлал, эмзэг байдлын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, (ii) эрсдэлтэй ТББ-уудтай хамтран ажиллаж ТС эрсдэлтэй тэмцэх сайн туршлагыг бий болгох, (iii) АББ-ууд гүйлгээгээ хяналт, зохицуулалттай санхүүгийн сувгаар дамжуулан

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

хийхийг дэмжих. ТББ-ын тухай хуульд заасан шийтгэл нь үйлдсэн гэмт хэрэгт дүйцэх, урьдчилан сэргийлэхүйц байх зарчим хангагдахгүй байна. **Монгол Улс Зөвлөмж 8-ыг хэсэгчлэн биелүүлсэн байна.**

### *Зөвлөмж 9 – Санхүүгийн байгууллагын нууцлалтай холбоотой хууль тогтоомж*

112. Монгол Улс 2007 оны ХҮТ-д хуучин зөвлөмж 4-ийн дийлэнхийг биелүүлсэн, ингэхдээ үр дүнтэй байдал бүрэн тогтоогдоогүй гэсэн үнэлгээтэй байжээ.

113. *Шалгуур 9.1* – Монгол Улсад банк, СБ-ын нууцлалын талаарх хууль тогтоомж байхгүй ба эрх бүхий байгууллагууд шаардлагатай мэдээллээ гаргуулан авах эрхтэй. Монгол Улсын Хувь хүний нууцын тухай хууль 1995, Хуулийн этгээдийн нууцын тухай хууль болон Банкны тухай хуулиуд нь ФАТФ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэхэд саад болохооргүй байна:

- МУТСТ хуулийн 12.1-д МҮЭ нь СМА болон эрх бүхий байгууллагад мэдээлэл өгснийг банкны болон мэргэжлийн нууц задруулсан гэж үзэхгүй хэмээн заажээ. Мэдээлэл солилцоог баталгаажуулсан зүйл анги байдаг аж.
- Банкны тухай хуулийн 7-д эрх бүхий байгууллагууд МУТСТ зорилгоор мэдээлэл гаргуулан авах эрхтэйг заажээ: (i) 2.2-2.5-р заалтад Монголбанк болон түүний хянан шалгагчид, шүүх прокурорын газар, СЗХ зэрэг нь өөрсдийн хууль ёсны дагуу үүргээ гүйцэтгэж байгаа тохиолдолд мэдээлэл авч ашиглах боломжтойг заасан бол, (ii) 2.4-2.5-р заалтад гадны эрх бүхий байгууллагад Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу мэдээлэл гаргаж өгөх талаар тусгажээ.
- МУТСТ хуулийн 7.4-т МҮЭ-үүд СМА, ХСБ болон терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагад тодорхой гүйлгээ, түүнд оролцогч талуудын талаарх мэдээллийг гаргаж өгөхөөр заажээ.
- МУТСТ хуулийн 22.1-д СМА, хянан шалгах байгууллагууд, ХСБ-ууд, татвар, гааль, ТС-тэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагууд мэдээлэл солилцох талаар заасан нь мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах үүргийг илт бүдэгрүүлсэн байна. Мөн хуулийн 21-д СМА нь гадны байгууллагуудтай хамтран ажиллан мэдээлэл гаргаж өгөх боломжтой хэмээн тусгажээ.
- Гэсэн хэдий ч, корреспондент банк, цахим шилжүүлэг, гуравдагч этгээдийн талаар СБ-ууд мэдээлэл хэрхэн солилцож буй нь тодорхойгүй байна.

### *Дүгнэлт*

114. СБ-ын нууцлалын талаарх хууль тогтоомж нь МУТСТ тогтолцоонд саад тотгор учруулахааргүй байна. Харин корреспондент банк, цахим шилжүүлэг, гуравдагч этгээдтэй холбоотой шаардлагыг биелүүлэх зорилгоор мэдээлэл солилцож буй нь тодорхойгүй байгаа нь бага зэргийн сул тал болохоор байна. **Монгол Улс Зөвлөмж 9-ийн дийлэнхийг биелүүлсэн байна.**

### *Зөвлөмж 10 – Харилцагчийг таньж мэдэх*

115. 2007 оны ХҮТ-д Монгол Улс хуучин зөвлөмж 5-ыг биелүүлээгүй гэсэн үнэлгээтэй байв. МУТСТ хуулийн дагуух ХТМ шаардлагыг Монгол Улсын бүх СБ-ууд хэрэгжүүлж байсан ч дараах салбарт хууль эрх зүйн шаардлага үгүйлэгдэж байна:

- Цахим шилжүүлэгтэй холбоотой ХТМ арга хэмжээ,
- Харилцагчдын мэдээллийг баталгаажуулах,
- Хуулийн этгээдийг төлөөлж буй гэх иргэн төлөөлөх эрх авсан эсэхийг баталгаажуулах,
- Харилцагч нь өөр иргэнийг төлөөлж буй эсэхийг тогтоох,
- Эцсийн өмчлөгчийн мэдээллийг олж авах,
- Хуулийн этгээд болох харилцагчийн цаана жинхэнэ эзэмшигч иргэн нь хэн болохыг тодорхойлох,
- ХТМ журмын дагуу олж авсан мэдээлэл, баримт бичгийг тухай бүр шинэчлэх.

116. Харилцагчийн эрсдэлийн түвшнээс хамааран ХТМ ажиллагааг төрөлжүүлэх заалт МУТСТ хуульд байхгүй аж. Түүнчлэн харилцагч мэдээлэл өгөхөөс татгалзах тохиолдолд СГТ бүрдүүлэх шаардлага байхгүй аж. Мөн харилцагчийн өмнө нь өгсөн мэдээлэл үнэн зөв байгаагүй тохиолдолд бизнесийн харилцааг таслан СГТ бүрдүүлэн хүргүүлэх шаардлага мөн алга. Монгол Улсын 2014 оны тайланд зөвлөмж 5-ын дийлэнхийг биелүүлсэн үнэлгээтэй болсон билээ.

117. *Шалгуур 10.1* – МУТСТ хуулийн 4.2-т МҮЭ-үүд нэргүй, эсхүл хуурамч нэрээр данс нээхийг хориглодог. МҮЭ нь ийм данснаас гүйлгээ хийхийг мөн хориглодог.

118. *Шалгуур 10.2* – МУТСТ хуулийн 5.1-д МҮЭ-ийг дараахь тохиолдолд ХТМ шаардлагатайг заажээ: (а) санхүүгийн харилцаа үүсгэхийн өмнө, (b) дансгүй, эсхүл санхүүгийн тогтвортой харилцаа үүсгээгүй хуулийн этгээд болон хувь хүн тохиолдлын чанартайгаар 20 сая төгрөг, түүнээс дээш гүйлгээ хийхийн өмнө (~9,900 ам.доллар), (c) харилцагчийн 24 цагийн дотор хийсэн, хоорондоо холбоо бүхий хэд хэдэн удаагийн гүйлгээний тус бүрийн үнийн дүн нь 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бол, (d) тухайн харилцагч, тухайн гүйлгээг МУТС үйл ажиллагаатай холбоотой гэж сэжиглэсэн тохиолдолд, (e) харилцагчийн талаар өмнө авсан мэдээллийн үнэн зөв эсэхэд эргэлзсэн тохиолдолд. МУТСТ тухайн хуулийн 5.2.6-д банк, санхүүгийн байгууллагын хоорондын шилжүүлэг хийгч, хүлээн авагчийг таньж мэдэх шаардлагыг тусгасан ба ингэхдээ дүнгийн хувьд ямар нэг босго тавиагүй аж.

119. 24 цагийн дотор хийсэн хоорондоо холбоо бүхий гүйлгээг таньж мэдэх шаардлага нь учир дутагдалтай юм. Учир нь хэлцэл хэдэн хоногийн дараа хийгдэх боломжтой ба дүн нь босго үзүүлэлтээс хэтэрч болно. МУТС эрсдэлтэй гүйлгээний хувьд ямар нэгэн босго эсвэл чөлөөлөх үзүүлэлт хамаарахгүй гэдгийг хуульд тусгаж өгөөгүй болно (тэгж ойлгодог ч гэсэн).

120. *Шалгуур 10.3* – МУТСТ хуулийн 5.2.1, 5.2.2, 5.2.5-т МҮЭ нь тухайн харилцагч хувь хүн үү, хуулийн этгээд үү, аль эсвэл эрх зүйн бусад зохицуулалт уу гэдгийг тодорхойлно.

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

МҮЭ нь харилцагчийн мэдээллийг найдвартай буюу бие даасан эх сурвалжаас баталгаажуулж, иргэний үнэмлэх, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ зэргийг ашиглана. ХЭУБ-ийн тухай хуулийн 3.1.1-д “хуулийн этгээд” гэж Иргэний хуулийн 25-д заасан шинжийг агуулсан зохион байгуулалтын нэгдлийг ойлгоно гэжээ. Түүнчлэн, УСЖ-ын 5.2, 5.3, 5.4-т иргэн, хуулийн этгээд, эрх зүйн бусад зохицуулалтыг таньж мэдэхэд шаардлагатай нэмэлт мэдээлэл, баримт бичгийн бүрдүүлбэрийг тусгажээ.

121. *Шалгуур 10.4* – УСЖ-ын 5.2-т харилцагч нь хэн нэгнийг төлөөлж байгаа бол төлөөлүүлж буй этгээдийн мэдээллийг авахыг шаарддаг. Үүнтэй адил заалт (УСЖ-ын 5.3, 5.4) хуулийн этгээд буюу эрх зүйн бусад зохицуулалтын хувьд мөн үйлчилнэ. Түүнчлэн, МУТСТ хуулийн 2.5-р зүйлд, харилцагч нь хуулийн этгээд, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч бол түүний нэрийн өмнөөс харилцах этгээд нь тийм эрхтэй эсэхийг нягталж уг этгээдийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийг тодорхойлж, баримт бичигтэй нь тулгаж шалгахаар заажээ. Харин МҮЭ нь иргэнийг төлөөлж буй иргэнийг нягтлах тухай тус зүйлд байдаггүй аж.

122. *Шалгуур 10.5* – МУТСТ хуулийн 5.1-д заасны дагуу МҮЭ нь ХТМ арга хэмжээ авахдаа найдвартай бие даасан мэдээллийн эх сурвалж ашиглахыг тусгажээ. Эцсийн өмчлөгчтэй холбоотой ХТМ арга хэмжээг дурдвал: (i) МУТСТ хуулийн 5.2.4-ын дагуу МҮЭ нь хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг тодорхойлно; (ii) УСЖ-ын 5.8-ын дагуу МҮЭ нь эцсийн өмчлөгчийг тодорхойлох боломжит бүх арга хэмжээ авна; (iii) УСЖ-ын 5.1-ын дагуу МЭҮ нь хэрэв харилцагч шаталсан холбоо бүхий бүтэцтэй байвал холбоос бүрд харгалзах өмчлөлийн бүтцийг тогтоох байдлаар эцсийн өмчлөгчийг тодорхойлно хэмээн тус тус заажээ.

123. *Шалгуур 10.6* – УСЖ-ын 3.1.2-т зааснаар МҮЭ нь харилцагчийн эрсдэлийн хувийн хэргийг (үүний дотор бизнесийн харилцааны зорилго, мөн чанар) бүрдүүлэх шаардлагатай. Түүнчлэн, тус журмын 5.7.3-т МҮЭ-ийн харилцагчийн талаарх мэдээлэл нь санхүүгийн харилцаа, гүйлгээний мөн чанарыг ойлгоход хангалтгүй байвал мэдээллийг шинэчлэхээр заажээ.

124. *Шалгуур 10.7* – УСЖ-ын 3.1.4-т харилцагчийн гүйлгээг байнгын хяналтанд байлгаж харилцагчийн эрсдэлийн хувийн хэрэг болон холбогдох мэдээлэлд тулгуурлан харилцагчийн гүйлгээг нягтлах шаардлагатай. Тус журмын 5.6-ийн дагуу МҮЭ нь ХТМ хүрээнд цуглуулсан баримт бичиг, мэдээлэлд орсон өөрчлөлтийг тодорхой хугацааны давтамжтайгаар нягталж шинэчлэх үүрэгтэй. УСЖ-ын 5.7-д харилцагчийн мэдээллийг дахин нягтлах тохиолдлыг заажээ: (i) харилцагч өндөр дүнтэй гүйлгээ хийх, (ii) харилцагчийн гүйлгээний төрөл, давтамж, утга, дүнд өөрчлөлт гарах эсвэл дансыг ашиглаж буй хэв шинж өөрчлөгдөх, (iii) МҮЭ-дэд буй харилцагчийн талаарх мэдээлэл нь санхүүгийн харилцаа, гүйлгээний мөн чанарыг ойлгоход хангалтгүй байх. Иймд шаардлагатай тохиолдолд харилцагчийн орлогын эх үүсвэрийг дахин нягтлах шаардлагатай ажээ.

125. *Шалгуур 10.8* – МУТСТ хуулийн 5.2.4-т МҮЭ нь хуулийн этгээд харилцагчийн эзэмшлийн болон хяналтын бүтцийг сайтар ойлгосон байхыг заажээ. УСЖ-ын 5.1, 5.4-т МҮЭ нь хувьцаа эзэмшигчид, хуулийн этгээд болон хуулийн бусад зохицуулалт бүхий харилцагчийн бизнесийнх нь талаар мэдээлэл цуглуулж бизнесийн мөн чанар, эзэмшил, хяналтыг ойлгох ёстойг заасан байна.

126. *Шалгуур 10.9* – МУТСТ хуулийн 5.2.2-т зааснаар харилцагч нь хуулийн этгээд бол түүний нэр, оршин байгаа газрын хаяг, нотолгоо зэргийг тодорхойлон баталгаажуулж удирдлагын талаар дэлгэрэнгүй мэдээллийг гаргаж авна. УСЖ-ын 5.3-т МҮЭ нь хуулийн этгээдээс дараах мэдээллийг гаргуулан баталгаажуулахаар заажээ: (i) улсын бүртгэлийн гэрчилгээн дээрх нэр, (ii) хуулийн этгээдийг үүсгэн байгуулах/эзэмших баримт бичиг, дотоод дүрэм журам, удирдлагын талаарх мэдээлэл, (iii) албан газрын байнгын хаяг. Эрх зүйн бусад зохицуулалт бүхий хуулийн этгээдийн тухайд УСЖ-ын 5.4-т зааснаар МҮЭ нь дараах мэдээллийг магадлах шаардлагатай: (i) гэрээнд заасан хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий этгээдийн нэр, хяга, бусад бүртгэлийн мэдээлэл, (ii) төлөөлөх эрхтэй этгээдийг томилох, чөлөөлөх эрх бүхий хувь хүн, эсвэл хуулийн этгээдийн мэдээллүүд, (iii) хөрөнгийн ашгийг хүртэх эрхтэй этгээдийн мэдээлэл.

127. *Шалгуур 10.10* – МУТСТ хуулийн 5.2.4-т МҮЭ нь хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг тодорхойлохын тулд боломжит бүх арга хэмжээ авахаар заажээ. УСЖ-ын 5.1-д харилцагч нь хуулийн этгээд болон эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээд гэдгээс үл хамааран түүний эзэмшил, хяналтад байгаа хөрөнгө болон эд хөрөнгөөс эцсийн ашиг хүртэх этгээдийг тодорхойлон мэдээллийг баталгаажуулахаар заажээ. Үргэлжилсэн холбоо бүхий удирдлагын бүтэцтэй бол МҮЭ нь холбоос бүрд харгалзах өмчлөлийн бүтцийг тогтоох байдлаар эцсийн өмчлөгч тодорхой болох хүртэл үргэлжлүүлнэ. Гэсэн хэдий ч бусад арга хэрэгслээр хяналт хэрэгжүүлж буй буюу дээд шатны удирдлагад алба хашиж буй хувь хүнийг таньж мэдэх заалт МУТСТ хууль болон УСЖ-д байхгүй ажээ.

128. *Шалгуур 10.11* – Эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээд болон итгэмжлэгдсэн төлөөлөгч бүхий харилцагчийн хувьд УСЖ-ын 5.1, 5.4-ийн дагуу МҮЭ нь хөрөнгийг эзэмших, хянах эрх бүхий хүн; хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий хүн; хөрөнгийг үр ашгийг хүртэх эрх бүхий хүнийг тодорхойлон баталгаажуулахын тулд боломжит арга хэмжээг авах шаардлагатай аж. УСЖ-ын 5.1-д МҮЭ нь хуулийн этгээд болон эрх зүйн бусад зохицуулалт бүхий бусад этгээдийн эд хөрөнгийг эзэмших, хянах болон захиран зарцуулах эрх бүхий хувь хүнийг тодорхойлон баталгаажуулах шаардлагатай. Үргэлжилсэн холбоо бүхий удирдлагын бүтэцтэй бол МҮЭ-үүд холбоос бүрд харгалзах өмчлөлийн бүтцийг тогтоох байдлаар эцсийн өмчлөгч тодорхой болох хүртэл үргэлжлүүлнэ. Эл тайлангийн 1-р бүлэгт дурьдсанаар, Монгол Улсын хуулиар экспресс траст болон ижил төрлийн бүтэц, үүрэгтэй эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийг зөвшөөрдөггүй бөгөөд гадаадын траст нь Монгол Улсын эдийн засагт хамаарах зүйл биш юм.

129. *Шалгуур 10.12* – Монгол Улсад амь насны даатгалын үр ашиг хүртэх этгээдийн хувьд тусгайлсан ХТМ үйл явц байдаггүй аж.

130. *Шалгуур 10.13* – ХТМ өргөтгөсөн процедурт амь насны даатгалын үр ашиг хүртэх этгээдийг эрсдэлийн хүчин зүйл болгон авч үзэх шаардлага МҮЭ-эд тавигддаггүй аж.

131. *Шалгуур 10.14* – МУТСТ хуулийн 5.1.1-д зааснаар МҮЭ нь санхүүгийн харилцаа үүсгэхийн харилцагчийг таньж мэдэх үүрэгтэй. Өөрөөр хэлбэл, Монгол Улс ХТМ үйл явцыг хойшлуулдаггүй. Түүнчлэн, УСЖ-ын 5.10-т харилцагчийн болон эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийн үнэн бодит байдлыг нягтлах боломжгүй тохиолдолд тухайн этгээдэд данс нээх, бизнесийн харилцаа үүсгэх, гүйлгээ хийхийг МҮЭ-эд хориглодог байна.

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

132. *Шалгуур 10.15* – Монгол Улс ХТМ үйл явцыг хойшлуулдаггүй тул МУТСТ хуульд ХТМ-ээс өмнө явагдсан бизнесийн харилцааны эрсдэлийг удирдах заалт байхгүй аж.

133. *Шалгуур 10.16* – УСЖ-ын 3.1.4-т МҮЭ нь харилцагчийн мэдээлэл болон эрсдэлийн зураглалд тулгуурлан харилцагчид байнгын хяналт тавих үүрэгтэй. УСЖ-ын 5.7-д МҮЭ нь ямар тохиолдолд харилцагчийн мэдээллийг дахин нягтлах үүрэгтэйг заажээ. Түүнчлэн, тус журмын 5.5, 5.6-д зааснаар МҮЭ нь харилцагчийн болон эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг бизнесийн харилцааны туршид цуглуулан хадгалж, үнэн зөв бодит байдалд тогтмол хяналт тавих үүрэгтэйг заажээ.

134. *Шалгуур 10.17* – МУТСТ хуулийн 5.8-д зааснаар МҮЭ нь эрсдэлтэй бизнесийн харилцаа, гүйлгээг тодорхойлж өргөтгөсөн ХТМ үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнтэй адилаар, УСЖ-ын 4.1.1-д өндөр эрсдэлтэй гэж үзсэн харилцагч, гүйлгээнд ХТМ үйл ажиллагааг нарийвчлан хийхээр заажээ.

135. *Шалгуур 10.18* – МУТСТ хуульд болон УСЖ-д хялбарчилсан ХТМ арга хэмжээний талаар тусгагдаагүй ажээ.

136. *Шалгуур 10.19* – МУТСТ хуулийн 5.4-т зааснаар харилцагч холбогдох мэдээлэл өгөхөөс татгалзвал МҮЭ үйлчилгээ үзүүлэхээс татгалзах үүрэгтэй. УСЖ-ын 5.10-т МҮЭ нь харилцагчийн талаарх мэдээллийн үнэн бодит байдлыг нягтлах боломжгүй тохиолдолд тухайн этгээдэд данс нээх, бизнесийн харилцаа үүсгэх, гүйлгээ хийхээс татгалзахаар заажээ. Мөн өмнө нь үүсгэсэн бизнесийн харилцааг зогсоох арга хэмжээ авч СГТ-гаар мэдээлнэ гэсэн байна.

137. *Шалгуур 10.20* – УСЖ-ын 5.11-д зааснаар МҮЭ нь хөрөнгө эсвэл гүйлгээ хийх оролдлогыг МУТС-тэй холбоотой эсвэл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого гэж сэжиглэсэн бөгөөд ХТМ үйл ажиллагааг хийх эсвэл үргэлжлүүлэх нь харилцагчид өөрийг нь сэжиглэж байгаа нь тодорхой болно гэсэн итгэл төрсөн бол ХТМ үйл ажиллагааг зогсоож, нэн даруй СГТ-гаар СМА-нд мэдээлэх аж.

### *Дүгнэлт*

138. ХТМ арга хэмжээг гол төлөв МУТСТ хуульд болон УСЖ-д тусгажээ. Өргөтгөсөн ХТМ үйл ажиллагаатай холбоотой зарим жижиг дутагдлыг нэрлэвэл: (i) 24 цагийн дотор хийсэн хоорондоо холбоо бүхий гүйлгээг таньж мэдэх шаардлага нь учир дутагдалтай юм; (ii) хуулийн этгээдийн хяналтыг хэрэгжүүлж буй хувь хүнийг таньж мэдэх ажиллагааны түвшин. Монгол Улс амь насны даатгалын ганцхан компанитай, тус салбар нь бага эрсдэлтэй тул шалгуур 10.12, 10.13-т заасан дутагдалд бага жин өгсөн болно. Монгол Улс **Зөвлөмж 10-ын дийлэнхийг биелүүлсэн байна.**

### *Зөвлөмж 11 – Баримт, материал хадгалалт*

139. 2007 оны ХҮТ-д Монгол Улс хуучин зөвлөмж 10-ыг хэсэгчлэн биелүүлсэн үнэлгээтэй байв. Тус тайланд дурдсанаар: (i) тухайн гүйлгээг сэргээхүйц хэмжээний мэдээллийг МҮЭ хадгалдаггүй, (ii) данс хааж бизнесийн харилцааг зогсоосноос хойш 5 жилийн турш харилцагчийн болон дансны мэдээллийг хадгалах, эрх бүхий байгууллагын

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

мэдээлэл авах хүсэлтийн дагуу шуурхай гаргаж өгөхөд бэлэн байдалтай хадгалах зохицуулалт байхгүй байжээ.

140. Монгол улсын 2013 оны тайланд хуучин Зөвлөмж 10-ыг хэрэгжүүлэхэд үлэмж дэвшил гарсныг дурдаж МУТСТ хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт нь зөвлөмж 10-ын биелэлтийг үндсэнд нь буюу бүрэн хангахад нөлөөлснийг онцолжээ.

141. *Шалгуур 11.1* – МУТСТ хуулийн 8.1-д СБ-ууд дотоод, гадаадын бүх харилцагчид, тэдгээрийн данс болон гүйлгээний талаарх мэдээллийг хадгалах үүрэгтэй гэжээ. Данс хаагдсанаас эсвэл бизнесийн харилцаа дуусгавар болсноос хойш 5-аас доошгүй жил хадгална. Түүнчлэн, УСЖ-ын 6.1-д хадгалах баримтын төрлийг (тухайлбал, бэлэн болон бэлэн бус гүйлгээ г.м.) заасан бөгөөд бизнесийн харилцаа дуусгавар болсноос хойш буюу тохиолдлын чанартай гүйлгээ хийснээс хойш 5-аас доошгүй жилээр хадгалахаар заажээ.

142. *Шалгуур 11.2* – МУТСТ хуулийн 8.1-д зааснаар СБ-ууд 5-н жилийн хугацаанд ХТМ (МУТСТ хуулийн 5-р зүйл)-тэй болон тусгай хяналт бүхий гүйлгээ (МУТСТ хуулийн 6-р зүйл)-тэй холбоотой мэдээллийг хадгалах үүрэгтэй. УСЖ-ын 6.1-д бизнесийн харилцаа дуусгавар болсон буюу тохиолдлын чанартай гүйлгээ хийгдсэнээс хойш 5 жилийн турш мэдээллийг хадгалах талаар заажээ. Хадгалах баримтын төрөлд биеийн байцаалтын хуулбар, ХТМ-тэй холбоотой мэдээлэл, гүйлгээ, дансны мэдээллийг нарийвчлан шалгах явцад олж авсан мэдээлэл, дүн шинжилгээ зэрэг хамаарна.

143. *Шалгуур 11.3* – УСЖ-ын 6.2-т зааснаар МУТСТ хууль болон тус журмын дагуу хадгалах баримт нь тухайн гүйлгээг сэргээх боломжтой, холбогдох бүх мэдээллийг агуулсан байхаар заажээ.

144. *Шалгуур 11.4* – МУТСТ хуулийн 8.2-ын дагуу СБ-ууд мэдээллийг эрх бүхий байгууллагын хүсэлтээр шуурхай гаргаж өгөхөд бэлэн байдалтай хадгална. МУТСТ хуулийн 7.4-т СБ-ууд тогтоосон журмын дагуу тодорхой гүйлгээний талаарх мэдээллийг ХСБ-уудад гаргаж өгнө гэжээ. Түүнчлэн, УСЖ-ын 6.2-т зааснаар хадгалах баримт нь эрх бүхий этгээдийн мэдээлэл авахаар гаргасан хүсэлтийн дагуу шуурхай гаргаж өгөхөд бэлэн байдалтай байх ёстой ажээ.

### *Дүгнэлт*

145. **Монгол Улс Зөвлөмж 11-ийг биелүүлсэн байна.**

### ***Зөвлөмж 12 – Улс төрд нөлөө бүхий этгээд /УТНБЭ/***

146. 2007 оны ХҮТ-д Монгол Улс хуучин зөвлөмж 6-г биелүүлээгүй гэсэн үнэлгээтэй байв. Тухайн үеийн УТНБЭ-дийн тодорхойлолт нь ФАТФ-ын стандарттай нийцэхгүй байсны дээр СБ-ууд УТНБЭ-ийн хувьд өргөтгөсөн ХТМ арга хэмжээ авах зохицуулалт байхгүй байв.

147. Гадаад (УСЖ-ын 7.2-р зүйл), дотоодын (Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 2-р зүйл болон УСЖ-ын 7.2) УТНБЭ-ийн өнөөгийн тодорхойлолт нь ФАТФ-ын стандарттай нийцэж байна.

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

148. *Шалгуур 12.1* – УСЖ-ын 7.1-д зааснаар МҮЭ нь дотоод хяналтын хөтөлбөрийг хэрэгжүүлж УТНБЭ, түүний гэр бүлийн гишүүд болон нэгдмэл сонирхолтой этгээдийг тодорхойлох, тэдгээрийг ХТМ өргөтгөсөн үйл ажиллагаанд хамруулахаар заажээ. УСЖ-ын 4.2-т ХТМ өргөтгөсөн арга хэмжээг дараахь байдлаар тодорхойлжээ: (i) харилцагчийн бизнес, хөрөнгийн эх үүсвэр, гүйлгээний зориулалтын талаар мэдээллийг харилцагчаас гаргаж авах бөгөөд тухайн мэдээллийн үнэ бодит байдлыг нягтлах, (ii) харилцагчтай бизнесийн харилцаа тогтоохоос өмнө болон цаашид үргэлжлүүлэх талаар гүйцэтгэх удирдлагын зөвшөөрлийг нь авах (УСЖ-ын 4.3), (iii) харилцагчдын гүйлгээнд тавих хяналтын давтамж, цар хүрээг нэмэгдүүлэх, харилцан хамааралтай бусад этгээдийг ХТМ хяналтад хамруулах, ХТМ явцад харилцагчаас авсан мэдээллийг нягтлах.

149. *Шалгуур 12.2* – УСЖ-ын 7.1, 4.2-р зүйл нь дотоодын УТНБЭ болон олон улсын байгууллагыг төлөөлж буй/төлөөлж байсан этгээдэд хамаарна. Гэсэн хэдий ч, УСЖ-д харилцагчийн эцсийн өмчлөгчийг эсвэл олон улсын байгууллагыг төлөөлж буй этгээдийн эцсийн өмчлөгчийг хамрах заалт байхгүй ажээ.

150. *Шалгуур 12.3* – УСЖ-ын 7.3-р зүйлд УТНБЭ-ийн гэр бүл, нэгдмэл сонирхолтой этгээдийг УТНБЭ-тэй адил авч үзэхээр заажээ.

151. *Шалгуур 12.4* – Даатгалын салбарт дээрх шаардлага үйлчилнэ. УСЖ дагуу даатгагч нь даатгалын үр шим хүртэгч эсвэл үр шим хүртэгчийн эцсийн өмчлөгчийг тодорхойлох шаардлагагүй. Түүнчлэн, амь нас даатгагч нь нөхөн төлбөр хийхээс өмнө дээд удирдлагад мэдэгдэх, бизнесийн харилцааг бүхэлд нь нарийвчлан судлах, өндөр эрсдэл илэрсэн үед СГТ бүрдүүлэх шаардлага байхгүй аж.

### *Дүгнэлт*

152. Монгол Улс УТНБЭ-тэй холбоотойгоор амь насны даатгалын салбарт бага зэргийн доголдолтой байна. Амь насны даатгалын салбар ганцхан компанитай, эрсдэл багатай тул шалгуур 12.4-т дурьдсан доголдолд бага жин өгсөн болно. Монгол Улс **Зөвлөмж 12-ын дийлэнхийг биелүүлсэн байна.**

### *Зөвлөмж 13 – Корреспондент банкны үйл ажиллагаа*

153. 2007 оны ХҮТ-д Монгол Улс Зөвлөмж 7-г биелүүлээгүй гэсэн үнэлгээтэй байв. Хил дамнасан харилцагч банкны хувьд өргөтгөсөн ХТМ арга хэмжээ авахыг СБ-аас шаарддаггүй байв. 2007 оноос хойш, Монгол Улс МУТСТ хуульд нэмэлт өөрчлөлт оруулан тус зөвлөмжийг хэрэгжүүлж эхэлжээ.

154. *Шалгуур 13.1* – Харилцагч банктай холбоотой шаардлагыг МУТСТ хуулийн 5.6-д, УСЖ-ын 8-р бүлэгт тус тус тусгажээ. УСЖ-ын 8.1-д СБ-ууд дараахь арга хэмжээг авбал зохино: (i) харилцагч байгууллагын нэр хүнд, МУТСТ-тэй холбоотойгоор шалгагдаж байсан эсэхийг шалгах, (ii) харилцагч байгууллагын МУТСТ хяналтын тогтолцоог үнэлэх, (iii) корреспондент харилцаа тогтоохын өмнө дээд түвшний удирдлагын зөвшөөрлийг авах, (iv) харилцаанаас үүсэх хоёр талын хариуцлагыг тодорхойлсон гэрээ байгуулах шаардлагатай.

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

155. *Шалгуур 13.2* – УСЖ-ын 8.1.6-д корреспондент харилцаа үүсгэх банк, СБ нь МҮЭ дээр байрших дансыг ашиглан шууд гүйлгээ хийх эрхийг өөрийн аль нэг харилцагчдаа зөвшөөрдөг эсэхийг мэдэх, хэрэв тийм бол уг харилцагчийн мэдээллийн үнэн бодит байдлыг корреспондент харилцаа үүсгэх банк, СБ нягталсан эсэхийг, түүний гүйлгээнд байнгын хяналт тавьдаг эсэхийг мөн хүсэлт гаргасан тохиолдолд уг харилцагч, түүний гүйлгээтэй холбогдох мэдээллийг гаргаж өгөх боломжтой эсэхийг баталгаажуулахаар заажээ.

156. *Шалгуур 13.3* – УСЖ-ын 8.1.7-д СБ-ыг халхавч банк, санхүүгийн байгууллагатай корреспондент харилцаа үүсгэхийг хориглосон байдаг. Нөгөө талаас халхавч банктай тогтоосон бизнесийн харилцааг үргэлжлүүлэхийг хориглосон заалт байхгүй аж. УСЖ-ын 8.1.8-ын дагуу хэрэв корреспондент харилцаатай СБ нь дансаа халхавч банкинд ашиглахыг зөвшөөрдөг бол түүнтэй корреспондент харилцаа үүсгэхээс татгалзах ёстой ажээ.

### *Дүгнэлт*

157. Халхавч банктай үүсгэсэн бизнесийн харилцааг үргэлжлүүлэхийг МУТСТ хуульд хориглох тал дээр бага зэргийн доголдол байна. **Монгол Улс Зөвлөмж 13-ын дийлэнхийг биелүүлсэн байна.**

### *Зөвлөмж 14 – Мөнгө болон үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ*

158. 2007 оны ХҮТ-д Монгол Улс хуучин тусгай зөвлөмж 6-г биелүүлээгүй үнэлгээтэй байв. МУТСТ үүргийг хэрэгжүүлэх удирдамж, чиглэлээр мөнгө, үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ үзүүлэгч (МҮБЗШҮҮ)-дийг хангаагүй, СББМҮҮ-дийн салбарт МУТСТ тогтолцоо хэрэгждэггүй, МҮБЗШҮҮ-дээс агентуудын жагсаалт хөтлөхийг шаарддаггүй гэж дүгнэсэн байжээ.

159. *Шалгуур 14.1* – Монгол Улсад МҮБЗШҮҮ-ид тусгай зөвшөөрөл авдаг. МҮБЗШҮҮ-ид нь нэг бол (i) Банкны тухай хуулийн 6-р зүйл, Банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журмын 4-р бүлэгт заасны дагуу Монголбанкнаас “гадаад төлбөр тооцоо хийх зөвшөөрөл” авна; аль эсвэл (ii) ББСБ-ын үйл ажиллагааны тухай хуулийн 7-р зүйлийн дагуу СЗХ-ноос “цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ” үзүүлэх зөвшөөрөл авдаг байна.

160. *Шалгуур 14.2* – Монгол Улс зөвшөөрөлгүй буюу бүртгэлгүй МҮБЗШҮҮ-дийг тогтоож шийтгэсэн гэх баримт алга. Банкны тухай хуулийн 68.1.2-т тусгай зөвшөөрөл авалгүй банкны үйл ажиллагаа эрхэлсэн хүний олсон орлогыг хурааж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50-150 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор заажээ. Харин ББСБ-ын үйл ажиллагааны тухай хуулийн 20.1.2-т зөвшөөрөл авалгүй ББСБ-ын үйл ажиллагаа эрхэлсэн хүний хууль бус орлогыг хурааж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20-40 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор заажээ. Эдгээр шийтгэл нь гэмт үйлдэлд тохирсон, дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэхүйц байж чадахгүй байна.

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

161. *Шалгуур 14.3* – МҮБЗШҮҮ-ид нь банк эсвэл ББСБ болохын хувьд МУТСТ хуулийн дагуу МҮЭ-д хамаарах бөгөөд Монголбанк эсвэл СЗХ-ны МУТСТ хяналт шалгалтад хамрагддаг байна.

162. *Шалгуур 14.4* – МҮБЗШҮ эрхэлж буй банкууд агентийг ашигладаггүй аж. Дотоодын МҮБЗШҮҮ-дийн хувьд банкууд өөрсдийн салбар нэгжээ ашигладаг бол хил дамнасан МҮБЗШҮҮ-дийн хувьд банкууд корреспондент банкны харилцаагаа ашигладаг ажээ. Гэсэн хэдий ч дараахь зүйлс тодорхойгүй үлдэж байна: (i) МҮБЗШҮ үзүүлэгч ББСБ-ууд төлөөлөгч ашигладаг эсэх, (ii) төлөөлөгч зөвшөөрөл авч бүртгүүлэх шаардлагатай эсэх буюу ББСБ-ууд төлөөлөгчдийн жагсаалтыг хөтлөх шаардлагатай эсэх.

163. *Шалгуур 14.5* – Банкууд төлөөлөгчдийг ашигладаггүй байна. МЗБЗШҮ үзүүлэгч ББСБ-ууд өөрийн төлөөлөгчдөө МУТСТ хөтөлбөрт хамруулж комплаенсийг хянадаг эсэх нь тодорхойгүй байна.

### *Дүгнэлт*

164. Монгол Улсын Зөвлөмж 14-ийн хэрэгжилт дунд зэргийн доголдолтой байна. Дараахь зүйлс тодорхойгүй байна: (i) МҮБЗШҮ үзүүлэх зөвшөөрөлгүй этгээдэд ногдуулах шийтгэл нь тохирсон, дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэхүйц эсэх, (ii) МҮБЗШҮ үйлчилгээ үзүүлж буй ББСБ-ын төлөөлөгчид тусгай зөвшөөрөл авдаг буюу бүртгүүлдэг эсэх, өөрөөр хэлбэл ББСБ-ууд нь төлөөлөгчдийн жагсаалтыг хөтөлж тэднийг МУТСТ хөтөлбөрт хамруулж комплаенсийг нь хянадаг эсэх. **Монгол Улс Зөвлөмж 14-ийг хэсэгчлэн биелүүлсэн байна.**

### *Зөвлөмж 15 – Шинэ технологи*

165. 2007 оны ХҮТ-д Монгол Улс хуучин зөвлөмж 8-ыг биелүүлээгүй гэсэн үнэлгээтэй байв. Технологийн дэвшлийг МУТС гэмт хэрэгт урвуулан ашиглахаас сэргийлсэн хууль журмын зохицуулалт байхгүй байв. Харин 2007 оноос хойш Монгол Улс тус зөвлөмжийг хэрэгжүүлэх үүднээс МУТСТ хуульд нэмэлт өөрчлөлт оруулжээ.

166. *Шалгуур 15.1* – МҮЭ-тэй холбоотойгоор МУТСТ хуулийн 5.5-т МҮЭ-үүд шинэ технологи ашиглан хийгдэж байгаа гүйлгээнд онцгой анхаарч, уг гүйлгээнээс үүсч болох МУТС эрсдэлээс урьдчилан сэргийлэх тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлнэ гэж заасан байдаг. УСЖ-ын 9.1.1-д МҮЭ нь шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэр, бизнесийн шинэ харилцааны МУТСТ эрсдэлийг үнэлэх, шинэ технологи ашигласнаар одоо байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээний МУТСТ эрсдэл хэрхэн өөрчлөгдөхийг үнэлэх ёстойг заажээ.

167. ҮЭҮ-нд банкны салбарт шинэ технологи нэвтэрч буйтай холбоотой МУТС эрсдэлийг тодорхойлон үнэлжээ. Тухайлбал, төлбөрийн үйлчилгээнд шинэ технологи нэвтэрч буй нь өндөр эрсдэл бий болгож буйг дурджээ. Монголбанкны эрсдэлд суурилсан МУТСТ хяналт шалгалтын тогтолцоо нь МУТС эрсдэлийг тодорхойлохдоо шинэ технологийг мөн хамруулан авч үздэг аж. Харин СЗХ МУТС эрсдэлийн үнэлгээнд шинэ технологийн асуудлыг авч үздэг эсэх нь тодорхойгүй байна.

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

168. *Шалгуур 15.2* – УСЖ-ын 9.1.2-т МҮЭ нь шинэ технологи нэвтрүүлснээс үүдэх МУТСТ эрсдэлийг бууруулах, үр нөлөөг нь багасгах талаар зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заажээ. Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологийг нэвтрүүлэхээс өмнө эрсдэлийн үнэлгээ хийнэ гэсэн заалт байхгүй ч тэгдэггүй гэсэн үг биш юм.

### *Дүгнэлт*

169. Монгол Улс Зөвлөмж 15-ыг хэрэгжүүлэхтэй холбоотой бага зэргийн доголдол байна. СЗХ-ны зүгээс шинэ бүтээгдэхүүн, технологиос үүдэлтэй МУТС эрсдэлийг үнэлдэг эсэх нь тодорхойгүй ажээ. УСЖ-ын 9.1.2-т МҮЭ нь шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, технологи нэвтрүүлэхээс өмнө эрсдэлийн үнэлгээ зайлшгүй хийх шаардлагыг тусгаагүй аж. **Монгол Улс Зөвлөмж 15-ын дийлэнхийг биелүүлсэн байна.**

### *Зөвлөмж 16 – Цахим шилжүүлэг*

170. Монгол Улс 2007 оны ХҮТ-д хуучин Тусгай зөвлөмж 7-г биелүүлээгүй гэсэн үнэлгээтэй байв. Дараахь зүйлсийг МҮЭ-ээс шаардах хууль эрх зүйн зохицуулалтгүй байв: (i) шилжүүлэгчийн талаарх мэдээллийг олж аван хадгалах, шалгах, (ii) гадаад цахим шилжүүлгийн төлбөрийн баримтанд шилжүүлэгчийн мэдээллийг бүрэн тусгах, (iii) цахим шилжүүлэг хийх үед шилжүүлэгчдийн мэдээллийг бүрэн дамжуулахыг зуучлагч болон хүлээн авагч МҮЭ-үүдээс шаардах, (iv) шилжүүлэгчийн талаарх бүрэн мэдээлэлгүй цахим шилжүүлгийн хувьд эрсдэлд суурилсан арга хэмжээ авахыг хүлээн авагч МҮЭ-ээс шаардах. Харин 2007 оноос хойш Монгол Улс тус зөвлөмжийг хэрэгжүүлэх үүднээс МУТСТ хуульд нэмэлт өөрчлөлт оруулжээ.

171. *Шалгуур 16.1* – МУТСТ хуулийн 5.2.6-ийн дагуу Монгол Улс цахим шилжүүлгийн хувьд ямар нэг босго тавьдаггүй аж. УСЖ-ын 10.1-д гадаад цахим шилжүүлэг хийж буй МҮЭ нь шилжүүлгийн цахим зурвас (message)-т: (i) шилжүүлэгч болон хүлээн авагчийн бүтэн нэр, (ii) шилжүүлэгч болон хүлээн авагчийн гүйлгээ хийхэд ашигласан дансны дугаар, (iii) шилжүүлэгчийн хаяг эсхүл биеийн байцаалт, эсхүл төрсөн газар зэрэг мэдээллийг үнэн зөвөөр тусгахыг шаарддаг ажээ.

172. *Шалгуур 16.2* – УСЖ-ын 10.3-р зүйл энэхүү шалгуурыг хангалттай түвшинд хангахаар байна.

173. *Шалгуур 16.3* – Монгол Улс гадаад цахим шилжүүлгийн хувьд минимум босго тавьдаггүй.

174. *Шалгуур 16.4* - Монгол Улс гадаад цахим шилжүүлгийн хувьд минимум босго тавьдаггүй.

175. *Шалгуур 16.5-16.6* – УСЖ-ын 10.5-ын дагуу, дотоодын цахим шилжүүлэг хийж буй СБ нь цахим шилжүүлгийн зурваст шилжүүлэгчийн бүрэн мэдээлэл буюу дансны дугаарыг хавсаргана. УСЖ-ын 10.6-д дотоод цахим шилжүүлэгт шилжүүлэгчийн бүрэн мэдээллийг цахим зурваст хавсаргаагүй бол цахим шилжүүлгийг хүлээн авсан МҮЭ болон СМА цахим шилжүүлгийг хийсэн МҮЭ-ээс шилжүүлэгчийн мэдээллийг авах хүсэлт гаргаж болохоор заажээ. Цахим шилжүүлгийг хийсэн МҮЭ нь дээрх хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор шилжүүлэгчийн талаарх өөрт байгаа мэдээллийг гаргаж өгнө.

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

176. *Шалгуур 16.7* – УСЖ-ын 10.9-д МҮЭ нь ХТМ хүрээнд цуглуулсан цахим шилжүүлгийн талаарх мэдээллийг 5-аас доошгүй жил хадгална. УСЖ-ын 6.2-т заасны дагуу хадгалах мэдээлэл нь тухайн гүйлгээг сэргээх боломжтой, хуульд заасан эрх бүхий этгээдийн мэдээлэл авах хүсэлтийн дагуу шуурхай гаргаж өгөхөд бэлэн байдалтай хадгална гэжээ.

177. *Шалгуур 16.8* – УСЖ-ын 10.2-ыг харвал зөвхөн 16.1 шалгуурыг үл хангах МҮЭ-эд цахим шилжүүлэг хийхийг хориглох аж; харин 16.2-16.7 шалгуурыг хангахгүй байх нь хориглох заалт болохгүй аж.

178. *Шалгуур 16.9* –УСЖ-ын 10.2-т шилжүүлэгч болон хүлээн авагчийн мэдээлэл дутуу нөхцөлд МҮЭ-д гадаад цахим шилжүүлэг хийхийг хориглох тул зуучлагч СБ-аас ч ялгаагүй шилжүүлэгч, хүлээн авагчийн мэдээлэл бүхий гадаад цахим шилжүүлэг хийхийг шаарддаг байж таараа. УСЖ-ын 10.7-д эдгээр зуучлагч СБ-ууд шилжүүлэгч болон хүлээн авагчийн мэдээллийг 5-аас доошгүй жил хадгалахаар заажээ.

179. *Шалгуур 16.10* – УСЖ-ын 10.7-д гадаад цахим шилжүүлгийг дамжуулан өнгөрүүлж байгаа МҮЭ нь бүх мэдээллийг 5-аас доошгүй жил хадгалахаар заажээ. Иймд гадаад цахим шилжүүлгийн зурваст шилжүүлэгч ба хүлээн авагчийн мэдээллийг тусгах техникийн хүндрэл бэрхшээл тулгарлаа ч хүсэлт илгээсэн СБ буюу зуучлагч СБ-ын бүх мэдээллийг хадгалахыг МҮЭ-ээс шаарддаг байна.

180. *Шалгуур 16.11* – УСЖ-ын 10.1, 10.2-т шаардлага хангаагүй цахим шилжүүлэг хийхийг МҮЭ-д хориглох тул шилжүүлэгч, хүлээн авагчийн мэдээлэл дутуу гадаад цахим шилжүүлгийг илрүүлж тогтоох үүрэг зуучлагч СБ-уудаас шууд бусаар оногдож байна.

181. *Шалгуур 16.12* – УСЖ-ын 10.8-ын дагуу МҮЭ нь цахим шилжүүлгийг хийх, дамжуулах, зогсоох, татгалзах эсэхийг шийдэх эрсдэлд суурилсан үр дүнтэй хяналтын тогтолцоотой байна. Энэ хяналтын тогтолцоо нь гүйлгээг СГТ-гаар СМА-нд мэдээлэх, бизнесийн харилцааг зогсоох, санхүүгийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, тусгайлсан хяналт тавих бодлого, журамтай нийцсэн байна.

182. *Шалгуур 16.13* - УСЖ-ын 10.1, 10.2-т шаардлага хангаагүй цахим шилжүүлэг хийхийг МҮЭ-д хориглох тул шилжүүлэгч, хүлээн авагчийн мэдээлэл дутуу гадаад цахим шилжүүлгийг илрүүлж тогтоох үүрэг хүлээн авагч СБ-уудаас шууд бусаар оногдож байна.

183. *Шалгуур 16.14* – УСЖ-ын 10.9-ийн дагуу цахим шилжүүлэг хүлээн авсан МҮЭ нь шилжүүлгийг хүлээн авч буй харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг гүйцэтгэх үүрэгтэй бөгөөд бүх мэдээллийг 5-аас доошгүй жил хадгалах үүрэгтэй. МУТСТ хуулийн 5.2.3-ын дагуу, ХТМ үйл ажиллагааг цахим шилжүүлгийн эцсийн хүлээн авагчийг тодруултал хэрэгжүүлнэ. УСЖ-ын 6.2-т хадгалах мэдээлэл нь тухайн гүйлгээг сэргээх боломжтой, хуульд заасан эрх бүхий этгээдийн мэдээлэл авах хүсэлтийн дагуу шуурхай гаргаж өгөхөд бэлэн байдалтай хадгалагдахаар заажээ.

184. *Шалгуур 16.15* – УСЖ-ын 10.8-ын дагуу МҮЭ нь цахим шилжүүлгийг хийх, дамжуулах, зогсоох, татгалзах эсэхийг шийдэх эрсдэлд суурилсан үр дүнтэй хяналтын тогтолцоотой байна. Энэ хяналтын тогтолцоо нь гүйлгээг СГТ-гаар СМА-нд мэдээлэх, бизнесийн харилцааг зогсоох, санхүүгийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, тусгайлсан хяналт тавих бодлого, журамтай нийцсэн байна.

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

185. *Шалгуур 16.16* – МҮБЗШҮҮ-ид МУТСТ хуулийн 4.1-ийн дагуу МҮЭ тул цахим шилжүүлэгтэй холбоотой шаардлагыг хангах үүрэгтэй. Монгол улсын хууль тогтоомжид Зөвлөмж 16 бүрэн тусгалаа олж чадаагүй байна.

186. *Шалгуур 16.17* - МҮБЗШҮҮ-ид МУТСТ хуулийн 4.1-ийн дагуу МҮЭ болно. МУТСТ хуулийн 7-р зүйлийн дагуу СМА-нд СГ тайлагнахаар заажээ. Гэхдээ СГТ-гаар мэдээлэх эсэхийг тодорхойлохын тулд цахим шилжүүлгийн шилжүүлэгч ба хүлээн авагч талыг хоёуланг нь хянах шаардлагыг МҮБЗШҮҮ-дэд тавьдаггүй аж. Сэжигтэй цахим шилжүүлэг хийгдсэн улсад нь СГТ-аар мэдээлж, хувийг Монголын СМА-нд давхар хүргүүлэх шаардлагыг МҮБЗШҮҮ-дэд тавьдаггүй байна.

187. *Шалгуур 16.18* – Цахим шилжүүлэг хийж буй МУТСТ хуулийн 4.1-д заасан МҮЭ нь ТТ тухай хуулийн 7.1.7-г буюу НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс террорист гэж зарласан этгээдтэй холбоотой хөрөнгийг царцаах үүрэгтэй. ТЭЖО журмын 5.1-д жагсаалтад орсон иргэн, хуулийн этгээдээс бүхэлд нь буюу хэсэгчлэн, дангаараа буюу хамтран, шууд буюу шууд бусаар эзэмшдэг буюу хяналтаа хэрэгжүүлдэг бүхий л мөнгөн хуримтлал, бусад хөрөнгө нэн даруй царцаахыг шаардана гэжээ. Мөн журамд чөлөөлсөн хөрөнгийн талаар болон хөрөнгө шилжүүлэхийг оролдсон тухай мэдээллийг арилжааны банк нь Монголбанкинд, СБ болон санхүүгийн бус үйлчилгээ эрхлэгч этгээд нь СЗХ-нд тус тус мэдээлэхээр заажээ. Гэсэн хэдий ч, *дэд шалгуур 6.5(a)-д дурьдсанаар* хөрөнгө царцаах үүрэг хэрэгждэггүй ажээ. Хэдий тийм ч жагсаалтад орсон этгээдийн хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох, хянахад УСЖ-ын 5.12 нөлөөлөх талтай, учир нь тус заалт нь НҮБ-ын АЗ-ийн 1267-р тогтоолд террорист гэж зарласан этгээдэд данс нээх, гүйлгээ хийх, санхүүгийн аливаа үйлчилгээ үзүүлэхийг МҮЭ-эд хориглодог ажээ.

### *Дүгнэлт*

188. Монгол Улс Зөвлөмж 16-г хэрэгжүүлэхэд дараахь бага зэргийн доголдол ажиглагдаж байна: (i) шалгуур 16.8-д заасан цахим шилжүүлгийг хориглох явдал хязгаарлагдмал; (ii) МҮБЗШҮҮ-дэд цахим шилжүүлэгтэй холбоотой шаардлагыг тавьдаг ч Зөвлөмж 16-ийн хэрэгжилт бага зэрэг доголдож байна; (iii) СГТ-гаар мэдээлэх эсэхийг тодорхойлохын тулд цахим шилжүүлгийн шилжүүлэгч ба хүлээн авагч талыг хоёуланг нь хянах шаардлагыг МҮБЗШҮҮ-дэд тавьдаггүй аж; (iv) ТТ тухай хууль болон ТЭЖО журамд тусгасан хөрөнгө царцаах зохицуулалтыг хэрэгжүүлэх боломжгүй. Хэдий тийм ч сүүлд дурьдсан доголдолд бага жин өгсөн нь Монгол Улсын ТС эрсдэлийн төсөөлөлтэй холбоотой. **Монгол Улс Зөвлөмж 16-ийн дийлэнхийг биелүүлсэн байна.**

### *Зөвлөмж 17 – Гуравдагч этгээдэд тулгуурлах*

189. 2007 оны ХҮТ-д Монгол Улс хуучин зөвлөмж 9-ийг хэсэгчлэн биелүүлсэн гэсэн үнэлгээтэй байв. МУТСТ хуульд дараахь зүйл тусгагдаагүй байжээ: (i) МҮЭ нь ХТМ үйл ажиллагаагаар цуглуулсан мэдээллийг баталгаажуулах үүрэгтэй, (ii) нотариатад тулгуурлаж буй МҮЭ нь нотариатчдын ХТМ болон баталгаажуулах үйл явцыг олж мэдэх ёстой, (iii) ХТМ болон баталгаажуулах үйл ажиллагааны эцсийн хариуцлагыг МҮЭ хүлээх.

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

190. *Шалгуур 17.1* – УСЖ-ын 11-р бүлэгт МҮЭ нь ХТМ үйл ажиллагааг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлж болохоор заажээ. Гуравдагч этгээд нь цуглуулсан мэдээллийг МҮЭ-ийн хүсэлтийн дагуу шуурхай гаргаж өгөх боломжтой байх шаардлагатай. Гуравдагч этгээд нь МУТСТ хууль тогтоомжийн хэрэгжилтийн хүрээнд эрх бүхий байгууллагаас хяналт, шалгалтад хамрагддаг этгээд байх бөгөөд түүний ХТМ үйл ажиллагаа нь МУТСТ хуулийн шаардлагад нийцсэн, цуглуулсан баримт материалыг шаардлагад нийцүүлэн хадгалах ёстой. Нөгөө талаас УСЖ-ын 11-р бүлэгт дараах асуудал тодорхой бус байна: (i) гуравдагч этгээдэд тулгуурлах нь зөвхөн СБ-ууд болон СББМҮҮ-дээр хязгаарлагдаж аутсорсинг, агентлагийн харилцаа холбоо үүнд хамаарахгүй эсэх, (ii) ХТМ үйл ажиллагааны аль хэсгийг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх, мөн (iii) ХТМ үйл ажиллагааны эцсийн хариуцлагыг МҮЭ хүлээх. Түүнчлэн, нотариатын хувьд МҮЭ нь мэдээллийг бие даан баталгаажуулах үүрэгтэй эсэх нь тодорхойгүй байна.

191. *Шалгуур 17.2* – Гуравдагч этгээдийн улсын эрсдэлийг харгалзан үзэх зохицуулалт байхгүй байна.

192. *Шалгуур 17.3* – МҮЭ болон гуравдагч этгээд нь санхүүгийн нэг нэгдэлд харьяалагдах тохиолдлыг авч үзсэн зохицуулалт алга.

### *Дүгнэлт*

193. Монгол Улс Зөвлөмж 17-г хэрэгжүүлэхтэй холбоотой томоохон доголдол ажиглагдаж байна. Үүнд: (i) гуравдагч этгээдэд тулгуурлах явдлыг зөвхөн СБ болон СББМҮҮ-дээр хязгаарлах шаардлага байхгүй юм, (ii) гуравдагч этгээдэд тулгуурлах нь харилцагч, эцсийн өмчлөгч, бизнесийн мөн чанарыг тодорхойлох төдийхнөөр хязгаарлагдаж байна, (iii) ХТМ үйл ажиллагааны эцсийн үүрэг хариуцлагыг МҮЭ хүлээх зохицуулалт алга, (iv) гуравдагч этгээдийн байрлах улсыг тодорхойлохдоо тухайн улсын эрсдэлийн түвшинг тодорхойлдог байх, (v) нэг санхүүгийн нэгдэлд харьяалагдах гуравдагч этгээдэд тулгуурлах зохицуулалт боловсруулах. **Монгол Улс Зөвлөмж 17-г биелүүлээгүй байна.**

### *Зөвлөмж 18 – Дотоод хяналт болон гадаад дахь салбар, охин компани*

194. 2007 оны ХҮТ-нд Монгол Улс хуучин Зөвлөмж 15-ыг хэсэгчлэн биелүүлсэн гэсэн үнэлгээтэй байв. Хуучин Зөвлөмж 22 нь Монголд хамаарахгүй байв. Учир нь тэр үед гадаад салбар, охин компанитай МҮЭ байхгүй байжээ. МУТСТ хуулийн 14-т МҮЭ нь МУТСТ чиглэсэн дотоод хяналтын хөтөлбөр баталж, мөрдүүлнэ гэсэн ч дараахь асуудал зохицуулалтгүй байв: (i) дотоод хяналт хэрэгжүүлэх хараат бус аудитын нэгжтэй байх, (ii) ажилтнуудад МУТСТ сургалтыг тогтмол зохион байгуулах, (iii) ажилтан сонгон шалгаруулах шүүлтүүртэй байх.

195. *Шалгуур 18.1* – МУТСТ хуулийн 14-т МҮЭ нь МУТСТ дотоод хяналтын хөтөлбөрийг мөрдүүлэх шаардлагатай гэж заажээ. Харин УСЖ-ын 3.6-д: (i) хэрэгжилтэд хяналт тавих ажилтан нь удирдах түвшний ажилтан байх, (ii) ашиг сонирхлын зөрчилтэй, залилан, луйвар болон шударга бус зан чанарыг итгэх бусад гэмт хэрэг үйлдэж ял эдэлж байсан этгээдийг ажилд авахгүй байх; (iii) ажилтнуудад зориулсан МУТСТ сургалтын

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

хөтөлбөртэй байх, (iv) МУТСТ дотоод бодлого, журам, хяналтын хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнтэй байдалд хяналт тавих чиг үүрэг бүхий гүйцэтгэх удирдлагаас хараат бус дотоод аудитын нэгжтэй байхаар заажээ. Ажилтан сонгон шалгаруулах үйл ажиллагаа нь зөвхөн ашиг сонирхлын зөрчил болон луйврын ялтай этгээдээр хязгаарлагдаж байгаа нь учир дутагдалтай юм.

196. *Шалгуур 18.2* –УСЖ-ын 3.4-т МУТСТ-ээс урьдчилан сэргийлэх дотоод бодлого, журам болон хяналтын хөтөлбөр нь дотоод, гадаадад байх бүх салбар нэгж, охин компанид нэгэн ижил хэрэгжинэ гэжээ. Түүнчлэн, УСЖ-ын 3.6.5-т хэрэгжилтэд хяналт тавих ажилтан нь МҮЭ-ийн бүх салбар, нэгж, охин компаний бүх баримт бичиг, тэр дундаа харилцагч болон гүйлгээний талаарх баримт, мэдээлэлтэй танилцах, гаргуулан авах эрхтэй аж. Гэсэн хэдий ч санхүүгийн нэгдлийн хэмжээнд дараахь асуудлыг авч үзсэн зүйл алга: МУТС эрсдэлийг удирдах зорилгоор мэдээлэл солилцох; санхүүгийн нэгдлийн түвшинд комплаенс, аудитын үйл ажиллагааг хангах; мэдээлэл солилцооны нууцлал, аюулгүй байдлыг хангах.

197. *Шалгуур 18.3* – Монгол Улсын банкууд, ББСБ-ууд гадаадад салбар нэгжгүй ч УСЖ-ын 12.1-д МҮЭ нь гадаадад салбар нэгж болон дийлэнх хувьцааг нь эзэмшдэг охин компанитай бол Монгол Улсын МУТСТ хууль тогтоомжийг тухайн улсын хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэхээр заажээ. Хэрэв тухайн орны хууль тогтоомж нь Монгол Улсын МУТСТ хууль тогтоомжийн хэрэгжилтэд аливаа шалтгаанаар саад болж байвал энэ талаар дотоодын хяналт зохицуулалтын байгууллагад мэдэгдэж шийдвэрлүүлэх ёстой аж.

### *Дүгнэлт*

198. Монгол Улсын хууль тогтоомжтой холбоотой бага зэргийн доголдол нь дараахь зүйлтэй холбоотой байна. Үүнд: (i) ажилтнуудыг сонгон шалгаруулах үйл явц, (ii) санхүүгийн нэгдлийн хэмжээний хөтөлбөрийн хэрэгжилт нь ФАТФ-ын стандарттай бүрэн нийцэхгүй байна. **Монгол Улс Зөвлөмж 18-ын дийлэнхийг биелүүлсэн байна.**

### *Зөвлөмж 19 – Өндөр эрсдэлтэй улс орнууд*

199. 2007 оны ХҮТ-д Монгол Улс хуучин Зөвлөмж 21-ийг хагас биелүүлсэн байв. Монголбанк МУТСТ хуулийн дагуу өндөр эрсдэлтэй улс орнуудын жагсаалтыг гаргаагүй байжээ. Түүнчлэн, өндөр эрсдэлтэй орнуудын эсрэг авч буй арга хэмжээ тодорхой бусаас гадна МҮЭ нь тусгай хяналтын хүрээнд олж авсан мэдээллийг хадгалах үүрэг хүлээдэггүй байжээ.

200. *Шалгуур 19.1* – МУТСТ хуулийн 6.1.4, 6.2-ын дагуу МҮЭ нь МУТСТ чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас МУТСТ хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж тодорхойлогдсон улсаар дамжуулан хийсэн гүйлгээнд тусгайлан хяналт тавих, нэмэлт мэдээлэл, тайлбар гаргуулах, гүйлгээ, бизнесийн харилцааны зорилго, мөн чанарыг боломжийн хүрээнд шалгаж, үр дүнг бичгээр хадгалах үүрэгтэй аж. Олон улсын байгууллага гэдэгт ФАТФ-ыг яг нэрлээгүй ч хамруулж ойлгож байгаа бололтой. Гэсэн

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

хэдий ч, МУТСТ хуульд тухайн улсын эрсдэлд тохирсон ХТМ үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг тусгаагүй ажээ.

201. *Шалгуур 19.2* – Өргөтгөсөн ХТМ арга хэмжээг эс тооцвол, Монгол Улс хууль тогтоомждоо эрсдэлд нь тохирсон хориг арга хэмжээг ФАТФ-ын зөвлөснөөр (зөвлөөгүй байсан ч тэр) авах талаар тусгаагүй ажээ.

202. *Шалгуур 19.3* – МУТСТ хуулийн 19.2.3-т зааснаар Монголбанк, СЗХ болон СМА нь МҮЭ-д зориулан заавар, дүрэм, журам, удирдамж, зөвлөмж гаргана. 2014 оны 10 дугаар сард, СМА-наас банкуудад ФАТФ-ын МУТСТ сул тогтолцоотой, өндөр эрсдэлтэй болон хамтран ажиллахаас татгалзах улс орнуудын шинэчилсэн жагсаалтыг хүргүүлсэн байна. СМА нь тус жагсаалтыг бусад МҮЭ-үүдэд хүргүүлээгүй аж.

### *Дүгнэлт*

203. Монгол Улс Зөвлөмж 19-ийг хэрэгжүүлэх шаардлага байсаар байна. Монгол Улс өндөр эрсдэлтэй орнуудын хувьд ХТМ өргөтгөсөн үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлага тавьдаг ч дараах дунд зэргийн доголдол ажиглагдаж байна. Үүнд: (i) МУТСТ хуульд өндөр эрсдэлтэй улс орнуудыг ФАТФ-аас тодорхойлсноор хэмээн томъёолоогүй байна; (ii) эрсдэлтэй нь уялдуулан ХТМ болон хориг арга хэмжээг төрөлжүүлэх шаардлага тавьдаггүй аж. **Монгол Улс Зөвлөмж 19-ийг хэсэгчлэн биелүүлсэн байна.**

### *Зөвлөмж 20 – Сэжигтэй гүйлгээг мэдээлэх*

204. 2007 оны ХҮТ-д Монгол Улс хуучин Зөвлөмж 13 болон Тусгай зөвлөмж 4-ийг биелүүлээгүй үнэлгээтэй байв. МУТС-тэй холбоотой СГ-г тайлагнах үйл ажиллагаа ноцтой доголдож буйг тухайн үед онцолж байжээ. МУ-тай холбоотой СГТ нь явцуу хүрээг хамарч олон улсын жишгээс хол хоцорч байв. ТС-ийн СГ-ээг тайлагнах зохицуулалт байхгүй байв. Монгол Улс МУТСТ хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар Зөвлөмж 13 болон Тусгай зөвлөмж 4 дийлэнхийг биелэгдэх болсныг 2014 оны тайланд дурджээ.

205. *Шалгуур 20.1* – МУТСТ хуулийн 7.2-д МҮЭ нь хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ тухай 24 цагийн дотор батлагдсан маягт, журмын дагуу СМА-нд мэдээлэхээр заажээ. Хуулийн 7.2-р зүйл нь (i) УСЖ-ын 14-р бүлэг, (ii) СМА-нд банкнаас мэдээлэл ирүүлэх журамтай харилцан шүтэлцээтэй. УСЖ-ын 1.2.6-д “гэмт хэргээс олсон орлого”-ыг “Монгол Улсад болон гадаад улсад үйлдсэн гэмт хэрэг, хууль бус үйл ажиллагаанаас шууд болон шууд бусаар олсон эд хөрөнгө, ашиг болон орлогыг хэлнэ” хэмээн тодорхойлжээ. УСЖ дахь энэхүү тодорхойлолт нь мөнгөн орлогыг түлхүү хамарч байгаагаараа учир дутагдалтай юм. Гэтэл ФАТФ-ын стандартын дагуу “хөрөнгө” нь мөнгөн хөрөнгө төдийгүй үл хөдлөх хөрөнгө, алт болон үнэт металл зэргийг мөн хамрах ажээ.

206. *Шалгуур 20.2* – МУТСТ хуулийн 7.2-р зүйлийн дагуу СГТ дах гүйлгээний үнийн дүнд хязгаарлалт тавихгүй бөгөөд гүйлгээ хийх оролдлогыг мөн сэжигтэй гүйлгээгээр тайлагнах шаардлагатай.

### *Дүгнэлт*

207. МҮЭ нь хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол СГТ-аар мэдээлэх үүрэгтэй. Гэвч “гэмт хэрэг үйлдэж олсон орлоготой холбоотой” орлого гэдэгт зөвхөн мөнгөн хөрөнгийг ойлгох бага зэргийн дутагдал байна. **Монгол Улс Зөвлөмж 20-ийн дийлэнхийг биелүүлсэн байна.**

### *Зөвлөмж 21 – Мэдээллийг задруулах болон нууцлал*

208. 2007 оны ХҮТ-д Монгол Улс хуучин Зөвлөмж 14-ийг хэсэгчлэн биелүүлсэн гэсэн үнэлгээтэй байв. Сэжигтэй гүйлгээг тайлагнасан МҮЭ-ийн захирлууд, ажилтнууд эрүүгийн болон иргэний хариуцлагаас хамгаалагдсан эсэх нь тодорхойгүй байв.

209. *Шалгуур 21.1* – МУТСТ хуулийн 12.1-д зааснаар СМА-нд СГТ мэдүүлсэн МҮЭ-ийг банкны болон мэргэжлийн нууц задруулсан гэж үзэхгүй аж. МУТСТ хуулийн 12.2-т МҮЭ-ийн өгсөн мэдээлэл МУТС зорилгогүй байсныг тогтоосон нь тухайн мэдээлэл өгсөн этгээдийг хариуцлагад татах үндэслэл болохгүйг заажээ. МУТСТ хуулиар СГТ мэдүүлсэн МҮЭ-ийг банкны болон мэргэжлийн нууц задруулсан гэж үзэхгүйг бататгажээ. Гэсэн хэдий ч (i) МУТСТ тухай хуульд иргэний болон эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүйг шууд зааж өгөөгүй, (ii) МУТСТ хуулийн 12.1, 12.2 заалт нь МҮЭ-ийн тухайн захирал, ажилтанд хамаарахгүй байна.

210. *Шалгуур 21.2* – МУТСТ хуулийн 13.1-д МҮЭ болон СМА нь ХСБ-аас бусад этгээдэд харилцагчийн гүйлгээний талаарх мэдээлэл дамжуулахыг хориглохоор заажээ. СМА-нд банкнаас мэдээлэл ирүүлэх журмын 2.5, 5.9-т СМА-нд хүргүүлсэн СГТ, БМГТ, ГТТГТ болон бусад мэдээллийг задруулахыг банкны удирдлага болон ажилтнуудад хоригложээ. Мөн журмын 6.2-т СГ-ээг мэдээлэх үүрэгтэй банкны ажилтан болон тухайн тайлантай танилцсан ажилтнуудыг СГТ, БМГТ, ГТТГ тайланг бэлтгэсэн, СМА-нд мэдээлсэн, мэдээлэх гэж байгаа талаар задруулахыг хориглох аж. СМА-нд СГТ-г мэдээлэх гэж буйг задруулахыг МҮЭ-үүд болон тэдний захирлууд, ажилтнууд болон албан хаагчдад хориглодог бол банк бус МҮЭ-үүдийн захирлууд, ажилтнууд болон албан хаагчдад мөн адил хориглосон зүйл, заалт байхгүй аж.

### *Дүгнэлт*

211. Монгол Улсын Зөвлөмж 21-тэй холбоотой дунд зэргийн доголдлыг дурьдвал: (i) МУТСТ хуульд СГТ-г мэдүүлж буй этгээдийг иргэний болон эрүүгийн хариуцлагаас хамгаалахыг шууд заасан зүйл анги байхгүй, (ii) МУТСТ хуулийн 12.1, 12.2-р зүйл нь зөвхөн МҮЭ-ийн хувьд хүчинтэй, харин тэдгээрийн захирлууд, ажилтнууд болон албан хаагчдыг хамрахгүй байна, (iii) мэдээлэл задруулахгүй байх заалт нь зөвхөн МҮЭ болон тэдгээрийн захирлууд, ажилтнууд, албан хаагчдад хамааралтай болохоос биш банк бус МҮЭ-ийн захирлууд, ажилтнууд, албан хаагчдад хамаарахааргүй байна. **Монгол Улс Зөвлөмж 21-ийг хэсэгчлэн биелүүлсэн байна.**

### *Зөвлөмж 22- СББМҮҮ Харилцагчийг таньж мэдэх*

#### *Удиртгал*

212. Бүлэг 1-д дурьдсанчлан Монгол Улс СББМҮҮ-ийг бүрэн хамруулж чадахгүй байна. СББМҮҮ-эд үл хөдлөх хөрөнгийн зуучлагчид, үнэт метал, чулууны арилжаа эрхлэгчид, нягтлан бодогчид, хуульчид, нотариатчид, компаний үйлчилгээ үзүүлэгчид багтана. МУТСТ тогтолцоонд зөвхөн үл хөдлөх хөрөнгийн зуучлагчид болон нотариатчид хамрагдаж байна. Бүлэгт 1 болон Зөвлөмж 35-д авч үзсэнчлэн, МУТСТ хууль зөвхөн нотариатчдын хувьд үйлчилж харин үл хөдлөх эд хөрөнгийн зуучлагчдад хамаарахгүй байна.

213. Казино байгуулахыг хориглох тухай хуулийн<sup>79</sup> 1-д заасны дагуу казино Монгол Улсад хориотой.

214. Бүлэг 1-д дурьдсанчлан, үл хөдлөх хөрөнгийн бизнес хийдэг 3,475 хуулийн этгээд ОӨУБЕГ-т бүртгэлтэй ажээ. Тэдний дэлгэрэнгүй мэдээллийг бидэнд гаргаж өгөөгүй болно. МУТСТ хуулийн үйлчлэлд үл хөдлөх хөрөнгийн 8 зуучлагч хамруулжээ. Харин бусад компани яагаад хамрагдахгүй байгаа нь ойлгомжгүй байна. Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтаас Нягтлан бодох хуулийн дагуу 3,941 лицензийг олгожээ. Хуульчдын холбооноос Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу 5,507 зөвшөөрөл олгожээ. УУХҮЯ-наас Тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу үнэт металл, чулууны арилжаа эрхлэгч ААН-үүдэд олгосон зөвшөөрлийн тоо тодорхойгүй байна. Нотариатын үйлчилгээ үзүүлэгч 304 хуулийн этгээд байгаа бол хувиараа нотариат эрхэлж буй хүний тоо тодорхойгүй ажээ.

215. Бүлэг 1 болон Зөвлөмж 25-д дурьдсанчлан, Монгол Улсад экспресс трастыг үүсгэн байгуулах боломжгүй бөгөөд Монголд гадаадын траст ажиллаж буй баримт алга. Компанийн үйлчилгээний хувьд үүсгэн байгуулах зарим үйлчилгээг нотариатчид үзүүлдэг. Харин компанийн захирал, нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэх; бүртгэлтэй офис, хаягаар хангах; хувьцаа эзэмшигчийг төлөөлөх зэрэг үйлчилгээ үзүүлдэг хувь хүн, компани байхгүй аж.

216. 2007 оны харилцан үнэлгээгээр Монгол Улс ФАТФ-ын Зөвлөмж 12-ыг биелүүлээгүй байв. Итгэлцлийн үйлчилгээ үзүүлэгчдийг эс тооцвол Монгол Улсын МУТСТ тогтолцоонд СББМҮҮ-ид хамрагдахгүй байгааг тухайн үед дурьдсан байдаг.

217. *Шалгуур 22.1* - Зөвлөмж 10-ын ХТМ шаардлага зөвхөн нотариатчдын хувьд үйлчилж байгаа тул МУТСТ хуулийн хамрах хүрээг өргөжүүлэх шаардлагатайг дээр өгүүлсэн. СББМҮҮ-дийн үндсэн хууль тогтоомжид Зөвлөмж 10 тусгагдсаныг Монгол Улс нотлоогүй болно.

218. *Шалгуур 22.2* - Зөвлөмж 11-ийн мэдээлэл хадгалах шаардлага зөвхөн нотариатчдын хувьд үйлчилж байгаа тул МУТСТ хуулийн хамрах хүрээг өргөжүүлэх шаардлагатайг дээр өгүүлсэн. Нотариатын хуулийн дагуу нотариатчид мэдээллээ хадгалах үүрэгтэй ч хугацааг зааж өгөөгүй байна. СББМҮҮ-дийн үндсэн хууль тогтоомжид Зөвлөмж 11 тусгагдсаныг Монгол Улс нотлоогүй болно.

---

<sup>79</sup> 2017 оны УИХ-аар хэлэлцүүлэх хуулийн жагсаалтад казиног зөвшөөрсөн хуулийн төсөл байгаа ажээ.

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

219. *Шалгуур 22.3* - Зөвлөмж 12-ын УТНБЭ-тэй холбоотой шаардлага зөвхөн нотариатчдын хувьд үйлчилж байгаа тул МУТСТ хуулийн хамрах хүрээг өргөжүүлэх шаардлагатайг дээр өгүүлсэн. СББМҮҮ-дийн үндсэн хууль тогтоомжид Зөвлөмж 12 тусгагдсаныг Монгол Улс нотлоогүй болно.

220. *Шалгуур 22.4* - Зөвлөмж 15-ын шинэ технологитой холбоотой шаардлага зөвхөн нотариатчдын хувьд үйлчилж байгаа тул МУТСТ хуулийн хамрах хүрээг өргөжүүлэх шаардлагатайг дээр өгүүлсэн. СББМҮҮ-дийн үндсэн хууль тогтоомжид Зөвлөмж 15 тусгагдсаныг Монгол Улс нотлоогүй болно.

221. *Шалгуур 22.5* - Зөвлөмж 17-гийн гуравдагч этгээдэд тулгуурлахтай холбоотой шаардлага зөвхөн нотариатчдын хувьд үйлчилж байгаа тул МУТСТ хуулийн хамрах хүрээг өргөжүүлэх шаардлагатайг дээр өгүүлсэн. СББМҮҮ-дийн үндсэн хууль тогтоомжид Зөвлөмж 17 тусгагдсаныг Монгол Улс нотлоогүй болно.

### *Дүгнэлт*

222. МУТСТ шаардлага СББМҮҮ-дээс зөвхөн нотариатчдад хамаарах тул МУТСТ хууль явцуу хүрээнд үйлчилж байна. Зөвлөмж 12, 15, 17-той холбоотой цуврал дутагдал, доголдол оршиж байна. **Монгол Улс Зөвлөмж 22-ыг биелүүлээгүй байна.**

### *Зөвлөмж 23- СББМҮҮ Бусад арга хэмжээ*

223. 2007 оны харилцан үнэлгээгээр Монгол Улс ФАТФ-ын хуучин Зөвлөмж 16-г биелүүлээгүй гэсэн үнэлгээтэй байв. Тус тайланд МУТСТ тогтолцоонд СББМҮҮ-ид хамрагдахгүй байгааг дурьдаад тэд СГТ-г мэдээлэхгүй байна гэжээ.

224. *Шалгуур 23.1* - Зөвлөмж 20-ийн СГТ-г мэдээлэх шаардлага зөвхөн нотариатчдын хувьд үйлчилж байгаа тул МУТСТ хуулийн хамрах хүрээг өргөжүүлэх шаардлагатайг дээр өгүүлсэн. СББМҮҮ-дийн үндсэн хууль тогтоомжид Зөвлөмж 20 тусгагдсаныг Монгол Улс нотлоогүй болно.

225. *Шалгуур 23.2* - Зөвлөмж 18-ын дотоод хяналтын шаардлага зөвхөн нотариатчдын хувьд үйлчилж байгаа тул МУТСТ хуулийн хамрах хүрээг өргөжүүлэх шаардлагатайг дээр өгүүлсэн. СББМҮҮ-дийн үндсэн хууль тогтоомжид Зөвлөмж 18 тусгагдсаныг Монгол Улс нотлоогүй болно.

226. *Шалгуур 23.3* - Зөвлөмж 19-ийн өндөр эрсдэлтэй улс орнуудтай холбоотой шаардлага зөвхөн нотариатчдын хувьд үйлчилж байгаа тул МУТСТ хуулийн хамрах хүрээг өргөжүүлэх шаардлагатайг дээр өгүүлсэн. СББМҮҮ-дийн үндсэн хууль тогтоомжид Зөвлөмж 19 тусгагдсаныг Монгол Улс нотлоогүй болно.

227. *Шалгуур 23.4* - Зөвлөмж 21-ийн мэдээллийг нууцлах, задруулахгүй байх шаардлага зөвхөн нотариатчдын хувьд үйлчилж байгаа тул МУТСТ хуулийн хамрах хүрээг өргөжүүлэх шаардлагатайг дээр өгүүлсэн. СББМҮҮ-дийн үндсэн хууль тогтоомжид Зөвлөмж 21 тусгагдсаныг Монгол Улс нотлоогүй болно.

### *Дүгнэлт*

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

228. МУТСТ шаардлага СББМҮҮ-дээс зөвхөн нотариатчдад хамааралтай тул МУТСТ хууль явцуу хүрээнд үйлчилж байна. Зөвлөмж 18, 19, 20, 21-тэй холбоотой цуврал дутагдал, доголдол оршиж байна. **Монгол Улс Зөвлөмж 23-ыг биелүүлээгүй байна.**

### *Зөвлөмж 24- Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон тод байдал*

229. 2007 оны ХҮТ-д Монгол Улс Зөвлөмж 33-ыг “хэсэгчлэн биелүүлсэн” үнэлгээтэй байв. Компани эсхүл хуулийн этгээдийг удирдан чиглүүлж, хянаж буй хувь хүний мэдээлэл ил байдаггүйг тус тайланд дурджээ. Хувьцааны эцсийн өмчлөгчийг бүртгэх, тэдний мэдээллийг тухай бүр шинэчлэн ил болгох шаардлага компанид тавигддаггүй байв. Компаний дүрэм, үйл ажиллагааны өөрчлөлтийг тухай бүр мэдээлэхгүй бол хариуцлага хүлээлгэх тогтолцоо байхгүй байжээ.

230. *Шалгуур 24.1* – ИХ-ийн 33-р зүйлийн дагуу Монгол Улсад ашгийн төлөө нөхөрлөл, компани; ашгийн төлөө бус холбоо, сан болон хоршоо байгуулж болно. Хуулийн этгээдийн үндсэн шинж чанарыг мөн хуулийн 33-38-р зүйлд тодорхойлжээ.

231. ИХ-ийн 35-р зүйлд бүрэн хариуцлагатай хуулийн этгээд болох нөхөрлөлийн үндсэн шинжийг тодорхойлжээ.

232. Компанийн тухай хуулийн 3-5 дугаар зүйлд компаний хэлбэр болон үндсэн шинжийг тодорхойлжээ. Монгол Улсад хувьцаат (4-р зүйл) болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийг (5-р зүйл) үүсгэн байгуулж болно.

233. ИХ 36-р зүйлд холбоо, сан, хоршоог тодорхойлжээ. Зөвлөмж 8-д өгүүлсэнчлэн, эдгээр ашгийн бус байгууллагыг зорилтот хуулиар зохицуулна.

234. Тухайлсан хууль тогтоомжид хуулийн этгээдийн хэлбэр тус бүрийн үндсэн шинж тэмдэг, тэднийг үүсгэн байгуулах үйл явц болон дүрэмд тусгавал зохих мэдээллийг тодорхойлжээ.

235. Улсын бүртгэлийн тухай хуулийн 4.4-р зүйлийн дагуу хуулийн этгээд нь ОӨУБЕГ-т бүртгүүлсэн байх ёстой.

236. *Шалгуур 24.2* - Монгол Улс хуулийн этгээдийн МУТС эрсдэлийг хуулийн этгээдийн төрөл тус бүрээр үнэлээгүй болно (ҮЭҮ-нд мөн үнэлэгдээгүй).

237. *Шалгуур 24.3* - хуулийн этгээдээр бүртгэхийг Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 5.4-р зүйл болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 болон 11-р зүйлд тусгаж өгсөн нь *Шалгуур 24.3*-ыг хангаж байна. ОӨУБЕГ нь Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдийн мэдээллийг биет болон цахим хэлбэрээр хадгалах үүрэгтэй Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг юм. Эрх бүхий байгууллагууд ОӨУБЕГ-ын мэдээллийн санд шууд хандах эрхтэй бол иргэд хүсэлт гаргасны үндсэн дээр мэдээлэл авна.

238. *Шалгуур 24.4* – Тус шалгуурын шаардлагыг Компанийн тухай хуулийн 16-р зүйлд тусгажээ. Хуулийн этгээдийн мэдээллийн өөрчлөлтийг ОӨУБЕГ-т хүргүүлэхийг Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 5.4.7-д заасан байдаг бол Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд үүнийг ажлын 15 хоногийн дотор гүйцэтгэхээр тусгажээ. Тус шалгууртай холбоотой ч ОӨУБЕГ-т бүртгүүлэх шаардлагагүй бусад мэдээллийг

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

Компанийн тухай хуулийн 97-р зүйлийн дагуу компани нь төв байрандаа хувьцаа эзэмшигч болон эрх бүхий байгууллагын шаардлагаар танилцуулахад бэлэн хадгална.

239. *Шалгуур 24.5* - хуулийн этгээд шинээр бүртгүүлэх эсхүл хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт орвол ОӨУБЕГ-ын мэдээллийн санг шинэчилнэ. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 13.1-р зүйлд гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийг бүртгэх эсэхийг өргөдөл хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор шийдвэрлэнэ. Харин бусад хуулийн этгээдийн хувьд материал (мөн хуулийн 17.1-17.3-т заасан) хүлээн авснаас хойш ажлын 2 хоногийн дотор бүртгэнэ. Мэдээллийн үнэн зөвийг шалгах эсхүл баталгаажуулах механизм ОӨУБЕГ-т байхгүй байна.

240. *Шалгуур 24.6* – СБ болон зарим СББМҮҮ-ийн ХТМ үүрэг хариуцлагыг МУТСТ хуулийн 5.2.4-г тодорхойлжээ. УСЖ-ын 5-р зүйлд МҮЭ нь харилцагчийн тухай мэдээллийг олж авах ёстой гэжээ. Эрх бүхий байгууллага нь хүсэлт гарган ХТМ мэдээлэлтэй танилцах боломжтой. Компанийн үйлчилгээ эрхэлж буй хувь хүн, этгээдэд ХТМ үүрэг хамаардаггүй байна. Гэхдээ Компанийн тухай хуулийн 97-д компани хувьцаа эзэмшигчдийн талаар баримт бичиг хадгалахаар заасан нь дээрх доголдлыг арилгаж *Шалгуур 24.6(a)*-г хангаж байна. ТББ-ын тухай хуулийн 10-р зүйл, ХЗХ-ны хуулийн 6, 9-р зүйлд холбоо, сан, хоршоодод тавигдах шаардлагыг тус тус тогтоожээ.

241. *Шалгуур 24.7* – УСЖ-ын 5.5-р зүйлд МҮЭ нь үндсэн болон ЭӨ-ийн мэдээллийг бизнесийн харилцааны туршид цуглуулан хадгалах, 5.6-д тухайн мэдээллийг тодорхой хугацааны давтамжтайгаар нягталж шинэчлэх үүргийг тус тус тусгажээ. Компанийн тухай хуулийн 97-д компани хувьцаа эзэмшигчдийн талаар баримт бичиг хадгалахаар заасан нь СББМҮҮ-ийн ХТМ цар хүрээний доголдлыг арилгаж байна. ТББ-ын тухай хуулийн 10-р зүйл, ХЗХ-ны хуулийн 6, 9-р зүйлд холбоо, сан, хоршоодод тавигдах шаардлагыг тус тус тогтоожээ.

242. *Шалгуур-24.8* – ХСБ болон эрх бүхий байгууллагууд компанийн үндсэн хийгээд ЭӨ-ийн мэдээллийг ОӨУБЕГ-аар дамжуулан, аль эсвэл компаниас шууд гаргуулан авах эрхтэй. Түүнчлэн Компанийн тухай хуулийн 97-р зүйлд компанийн хадгалах мэдээллийг зааж өгсөн нь Шалгуур 24.8-ыг хангахаар байна.

243. *Шалгуур 24.9* - Компанийн тухай хуулийн 97.4-т компанийн дүрмээс бусад баримт бичгийг компани нь 5 жилийн хугацаагаар хадгалах бөгөөд энэ хугацаа дууссаны дараа тэдгээрийг архивт шилжүүлнэ гэжээ. МУТСТ хуулийн 8-р зүйлд МҮЭ харилцагчийн хийсэн гүйлгээ, данс болон харилцагчийн талаар олж авсан мэдээлэл, баримт бичгийг тухайн данс хаагдсан, эсхүл гүйлгээ хийгдсэнээс хойш 5-аас доошгүй жилийн хугацаанд хадгална гэжээ. Улсын төвлөрсөн бүртгэлийг хариуцаж буйн хувьд ОӨУБЕГ нь Улсын бүртгэлийн газар (ОӨУБЕГ-ын хуучин нэр) болон Архивын ерөнхий газрын дарга нарын хамтарсан 2014 оны 714/А-91 тоот тушаалын дагуу мэдээллийг тодорхой бус хугацаагаар хадгалах үүрэгтэй.

244. *Шалгуур 24.10* – ХСБ болон эрх бүхий байгууллагууд компанийн үндсэн хийгээд ЭӨ-ийн мэдээллийг ОӨУБЕГ-аар дамжуулан, аль эсвэл компаниас шууд гаргуулан авах эрхтэй. ХСБ-ууд ЭӨ-ийн мэдээллийг компаниас шууд, аль эсвэл МҮЭ-үүдээс гаргуулан авах боломжтой. Улсын Бүртгэлийн ерөнхий хуулийн 11.5.9-т улсын бүртгэгч нь шүүх, цагдаа, прокурор зэрэг эрх бүхий бусад байгууллагад зохих журмын дагуу лавлагаа өгөх,

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

улсын бүртгэлтэй холбоотой асуудлаар туслалцаа үзүүлэх, мэргэжлийн дүгнэлт гаргах үүрэгтэй гэжээ.

245. *Шалгуур 24.11* – Компанийн тухай хуулийн 3.7-р зүйлийн дагуу хувьцаат компаний хувьцаа нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдсэн байх ёстой бол мөн хуулийн 4.2-т хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан худалдахаас бусад хэлбэрээр шилжүүлсэн бол хувьцаа эзэмшигчийн бүртгэл хөтлөх этгээдэд бүртгүүлэх үүрэгтэй гэжээ. Энэ нь дэд шалгуур 24.11 (с) -г хангаж байна.

246. *Шалгуур 24.12* – Компаний зүгээс номинал хувьцаа (nominee shares) гаргах эсхүл номинал захирал (nominee director) томилох нь Монгол Улсад хориотой. Компаний хувьцаатай холбоотой эрхийг Үнэт цаасны тухай хуулийн 46-р зүйлд заасан үнэт цаасны кастодиан үйл ажиллагаагаар дамжуулан хэрэгжүүлнэ. Үүнийг зөвхөн арилжааны банк, түүний хараат болон охин компани эсхүл үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага гүйцэтгэнэ. Кастодианы үйл ажиллагааг Монголбанк, СЗХ-ны 85А/106 тоот хамтарсан тушаалаар баталсан Кастодианы тусгай зөвшөөрлийн журам болон кастодиан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөөр зохицуулна.

247. *Шалгуур 24.13* – Зөрчилд ногдуулах шийтгэл нь зөрчилтэй нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэхүйц биш байна. Улсын бүртгэлийн тухай хуулийн 21-р зүйлд хууль зөрчигчид хариуцлага хүлээлгэхээр заажээ. Гэсэн хэдий ч ОӨУБЕГ-т бүртгүүлэх, мэдээлэл шинэчлэх зөрчилд оногдуулах цорын ганц шийтгэл нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1-3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгуулийн шийтгэл ажээ (125-375 ам.доллар).

248. Компанийн тухай хуулийн 100.1.2-т мөн хуулийн 97.1-т заасан үүргээ зөрчсөн (баримт бичиг хадгалах) ААН-ид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20-30 дахин ( 2,500-3,750 ам. доллар), хувь хүнд цалингийн доод хэмжээг 5-10 (625-1,250 ам.доллар) дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгууль ногдуулна гэжээ.

249. *Шалгуур 24.14* – Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.1.7 болон 11 дүгээр зүйлд тус шалгуурыг тусгажээ.

250. *Шалгуур 24.15* - Гадаад улс орнуудаас авч буй үндсэн хийгээд ЭӨ-ийн мэдээллийн чанарыг шалгах механизм Монгол Улсад байхгүй аж.

### *Дүгнэлт*

229. Монгол Улс хуулийн бүх төрлийн этгээдийг бүртгэх төвлөрсөн тогтолцоотой. Гэхдээ ЭӨ-ийн мэдээллийг бүртгэж баталгаажуулахыг хатуу журамласан зүйл алга. МҮЭ-ийн ХТМ хүрээнд цуглуулсан компаний ЭӨ-ийн мэдээллийг ХСБ-ууд ашиглах боломжтой. Монгол Улс эрсдэлийн үнэлгээг хуулийн этгээдийн төрлөөр гүйцэтгээгүй бөгөөд Зөвлөмж 24-т хамаарах зөрчилд оногдуулах шийтгэл нь урьдчилан сэргийлэхүйц байж чадахгүй байна. Гадаад улс орнуудаас ирүүлж буй үндсэн хийгээд ЭӨ-ийн мэдээллийн чанарыг шалгах механизм Монгол Улсад байхгүй аж. **Монгол Улс Зөвлөмж 24-ийг “хэсэгчлэн биелүүлсэн” үнэлгээтэй байна.**

### *Зөвлөмж 25- Эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн ил тод байдал болон эцсийн өмчлөгч*

252. 2007 оны ХҮТ-д Монгол Улс хуучин Зөвлөмж 43-ыг “хэсэгчлэн биелүүлсэн” үнэлгээ авч байв. Монгол Улс дахь итгэлцлийн үйл ажиллагаа нь итгэмжлүүлэгч, итгэмжлэгдэгч болох ББСБ-ын хооронд байгуулсан "итгэлцлийн гэрээ" хэлбэртэй байгааг тус тайланд онцолжээ. Гэхдээ ЭӨ-ийн мэдээллийг гаргаж өгөх шаардлагыг ББСБ-уудад тавьдаггүй байжээ.

253. Бүлэгт 1-д дурьдсанчлан Монгол Улсад экспресс траст, түүнтэй адил төстэй бүтэц, чиг үүрэг бүхий гэрээ, механизм байгуулахыг хуулиар хориглосон байдаг. Монгол Улс ИХ-ийн 406-р зүйлийн дагуу итгэлцлийн трастыг “траст гэрээ” хэлбэрээр зохицуулдаг. 2008 онд баталсан Банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээний журам нь “траст гэрээ”-ний бүтэц, чиг үүргийг улам тодорхой болгожээ. Иймээс энэхүү механизм нь экспресс траст буюу түүнтэй адил төстэй бүтэц, чиг үүрэгтэй хуулийн механизм биш гэж бид дүгнэж байна.

254. *Дэд шалгуур 25.1 (a) – 25.1 (b)* - Монгол Улсад экспресс траст, түүнтэй адил төстэй бүтэц, чиг үүрэг бүхий гэрээ, механизм байгуулахыг хуулиар хориглосон байдаг.

255. *Шалгуур үзүүлэлт 25.1 (c)* – МУТСТ хууль болон УСЖ-ын дагуу нотариатч нь мэргэжлийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах бол Зөвлөмж 10-ын дагуу ХТМ-үйл ажиллагаа явуулж УСЖ-ын 5.1, 5.4-ийн дагуу өмч эзэмшдэг, хяналт тавьдаг эсхүл өмчтэй холбоотой ашиг сонирхолтой (итгэмжлүүлэгч), өмч захиран зарцуулдаг (итгэмжлэгдэгч) болон өмчийн үр ашгийг хүртдэг (эцсийн өмчлөгч) хүмүүсийг тодорхойлж шалгана. Нотариатч нь харилцагчийн өмчтэй холбоотой ашиг сонирхлыг "тодорхойлж баталгаажуулах" буюу өмчийг эзэмшиж, хянаж эсвэл ашиг хүртэж буй хуулийн этгээдийн өмчтэй холбоотой ашиг сонирхлыг "тодорхойлж баталгаажуулах" шаардлагатай. Өмчлөлийн шаталсан бүтэцтэй тохиолдолд МҮЭ нь ЭӨ буюу хяналт тавьж буй этгээдийг баталгаажуулах хүртэл өмчлөлийн шат болгоныг шалгаж магадлна. МУТСТ хуулийн 8-р зүйлийн дагуу нотариатч нь энэхүү мэдээллийг 5-аас доошгүй жилийн хугацаанд хадгална.

256. СББМҮҮ-ийн үндсэн хууль тогтоомжид СББМҮҮ-ид нь итгэмжлүүлэгч, итгэмжлэгдэгч, үр ашиг хүртэгчид эсхүл хяналт хэрэгжүүлж буй аливаа этгээдийн мэдээллийг цуглуулж 5-аас доошгүй жил хадгалах тухай тусгагдсаныг Монгол Улс нотлоогүй болно.

257. *Шалгуур 25.2* – УСЖ-ын дагуу нотариат нь мэргэжлийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах тохиолдолд дараах арга хэмжээ хэрэгжүүлнэ: (i) бизнесийн харилцаа болон гүйлгээг байнгын хяналтад байлгаж харилцагчийн хувийн хэрэг болон харилцагчийн талаарх холбогдох мэдээлэлд тулгуурлан харилцагчийн гүйлгээг нягтална (УСЖ-ын 3.1.4); (ii) ХТМ хүрээнд цуглуулсан баримт бичиг, мэдээлэлд орсон өөрчлөлтийг тодорхой хугацааны давтамжтайгаар нягталж шинэчилнэ (УСЖ-ын 5.6).

258. Бусад СББМҮҮ-дийг зохицуулж буй хууль тогтоомжид мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хангах, тогтмол шинэчлэх заалт тусгагдсаныг Монгол Улс нотлоогүй болно.

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

259. *Шалгуур 25.3* - Бизнесийн харилцаа холбоо үүсгэх эсхүл босго дүнгээс хэтэрсэн гүйлгээ хийх үед итгэмжлэгдсэн төлөөлөгч нь СБ буюу СББМҮҮ-ид статусаа мэдэгдэх албагүй ажээ.

260. *Шалгуур 25.4* – Гадаадын трастын итгэмжлэгдсэн төлөөлөгч нь трасттай холбоотой мэдээллийг эрх бүхий байгууллагад гаргаж өгөх эсвэл ЭӨ, трастын хөрөнгийн мэдээллээр СБ болон СББМҮҮ-дийг хангахыг (ХТМ хүрээнд) хориглосон зүйл байхгүй аж.

261. *Шалгуур 25.5* – ЭБШХ-ийн дагуу ХСБ-ууд МҮЭ-ээс ХТМ мэдээллийг тухай бүр гаргуулж авах эрхтэй. Энэ нь МҮЭ-ийн харилцагч итгэмжлэгдэгч эсхүл тохиолдлын гүйлгээ хийх итгэмжлэгдэгчийн (мэргэжлийн эсхүл мэргэжлийн бус) аль алинд хамаарна. СББМҮҮ-ийг хамрах хүрээ асуудалтай байгаагийн дээр МУТСТ хууль үл хөдлөх эд хөрөнгийн зуучлагчдад хамаарахгүй байна. Иймээс МУТСТ шаардлагыг биелүүлэх үүрэг СББМҮҮ-дээс зөвхөн нотариатчдад оногдох ажээ.

262. *Шалгуур 25.6* - Монгол Улс СБ-ын ХТМ хүрээнд олж авсан мэдээллийг олон улсын түвшинд хуваалцах боломжтой. Үүнийг Монгол Улс ЭЗХТ-ны гэрээ, байгууллага хоорондын болон гадаадын эрх бүхий байгууллагатай байгуулсан харилцан ойлголцлын санамж бичиг (ХОСБ)-ийн хүрээнд хэрэгжүүлэх боломжтойг Зөвлөмж 40-д өгүүлсэн билээ.

263. *Шалгуур 25.7* - Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй гадаадын итгэмжлэгдэгчид статусаа мэдүүлээгүйн төлөө хүлээлгэх хуулийн хариуцлага байхгүй аж.

264. *Шалгуур 25.8* – Зөвлөмж 35-д дурьдсанчлан, эрүүгийн ял шийтгэлийг зөвхөн ЭХ-д заажээ. ЭХ-д МУТСТ хуулийн буюу УСЖ-ийн зөрчлийг гэмт хэрэгт тооцсон зүйл байхгүй аж. Мэргэжлийн итгэмжлэгдэгчийн үүрэг гүйцэтгэж буй нотариатын МУТСТ хууль буюу УСЖ-ын зөрчилд Нотариатын тухай хуулиар (12-р бүлэг) хүлээлгэх хариуцлага нь гаргасан зөрчилд нь тохирсон, дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэхүйц биш ажээ.

### *Дүгнэлт*

252. Монгол Улсад экспресс траст, түүнтэй адил төстэй бүтэц, чиг үүрэг бүхий гэрээ, механизм байгуулахыг хуулиар хориглосон байдаг. Иймээс Зөвлөмж 25 сонгодог утгаараа Монгол улсад хамаарахгүй юм. Гэхдээ итгэлцлийн хууль зөвшөөрөгдсөн эсэхээс үл хамааран бүх улс оронд тавигдах шаардлага Зөвлөмж 25-д байдаг. СББМҮҮ-ийг бүрэн хамарч чадахгүй байна. Мэргэжлийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллаж буй нотариатчид л МУТСТ хууль болон УСЖ-ын ХТМ, мэдээлэл хадгалах шаардлагыг биелүүлэх үүрэгтэй аж. Гэтэл энэхүү үүргийн зөрчилд хүлээлгэх хариуцлага нь зөрчилд нь дүйцэхүйц, урьдчилан сэргийлэхүйц байж чадахгүй байна. Бизнесийн харилцаа холбоо үүсгэх эсхүл босго дүнгээс хэтэрсэн гүйлгээ хийх үед гадаадын итгэмжлэгдсэн төлөөлөгч нь СБ буюу СББМҮҮ-ид статусаа тайлагнах албагүй ажээ. **Монгол Улс Зөвлөмж 25-ыг “хэсэгчлэн биелүүлсэн” үнэлгээтэй байна.**

### *Зөвлөмж 26- Санхүүгийн байгууллагуудын зохицуулалт, хяналт шалгалт*

266. 2007 оны ХҮТ-д Монгол Улс хуучин Зөвлөмж 23-ыг “хэсэгчлэн биелүүлсэн” үнэлгээтэй байжээ. МУТСТ хяналт шалгалтад ББСБ-ууд хамрагдахгүй байгааг тус тайланд дурдаж СЗХ-нд хяналт шалгалт хэрэгжүүлэх нөөц боломж байхгүй байгааг дурджээ. Халхавч банкны асуудлыг хуучин Зөвлөмж 18, харин одоо Зөвлөмж 26-д авч үздэг болсон билээ. 2012 оны явцын тайланд Монгол Улс хуучин Зөвлөмж 23-ын дийлэнхийг биелүүлсэн үнэлгээ авахуйц дэвшил гаргасныг тэмдэглэжээ.

267. *Шалгуур 26.1* - МУТСТ хуулийн 19.1-ийн дагуу Монголбанк банкуудын МУТСТ хяналт шалгалтыг, харин СЗХ, СМА нь бусад СБ-уудын, тухайлбал ББСБ, даатгалын компаниуд, хөрөнгө оруулалтын сангууд, үнэт цаасны компаниуд, ХЗХ-ын МУТСТ хяналт шалгалтыг хариуцна.

268. *Шалгуур 26.2* - Банкны тухай хуулийн 6-р зүйлийн дагуу банкууд, тэдгээрийн охин болон харьяа компаниуд Монголбанк эсхүл СЗХ-оос зөвшөөрөл авна. Мөн хуулийн 18.2-т заасны дагуу банкууд болон тэдгээрийн салбарууд үүсгэн байгуулах зөвшөөрлийг Монголбанкнаас авна. Бусад СБ-ууд, тухайлбал үнэт цаас, даатгалын компаниуд, даатгалын зуучлагчид, брокерууд болон үнэлгээ гүйцэтгэгчид СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хуулийн 22.1-д заасны дагуу СЗХ-ноос тусгай зөвшөөрөл авна. Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд хамаарах мөнгө болон үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ үзүүлэгчид, валютын арилжаа эрхлэгчид ББСБ-ын үйл ажиллагааны тухай хуулийн 6.1-р зүйлийн дагуу СЗХ-оос тусгай зөвшөөрөл авна.

269. Монгол Улсад халхавч банк үүсгэн байгуулахыг шууд хориглосон зүйл байхгүй аж. Гэхдээ банкны лицензтэй холбоотой шаардлагыг Банкны тухай хууль болон Монгол улсын арилжааны банкны тусгай зөвшөөрлийн тухай журамд хангалттай тусгагдсан тул банк доторхи үйл явц, удирдлагыг зохистой байлгах боломжтой аж.

270. *Шалгуур 26.3* - Банкны тухай хуулийн 32.1.2-ын дагуу банкны ТУЗ-ийн гишүүд төрийн эсрэг болон эдийн засгийн гэмт хэргийн ял шийтгэлгүй байх ёстой. Түүнчлэн Банкны тусгай зөвшөөрлийн тухай журмын 2.2.5 болон 2.2.7-р зүйлийн дагуу банкны үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн гишүүд, Аудитын хорооны дарга, гүйцэтгэх захирлууд гэмт хэрэг үйлдэж байгаагүйг ЦЕГ-аас нотлох шаардлагатай. Харин гэмт хэрэгтнүүдийн хамсаатнууд банкны үлэмж буюу хяналтын багцыг эзэмшихээс (эсхүл ЭӨ байх) урьдчилан сэргийлэх хууль, журам байгааг Монгол Улс нотлоогүй болно.

271. ББСБ-ын үйл ажиллагааны тухай хуулийн 13.5.2-т заасны дагуу ББСБ-ын ТУЗ-ийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал нар ял шийтгэлгүй байх ёстой. Дээрхтэй адил гэмт хэрэгтнүүдийн хамсаатнууд ББСБ-ын үлэмж буюу хяналтын багцыг эзэмшихээс (эсхүл ЭӨ байх) урьдчилан сэргийлэх хууль, журам байгааг Монгол Улс нотлоогүй болно.

272. Үнэт цаасны зах зээлийн бүртгэлийн тухай журмын 3.1.5-д заасны дагуу хувьцаа эзэмшигчид (бүртгэлтэй компанийн хувьд хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшигч), ТУЗ-ийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, дотоод хяналтын болон бусад ажилтнууд ял шийтгэлгүй байна. Дээрхтэй адил гэмт хэрэгтнүүдийн хамсаатнууд СБ-ын хяналтын

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

багцыг эзэмших буюу ЭӨ байхаас урьдчилан сэргийлэх хууль, журам байгааг Монгол Улс нотлоогүй болно.

273. Даатгалын тухай (20-р зүйл) болон Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн (14-р зүйл) дагуу үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохоос өмнө үүсгэн байгуулагчийг нягтлан шалгана. Харин энэхүү шалгалтад гэмт хэргийн магадалгаа багтаж буй эсэх тодорхойгүй байна.

274. ХЗХ-ны тухай хуулийн 34.3 болон 39.6-р зүйлд заасны дагуу ТУЗ-ийн болон гүйцэтгэх захирлууд ял шийтгэлгүй, хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэлгүй, ашиг сонирхлын зөрчилгүй, дампуурсан хуулийн этгээдийг удирдаж байгаагүй байх ёстой. Гэхдээ гэмт хэрэгтнүүдийн хамсаатнууд СБ-ын хяналтын багцыг эзэмших буюу ЭӨ байхаас урьдчилан сэргийлэх тогтолцоо байхгүй аж.

275. *Шалгуур 26.4-* Монгол Улсын хууль тогтоомжид Үндсэн Зарчмуудыг дагаж мөрдөхийг шууд тусгасан зүйл алга. Гэхдээ тэдгээртэй холбоотой зарим зүйл анги МУТСТ хууль, УСЖ-д байгааг тэмдэглэх нь зүйтэй. Тухайлбал, үүнд МУТСТ хуулийн 14-т тусгагдсан дотоод хяналт, 5-р зүйлд тусгагдсан ХТМ үйл ажиллагааг дурдаж болно. Даатгалын болон үнэт цаасны компаниуд эрсдэлд суурилсан хяналт шалгалтад хамрагддаггүй ажээ. Харин бусад СБ-ыг (тухайлбал, мөнгө болон үнэ бүхий зүйл шилжүүлэгчид, валют арилжаалагчид) МУТСТ хуулийн дагуу зохицуулна. Гэхдээ хяналт шалгалт нь МУТС эрсдэлд суурилдаггүй аж. Монгол Улс МУТСТ нэгтгэсэн бүлгийн хяналт шалгалт хэрэгжүүлдэг эсэх нь тодорхойгүй байна.

276. *Шалгуур 26.5-* Банкны газар дээрх хяналт шалгалтын хугацаа, давтамж, хамрах хүрээ болон үнэлгээний үзүүлэлтүүдийг тодорхойлохдоо зайнаас хэрэгжүүлэх хяналт шалгалтаар илэрсэн эрсдэлд тулгуурладаг байна (Банкны МУТСТ үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалт хийх журмын 1.2-р зүйл, Банкны МУТСТ үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих журмын 1.2.2-р зүйл). Зайнаас хийх хяналт шалгалтаар банкны бүтэц, бүтээгдэхүүн болон үйлчилгээ, хүргэх арга хэрэгсэл, мэдээллийн үйл ажиллагаа (тухайлбал, банкны МУТСТ Эрсдэлийн Үнэлгээний Матрицын үйл ажиллагаа, Мониторинг болон Комплаенсийн Асуулга болон тэдгээртэй холбоотой баримт бичиг) зэргийг шалгана (Банкны зайнаас хяналт шалгалт хийх журмын 2.1-р заалт).

277. Бусад СБ-ад МУТСТ хяналт шалгалт хийхдээ тухайн байгууллагын МУТС эрсдэл, бодлого, дотоод хяналт болон үйл ажиллагаа; улс орны МУТС эрсдэл; болон тухайн СБ-ын онцлог нөхцөл байдлыг харгалзан үздэггүй ажээ.

278. *Шалгуур 26.6 -* СБ-ын удирдлага, үйл ажиллагаанд томоохон өөрчлөлт гарахад МУТС эрсдэлийн үнэлгээг зайлшгүй гүйцэтгэх заалт байхгүй аж. Банкуудад газар дээрх хяналт шалгалт хийх журмын дагуу хянан шалгагч нь банкны эрсдэлийн үнэлгээг гүйцэтгэж тусгай зөвшөөрөл, өөрийн хөрөнгө, удирдлага болон банкны хувьцаа эзэмшигч нартай холбоотой өөрчлөлтийг нягтлах шаардлагатай. Банкинд зайнаас хийх хяналт шалгалтыг тогтмол хэрэгжүүлэх ба ингэхдээ банкнаас 6 сар тутам нөхөж ирүүлэх “Өгөгдөл, тоо баримтын нэгтгэл” болон “МУТСТ асуулга”-ыг үндэслэнэ. Банкууд эрсдэлийн матрицыг ашиглан МУТС эрсдэлийн үнэлгээг шинэчлэх үүрэгтэй ч үүнийг гүйцэтгэж буй давтамж тодорхой бус байна. Банкаас бусад санхүүгийн байгууллагуудад ийм төрлийн шаардлага тавигддаггүй аж.

### *Дүгнэлт*

279. Монгол Улсын Зөвлөмж 26-ийн хэрэгжилтэд дунд зэргийн доголдол оршиж байна. Монгол Улсад гэмт хэрэгтнүүд, тэдний хамсаатнууд СБ-ын удирдлагад багтах, СБ-ын үлэмж буюу хяналтын багцыг эзэмших (эсвэл ЭӨ байх)-ээс урьдчилан сэргийлэх тогтолцоо төгөлдөржөөгүй байна. Мөн Үндсэн Зарчмуудыг хуульчилсан зүйл анги алга. Үүнээс гадна хяналт шалгалтын давтамж, цар хүрээг тодорхойлохдоо Монгол Улсын МУТС эрсдэлийг харгалзан үзэхгүй байна. ЭСА-д үндэслэн харилцан адилгүй хяналт шалгалтыг СБ-уудад хэрэгжүүлж буй зүйл алга. Үүгээр зогсохгүй, СБ-ын удирдлага болон үйл ажиллагаанд томоохон өөрчлөлт, хөдөлгөөн гарах үед МУТС эрсдэлийн үнэлгээг зайлшгүй гүйцэтгэх заалт байхгүй аж. **Монгол Улс Зөвлөмж 26-г “хэсэгчлэн биелүүлсэн” үнэлгээтэй байна.**

### *Зөвлөмж 27-Хянан шалгагчдын эрх мэдэл*

280. 2007 оны ХҮТ-д Монгол Улс хуучин Зөвлөмж 29-ийн “дийлэнхийг биелүүлсэн” үнэлгээтэй байв. Монголбанк, СМА болон СЗХ нь хяналт шалгалт хэрэгжүүлэх хангалттай эрх мэдэлтэй ч СЗХ тус эрхээ үр дүнтэй хэрэгжүүлэхгүй байгааг тус тайланд дурджээ.

281. *Шалгуур 27.1* - Төв банкны тухай хуулийн 24, 25-р зүйл, СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хуулийн 24, 25-р зүйл болон МУТСТ хуулийн 19-р зүйлд заасныг дагуу Монголбанк, СЗХ, СМА нь СБ-аас уудад хяналт шалгалт хийх, МУТСТ хууль тогтоомжийн биелэлтийг шаардах эрхтэй.

282. *Шалгуур 27.2* - Төв банкны тухай хуулийн 24, 25-р зүйлийн дагуу Монголбанкны хянан шалгагчид газар дээрх болон зайнаас хийх хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ. Үүний хүрээнд МУТСТ хуулийн 19.1-р зүйл, газар дээрх болон зайнаас хийх хяналт шалгалтын журмуудын дагуу МУТСТ хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ. СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хуулийн 24, 25-р зүйлийн дагуу СЗХ нь холбогдох байгууллагуудын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, үүний дотор МУТСТ хуулийн 19.1-д заасан МУТСТ хяналт шалгалтыг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй. МУТСТ хуулийн 16.7-д заасны дагуу СМА-ны дарга нь улсын ахлах байцаагчийн, харин СМА-ны хянан шалгагч, шинжээчид улсын байцаагчийн эрхтэй байдаг. Мөн хуулийн 19.1-ийн дагуу СМА нь СЗХ-той хамтран ББСБ, ХЗХ, хөрөнгө оруулалтын сан, үнэт цаасны арилжаа эрхлэгчид, даатгалын байгууллагуудыг шалгах эрхтэй. Зөрчил эсхүл гэмт хэргийн сэжиг илэрсэн тохиолдолд эрх бүхий байгууллагууд гэнэтийн шалгалт хийх боломжтойг Монгол Улс нотолж байна.

283. *Шалгуур 27.3*- Төв банкны тухай хуулийн 25-р зүйлийн дагуу Төв банкны хянан шалгагч нь банкны данс бүртгэл, тайлан, тэнцэл, санхүүгийн баримтад хяналт шалгалт хийх, тайлбар, лавлагаа гаргуулж авах, асуулт тавьж, хариулт авах; шаардлагатай магадалгаа, баримтын хуулбарыг уг банкны харилцагч иргэн, хуулийн этгээд, банк, санхүүгийн болон бусад байгууллагаас үнэ төлбөргүй гаргуулан авах эрхтэй. МУТСТ зайнаас болон газар дээрх хяналт шалгалт гүйцэтгэх журмын дагуу хянан шалгагч нь төрөл бүрийн мэдээлэл гаргуулан авах, цуглуулах эрхтэй аж.

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

284. СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хуулийн 25-р зүйлийн дагуу СЗХ нь шалгалтад шаардлагатай мэдээ, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах эрхтэй. Мөн хуулийн 27-р зүйлд СЗХ нь тодорхой төрлийн буюу тусгайлан заасан мэдээлэл, санхүүгийн болон бусад баримт бичиг гаргаж өгөхийг бичгээр шаардаж болно; тусгай зөвшөөрөл эзэмшигч нь компанийн аливаа хэлбэрийн нэгдлийн гишүүн бол СЗХ тухайн нэгдэлд багтах аль ч этгээдийн, эсхүл уг нэгдлийн санхүүгийн тайланг шаардаж болно гэжээ. Хянан шалгагч нар шүүхийн шийдвэр гаргуулахгүй мэдээ, материал гаргуулан авах боломжтой.

285. *Шалгуур 27.4* – Төв банкны тухай хуулийн 25-р зүйлд банк, түүний үйл ажиллагаатай холбогдсон хууль тогтоомжийг (тухайлбал, МУТСТ хууль) зөрчсөн гэм буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу захиргааны хариуцлага хүлээлгэнэ гэжээ. Зөвлөмж 35-д тодорхойлсончлон, МУТСТ шаардлагыг зөрчсөн тохиолдолд захиргааны болон санхүүгийн хариуцлагыг (тухайлбал банкны үйл ажиллагааг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хязгаарлах, зогсоох, түдгэлзүүлэх, банкны лицензийг хүчингүй болгох) хүлээлгэх боломжтой. Үүнээс гадна банкны шийдвэр банкны хууль тогтоомж, Монголбанкны шийдвэртэй харшилж байвал Төв банкны тухай хуулийн 28-р зүйлийн дагуу Монголбанкны Ерөнхийлөгч түүнийг хүчингүй болгох эрхтэй. СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3-р зүйлийн дагуу СЗХ нь санхүүгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох эрхтэй. Мөн хуулийн 25-р зүйлийн дагуу СЗХ нь шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах талаар хугацаатай үүрэг өгч, биелэлтийг хангуулах; зөрчлийг арилгах хүртэл тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоох; хууль тогтоомжийн дагуу захиргааны шийтгэл ногдуулах; тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжийг ноцтой буюу удаа дараа зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох талаар Хороонд санал оруулах эрхтэй аж. Гэсэн хэдий ч СБ-уудад хүлээлгэсэн захиргааны хариуцлага одоогоор байхгүй бөгөөд МУТСТ зөрчилд хүлээлгэх хариуцлагыг хууль тогтоомжид тодорхой тусгаагүй ажээ. МУТСТ хуулийн 18.2-р зүйлд СМА-ны хянан шалгагч МУТСТ тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгаж, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, эсхүл эрх бүхий ХСБ-ад шилжүүлж шалгуулах буюу тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгуулах талаар санал боловсруулж эрх бүхий этгээдээр шийдвэрлүүлэх эрхтэй гэжээ. Улсын байцаагчийн тухай хуулийн дагуу СМА-ны хянан шалгагч нар МҮЭ-д хариуцлага хүлээлгэх эрхтэй гэж байгаа боловч биднийг Монголд ажиллах үеэр тус хууль хүчин төгөлдөр болоогүй байв.

### *Дүгнэлт*

286. Монголбанк, СЗХ болон СМА нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд СБ-уудад МУТСТ хяналт шалгалт хэрэгжүүлнэ. СБ-уудад хүлээлгэх хариуцлагыг тодорхой томъёолоогүй, хүлээлгээгүйгээс үүдэн бага зэргийн доголдол оршиж байна. **Монгол Улс Зөвлөмж 27-гийн “дийлэнхийг биелүүлсэн” үнэлгээ авч байна.**

### *Зөвлөмж 28 – СББМҮҮ-ийн зохицуулалт, хяналт шалгалт*

288. Монгол Улс 2007 оны ХҮТ-д хуучин Зөвлөмж 24-ийг “биелүүлээгүй” гэсэн үнэлгээтэй байв. МУТСТ хяналтаас СББМҮҮ-ид мултран үлдсэн тул СМА-ны СББМҮҮ-дийг хянаж чадахгүй байгааг тус тайланд дурджээ.

289. *Шалгуур 28.1* - Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай хуулийн 1-д зааснаар Монгол Улсын нутаг дэвсгэрт казино байгуулах, ажиллуулахыг хориглоно.

290. *Шалгуур 28.2* - СББМҮҮ-дээс зөвхөн нотариатчид МУТСТ хуулийг биелүүлэх үүрэгтэйг Зөвлөмж 22 болон 23-д дурьдсан. МУТСТ хуулийн 19.1-ийн дагуу үл хөдлөх хөрөнгийн зуучлагчдыг СЗХ болон СМА хянах үүрэгтэй. Нотариатчид МУТСТ хуулийн үйлчлэлд хамрагдаж буй ч тэднийг шалгах субъект тодорхойгүй ажээ.

291. *Шалгуур 28.3* - Бусад СББМҮҮ-дийн МУТСТ хэрэгжилтийг хэрхэн хянаж буйг Монгол Улс танилцуулаагүй болно.

292. *Шалгуур 28.4* - МУТСТ хуулийн 18.2 болон 18.3-р зүйлийн дагуу СМА нь үл хөдлөх хөрөнгийн зуучлагч болон нотариатуудын МУТСТ тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах, тэд хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих эрхтэй.

293. Гэмт хэрэгтнүүдэд мэргэжлийн зөвшөөрөл олгож үл болохыг Нотариатын тухай хуулийн 15-р зүйл болон Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 19-р зүйлд тусгаагүй ажээ.

294. Зөвлөмж 35-д дурьдсанчлан, гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэхүйц шийтгэлийн арга хэмжээ Нотариатын тухай хууль (44-р зүйл)-д байхгүйн дээр МУТСТ хууль болон УСЖ-ын зөрчилд СМА хариуцлага хүлээлгэж чадах эсэх нь тодорхойгүй байна. ТТ хууль болон СЗХАХ журмын хөрөнгө царцаах заалт хэрэгжих боломжгүй гэж бид үзэж байна. Үл хөдлөх хөрөнгө зуучлагчдаар МУТСТ хууль болон УСЖ-ыг мөрдүүлэх боломжгүй байгаа нь тэдэнд хүлээлгэх хариуцлага байхгүйтэй холбоотой.

295. *Шалгуур 28.5* – СББМҮҮ-ид МУТСТ хууль, УСЖ, ТТ хууль, ТЭЖО журмыг мөрдөж хэрэгжүүлэхгүй байна. СББМҮҮ-дийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьсан зүйл байхгүй ажээ.

### *Дүгнэлт*

296. СББМҮҮ-ид МУТСТ хууль тогтоомжийн хэрэгжилт, хяналтын гадуур сугарч үлдсэн ноцтой доголдол оршиж байна. Үл хөдлөх хөрөнгийн зуучлагч бус СББМҮҮ-дийг зохицуулж буй субъект байхгүй ажээ. СББМҮҮ-ид МУТСТ хяналт шалгалтад хамрагдахгүй байна. **Монгол Улс Зөвлөмж 28-ыг “биелүүлээгүй” үнэлгээ авч байна.**

### *Зөвлөмж 29- Санхүүгийн мэдээллийн алба*

297. 2007 оны ХҮТ-д Монгол Улс хуучин Зөвлөмж 26-г “биелүүлээгүй” үнэлгээтэй байв. СМА нь СГТ хүлээн авч эхлээгүй, мөрдөн шалгах байгууллагуудад мэдээлэл шилжүүлэх эрх мэдэл нь тодорхойгүй, сэжигтэй гүйлгээг хэрхэн тодорхойлж СМА-нд

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

хүргүүлэх талаар МҮЭ-үүдэд чиглэл өгөхгүй байгааг тус тайланд тэмдэглэжээ. Харин 2011 оны явцын тайланд Монгол Улс хуучин Зөвлөмж 26-гийн “дийлэнхийг биелүүлсэн” үнэлгээ авчээ.

298. *Шалгуур 29.1* - Монгол Улс МУТСТ хуулийн дагуу 2006 оны 11-р сарын 29-нд СМА-ыг байгуулжээ. 2013 онд тус хуульд нэмэлт өөрчлөлт орж Монголбанкны дэргэдэх СМА-ны үйл ажиллагааг 16-р зүйлд тусгажээ. Мөн хуульд СМА-ны бүрэн эрх, үйл ажиллагааг тодорхойлж СГТ, БМГТ болон бусад тайлан мэдээг хүлээн авч дүн шинжилгээ хийх, МУТС сэжиглэх үндэслэлтэй байвал ХСБ байгууллагад шилжүүлэхийг заажээ.

299. *Шалгуур 29.2* - СМА нь МУТСТ хуулийн дагуу СГТ, БМГТ болон бусад тайлан мэдээ хүлээн авах эрхтэй. МУТСТ хуулийн 7.2-т хөрөнгө, гүйлгээ хийх оролдлогыг МУТС, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол МҮЭ нь энэ тухай 24 цагийн дотор СМА-нд мэдээлэхээр заажээ. Мөн хуулийн 7.1-д МҮЭ 20 сая ₮ (9,700 ам.доллар), түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын 5 өдрийн дотор СМА-нд мэдээлнэ гэжээ. Үүнээс гадна МУТСТ хуулийн 15.2-ын дагуу бэлэн мөнгөний мэдүүлгийг ГЕГ нэгтгэж сар бүр СМА-нд хүргүүлнэ. СМА-наас банкуудад зориулан “СМА-нд банкнаас мэдээлэл ирүүлэх журам”-ыг батлуулжээ.

300. *Дэд шалгуур 29.3 (a)* - СМА-нд банкнаас мэдээлэл ирүүлэх журмын 4-т СМА нь СГТ-тай холбоотой нэмэлт мэдээлэл банкнаас гаргуулан авна гэжээ. Энэхүү журам нь зөвхөн банкуудад хамаарна. СМА нь банк бус МҮЭ-ээс нэмэлт мэдээлэл гаргуулах тухай МУТСТ тухай хуульд байхгүй аж.

301. *Дэд шалгуур 29.3 (b)* - МУТСТ хуулийн 18.5-д СМА хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор иргэний, хуулийн этгээдийн болон эд хөрөнгийн бүртгэл, нийгмийн даатгалын бүртгэл, хилээр нэвтэрсэн тухай бүртгэл, хөрөнгө оруулалтын бүртгэл, банк хоорондын гүйлгээний бүртгэлийн лавлагааг холбогдох байгууллагаас гаргуулж авах эрхтэй гэжээ. Сэжигтэй гүйлгээний дүн шинжилгээ хийх зааврын хүрээнд СМА нь мэдээллийг нээлттэй эх сурвалжаас эсвэл ХОСБ, хууль эрх зүйн актууд, мэдээлэл солилцох бусад гэрээ хэлэлцээрийн хүрээнд эрх бүхий болон төрийн бус байгууллагаас мэдээлэл цуглуулна. СМА нь ХОСБ-ийн хүрээнд ЦЕГ, ТЕГ, АТГ, ГЕГ, УПЕГ-тай хамтран ажиллаж байна.

302. *Шалгуур 29.4* – МУТСТ хуулийн 18.1.1 болон 18.1.2-ын дагуу СМА нь МҮЭ-ээс ирүүлсэн мэдээллийг хүлээн авах, цуглуулах, түүнд дүн шинжилгээ хийх; МУТС үндэслэлтэй гүйлгээ байна гэж үзсэн тохиолдолд тухайн мэдээллийг ХСБ-д шилжүүлэх, шилжүүлсэн сэжигтэй бэлэн ба бэлэн бус мөнгөний гүйлгээний талаар мэдээллийн сан бүрдүүлэх үүрэгтэй ажээ. Хуульд СМА-ны зүгээс үйл ажиллагааны болон стратегийн дүн шинжилгээ хийхийг заагаагүй ажээ. Тайлант хугацаанд СМА нь үйл ажиллагааны шинжилгээ гүйцэтгэж шилжүүлж байсан болохоос биш стратегийн дүн шинжилгээ огт хийж үзээгүй аж. Үйл ажиллагааны дүн шинжилгээг хэрэгжүүлэх хүрээнд СМА нь 2011 онд “СГТ-д дүн шинжилгээ хийх аргачлал” гаргажээ. СМА нь стратегийн дүн шинжилгээ хийх дотоод зааврыг саяхан боловсруулжээ.

303. *Шалгуур 29.5* - МУТСТ хуулийн 18.1.2-т СМА нь тухайн гүйлгээг МУТС үндэслэлтэй байна гэж үзвэл мэдээллийг ХСБ-д шилжүүлнэ гэжээ. СМА-ны мэдээлэл

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

хүлээж авах, боловсруулах, шилжүүлэх журмын 4.5-т СМА нь эрх бүхий байгууллагын хүсэлтийн дагуу МУТСТ-тэй холбоотой мэдээлэл гаргаж өгч болно гэжээ. Нууцлалыг СМА-ны үйл ажиллагаанд баримтлах нууцын тухай журмаар зохицуулах ба тус журмын 4-р бүлэгт ХСБ-ад тайлан, мэдээллийг биечлэн хүргүүлэх зааврыг тусгажээ.

304. *Дэд шалгуур 29.6 (a)* – МУТСТ хуулийн 13.2-т СМА нь харилцагчийн гүйлгээтэй холбогдох мэдээллийн нууцлалыг хуульд зааснаас бусад тохиолдолд задруулахыг хориглоно гэжээ. СМА-ны аюулгүй ажиллагааны журмын 2-р бүлэгт СМА-ны МТ-ийн мэдээллийг хэрхэн хадгалах, хамгаалах, ашиглах талаар тусгажээ.

305. *Дэд шалгуур 29.6 (b)* - СМА-нд зөвхөн төрийн албан хаагчид ажиллана. СМА-нд ажиллах хүн ашиг сонирхлын зөрчилгүй, ял шийтгэлгүй гэдгээ цагдаа, АТГ-аар шалгуулж баталгаажуулна. Мөн СМА-ны үйл ажиллагаанд баримтлах нууцын тухай журмын 2.1, 6.6-д СМА-ны ажилтнууд нууц мэдээлэлтэй ажиллах үүрэг хариуцлагаа ухамсарлаж, нууцыг чанд хадгалах үүрэгтэй хэмээн заажээ.

306. *Дэд шалгуур 29.6 (в)* - СМА-ны аюулгүй ажиллагааны журамд албан тасалгаа, эд зүйлс, тоног төхөөрөмж, МТ-ийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах талаар тусгажээ. СМА, Монголбанкны МТ-ийн ажилтнууд өгөгдөл, мэдээллийг ашиглах, хадгалах, дамжуулах компьютер, тоног төхөөрөмж, програм хангамжийг шалгах, засварлах, боловсруулахдаа энэхүү журмыг мөрдлөг болгоно.

307. *Дэд шалгуур 29.7 (a)* – МУТСТ хуулийн 16.1-р зүйлд СМА нь МҮЭ-ээс мэдээлэл хүлээн авах, түүнд дүн шинжилгээ хийх, шаардлагатай бол ХСБ-д дамжуулах үүрэг бүхий хараат бус, бие даасан байгууллага байна гэжээ. СМА-ны мэдээлэл хүлээж авах, боловсруулах, шилжүүлэх журмын 4.2-ын дагуу ХСБ-д шилжүүлэх мэдээллийг СМА-ны дарга баталгаажуулна.

308. *Дэд шалгуур 29.7 (b)* – МУТСТ хуулийн 18.1.2-р зүйлийн дагуу СМА нь МУТС үндэслэлтэй гүйлгээ байна гэж үзсэн тохиолдолд мэдээллийг эрх бүхий хууль сахиулах болон терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагад шилжүүлнэ. Түүнчлэн МУТСТ хуулийн 19.2.4-т СМА нь тус хуулийн хэрэгжилтэд хяналт тавихтай холбогдуулж эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, МУТСТ гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлэхийг заажээ. СМА нь ЦЕГ, ТЕГ, АТГ, ГЕГ, УПЕГ-тай ХОСБ байгуулжээ.

309. МУТСТ хуулийн 21.1-д СМА нь ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг, нууцлалын байдлаар ижил түвшний гадаад улсын болон олон улсын байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллана гэжээ.

310. *Дэд шалгуур 29.7 (c)* - МУТСТ хуулийн 16.2-р зүйлд заасны дагуу Монголбанкны бүтцэд СМА-ыг байгуулж, МУТСТ хуулийн 21, 18, 11, 10-р зүйлд чиг үүргийг нь тодорхойлжээ.

311. *Дэд шалгуур 29.7 (d)* - МУТСТ хуулийн дагуу Монголбанкны дэргэд СМА ажиллана. СМА-ны жилийн төсвийг ХАЗ-ийн саналыг үндэслэн СМА-ны дарга танилцуулснаар Монголбанкны Ерөнхийлөгч батална. СМА нь Монголбанкны захиргааны дүрэм журам, бодлого, процедур (тухайлбал, санхүүгийн тайлагнал)-ыг дагаж мөрдөнө. СМА нь захиргааны хувьд Монголбанкаас хамааралтай ч техник функцийн

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

хувьд Төв банкнаас хараат бус ажээ. СМА-ны дарга нь жилийн төсвийг захиран зарцуулах ба МУТСТ хуулийн дагуу бие даасан үйл ажиллагаа хэрэгжүүлнэ.

312. Шалгуур 29.8 - СМА нь 2009 онд Эгмонтын бүлэгт элсжээ.

### *Дүгнэлт*

313. Монгол Улс СМА-ыг байгуулж, СМА нь үйл ажиллагааны дүн шинжилгээ хийж байна. Монгол Улсын ноцтой доголдол, сул тал нь СМА-ны зүгээс стратегийн дүн шинжилгээ хийхгүй байгаад оршиж байна. **Монгол Улс Зөвлөмж 29-ийг “хэсэгчлэн биелүүлсэн” үнэлгээтэй байна.**

### *Зөвлөмж 30- Хууль сахиулах болон мөрдөн шалгах байгууллагуудын хариуцлага*

314. Монгол Улс 2007 оны ХҮТ-нд хуучин зөвлөмж 27-г “хэсэгчлэн биелүүлсэн” үнэлгээтэй байв. ТС гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүрэг ХСБ-уудад байхгүй нь тус гэмт хэргийг хуульд тодорхойлоогүйтэй холбоотой хэмээн тус тайланд дурджээ.

315. *Шалгуур 30.1* - Монгол Улсын Эрүүгийн хууль болон УЕПГ-ын 2015 оны А/67 дугаар тушаалын дагуу ЦЕГ, ТЕГ болон АТГ нь МУ гэмт хэргийг суурь гэмт хэргийн хүрээнд мөрдөн шалгах чиг үүрэг бүхий ХСБ-ууд юм. Эрүүгийн мөрдөн шалгах ажиллагаа эхэлмэгц УЕПГ нь тус ажиллагаанд хяналт тавьж, 2016 оны А/67 тоот тушаалын дагуу прокурор хяналт тавих харъяаллыг тогтооно:

- АТГ – төрийн албан хаагчидтай холбоотой МУ гэмт хэргийг мөрдөн шалгана.
- ТЕГ- МУ суурь гэмт хэрэг нь улсын аюулгүй байдал эсхүл хилийн гэмт хэрэгтэй холбоотой хэргийг мөрдөн шалгана.
- ЦЕГ- МУ бусад төрлийн суурь гэмт хэргийг ЦЕГ-ын ЭЦГ-ын Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн МУ тэмцэх тасаг мөрдөн шалгана.

316. ЭБШХ-ийн дагуу ТЕГ нь ЭХ-ийн 178<sup>2</sup>-т заасан ТС гэмт хэргийг мөрдөн шалгана.

317. *Шалгуур 30.2* – ЭБШХ-ийн 193.1.2-р зүйлийн дагуу хяналтын прокурор гэмт хэргийн сэжиг илэрвэл хэрэг нээж холбогдох ХСБ-д шалгуулахаар шилжүүлж болох ажээ.

318. *Шалгуур 30.3* – ЭБШХ-ийн 28.2.10-ын дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эд хөрөнгө тодорхойлох, царцаах, битүүмжлэх<sup>80</sup> эрхтэй. ЭБШХ-ийн 18-р бүлэгт тус ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэхийг заажээ: (i) 133.2-т хойшлуулшгүй тохиолдолд нэгжлэг хийх, эд хөрөнгийг битүүмжлэхээр заасан бол, (ii) 134.1-д эд хөрөнгө нь гэмт хэргийн гаралтай орлого гэж сэжиглэх хангалттай үндэслэл байгаа бол битүүмжлэх арга хэмжээ авна гэжээ.

319. Тухайн гүйлгээ МУТС зорилготой гэж үзэх үндэслэл байвал МУТСТ хуулийн 11-р зүйлд заасны дагуу СМА-ны дарга тус гүйлгээг ажлын 3 хүртэл хоног түдгэлзүүлэх эрхтэй. Шаардлагатай бол энэ хугацааг шүүхийн шийдвэрээр сунгана.

---

<sup>80</sup> Бидэнд өгсөн ЭБШХ-ийн орчуулгад “битүүмжлэх” болон “царцаах” гэсэн үгс адил утгатай хэрэглэгдэж байна.

320. *Шалгуур 30.4* - Хилийн тагнуулын алба нь ЭБШХ-ийн 26.1-ийн дагуу ЭХ-д<sup>81</sup> хамаарах хилийн гэмт хэргийг мөрдөн шалгах эрх бүхий байгууллага бөгөөд Зөвлөмж 30-д заасан хэрэг бүртгэгчийн үүргийг гүйцэтгэж болно.

321. *Шалгуур 30.5* - АТГ нь төрийн албан хаагчидтай холбоотой МУ хэргийг бүртгэж, мөрдөн шалгах чиг үүрэгтэй. АТГ-ын хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч дээр дурьдсан хэрэг бүртгэгч, мөрдөн шалгагчийн бүхий л үүргийг гүйцэтгэж болно. Авлигын эсрэг хуулийн 24-ийн дагуу АТГ нь тусгай зөвшөөрөл авалгүйгээр иргэд, ААН, байгууллагын банкны дансыг шалгах, түр хугацаагаар царцаах эрхтэй.

### *Дүгнэлт*

322. **Монгол Улсад Зөвлөмж 30-ийг “биелүүлсэн” үнэлгээ авч байна.**

### *Зөвлөмж 31- Хууль сахиулах болон мөрдөн шалгах байгууллагуудын эрх мэдэл*

323. Монгол Улс 2007 оны ХҮТ-нд хуучин Зөвлөмж 28-г “биелүүлсэн” үнэлгээ авч байв.

324. *Шалгуур 31.1* – ЭБШХ-ийн дагуу ХСБ-ууд нь МУТС болон суурь гэмт хэргүүдийг мөрдөн шалгана. ЭБШХ-ийн 28-ын дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь гэмт хэрэг үйлдсэнийг тогтоохын тулд шаардлагатай бүхий л арга хэмжээ авна:

325. *Нотлох баримт цуглуулах* (ЭБШХ-ийн 28.2.11): ЭБШХ-ийн 79-р зүйлд заасны дагуу нотлох баримт гэдэгт: (i) 28 дугаар зүйлийн дагуу ААН, албан тушаалтан, иргэдээс цуглуулах баримт бичиг, бусад материал, (ii) гэрчийн мэдүүлэг.

326. *Үзлэг, нэгжлэг хийх, эд хөрөнгө битүүмжлэх* (ЭБШХ-ийн 28.2.10): 18-р бүлэгт үзлэг, нэгжлэг хийх, эд хөрөнгө хөрөнгө битүүмжлэхийг авч үзсэн бол 135-р зүйлд биед нэгжлэг хийх асуудлыг авч үзжээ.

327. Түүнчлэн Банкны тухай хуулийн 7.2-т ХСБ-ын хүссэн мэдээллийг УПЕГ-ын газраар дамжуулан гаргаж өгөхийг заажээ.

328. *Шалгуур 31.2* – УПЕГ-ын хяналтан дор (Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 23.3-р зүйл) Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9-т заасны дагуу ХСБ-ууд нь мөрдөн шалгах өргөн цар хүрээтэй арга ашиглаж болох нь тус шалгуурыг хангаж байна.

329. *Шалгуур 31.3* – МУТСТ хуулийн 10.1-д тухайн дансыг МУТС зорилгоор ашиглаж байгаа гэж үзэх үндэслэл байгаа бол СМА нь харилцагчийн дансанд хяналт тавьж болно гэжээ. Банкны тухай хуулийн 7.2.3-т заасны дагуу банкууд харилцагчид урьдчилан мэдэгдэлгүйгээр эрх бүхий байгууллагад мэдээлэл өгч болно. Цаашилбал ХСБ нь мөрдөн шалгалт явуулахдаа хөрөнгө, дансны эзэмшигчид энэ талаар заавал мэдэгдэх албагүй юм.

330. *Шалгуур 31.4* - ЦЕГ нь сэжиглэж буй этгээдийн дансны гүйлгээний мэдээллийг СМА-аас авах хүсэлт тавьж болно. ЭЦГ болон СМА Мэдээлэл солилцох, хамтын ажиллагааны санамж бичиг байгуулжээ. Авлига, албан тушаалын гэмт хэрэг, холбогдох МУ гэмт хэргийг мөрдөн шалгахдаа АТГ нь Мэдээлэл солилцох, хамтран ажиллах гэрээний дагуу СМА-аас мэдээлэл гаргуулан авах боломжтой.

<sup>81</sup> ЭХ; 89-р зүйл (Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх), 90 (Улсын хилийн дэглэмийг зөрчих), 175 (хууль бус эд зүйлсийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх)

### Дүгнэлт

331. **Монгол Улс Зөвлөмж 31-ийг “биелүүлсэн” байна.**

### *Зөвлөмж 32- Бэлэн мөнгө тээвэрлэгчид*

332. 2007 оны ХҮТ-нд Монгол Улс хуучин Тусгай зөвлөмж IX-ийг “хэсэгчлэн биелүүлсэн” үнэлгээ авч байв. Тус зөвлөмжтэй холбоотой доголдол нь гаалийн декларацид мэдүүлэгчийн төлбөрийн хэрэгслүүд (Bearer negotiable instruments /BNI/ буюу МТХ)-ийг зохих түвшинд хамарч чадахгүй байгаад оршиж байв: (i) мөнгөний гарал үүсэл болон юунд зарцуулагдахыг баталгаажуулах механизм байхгүй, (ii) хил давж буй сэжигтэй мөнгийг СМА-д мэдэгдэх зохицуулалт байхгүй, (iii) худал мэдүүлэгт хүлээлгэх хариуцлага хангалтгүй байв.

333. *Шалгуур 32.1* - Монгол Улс деклараций болон тодруулгын холимог системтэй ажээ:

334. *Декларацийн систем* – МУТСТ хуулийн 15-р зүйлд зорчигч 15 сая ₮ (7,500 ам.доллар)-өөс дээш хэмжээний мөнгө, мэдүүлэгчийн төлбөрийн хэрэгсэл, цахим мөнгө буюу гадаад валют хилээр нэвтрүүлэх бол гаалийн декларацийн маягтад үнэн зөв мэдүүлнэ гэжээ.

335. *Тодруулгын систем* - Гаалийн тухай хуулийн 231-р зүйлийг хэрэгжүүлэх “Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх журам”-ын 6.4.5-д 5 сая ба түүнээс дээш ₮ (2,500 ам.доллар), түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют, чектэй тохиолдолд зорчигч (Гаалийн тухай хуулийн 228-ын дагуу Монгол Улсад орж, гарч буй бүх этгээд) гаалийн мэдүүлэг бичнэ. Тодруулгын систем МТХ-үүдийг хамардаггүй ажээ.

336. Эдгээр хоёр системийг “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудалд хэрэгжүүлдэг байна. Биднийг Монголд ажиллах үеэр онгоцны буудлын тодруулгын системийн талаарх мэдээлэл зөвхөн монгол хэл дээр байв. Тодруулгын системийг Монгол Улсын бусад хилийн боомтод хэрэгжүүлдэг гэж бид ойлгосон. Монгол Улсын Шуудан холбооны тухай хуулийн 24.1.4-т заасны дагуу гадаад, дотоод валютыг ачаа, шуудангаар илгээхийг хориглоно. Эл хуулийн орчуулгыг бидэнд гаргаж өгөөгүй болно.

337. *Шалгуур 32.2* – МУТСТ хуулийн 15.1-д зорчигч 15 саяас дээш ₮ (7,500 ам.доллар), эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют, санхүүгийн хэрэгсэл, цахим мөнгийг Монгол Улсын хилээр бэлнээр нэвтрүүлэх бол энэ тухай гаалийн мэдүүлэгт үнэн зөв мэдүүлнэ гэжээ. Тодруулгын систем нь МТХ-үүдийг хамардаггүй ажээ.

338. *Шалгуур 32.3* - Гаалийн тухай хуулийн дагуу гаалийн албан хаагчид гаалийн хууль тогтоомж (Гаалийн хяналт)-ийг сахиулах, мөрдүүлэх үүднээс хэд хэдэн төрлийн арга хэмжээ авч болно. Тухайлбал, Монголын тодруулгын системтэй холбоотойгоор зорчигчоос аман мэдүүлэг (Гаалийн тухай хуулийн 244-р зүйл) авч болно. Гэхдээ үнэн зөв мэдүүлэхийг шаардсан зүйл алга. Тодруулгын систем нь МТХ-үүдийг хамардаггүй ажээ.

339. *Шалгуур 32.4* - Гаалийн тухай хуулийн 243-ын дагуу гаалийн байцаагч деклараци болон бусад баримт бичиг, мэдээллийг шалгахдаа нэмэлт бичиг баримт, мэдээлэл шаардаж болно.

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

340. *Шалгуур 32.5* - Гаалийн хуурамч мэдүүлэг бөглөсөн зорчигчид дараах хариуцлага хүлээлгэнэ: (i) эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэгт (ЭХ-ийн 175-р зүйл) хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100-200 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 3-6 сар хүртэл хугацаагаар хорих, (ii) хөрөнгө хурааж (Гаалийн тухай хуулийн 295-р зүйл), хувь хүнийг 10,000-30,000 төгрөг (4-12.3 ам.доллар), хуулийн этгээдийг 50,000-100,000 төгрөг (20-41 ам.доллар)-өөр торгох. Хуурамч мэдүүлэг гаргагчид эрүүгийн (хууль бусаар хил давуулсан) болон торгуулийн хариуцлага хүлээлгэх ч шийтгэл нь гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэхүйц байж чадахгүй байна.

341. *Шалгуур 32.6* – МУТСТ хуулийн 15.2-т гаалийн байгууллага нь бэлэн мөнгөний мэдүүлгийг нэгтгэн, сар бүр СМА-нд хүргүүлнэ гэжээ. Гаалийн ерөнхий газар, Монголбанкны хамтын ажиллагааны шинэчилсэн журмын дагуу 2 байгууллага гадаад худалдаа, валютын гүйлгээний мэдээллийг солилцож, хилээр нэвтрүүлж буй бэлэн мөнгөний мэдээллийг СМА-нд өдөр бүр хүргүүлдэг ажээ (сэжигтэй тээвэрлэлтийг СМА-нд тэр даруй мэдэгддэг). Хамтын ажиллагааны журмыг бидэнд гаргаж өгөөгүй болно.

342. *Шалгуур үзүүлэлт 32.7* – Монгол Улс Хилийн нэгдсэн удирдлагын хөтөлбөртэй гэдгээ бидэнд мэдээлсэн болно. Тус хөтөлбөрийн хүрээнд хилийн хяналт, ХСБ-уудын хамтын ажиллагааг хангах Ажлын хэсэг ажилладаг байна.

343. ЦЕГ, ТЕГ, ИШГЕГ нь ГЕГ-тай хамтран ажиллах ХОСБ байгуулжээ. Эдгээр байгууллага нь тус санамж бичгээр ГЕТ-тай хамтран ажиллах хуулийн үүрэг хүлээдэг аж.

344. *Шалгуур 32.8* - Гаалийн тухай хуулийн 253-р зүйлд бараа, тээврийн хэрэгслийг саатуулахыг заажээ. Үүнд МУТС сэжигтэй эсхүл хуурамчаар мэдүүлсэн дотоод, гадаадын валют, үнэт цаас мөн орно. Гаалийн байгууллага нь худал мэдүүлсэн валют, МТХ-үүдийг саатуулж болох эсэх нь тодорхойгүй байна.

345. *Шалгуур 32.9* - Гаалийн тухай хуулийн 273.1.4-ийн дагуу Монгол Улс олон улсын гэрээ байгуулж болно. Ингэснээр Монгол Улс өөрийн тодруулах/мэдүүлэх системтэй холбоотойгоор хүлээн авсан хүсэлтийг биелүүлэх эрмэлзлээ баталгаажуулж байгаа болно.

346. *Шалгуур 32.10* - Гаалийн тухай хуулиар гаалийн байцаагч нь байгууллагын нууцыг чандлан хадгалах (276.2.1-р зүйл) үүрэг хүлээх ба гаалийн хяналтын арга хэмжээ авах, гаалийн бүрдүүлэлт хийхдээ албан тушаалаа урвуулан ашиглахаас зайлсхийнэ.

347. *Шалгуур 32.11* - Монгол Улсын тодруулгын системийн хүрээнд дотоод, гадаадын валют, үнэт цаасыг хураан авахыг Гаалийн тухай хуулийн 295-р зүйлийн дагуу зохицуулна.

### *Дүгнэлт*

348. Монгол Улс мэдүүлэх болон тодруулах холимог системтэй. Зөвхөн Чингисхаан нисэх буудалд хэрэгждэг мэдүүлэх систем нь дотоод, гадаад валют, МТХ-үүдийг хамарна. Харин тодруулах систем нь хилийн бусад бүх боомтод хэрэгждэг ч МТХ-үүдийг хамардаггүй байна. Гаалийн тухай хууль нь Зөвлөмж 32-ын шаардлагыг ерөнхийдөө хангахуйц байна. **Монгол Улс Зөвлөмж 32-ыг “хэсэгчлэн биелүүлсэн” үнэлгээтэй байна.**

### *Зөвлөмж 33 - Статистик*

349. Монгол Улс 2007 оны ХҮТ-нд Зөвлөмж 32-ийг “биелүүлээгүй” үнэлгээтэй байжээ. ХҮТ-нд ажил эхлээд удаагүй тул иж бүрэн тоо мэдээ байхгүй, СГТ, БМГТ, хилийн деклараци зэрэг мэдээллийг цуглуульж, шилжүүлэх ажил эхлээгүй байгааг дурджээ.

350. *Дэд шалгуур 33.1 (a)* - Монголбанкны Ерөнхийлөгчийн 364 тоот тушаалаар 2011 оны 6-р сард баталсан СМА-ны статистикийн тайлан мэдээ гаргах журмын дагуу СМА нь хүлээн авсан СГТ, БМГТ, ГГТ болон гаалийн мэдүүлэг, ХСБ-уудын лавлагаа болон шилжүүлсэн мэдээлэл зэрэг статистик гаргадаг. УСЖ-ын 14.4-р зүйлд заасны дагуу эдгээр статистик мэдээллийг СМА Монголбанкны цахим хуудсанд улирал тутам нийтэлдэг.

351. *Дэд шалгуур 33.1(b)- 33.1(c)* – МУТСТ статистик мэдээллийг гаргахад дараахь байгууллага оролцож байна:

- УПЕГ нь эрүүгийн хэргийн мөчлөгийг бүрэн хамарсан удирдлагын системийг (case management system) ашигладаг гэх мэдээллийг өгсөн ч холбогдох журам, иж бүрэн статистик мэдээллийг гаргаж өгөөгүй болно.

- МУТС болон суурь гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүрэг бүхий УПЕГ, АТГ, ТЕГ зэрэг ХСБ-ууд нь Бүртгэлийн мэдээллийн сангийн зөрчлийн журам, Гэмт хэргийн бүртгэлийн журам (№701), Мэдээллийн хяналт судалгааны бүртгэл (№703)-тэй холбоотой 2010 оны хамтарсан 43/182/223/121 тоот тушаалын дагуу гэмт хэргийн төрөл, мөрдөн байцаалтын мэдээлэл, ял шийтгэлийн мэдээлэл, хохирол, битүүмжилсэн, царцаасан, хураан авсан эд хөрөнгө, гэмт хэрэгт хамаарах талуудын статистикийг гаргах үүрэгтэй. Гэсэн ч бидэнд холбогдох хууль эрх зүйн акт, тоо статистикийг гаргаж өгөөгүй болно.

- СМА-ны статистикийн тайлан мэдээ гаргах журмын 3.1.6-р зүйлд заасны дагуу СМА нь царцаасан гүйлгээний статистикийг гаргана.

352. *Дэд шалгуур 33.1 (d)* - Монгол Улс ЭЗХТ болон бусад олон улсын хүсэлттэй холбоотой статистикийг зохих түвшинд гаргаж байна. Хариу өгөх хугацааг бидэнд ерөнхий байдлаар танилцуулсан болохоос биш тохиолдол тус бүрээр тайлбарлаагүй болно.

### *Дүгнэлт*

353. Монгол Улс (ялангуяа СМА) зарим статистик тоо мэдээ гаргаж байна. Гэхдээ МУТСТ үр дүнтэй байдлыг хангахуйц иж бүрэн тоо мэдээ, статистикийн тогтолцоо алга. Энэ асуудлыг эрх бүхий байгууллагуудын түвшинд зохицуулсан хууль тогтоомж байхгүй аж. **Монгол Улс Зөвлөмж 33-ыг “Хэсэгчлэн биелүүлсэн” байна.**

### *Зөвлөмж 34- Зааварчилгаа эргэх холбоо*

354. Монгол Улс нь 2007 оны ХҮТ-нд хуучин Зөвлөмж 25-ыг “биелүүлээгүй” үнэлгээтэй байв. Монголбанкнаас боловсруулсан МУТСТ зарим удирдамж, чиглэлийг

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

заавал мөрдөх албагүй байв. МУТСТ шинэ шаардлагыг МҮЭ-д Монголбанкнаас ч тэр, СЗХ-ноос ч тэр тайлбарлан таниулаагүй ирснийг тус тайланд дурджээ.

355. *Шалгуур 34.1* – МУТСТ хуулийн 19.2.3-р зүйлд СМА, Монголбанк, СЗХ нь МУТСТ үүргийн биелэлтийг хангах зорилгоор МҮЭ-дэд зориулан заавар, журам, чиглэл удирдамж, санал зөвлөмж хүргүүлэх эрхтэй. Энэ хүрээнд Монгол Улс дараах баримт бичгийг гаргажээ:

- МУТС-ээс урьдчилан сэргийлэх журам.
- Сэжигтэй гүйлгээний жишээнүүд.
- Сэжигтэй гүйлгээ бөглөх зааварчилгаа.
- Стратегийн дүн шинжилгээ хийх зааварчилгаа.
- Эцсийн өмчлөгчийг тодруулах зааварчилгаа.
- Улс төрийн нөлөө бүхий этгээдийг тодорхойлох.
- СМА-нд банкнаас мэдээлэл ирүүлэх журам.
- Сэжигтэй болон бэлэн гүйлгээг тайлагнах болон ХТМ үйл ажиллагааны зааварчилгаа.
- Хадгаламж, зээлийн хоршооны үнэлгээ болон газар дээрх хяналт шалгалтын зааварчилгаа.
- ББСБ-ын үйл ажиллагааны зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийн хүсэлтийн маягт бөглөх болон баримт материал бүрдүүлэх заавар.

356. СББМҮҮ нарт зориулан гаргасан удирдамж чиглэл байхгүй аж. Гэхдээ Монголбанк болон СМА-наас банкууд, ББСБ, даатгалын компани, үнэт цаасны компаниуд, ХЗХ-дод зориулан зохион байгуулсан сургалт, семинарт үл хөдлөх эд хөрөнгө зуучлагч нар, нотариатууд, нягтлан бодогчид, аудиторчууд мөн хамрагджээ.

### *Дүгнэлт*

357. Сургалт, семинарт МҮЭ бүгд хамрагдаж байгаа ч удирдамж чиглэлээр зөвхөн СББМҮҮ бус МҮЭ-ийг хангаж байна. **Монгол Улс Зөвлөмж 34-ийг “Хэсэгчлэн биелүүлсэн” үнэлгээтэй байна.**

### *Зөвлөмж 35- Шийтгэлийн арга хэмжээ*

358. Монгол Улс 2007 оны ХҮТ-нд Зөвлөмж 17-г “хэсэгчлэн биелүүлсэн” үнэлгээ авч байв. Тус тайланд СМА нь нэргүй данс нээсэн, харилцагчийн дутуу мэдээллээр гүйлгээ хийсэн МҮЭ-д захиргааны хариуцлага хүлээлгэх эрх мэдэл хязгаарлагдмал, харин СЗХ-ны хувьд эрх мэдэл хангалттай ч хариуцлага хүлээлгэсэн зүйл байхгүйн дээр тусгай зөвшөөрөлгүй хуулийн этгээдэд хариуцлага тооцож чадахгүй байгааг онцолсон байв.

359. *Шалгуур 35.1* – Эрүүгийн ял шийтгэл зөвхөн ЭХ-д тусгагдсан байдаг. МУТСТ хууль, ТТ хууль, УСЖ зөрчилд хариуцлага тооцох зүйл анги ЭХ-д байхгүй аж. Тухайлбал, хориг арга хэмжээний жагсаалтад бүртгэлтэй хувь хүн, хуулийн этгээдийн

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

хөрөнгийг үл царцаах, МУТС СГТ-г мэдээлэхгүй байх, МУТС холбоотой мэдээллийг задруулах зэрэг санаатай үйлдлийг ЭХ-иар эрүүгийн гэмт хэрэгт тооцохгүй байна.

360. Нөгөө талаас ЭХ-д дараах ял шийтгэл тусгагджээ: (i) банкны төлбөрийн чадвар, ашигт ажиллагаанд их хэмжээний хохирол учирсан (ЭХ-ийн 156-р зүйл) бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100-250 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх; хэргийг давтан үйлдсэн, эсхүл энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учруулсан бол эд хөрөнгийг хурааж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 251-500 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 5-аас дээш 8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх; (ii) үнэт цаасны хууль тогтоомжийг (ЭХ-ийн 158-р зүйл) зөрчсөний улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг 3 жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 151-200 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, 3-аас дээш 6 сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл 2 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх.

361. Зөвлөмж 6-ийн зөрчилд хүлээлгэх хариуцлага байхгүй ажээ. Иймээс хөрөнгө царцаах, хөрөнгө мөнгийг ашиглах нөхцөл боломжийг бүрдүүлэхгүй байх, СБ болон СББМҮҮ-ид царцаасан хөрөнгө, авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тайлагнах шаардлага хэрэгжих боломжгүй гэж бид үзэж байна. Зөвлөмж 6-д дурьдсанчлан: (i) ТТ хууль болон ТЭЖО журмын холбогдох хэсэгт ял шийтгэлийн арга хэмжээг тусгаагүй, (ii) зөрчилд шууд бус/өргөн хүрээтэй шийтгэл хүлээлгэх талаар ТТХ болон ТЭЖО журамд харилцан холбоотой заалтууд байхгүй, (iii) хувь хүн болон хуулийн этгээдэд шууд бус/өргөн хүрээтэй хариуцлага хүлээлгэж болохыг Монгол Улс нотлоогүй болно.

362. Зөвлөмж 8-ын зөрчилд хүлээлгэх хариуцлагыг ТББ тухай хуульд тусгажээ. ТББ-ын хуулийн зөрчлийг эрүүгийн гэмт хэрэг гэж үзээгүй бол ИТХ-аас дараах шийтгэл ногдуулах боломжтой: (i) орлогын хууль бус хуваарилалт - гүйцэтгэх удирдлагад - 40-60 мян. төг (16-25 ам.доллар), байгууллагад 100-150 мян. төгрөгийн (41-61 ам.доллар) торгууль ногдуулна, (ii) ТББ-ын санхүүгийн болон эдийн засгийн үйл ажиллагаанаас хувьдаа ашиг олох - гэм буруутай нь тогтоогдсон гүйцэтгэх албан тушаалтныг 40-60 мян. төгрөгөөр (16-25 ам.доллар) торгож, олсон орлогыг хураах, (iii) улс төрийн хандив-гүйцэтгэх удирдлагад 50-60 мян. төгрөгийн торгууль (20-25 ам.доллар), ААН-ид 200-250 мян. төг (82-102 ам.доллар) торгууль, (iv) жилийн тайланг гаргаж өгөөгүй - гүйцэтгэх албан тушаалтанд 10-20 мян. төг (4-8 ам.доллар) торгууль ногдуулна. Эдгээр шийтгэл нь гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэхүйц байж чадахгүй байна.

363. Зөвлөмж 9-23-ын зөрчилд хүлээлгэх хариуцлагыг (байгаа бол) СБ, СББМҮҮ-ийн үндсэн хууль тогтоомжид тусгасан бөгөөд зохицуулагчдын зүгээс шийтгэлийг ногдуулах боломжтой.

364. *Монголбанк* - Банкны тухай хуулийн 46-р зүйлийн дагуу хууль тогтоомж, дүрэм журам, төв банкны шийдвэрийн (тухайлбал, МУТСТ хууль, УСЖ) зөрчилд Монголбанкаас банкинд хүлээлгэх хариуцлага нь гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц боловч дахин үйлдэхээс сэргийлэхүйц биш байна. Зөрчлийн шинж чанараас хамааран дараах шийтгэлийг оногдуулж болно: сэрэмжлүүлэг; үүрэгт даалгавар; Захирлуудын зөвлөлөөр Гүйцэтгэх удирдлагыг түдгэлзүүлэх, чөлөөлөх шийдвэр гаргуулах; ТУЗ,

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтанд цалин олгохыг зогсоох; банкны үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн хязгаарлах/зогсоох; хянагчийг томилох; банкны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох; захиргааны торгууль ногдуулах.

365. МУТСТ хуулийн зөрчилд хүлээлгэх хариуцлага банкны ажилтнуудын хувьд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-15 дахин (625-1,875 ам.доллар); банк, салбар компани, салбар нэгжүүдийн хувьд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50-100 дахин (6,250-12,500 ам.доллар) нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгууль ногдуулах явдал болно (Банкны тухай хуулийн 68.1.5-р зүйл). Цаашилбал, Монголбанк, түүний хянан шалгагчийн шаардлагыг биелүүлээгүй болон Банкны тухай хуулийн 68.1.1-68.1.12-оос бусад заалтыг зөрчсөн хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50-250 дахин нэмэгдүүлсэнтэй, эрх бүхий ажилтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-25 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно.

366. СЗХ – СЗХ-ны зүгээс СБ-уудад захиргааны хариуцлага хүлээлгэх эрх мэдэл хязгаарлагдмал төдийгүй шийтгэл нь гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэхүйц биш аж:

- ББСБ нь хууль тогтоомжийг зөрчсөн бол (тухайлбал, МУТСТ хууль, УСЖ) СЗХ-ноос ББСБ-ын үйл ажиллагааны тухай хуулийн 19-р зүйлийн дагуу зөрчлийг арилгах тушаал гаргах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, гүйцэтгэх удирдлагыг чөлөөлөх буюу түүнд хариуцлага хүлээлгэх, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох болон бусад захиргааны арга хэмжээг авна. МУТС зөрчилд ББСБ-ын албан хаагчдад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-15 дахин (625-1,875 ам.доллар) нэмэгдүүлсэнтэй, харин ББСБ-ад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20-40 дахин (2,500-5,000 ам.доллар) нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгууль тус тус ногдуулна (ББСБ-ын үйл ажиллагааны тухай хуулийн 20.1.3).

- Даатгалын компани нь холбогдох хууль тогтоомж зөрчсөн бол (тухайлбал, МУТСТ хууль болон УСЖ) СЗХ-ноос Даатгалын тухай хуулийн 67.1-р зүйлийн дагуу тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, тушаал гаргах, хянан шалгагч эсхүл хянагчийг томилох, захиргааны шийтгэл оногдуулах зэрэг арга хэмжээ авна. МУТС зөрчилд даатгалын албан хаагчдад 50-100 мян. төг (20-40 ам.доллар), даатгалын компанид 500 мянгаас 1 сая төгрөг (200-400 ам.доллар)-ийн торгууль ногдуулна (Даатгалын тухай хуулийн 83.1.2).

- Хөрөнгө оруулалтын сан нь холбогдох хууль тогтоомж зөрчсөн бол (тухайлбал, МУТСТ хууль болон УСЖ) СЗХ-ноос Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 56.1-ийн дагуу хугацаат үүрэг даалгавар өгч болно. Энэ нь МУТСТ зөрчилд хүлээлгэж болох цорын ганц арга хэмжээ аж.

- Үнэт цаасны компани нь холбогдох хууль тогтоомж зөрчсөн бол (тухайлбал, МУТСТ хууль болон УСЖ) СЗХ-ноос Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 29 болон 30-р зүйлийн дагуу тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, үүрэг даалгаврыг биелүүлээгүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авна. МУТСТ зөрчилд эдгээрээс өөр хариуцлага хүлээлгэх боломжгүй.

- ХЗХ нь холбогдох хууль тогтоомж зөрчсөн бол (тухайлбал, МУТСТ хууль болон УСЖ) СЗХ-ноос ХЗХ-ны тухай хуулийн 56-р зүйлийн дагуу зөрчил арилгах арга хэмжээ

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

авах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгож болно. СЗХ нь ХЗХ-ны тухай хуулийн 57.1.4-т заасны дагуу хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3-5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний (375-625 ам.доллар), хувь хүнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэнтэй (375 ам.доллар) тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

367. Монгол Улсын МУТСТ тогтолцоонд СББМҮҮ-ээс зөвхөн үл хөдлөх эд хөрөнгийн зуучлагчид болон нотариатууд хамрагдаж байгааг Зөвлөмж 22-т дурьдсан билээ. Гэсэн хэдий ч үл хөдлөх эд хөрөнгийн зуучлагчид МУТСТ хууль, УСЖ-ыг дагаж мөрддөггүй нь тэдэнд хүлээлгэх хариуцлага байдаггүйтэй холбоотой. Харин нотариатчдад хүлээлгэх хариуцлага нь гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, давтан үйлдэхээс сэргийлэхүйц биш ажээ.

368. *Шалгуур 35.2* – Банкны болон ББСБ-ын захирлуудад хүлээлгэж болох хариуцлагыг дээр дурьдсан. Тэгвэл МҮЭ болон СББМҮҮ-ийн дээд удирдлагад тооцох хариуцлагыг албан хаагчдад хүлээлгэх хариуцлагын хүрээнд авч үздэг ажээ. Гэсэн хэдий ч шийтгэл нь гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, давтан үйлдэхээс сэргийлэхүйц биш байна.

### *Дүгнэлт*

369. Монгол Улсад нэвтрүүлсэн шийтгэврийн зарим арга хэмжээ нь гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, давтан үйлдэхээс сэргийлэхүйц байж чадахгүй байна. Эрүүгийн ял шийтгэлийг зөвхөн ЭХ-д тусгасан ба түүнд МУТСТ хууль, ТТ хууль, УСЖ зөрчлийг гэмт хэрэгт тооцох тухай байхгүй аж. СБ-ад хүлээлгэх захиргааны арга хэмжээ нь гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, давтан үйлдэхээс сэргийлэхүйц биш ажээ. Зөвлөмж 6-ийн зөрчилд хүлээлгэх хариуцлага байхгүй байна. СББМҮҮ-ээс зөвхөн нотариатчид МУТСТ хуулийг мөрдөж буй нь тус хуулийн хамрах хүрээ явцуу байгааг илтгэнэ. Нотариат, ТББ-ад хүлээлгэх хариуцлага нь гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, давтан үйлдэхээс сэргийлэхүйц байж чадахгүй байна. **Монгол Улс Зөвлөмж 35-ыг “хэсэгчлэн биелүүлсэн” үнэлгээтэй байна.**

### *Зөвлөмж 36- Олон улсын хамтын ажиллагааны арга хэрэгслүүд*

370. Монгол Улс 2007 оны ХҮТ-нд Тусгай Зөвлөмж I-ийг “биелүүлээгүй”, хуучин Зөвлөмж 35-ыг “хэсэгчлэн биелүүлсэн” үнэлгээ авч байв. Тус тайланд Монгол Улсыг (i) Палермогийн конвенцид элсээгүй буюу конвенцийн шаардлагыг хэрэгжүүлж эхлээгүй, (ii) Венийн конвенц, Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай конвенцийг бүрэн хэрэгжүүлээгүй, (iii) НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1267, 1373-р тогтоолыг бүрэн хэрэгжүүлээгүйг дурджээ. Монгол Улс ЭХ болон ЭБШХ-д нэмэлт өөрчлөлт оруулж, Журам 348-ыг гаргаснаар Тусгай зөвлөмж III, Зөвлөмж 35, Тусгай зөвлөмж V-ын “Дийлэнхийг хэрэгжүүлсэн” үнэлгээтэй болсныг 2014 оны явцын тайланд тэмдэглэжээ.

371. *Шалгуур 36.1* - Монгол Улс нь НҮБ-ын бүх конвенцийг соёрхон баталжээ:

- Венийн конвенц - 2001 онд.
- Палермогийн конвенц - 2008 онд.
- Авлигын эсрэг НҮБ-ын конвенц - 2003 онд.

- Терроризмыг санхүүжүүлэхийг хориглох тухай конвенц - 2003 онд.

372. *Шалгуур 36.2* - Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ хэмээн заажээ.

### *Дүгнэлт*

373. **Монгол Улс Зөвлөмж 36-г “биелүүлсэн” үнэлгээтэй байна.**

### *Зөвлөмж 37- Эрх зүйн харилцан туслалцаа*

374. Монгол Улс 2007 оны ХҮТ-нд хуучин Зөвлөмж 36-г “биелүүлсэн”, хуучин Тусгай Зөвлөмж V-ыг “хэсэгчлэн биелүүлсэн” үнэлгээтэй байв. Монгол Улс хуучин Зөвлөмж 36-ийн хувьд статистик мэдээ гаргаж өгөөгүйг тус тайланд дурджээ. Тусгай зөвлөмж V-ын хувьд, ТС гэмт хэрэг байхгүй нь тус асуудлаархи эрх зүйн харилцан туслалцааг хязгаарлаж болзошгүй гэсэн байна. Монгол Улс ЭХ болон ЭБШ хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, Журам 348-ыг гаргаснаар Тусгай зөвлөмж III, Тусгай зөвлөмж V-ын “дийлэнхийг биелүүлсэн” үнэлгээтэй болсныг 2014 оны явцын тайланд тэмдэглэжээ.

375. *Шалгуур 37.1* – ЭБШХ-ийн 45, 46-р бүлэгт МУТСТ болон суурь гэмт хэргийн ЭЗХТ үзүүлэх дүрэм журмыг тусгажээ. Монгол Улс харилцан туслах зарчмын хүрээнд ЭЗХТ үзүүлж болно.

376. Монгол Улс 28 улстай ЭЗХТ-ны гэрээтэй (Болгар, Канад, Хятад, Куба, Чех, БНАСАУ, Энэтхэг, Франц, Хонконг, Унгар, Казахстан, Киргизстан, Польш, Румын, ОХУ, Словак, Өмнөд Солонгос, Турк, Украин, Вьетнам), 15 улстай шилжүүлэн өгөх гэрээтэй (5 нь тусдаа гэрээ, харин бусад нь ЭЗХТ-ны хүрээнд зохицуулагдсан /Хятад, Энэтхэг, Хонконг, Казахстан, Өмнөд Солонгос/) болон ялтан шилжүүлэх 9 гэрээтэй (3 нь тусдаа гэрээ, харин бусад нь ЭЗХТ-ны хүрээнд зохицуулагдсан /Канад, Хятад, Өмнөд Солонгос/).

377. *Шалгуур 37.2* - Монгол Улсын Үндсэн хуулийн 56-р зүйл, Прокурорын байгууллагын тухай хуулийн 2.1-р зүйл болон УЕПГ-ын ЭБШХ-ийн заалтыг дагаж мөрдөх аргачилсан зааврын 16.2.3 (ЭЗХТ буюу өөр гэрээ байхгүй бол)-ын дагуу УЕПГ нь эрүүгийн хэрэгт ЭЗХТ үзүүлэх эрх бүхий байгууллага юм. ЭБШХ-ийн 398-р зүйлд гэрээнд заасан эрх бүхий байгууллага нь ЭЗХТ-ны хүсэлтийг дамжуулна гэжээ.

378. *Шалгуур 37.3* – ЭБШХ болон бусад холбогдох хууль тогтоомжид ЭЗХТ-г хязгаарласан буюу үндэслэлгүй нөхцөл шаардлага тавьсан зүйл байхгүй аж. Гэхдээ ЭБШХ-ийн 401.5-р зүйлд ЭЗХТ нь Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хууль тогтоомжтой харшлах ёсгүй гэжээ.

379. *Шалгуур 37.4* – ЭЗХТ-ны хүсэлтийн мэдээлэл бүрэн бус тохиолдолд хүсэлтийг буцааж болно. Төсөв буюу нууцлалтай холбоотойгоор ЭЗХТ үзүүлэхээс татгалзсан тохиолдол гараагүй байна.

380. *Шалгуур 37.5* – ЭЗХТ-ны нууцлалыг ЭБШХ-ийн хүрээнд зохицуулна. Тус хуулийн 401.1-д ЭЗХТ-аг ЭБШХ-ийн дагуу гүйцэтгэнэ гэжээ. ЭБШХ-ийн 189-ийн дагуу

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

мэдээллийг зөвхөн прокурорын<sup>82</sup> зөвшөөрлөөр, зөвхөн тогтоосон хэмжээнд олон нийтэд танилцуулах боломжтой. Түүнчлэн шаардлагатай тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын зүгээс гэмт хэрэгтэй холбоотой аливаа мэдээллийг задруулж үл болохыг хохирогч, иргэн, иргэний хэрэг нэхэмжлэгч, өмгөөлөгч, шинжээч, орчуулагч, хэргийн гэрч, мөрдөн шалгах ажиллагаанд оролцогч бусад этгээдэд анхааруулна.

381. *Шалгуур 37.6* - Монгол Улс МУТС, суурь гэмт хэрэгтэй холбоотой ЭЗХТ гүйцэтгэхдээ тус үйлдлийг Монгол Улсын хуулиар мөн гэмт хэрэгт тооцсон байх давхар шаарлага тавьддаггүй.

382. *Шалгуур 37.7* – Хоёр талын аль аль нь тухайн үйлдлийг гэмт хэрэгт тооцох зарчмыг Монгол Улс бусад улстай байгуулсан ЭЗХТ-ны гэрээний дагуу зохицуулдаг. Энэхүү давхар шаардлагын зарчмаар Монгол Улс Өмнөд Солонгос, Казахстан, Хятад, Словак гэсэн 4 улстай харилцдаг ажээ.

383. *Шалгуур 37.8* - ЭБШХ-ийн 401-д заасны дагуу ЭЗХТ-ны гүйцэтгэлийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нар ЭБШХ-д заасан дүрэм, Зөвлөмж 31-д заасан эрх мэдлийн хүрээнд хэрэгжүүлнэ.

### *Дүгнэлт*

384. **Монгол Улсад Зөвлөмж 37-г “биелүүлсэн” үнэлгээтэй байна.**

### *Зөвлөмж 38 - Эрх зүйн харилцан туслалцаа: Хөрөнгө царцаах, хураах*

385. Монгол Улс 2007 оны ХҮТ-нд Зөвлөмж 38-г “дийлэнхийг биелүүлсэн” үнэлгээ авч байжээ. Тус тайланд Монгол Улс хураасан хөрөнгийн сан үүсгэх, хураагдсан хөрөнгийг хүсэлт гаргасан улсад шилжүүлэх талаар авч үзээгүйг тэмдэглэжээ.

386. *Шалгуур 38.1* – Зөвлөмж 4-т дурьдсанчлан Монгол Улс ЭБШХ-ийн 8-р бүлгийн дагуу хөрөнгө царцаах, хураах хангалттай эрх мэдэлтэй. Монгол Улс гадны хүсэлтэд ЭЗХТ-ны гэрээ, ЭБШХ-ийн 41-р бүлэг болон УПЕГ-ын ЭБШХ-ийн заалтыг дагаж мөрдөх аргачилсан зааврын 16-р бүлгийг үндэслэн хариу үйлдэл үзүүлэх боломжтой.

387. *Шалгуур 38.2* - ЭХ-ийн 49-р зүйлд зөвхөн шүүхийн тогтоолоор эд хөрөнгийг хураах тухай заасан байдаг. Шүүхийн тогтоолгүй хөрөнгө хураах нь Монгол Улсын хууль тогтоомжийн суурь зарчмуудтай (Үндсэн хуулийн 5.2, 5.3-р зүйл) харшлах тул боломжгүй юм.

388. *Шалгуур 38.3* – Шалгуур 4.4-т дурьдсанчлан, Монгол Улс битүүмжилсэн хөрөнгийг удирдах маш ерөнхий системтэй ажээ.

389. *Шалгуур 38.4* - Хураагдсан хөрөнгийг өөр улсад шилжүүлэхийг хориглосон зүйл байхгүй ч үүнийг чухамхүү хэрхэн гүйцэтгэх нь тодорхой биш байна. Монгол Улс өнөөдрийг хүртэл 2 удаа хөрөнгө гадагш нь шилжүүлжээ.

### *Дүгнэлт*

---

<sup>82</sup> ЭБШХ-д прокурор гэж тусгасны дагуу 2007 оны ХҮТ-нд prosecutor болон prosecutor гэсэн нэр томъёог хамт хэрэглэсэн байгаатай нийцүүлсэн.

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

390. Монгол Улс ЭЗХТ-ны хүрээнд хөрөнгө царцаах, хураах зохицуулалттай ч хураасан хөрөнгийг удирдах, зохицуулах, шилжүүлэх тогтолцоо тодорхойгүй байна. **Монгол Улс Зөвлөмж 38-ын “дийлэнхийг биелүүлсэн” үнэлгээтэй байна.**

### *Зөвлөмж 39- Гэмт хэрэгтнийг шилжүүлэх*

391. Монгол Улс 2007 оны ХҮТ-нд хуучин Зөвлөмж 39-ийн “дийлэнхийг биелүүлсэн” үнэлгээ авч байв. Тус тайланд шилжүүлэн өгөх үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг тогтоох боломжгүй байна гэжээ.

392. *Шалгуур 39.1* - Монгол Улс ЭБШХ-ийн 46, 47-р бүлэгт заасны дагуу шилжүүлэн өгөх үйл ажиллагааг хэрэгжүүлэх бөгөөд МУТС нь шилжүүлэн өгөх үндэслэл болно. УПЕГ-ын ЭБШХ-ийн заалтыг дагаж мөрдөх аргачилсан зааврын 16-р бүлэгт шилжүүлэн өгөх үйл явцыг тодорхой заажээ.

393. ЭБШХ-ийн 406-р зүйлд дараахь нөхцөлд шилжүүлэн өгөхөөс татгалзана гэжээ:

- Гэмт хэрэгтний Монгол улсад орогнох хүсэлтийг зөвшөөрсөн.
- Гэмт хэрэгтэн нь ялаа эдэлж дууссан эсхүл ял шийтгэлийг өмнө нь бууруулсан/буруугүй болох нь нотлогдсон.
- Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хөөн хэлэлцэх хугацаа дуусгавар болсон буюу эрүүгийн хэрэг үүсгэх эсвэл ял оногдуулах боломжгүй нөхцөл байдал үүссэн.

394. УПЕГ-ын ЭБШХ-ийн заалтыг дагаж мөрдөх аргачилсан зааврын 16.5.10-р бүлгийн дагуу хэрэгтнийг шилжүүлэн өгөх тухай мэдэгдэл өгснөөс хойш 30 хоногийн дотор шилжүүлэн авагч тал шилжүүлэн аваагүй бол түүнийг улсын прокурорын шийдвэрийн дагуу чөлөөлнө.

395. Шилжүүлэн өгөх үйл ажиллагааг шилжүүлэн өгөх гэрээгээр (Монгол Улс 15 гэрээ байгуулжээ), аль эсвэл 2 талын болон олон талт тухайлсан гэрээгээр зохицуулах ажээ (ЭБШХ-ийн 405.1).

396. *Шалгуур 39.2* - Монгол Улс өөрийн иргэнийг шилжүүлэн өгдөггүй байна (Үндсэн хуулийн 15.2). ЭБШХ-ын 403-р зүйлд гадаадад гэмт хэрэг үйлдсэн Монгол Улсын иргэний хувьд тухайн улсын хүсэлтийн дагуу эрүү үүсгэхээр заажээ.

397. *Шалгуур 39.3* – Монгол Улс хэрэгтэн шилжүүлэхдээ тухайн үйлдлийг хоёр тал хоёулаа гэмт хэрэгт тооцох давхар шаардлагыг баримталдаг ажээ. Өөрөөр хэлбэл, тухайн үйлдэл нь Монгол Улсад ч тэр, гадаад улсад ч тэр гэмт хэрэгт тооцогдох ёстой.

398. *Шалгуур 39.4* - УПЕГ-ын ЭБШХ-ийн заалтыг дагаж мөрдөх аргачилсан зааврын 16.5-д шилжүүлэх хүсэлтийг шийдвэрлэх талаар тусгажээ. Шилжүүлэн өгөх ажлыг түргэвчлэх механизм байхгүй ч УПЕГ нь шүүхийн шийдвэргүйгээр шилжүүлэх шийдвэрийг гаргаж болно.

### *Дүгнэлт*

399. Монгол Улсын шилжүүлэн өгөх хууль тогтоомж, процедур зохих түвшинд байна. Жижиг сул тал, доголдол нь ЭБШХ-ийн 406-р зүйл буюу шилжүүлэн өгөхөөс татгалзах үндэслэлд оршиж байна (Монгол Улс зарим хүсэлтийг хангаж чадахгүйд хүргэж

болзошгүй). Мөн шилжүүлэх үйл явцыг түргэтгэх тодорхой механизм байхгүй аж. **Монгол Улс Зөвлөмж 39-ийн “дийлэнхийг биелүүлсэн” үнэлгээтэй байна.**

### *Зөвлөмж 40- Олон улсын хамтын ажиллагааны бусад хэлбэр*

400. Монгол Улс 2007 оны ХҮТ-нд хуучин Зөвлөмж 40-ийг “хэсэгчлэн биелүүлсэн” үнэлгээ авч байв. Эрх бүхий байгууллагууд хүлээн авсан мэдээллээ зохистой байдлаар, зөвшөөрлийн дагуу ашиглаж буйд хяналт тавих тогтолцоо сул, хамтын ажиллагаатай холбоотой тоо мэдээ байхгүй байсныг тус тайланд дурджээ. Гэвч энэхүү нөхцөл байдал өөрчлөгдсөнөөр Монгол Улс Зөвлөмж 40-ийн “дийлэнхийг биелүүлсэн” үнэлгээтэй болсныг 2012 он явцын тайланд тэмдэглэжээ.

401. *Шалгуур 40.1* - ТЕГ, ЦЕГ, ГЕГ, УПЕГ, АТГ, СМА, СЗХ, Монголбанк зэрэг эрх бүхий байгууллага нь МУТСТ, суурь гэмт хэргийн асуудлаар гадны ижил төстэй байгууллагатай хамтран ажиллах боломжтой. Мэдээллийг хүсэлтийн дагуу аль эсвэл ажлын журмаар солилцох боломжтой.

402. *Шалгуур 40.2* – МУТСТ болон суурь гэмт хэргийг бүртгэх, мөрдөн шалгах, таслан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч ХСБ-уудын гадаад хамтын ажиллагааг ЭБШХ-ийн 45-р бүлэг, УПЕГ-ын ЭБШХ-ийн заалтыг дагаж мөрдөх аргачилсан зааврын 16-р дугаар бүлэгт тусгажээ. Бүх мэдээлэл нь ЭБШХ-д заасан мэдээллийн аюулгүй байдлын шаардлагыг хангах ёстой. Гэсэн ч мэдээллийн аюулгүй байдлыг ХСБ тус бүрийн хувьд тогтоосон зүйл байхгүй, мэдээллийн хүсэлтийг эрэмбэлэх эсхүл цаг тухайд нь гүйцэтгэх процедур байхгүй аж.

403. СМА – МУТСТ хуулийн 18.1.1 болон 21-р зүйлд СМА-ны олон улсын хамтын ажиллагааг тодорхойлжээ. СМА нь ижил төстэй чиг үүрэгтэй буюу үйл ажиллагаатай гадаадын буюу олон улсын байгууллагатай мэдээлэл солилцож хамтран ажиллах боломжтой. СМА нь мэдээллийн нууцлалыг хамгаалах дотоод журамтай. Гадны байгууллагатай солилцох мэдээллийн аюулгүй байдлыг мөн журмаар зохицуулна.

404. *Зохицуулагчид* - Монголбанк нь банкны хяналт шалгалтыг хариуцсан байгууллагын хувьд Төв банкны тухай хуулийн 33-т заасны дагуу гадны байгууллагатай хамтран ажиллах боломжтой бөгөөд гадаадын 9 төв банктай ХОСБ байгуулжээ (хүсэлт дамжуулж, боловсруулах явцыг хөнгөвчлөнө). СЗХ нь банк бус салбарын хяналт шалгалтыг хариуцсан байгууллагын хувьд СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хуулийн 16.1.1-д заасны дагуу гадны байгууллагатай хамтран ажиллах боломжтой бөгөөд гадаадын 6 адил төстэй байгууллагатай ХОСБ байгуулсан нь хүсэлт дамжуулах, боловсруулах үйл явцыг дөхөмтэй болгожээ. Төв банкны тухай болон СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хуулийн аль алинд мэдээллийн (тухайлбал, ирүүлсэн мэдээллийн) аюулгүй байдлыг тусгажээ. Нөгөө талаас хүсэлтийн эрэмбийг тогтоох, хүсэлтийг заасан хугацаанд гүйцэтгэх тогтолцоо Монголбанкинд ч тэр, СЗХ-нд ч тэр үгүйлэгдэж байна. Ингэхдээ Монголбанк, СЗХ хамгийн тохиромжтой арга сонгох боломжтой эсэх нь тодорхойгүй байна.

405. *Шалгуур 40.3* - Эрх бүхий байгууллагууд хоёр талын болон олон талт гэрээ байгуулах албагүй ч мэдээлэл солилцох үүднээс гадны түншүүдтэйгээ ХОСБ байгуулах

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

нь нийтлэг ажээ. Тухайлбал, УПЕГ нь Турк, Тайланд, Киргиз, Узбекистан, Орос, Австри, Вьетнам зэрэг 7 оронтой ХОСБ байгуулжээ. СМА нь нийт 18 оронтой, тэр дотроо бүс нутгийн томоохон түншүүдтэй ХОСБ байгуулжээ. ЦЕГ нь ОХУ, БНХАУ, Өмнөд Солонгос зэрэг бүс нутгийн түншүүдтэйгээр санамж бичиг/олон талт гэрээ байгуулжээ. ГЕГ нь ОХУ, БНХАУ зэрэг 16 улс оронтой хамтын ажиллагааны болон ЭЗХТ-ны гэрээ үзэглэжээ. Шалгуур 40.2-т дурьдсанчлан, зохицуулагчид 15 улстай ХОСБ байгуулсан байна. Гэхдээ эдгээр санамж бичгийг цаг тухайд нь байгуулсан эсэх нь тодорхойгүй байна.

406. Шалгуур 37.1-д дурьдсанчлан Монгол Улс 20 улстай 28 удаагийн ЭЗХТ-ны гэрээ, 15 улстай 15 удаагийн шилжүүлэн өгөх гэрээ байгуулжээ.

407. *Шалгуур 40.4* – Гадаадын байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг хэрхэн шийдвэрлэснийг Монгол Улс танилцуулаагүй болно. СМА-наас гадаад түншүүдийн хүсэлтэд хариу өгсөн маш ерөнхий статистикийг Шалгуур 40.10-аас үзнэ үү.

408. *Шалгуур 40.5* – ЭБШХ болон түүнтэй холбогдох журам, заавар, МУТСТ хууль, Төв банкны тухай хууль, СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хуульд мэдээлэл солилцоог хязгаарласан, үндэслэлгүй нөхцөл шаардлага тавьсан зүйл үгүй ажээ. Хууль эрх зүйн актууд дахь мэдээлэл нууцлах заалтууд ХСБ-ууд, СМА болон зохицуулагчдад гадаадын байгууллагуудтай мэдээлэл солилцоход саад учруулахааргүй байна.

409. *Шалгуур 40.6-40.7* – Мэдээлэл ашиглалтад тавих зарим нэг хяналтын механизмыг тухайлбал, УПЕГ-ын ЭБШХ-ийн заалтыг дагаж мөрдөх аргачилсан зааварт болон ЭБШХ-д МУТС, суурь гэмт хэргийг бүртгэх, шалгах, таслан шийдвэрлэх ажиллагааны нэг хэсэг болгон тусгажээ. СМА нь мэдээллийн нууцлалыг хангах дотоод хяналт, журамтай бөгөөд энэ нь гадаадын байгууллагатай солилцох мэдээлэлд ч хамаарна. Монголбанк, СЗХ-ны үндсэн хууль тогтоомжид гадаад орнуудтай солилцох мэдээллийн нууцлалын асуудал шууд тусгагдаагүй ч албаны мэдээллийг ашиглах ерөнхий заалтууд байдаг ажээ.

410. *Шалгуур 40.8* - ЭБШХ-ийн дагуу гадаадын улс орнуудтай мэдээлэл солилцох ажлыг хэрэг нээх шатанд гүйцэтгэнэ. СМА нь мөн гадаадын байгууллагуудын нэрийн өмнөөс шалгаж магадлах ажлыг гүйцэтгэдэг. Монголбанк, СЗХ-ны үндсэн хууль тогтоомжид гадаадын байгууллагуудын нэрийн өмнөөс шалгаж лавлах тухай заалт байхгүй ч гадаад хамтын ажиллагааг зохицуулсан заалтууд байх бөгөөд ХОСБ-ийн хүрээнд зохицуулагчид энэ ажлыг гүйцэтгэх боломжтой ажээ.

### *СМА-дын мэдээлэл солилцоо*

411. *Шалгуур 40.9* - СМА нь МУТСТ хуулийн 21 болон 18.1.1-ийн дагуу МУ болон суурь гэмт хэргийн асуудлаар олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх бүрэн боломжтой. Эдгээр заалт нь СМА-нд гадаадын болон олон улсын ижил төстэй байгууллагатай мэдээлэл солилцох, хамтран ажиллах боломжийг бүрдүүлнэ. СМА нь бүс нутгийн томоохон түншүүдийг оролцуулаад 18 ХОСБ байгуулжээ.

412. *Шалгуур 40.10* – МУТСТ хуулийн 21 болон 18.1.1-ийн дагуу СМА нь гадаадаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн түүнд шаардлагатай мэдээллийг холбогдох хууль

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

тогтоомжийн дагуу шилжүүлэн өгч болно. СМА нь 2014 онд 2 удаа, 2015 онд 4, 2016 онд 8 удаа мэдээлэл гаргаж өгсөн гэдгээс өөр тайлбар хийгээгүй болно.

413. *Шалгуур 40.11* – МУТСТ хуулийн 21.1 болон 21.2 зүйлд СМА-ны шууд болон шууд бусаар авах эрхтэй мэдээллийг солилцох өргөн боломжийг СМА-нд олгожээ.

414. МУТСТ хуулийн 21.2-ын дагуу СМА нь гадаадын болон олон улсын ижил төстэй чиг үүрэгтэй байгууллагын хүсэлтийг үндэслэн түүнд шаардлагатай мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шилжүүлэн өгч болно. Өөрөөр хэлбэл, СМА нь МҮЭ-ээс гаргуулж авсан мэдээлэл болон МУТСТ хуулийн 18.5-д заасны дагуу холбогдох байгууллагаас гаргуулж авсан иргэний, хуулийн этгээдийн болон эд хөрөнгийн бүртгэл, нийгмийн даатгалын бүртгэл, хилээр нэвтэрсэн тухай бүртгэл, хөрөнгө оруулалтын бүртгэл, банк хоорондын гүйлгээний бүртгэлийн лавлагааг гадаадын СМА-тай солилцож болно.

### *Зохицуулагчдын мэдээлэл солилцоо*

415. *Шалгуур 40.12* - Монголбанк нь банкуудын, харин СЗХ болон СМА нь бусад СБ-ын МУТСТ хяналт шалгалтыг тус тус хариуцна. Төв банкны тухай хуулийн 33-т Монголбанкны гадаад харилцааг зохицуулсан бөгөөд Монголбанк гадаадын 9 түнштэй ХОСБ үзэглэснээр хүсэлтэд хариу өгөх, шилжүүлэх ажилд томоохон дөхөм болжээ. Банкны бус секторын МУТСТ хяналт шалгалтыг хариуцсан СЗХ-ны гадаад хамтын ажиллагааг СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хуулийн 16.1.1-д зааж өгсөн ба СЗХ нь гадаад түншүүдтэй 6 ХОСБ үзэглэснээр хүсэлтэд хариу өгөх, шилжүүлэх ажилд томоохон дөхөм болжээ. Гэхдээ санамж бичгүүдэд МУТСТ зорилгоор мэдээлэл солилцох заалтууд орсон эсэх нь тодорхойгүй байна (зарим санамж бичгийг орчуулаагүй байв). Шалгуур 40.9-т дурьдсанчлан, СМА-ны хувьд олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх таатай эрх зүйн орчин бүрджээ.

416. *Шалгуур 40.13* - Монголбанк, СЗХ-ны үндсэн хууль тогтоомжид мэдээллийг солилцох тухай тодорхой заагаагүй ч гадаад хамтын ажиллагааг зохицуулсан ажээ. Орчуулагдсан ХОСБ-ээс харахад зохицуулагчид гадаад түншүүдтэй мэдээлэл солилцох бүрэн боломжтой байна. Шалгуур 40.11-д дурьдсанчлан СМА нь мэдээлэл солилцох хангалттай эрх мэдэлтэй аж.

417. *Шалгуур 40.14* – Монголбанк, СЗХ-ны үндсэн хууль тогтоомжид зохицуулалтын, зохистой үзүүлэлтүүдийн болон МУТСТ мэдээллийг солилцох тухай тодорхой заагаагүй ч гадаад хамтын ажиллагааг тусгасан ажээ. Орчуулагдсан ХОСБ-ээс харахад зохицуулагчид гадаад түншүүдтэй зохицуулалтын, зохистой үзүүлэлтүүдийн болон МУТСТ мэдээллийг солилцох бүрэн боломжтой байна. Шалгуур 40.11-д дурьдсанчлан, СМА нь мэдээлэл солилцох хангалттай эрх мэдэлтэй аж.

418. *Шалгуур 40.15* - Монголбанк, СЗХ-ны үндсэн хууль тогтоомжид гадаад түншүүдийн өмнөөс шалгаж, магадлах ажиллагааг гүйцэтгэж болно хэмээн шууд заагаагүй ч гадаад хамтын ажиллагааг тусгасан ажээ. Орчуулагдсан ХОСБ-ээс харахад зохицуулагчид гадаад түншүүдийн өмнөөс шалгаж, магадлах ажиллагааг гүйцэтгэх бүрэн боломжтой юм. СЗХ нь гадаад түншүүдийн нэрийн өмнөөс 2 удаагийн шалгах ажлыг гүйцэтгэжээ.

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

419. *Шалгуур 40.16* - Монголбанк, СЗХ-ны үндсэн хууль тогтоомжид энэхүү шалгуурыг шууд заагаагүй ч албан ёсны мэдээлэл ашиглах заалт тусгагдсан бөгөөд шилжүүлж буй мэдээллийг хэрхэн ашиглах, гуравдагч этгээдэд дамжуулах нөхцөл, боломжийг ХОСБ-үүдэд тусгадаг байна.

### *ХСБ-ын мэдээлэл солилцоо*

420. *Шалгуур 40.17* - ЭБШХ-ийн 45-р бүлэгт МУТС болон суурь гэмт хэргийн мэдээллийг гадаадын түншүүдтэй солилцож болох талаар заажээ. Түүнчлэн УПЕГ, ЦЕГ, ТЕГ, АТГ, ГЕГ нь бүс нутгийн түншүүдтэй ХОСБ үзэглэснээр мэдээлэл солилцох боломж бүрджээ.

421. *Шалгуур 40.18* - ЭБШХ-ийн 401-д заасны дагуу ЭЗХТ-ны гүйцэтгэлийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нар ЭБШХ-д тусгасан дүрэм журмын дагуу, Зөвлөмж 31-д заасан эрх мэдлийн хүрээнд хэрэгжүүлнэ.

422. *Шалгуур 40.19* - ЭБШХ-ийн 45-р бүлэгт заасны дагуу ХСБ-ууд гадаадын байгууллагуудтай хамтран ажиллаж, мэдээлэл солилцох боломжтой бол мөн хуулийн 401.3-т зааснаар ЭЗХТ-аг гүйцэтгэхэд гадаадын байгууллага оролцож болох аж. Түүнчлэн, ЭБШХ-ийн дагуу гадаадын түншүүд нь эрүүгийн үйл ажиллагаанд экспертийн хувиар оролцох боломжтой аж. Монгол Улс мөрдөн шалгах ажиллагааг гадаадын түншүүдтэй хамтран гүйцэтгэж байжээ.

### *Түнш бус байгууллагуудын мэдээлэл солилцоо*

423. *Шалгуур 40.20* - МУТСТ хуулийн 21.1-д СМА нь гадаад улсын болон олон улсын байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллана гэсний дагуу СМА нь түнш бус байгууллагатай мэдээлэл солилцох боломжтой. Гэхдээ түнш бус байгууллага гэдэгт дурын байгууллагыг бус харин ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг буюу МУТСТ зохицуулагчийг ойлгоно.

424. Монгол Улсын эрх бүхий бусад байгууллага гадаадын түнш бус байгууллагатай мэдээлэл шууд солилцох боломжтой эсэх нь тодорхойгүй байна.

### *Дүгнэлт*

425. Монгол Улсын хууль тогтоомж нь ХСБ-ууд, СМА болон зохицуулагчдад гадаадын ижил төстэй байгууллагуудтай хамтран ажиллах, бүс нутгийн түншүүдтэй ХОСБ байгуулах өргөн боломжийг нээж байна. Гэхдээ эдгээр санамж бичгийг цаг тухайд нь байгуулсан эсэх нь тодорхойгүй байна. Мөн зохицуулагчдын (СМА-г эс тооцвол) үндсэн хууль тогтоомжид гадаадын байгууллагуудтай мэдээлэл солилцох заалт нь хэт ерөнхий байдлаар тусгагджээ. Монголбанк болон СЗХ нь гадаадын байгууллагуудтай 15 ХОСБ байгуулжээ. **Монгол Улс Зөвлөмж 40-ийн “дийлэнхийг биелүүлсэн” үнэлгээтэй байна.**

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

Хураангуй: Техникийн хэрэгжилтийн үндсэн сул талууд

| <b>Монгол Улс ФАТФ-ын зөвлөмжийг хэрэгжүүлсэн байдал</b>       |                       |   |
|--|-----------------------|---|
| <b>Зөвлөмж</b>   | <b>Үнэлгээ</b>        | <b>Үнэлгээнд нөлөөлсөн хүчин зүйлс</b>  |
| 1. Эрсдэлийн үнэлгээ, эрсдэлд суурилсан аргачлалын хэрэгжүүлэх | Хэсэгчлэн биелүүлсэн  | <ul style="list-style-type: none"> <li>• ҮЭҮ нь МУ аюул заналыг тодорхойлоход чиглэжээ. ҮЭҮ-нд МУ эрсдэлийг ойлгох, дүн шинжилгээ хийсэн зүйл алга. МУ эрсдэлийн иж бүрэн үнэлгээний хүрээнд МУ үр дагавар, эмзэг байдлыг авч үзээгүй аж.</li> <li>• ҮЭҮ-нд ТС аюул занал, эмзэг байдлыг тодорхойлж дүн шинжилгээ хийхэд анхаараагүй байна.</li> <li>• Засгийн газрын секторуудын түвшинд нөөцийн оновчтой хуваарилалтыг хийх замаар ҮЭҮ-д тодорхойлсон эрсдэлийг бууруулах стратеги бодлого үгүйлэгдэж байна.</li> <li>• Зөвлөмж 1-д тусгасан чөлөөлөх заалтыг Монгол Улс ашиглаагүй байна.</li> <li>• Зөвлөмж 22, 23, 26, 28-уудтай холбоотой цуврал доголдол оршиж байна.</li> <li>• МҮЭ-үүд МУТС дотоод хяналтын хөтөлбөртэй байх ёстой ч МУТСТ хууль, УСЖ-д МҮЭ нь эрсдэлээ ойлгох шаардлагатайг шууд тусгасан зүйл алга.</li> <li>• МҮЭ-үүд МУТС дотоод хяналтын хөтөлбөртэй байх ёстой ч МУТСТ хууль, УСЖ-д МҮЭ нь эрсдэлээ удирдаж бууруулах шаардлагатайг шууд тусгасан зүйл алга.</li> <li>• СБ, СББМҮҮ-ид хялбаршуулсан арга хэмжээ авах боломжгүй.</li> </ul> |
| 2. Үндэсний хамтын ажиллагаа, уялдаа холбоо                    | Хэсэгчлэн биелүүлсэн  | <ul style="list-style-type: none"> <li>• МУТСТ үндэсний стратеги, Үйл ажиллагааны хөтөлбөр батлагдаагүй байв.</li> <li>• Монгол Улсад МУ-тай тэмцэх бодлогыг үндэсний хэмжээнд хариуцах ХАЗ ажиллаж байна. Мөн Терроризмын эсрэг хуулийг хэрэгжүүлэх Терроризмтай тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөл (ТТАЗЗ) ажиллаж байна. Үйл ажиллагааны түвшинд эдгээр зөвлөлийн ажлын уялдаа хангалтгүй байна.</li> <li>• Монгол Улсад ҮОХЗДС-тэй тэмцэх ажлыг зохицуулах, уялдуулах механизм байхгүй байна.</li> </ul>   |
| 3. Мөнгө угаах гэмт хэрэг                                      | Дийлэнхийг биелүүлсэн | <ul style="list-style-type: none"> <li>• Монгол Улс Хууль бусаар хуулбарлах гэмт хэргийг эс тооцвол ФАТФ-аас тодорхойлсон суурь гэмт хэргийн бүх ангиллыг хамарч байна.</li> <li>• МУ хэрэг үйлдсэн хувь хүмүүст ногдуулах шийтгэл нь зөрчилтэй нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэхүйц байж чадахгүй байна.</li> <li>• МУ хэрэг үйлдсэн хувь хуулийн этгээдэд ногдуулах шийтгэл нь зөрчилтэй нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэхүйц байж чадахгүй байна.</li> </ul>   |
| 4. Хөрөнгө хураах  | Дийлэнхийг            | <ul style="list-style-type: none"> <li>• Монгол Улсад царцаасан, битүүмжилсэн, хураасан</li> </ul>  |

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

|   |                       |  |
|---|-----------------------|--|
| болон түр зуурын арга хэмжээ  | биелүүлсэн            | хөрөнгийг удирдах, шаардлагатай бол түүнийг чөлөөлөх механизм байхгүй байна.   |
| 5. Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг  | Дийлэнхийг биелүүлсэн | <ul style="list-style-type: none"> <li>Монгол Улс ТС гэмт хэрэгт Шалгуур 5.2 bis-г заасан хувь хүмүүсийн терроризмтой холбоотой аяллыг санхүүжүүлэх үйлдлийг оруулаагүй байна.</li> <li>Хуулийн этгээдэд ногдуулах эрүүгийн хариуцлага дахин үйлдэхээс сэргийлэхүйц байж чадахгүй байна.</li> </ul>  |
| 6. Терроризм болон ТС холбоотой санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ                     | Хэсэгчлэн биелүүлсэн  | <ul style="list-style-type: none"> <li>Монгол Улс хөрөнгө царцаах; санхүүжүүлэхийг хориглох; СБ-ууд болон СББМҮҮ-ид царцаасан хөрөнгө, авсан арга хэмжээгээ тайлагнах шаардлагыг хуулийн хүрээнд мөрдүүлэх боломжгүй байна.</li> <li>ТЕГ-г нөгөө талд мэдэгдэхгүйгээр үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн шууд заалт байхгүй аж.</li> <li>ТТ хууль, ТЭЖО журмаас өөр хөрөнгө царцаах зааврыг санхүүгийн салбар, СББМҮҮ нарт хүргүүлээгүй ажээ.</li> <li>Монгол Улсад гуравдагч этгээдийн эрхийг хамгаалах арга хэмжээ байхгүй аж.</li> <li>Монгол Улсад террорист жагсаалтаас гаргах, царцаасан хөрөнгийг чөлөөлөх олон нийтэд ил тод процедур байхгүй аж.</li> </ul> |
| 7. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ | Биелүүлээгүй          | <ul style="list-style-type: none"> <li>Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, түүнийг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх эрх зүйн орчин байхгүй байна.</li> </ul>  |
| 8. Ашгийн бус байгууллагууд (АББ)   | Хэсэгчлэн биелүүлсэн  | <ul style="list-style-type: none"> <li>ҮЭҮ-нд АББ-уудтай холбоотой аюул занал, эрсдэлийг зохих түвшинд тусгаагүй байна.</li> <li>Монгол Улс дараах ажил хийгээгүй байна: (i) эрсдэл өндөртэй АББ-уудын ойлголтыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх, (ii) эрсдэл өндөртэй АББ-уудтай хамтран ТС эрсдэл, эмзэг байдлыг арилгах туршлагыг бий болгох, (iv) АББ-ууд зохицуулалттай санхүүгийн сувгаар дамжуулан гүйлгээ хийхийг явдлыг өөгшүүлэн дэмжих.</li> <li>ТББ хуульд тусгасан шийтгэлийн арга хэмжээ нь гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэхүйц байж чадахгүй байна.</li> </ul>   |
| 9. Санхүүгийн байгууллагын нууцлалтай холбоотой хууль тогтоомж                            | Дийлэнхийг биелүүлсэн | <ul style="list-style-type: none"> <li>СБ-ын нууцын тухай хууль нь МУТСТ үйл ажиллагаанд саад тотгор учруулахгүй байгаа ч СБ-ууд нь корреспондент банк, мөнгөн шилжүүлэг, гуравдагч этгээдэд тулгуурах шаардлагыг хэрэгжүүлэх зорилгоор мэдээлэл хуваалцаж болох эсэх нь тодорхойгүй байна.</li> </ul>   |
| 10. Харилцагчийг таньж мэдэх  | Дийлэнхийг биелүүлсэн | <ul style="list-style-type: none"> <li>24 цагийн дотор хийгдсэн хоорондоо холбоотой гүйлгээний ХТМ шаардлага учир дутагдалтай байж болно, учир нь гүйлгээнүүд хэд хоногийн дараа,</li> </ul>   |

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

|  |                       |   |
|--|-----------------------|---|
|  |                       | <p>тогтоосон босгоос давсан байдлаар хийгдэж болно. МУТС-д сэжиглэж буй гүйлгээний хувьд ямар нэгэн босго эсхүл хөнгөлөлт үйлчлэхгүй гэдгийг заасан зүйл алга (гэхдээ тэгж ойлгогдохоор байгаа).</p> <ul style="list-style-type: none"> <li>• МУТСТ хуульд МҮЭ нь хуулийн этгээдийн ЭӨ-ийг тодорхойлох шаардлагатайг заажээ. Гэхдээ бусад арга хэрэгслээр дамжуулан хяналт тавьж буй хувь хүнийг тодорхойлох эсхүл удирдах албан тушаал хашиж буй хувь хүнийг тодорхойлох шаардлага тавигдахгүй байна.</li> <li>• Даатгалын салбарыг ҮЭҮ-нд бага эрсдэлтэй гэж тодорхойлсон ч амь насны даатгалын үр шимийг хүртэж буй этгээдэд тусгайлсан эсвэл өргөтгөсөн ХТМ үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлага тавигддаггүй байна.</li> </ul> |
| 11. Баримт, материал хадгалалт                     | Биелүүлсэн            | -   |
| 12. Улс төрд нөлөө бүхий этгээд (УТНБЭ)            | Дийлэнхийг биелүүлсэн | <ul style="list-style-type: none"> <li>• УСЖ нь дотоодын УТНБЭ, олон улсын байгууллагад өндөр албан тушаал хашдаг хүмүүст хамаарна. Гэхдээ үүнд харилцагчийн эцсийн өмчлөгч эсхүл олон улсын байгууллагын өндөр албан тушаалтны тодорхойлох заалт алга.</li> <li>• УТНБЭ шаардлага нь даатгалын салбарт мөн хамаарна. Гэхдээ амь насны даатгалын нөхөн олговрыг төлөхөөс өмнө дээд удирдлагад мэдэгдэх, бизнесийн харилцааг бүхэлд нь нэг бүрчлэн шинжлэх, өндөр эрсдэл илэрсэн тохиолдолд СГТ-ээр мэдэгдэх шаардлага тавигддаггүй байна. Монгол Улсад амь насны даатгалын үйлчилгээ үзүүлдэг зөвхөн 1 компани байдаг, даатгалын салбар нь эрсдэл багатайд тооцогдох тул 12.4 дэх доголдолд бага жин өгч байгаа болно.</li> </ul>   |
| 13. Корреспондент банкны үйл ажиллагаа             | Дийлэнхийг биелүүлсэн | <ul style="list-style-type: none"> <li>• УСЖ нь халхавч банк, СБ-тай санхүүгийн харилцаа тогтоохыг хориглодог. Гэхдээ халхавч банктай бизнесийн харилцааг үргэлжлүүлэхийг хориглосон заалт байхгүй аж.</li> </ul>   |
| 14. Мөнгө болон үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ | Хэсэгчлэн биелүүлсэн  | <ul style="list-style-type: none"> <li>• Тусгай зөвшөөрөлгүй, бүртгэлгүй мөнгө болон үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ үзүүлэгчдийг тогтоож, шийтгэл ногдуулсныг Монгол Улс нотлоогүй болно. Шийтгэлийн арга хэмжээ нь гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэхүйц байж чадахгүй байна.</li> <li>• Мөнгө болон үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ үзүүлж буй ББСБ-ууд: 1/ агентууд ажиллуулдаг эсэх; 2/ агентууд тусгай зөвшөөрөл авах, бүртгүүлэх шаардлагатай эсэх буюу ББСБ-ууд нь агентуудынхаа бүртгэл хөтлөх шаардлагатай эсэх; 3/ агентууд МУТСТ хөтөлбөрт хамрагддаг эсэх, тэдний комплаенсыг хянадаг эсэх нь тодорхойгүй байна.</li> </ul>  |

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

|  |                       |  |
|--|-----------------------|--|
| 15. Шинэ технологи                                       | Дийлэнхийг биелүүлсэн | <ul style="list-style-type: none"> <li>• СЗХ нь шинэ бүтээгдэхүүн, бизнесийн практик, шинэ технологи хөгжүүлэхтэй холбоотой МУТС эрсдэлийг тодорхойлж, үнэлгээ өгдөг эсэх нь тодорхойгүй байна.</li> <li>• Шинэ бүтээгдэхүүн, бизнесийн практик, шинэ технологийг хэрэгжүүлэхийн өмнө эрсдэлийн үнэлгээ хийх шаардлага МҮЭ-үүдэд тавигддаг эсэх нь тодорхойгүй байна.</li> </ul>   |
| 16. Цахим мөнгөн шилжүүлэг                               | Дийлэнхийг биелүүлсэн | <ul style="list-style-type: none"> <li>• Зөвхөн Шалгуур 16.1-ийг биелүүлээгүй тохиолдолд УСЖ-ын дагуу цахим мөнгөн шилжүүлэг гүйцэтгэхийг хориглодог байна. Угтаа бол Шалгуур 16.2-16.7 биелүүлээгүй нөхцөлд ч шилжүүлгийг хориглох ёстой.</li> <li>• Мөнгө болон үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ үзүүлэгч нар цахим мөнгөн шилжүүлэгт тавигддаг шаардлагыг биелүүлэх ёстой. Гэтэл Шалгуур 16.1-д хамаарах бүх арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд авч үзээгүй байна.</li> <li>• Мөнгө болон үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ үзүүлэгчид СГТ мэдээлэх үүрэгтэй. Гэтэл шилжүүлэгч, хүлээн авагч аль аль талыг нь хянаж буй үйлчилгээ үзүүлэгч хоёр талын мэдээллийг судлан үзэж шаардлагатай бол СГТ-аар мэдээлэх, мөнгө болон үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ үзүүлэгчээс сэжигтэй гүйлгээ хийгдсэн улс оронд СГТ-аар мэдээлэх, ийм мэдээллийг СМА-д хүргүүлэх зэрэг шаардлага тавигддаггүй ажээ.</li> <li>• ТТ хууль болон ТЭЖО журамд мөнгөн шилжүүлэг гүйцэтгэж буй СБ-уудад царцаах үүрэг ногдуулдаг ч үүнийг мөрдүүлэх боломжгүй байна. Монгол Улсын ТС эрсдэл бага байгаа нь дээрхи доголдлын нөлөөллийг сулруулж байна.</li> </ul> |
| 17. Гуравдагч этгээдэд тулгуурлах                        | Биелүүлээгүй          | <ul style="list-style-type: none"> <li>• УСЖ нь гуравдагч этгээдэд өөрийн нэрийн өмнөөс ХТМ үйл ажиллагааг гүйцэтгэхийг зөвшөөрдөг. Гэвч: (i) Гуравдагч этгээдэд тулгуурлах явдлыг зөвхөн гуравдагч этгээдийн СБ болон СБМҮҮ-ээр хязгаарлах, (ii) Гуравдагч этгээдэд тулгуурлах явдлыг зөвхөн бизнесийн мөн чанар, ЭӨ, харилцагчаар хязгаарлах, (iii) ХТМ эцсийн хариуцлага нь МҮЭ-д үлдэх, (iv) Гуравдагч этгээдийн аль улсад байгааг тодорхойлохдоо тухайн улсын эрсдэлийг харгалзан үзэх, (v) Нэг санхүүгийн нэгдэлд харьяалагдах МҮЭ-ийн гуравдагч этгээдэд тулгуурлах явдлыг зохицуулах зэрэг шаардлага байхгүй байна.</li> </ul>   |
| 18. Дотоод хяналт болон гадаад дахь салбар, охин компани | Дийлэнхийг биелүүлсэн | <ul style="list-style-type: none"> <li>• Шинэ ажилтныг шалгаруулахдаа зөвхөн ашиг сонирхлын зөрчил, өмнө нь залилангийн хэрэгт холбогдож байсан эсэхийг тодруулж байна.</li> <li>• МУТСТ хөтөлбөр бүлгийн түвшинд хэрэгжих шаардлага байхгүй байна (тухайлбал, МУТС</li> </ul>   |

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

|   |                       |   |
|---|-----------------------|---|
|   |                       | эрсдэлийн удирдлагын мэдээллийг хуваалцах, бүлгийн түвшинд комплаенс, аудитыг хэрэгжүүлэх, нууцлалыг хангах, солилцсон мэдээллийг ашиглах)  |
| 19. Өндөр эрсдэлтэй улс орнууд  | Хэсэгчлэн биелүүлсэн  | <ul style="list-style-type: none"> <li>Монгол Улс өндөр эрсдэлтэй орны харилцагчдын хувьд өргөтгөсөн ХТМ үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Гэхдээ: (i) МУТСТ хуульд ФАТФ-аас зарласан улс орнууд гэж заагаагүй; (ii) эрсдэлтэй нь уялдуулан өргөтгөсөн ХТМ үйл ажиллагааг хэрэгжүүлж хариу арга хэмжээ авах шаардлага байхгүй байна.</li> </ul>  |
| 20. Сэжигтэй гүйлгээг мэдээлэх  | Дийлэнхийг биелүүлсэн | <ul style="list-style-type: none"> <li>“Гэмт хэргийн гаралтай мөнгө” гэх тодорхойлолт нь зөвхөн мөнгөн орлогыг илэрхийлж, эд хөрөнгийг хамрахгүй байгаа бага зэргийн дутагдал оршиж байна.</li> </ul>   |
| 21. Мэдээллийг задруулах болон нууцлал  | Хэсэгчлэн биелүүлсэн  | <ul style="list-style-type: none"> <li>"Банкны болон мэргэжлийн нууцлал" гэх тодорхойлолтод иргэний болон эрүүгийн хариуцлагаас чөлөөлж буй нь тодорхойгүй байгаа бөгөөд УСЖ-ын 12.1, 12.2 нь зөвхөн МҮЭ-эд хамаарах ба захирлууд, ажилтнууд, албан хаагчдад хамаарахгүй байна.</li> <li>СМА-нд мэдээлэл ирүүлэх журам нь зөвхөн банк, түүний захирал, албан тушаалтан, ажилтнуудыг хамарч байна. Харин банкнаас бусад этгээдийн захирлууд, ажилтнуудад хуулиар хориглосон заалт байхгүй аж.</li> </ul> |
| 22. СББМҮҮ Харилцагчийг таньж мэдэх   | Биелүүлээгүй          | <ul style="list-style-type: none"> <li>МУТСТ хуулийг СББМҮҮ-ээс зөвхөн нотариатчид биелүүлэх үүрэгтэй нь тус хуулийн хамрах хүрээ доголдож буйг харуулж байна.</li> <li>Зөвлөмж 12, 15, 17-той холбоотой цуврал доголдол оршиж байна.</li> </ul>  |
| 23. СББМҮҮ бусад арга хэмжээ  | Биелүүлээгүй          | <ul style="list-style-type: none"> <li>МУТСТ хуулийг СББМҮҮ-ээс зөвхөн нотариатчид биелүүлэх үүрэгтэй нь тус хуулийн хамрах хүрээ доголдож буйг харуулж байна.</li> <li>Зөвлөмж 20, 18, 19, 21-той холбоотой цуврал доголдол оршиж байна.</li> </ul>  |
| 24. Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон ил тод байдал                          | Хэсэгчлэн биелүүлсэн  | <ul style="list-style-type: none"> <li>Монгол Улс МУТС эрсдэлийн үнэлгээг хуулийн этгээдийн төрөл бүрээр хийж гүйцэтгээгүй байна.</li> <li>ОӨУБЕГ-т ирүүлж буй мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг шалгах механизм байхгүй байна.</li> <li>Шийтгэлийн арга хэмжээ нь зөрчилтэй нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэхүйц байж чадахгүй байна.</li> <li>Хүлээн авч буй туслалцааны чанарыг хянах механизм байхгүй байна.</li> </ul>  |
| 25. Эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн ил тод байдал болон эцсийн өмчлөгч | Хэсэгчлэн биелүүлсэн  | <ul style="list-style-type: none"> <li>Итгэмжлүүлэгч нь бизнесийн харилцаа холбоо үүсгэх эсхүл босго дүнгээс дээш дүнтэй гүйлгээг хийхдээ СБ болон СББМҮҮ-д статусаа мэдэгдэх шаардлага тавигддаггүй байна.</li> <li>ЭБШХ-ийн дагуу ХСБ-ууд нь МҮЭ-үүдийн ХТМ хүрээнд цуглуулсан мэдээллийг гаргуулан авах</li> </ul>   |

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

|  |                       |   |
|--|-----------------------|---|
|  |                       | <p>эрхтэй. Гэхдээ СББМҮҮ-ийг хамрах хүрээнд доголдол оршиж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• СБ-ын ХТМ хүрээнд цуглуулсан мэдээллээр Монгол Улс олон улсын туслалцаа үзүүлэх боломжтой. Гэхдээ Зөвлөмж 40-өөс эхлэн цуврал доголдол оршиж байна.</li> <li>• Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй гадаадын трастуудад хүлээлгэх хуулийн хариуцлага, шийтгэл байхгүй тул тэд траст гэсэн статусаа илчилдэггүй ажээ.</li> </ul>   |
| 26. Санхүүгийн байгууллагуудын хяналт шалгалт, зохицуулалт   | Хэсэгчлэн биелүүлсэн  | <ul style="list-style-type: none"> <li>• Монгол Улсад халхавч банк байгуулахыг шууд хориглосон заалт байхгүй.</li> <li>• Гэмт хэрэгтнүүд эсхүл тэдний хамсаатнууд СБ-ын дийлэнхи эсхүл хяналтын багц эзэмших (эцсийн өмчлөгч болох), удирдах албан тушаал хашихаас урьдчилан сэргийлэх хуулийн болон зохицуулалтын арга хэмжээ хангалтгүй байна.</li> <li>• Монгол Улсын хууль тогтоомжид ФАТФ-ын Үндсэн Зарчмуудыг дагаж мөрдөхийг шууд заасан зүйл байхгүй.</li> <li>• МУТС хяналт шалгалтын давтамж, хамрах хүрээг МУТС эрсдэлтэй нь уялдуулах хууль тогтоомж байхгүй ажээ.</li> <li>• СБ-ын удирдлага, үйл ажиллагаанд томоохон хөдөлгөөн гарах үед МУТС эрсдэлийн үнэлгээг дахин гүйцэтгэх шаардлага байхгүй байна.</li> </ul> |
| 27. Хянан шалгагчдын эрх мэдэл   | Дийлэнхийг биелүүлсэн | <ul style="list-style-type: none"> <li>• Монголбанк, СЗХ, СМА нь Холбогдох хууль тогтоомжийн дагуу МУТСТ хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ. Гэхдээ шийтгэлийн арга хэмжээ нь тодорхойгүй бөгөөд Зөвлөмж 35-аас эхлээд цуврал доголдол оршиж байна.</li> </ul>  |
| 28. Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч нар (СББМҮҮ)-ын хяналт шалгалт, зохицуулалт | Биелүүлээгүй          | <ul style="list-style-type: none"> <li>• МУТС хуулийг СББМҮҮ-ээс зөвхөн нотариатчид биелүүлэх үүрэгтэй нь тус хуулийн хамрах хүрээ доголдож буйг харуулж.</li> <li>• Үл хөдлөх эд хөрөнгийн зуучлагчдад хяналт тавих зохицуулагч байхгүй байна.</li> <li>• СББМҮҮ-ид МУТС хууль болон УСЖ-ын биелэлтийг хангасан зүйл байхгүй, хяналт шалгалтад хамрагдаж байгаагүй байна.</li> </ul>   |
| 29. Санхүүгийн мэдээлэлын алба   | Хэсэгчлэн биелүүлсэн  | <ul style="list-style-type: none"> <li>• СМА нь нэмэлт мэдээллийг зөвхөн банкуудаас гаргуулах боломжтой. Харин бусад МҮЭ-ээс нэмэлт мэдээлэл шаардах зохицуулалт байхгүй байна.</li> <li>• СМА нь стратегийн дүн шинжилгээ хийж байгаагүй.</li> <li>• СМА-ны дарга нь төсвөө захиран зарцуулах эрхтэй ч бүтэц, стратеги төлөвлөгөө, албаны төсвийг Монголбанкны Ерөнхийлөгчөөр батлуулдаг байна.</li> </ul>   |
| 30. Хууль сахиулах болон мөрдөн шалгах байгууллагуудын   | Хангасан              | -   |

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

|  |                       |  |
|--|-----------------------|--|
| хариуцлага   |                       |  |
| 31. Хууль сахиулах болон мөрдөн шалгах байгууллагуудын эрх мэдэл     | Хангасан              | -  |
| 32. Бэлэн мөнгө тээвэрлэгчид   | Хэсэгчлэн биелүүлсэн  | <ul style="list-style-type: none"> <li>Монгол Улс нь гаалийн мэдүүлгийн болон тодруулгын холимог тогтолцоотой. Мэдүүлгийн систем нь дотоод, гадаад валют, МТХ-ийг хамардаг боловч зөвхөн олон улсын нисэх онгоцны буудалд хэрэгжиж байна. Тодруулах систем нь бусад бүх хилийн цэгүүдэд хэрэгжиж байгаа ч МТХ-үүдийг хамрахгүй байна.</li> </ul>   |
| 33. Статистик  | Хэсэгчлэн биелүүлсэн  | <ul style="list-style-type: none"> <li>Монгол Улс МУТС мөрдөн шалгалт, ял шийтгэл, царцаасан, битүүмжилсэн, хураасан хөрөнгө, ЭЗХТ болон олон улсын хүсэлт зэрэгтэй холбоотой цогц иж бүрэн статистик мэдээ байхгүй байна.</li> <li>Эрх бүхий байгууллага бүрийг хамарсан хууль тогтоомж байхгүй байна.</li> </ul>   |
| 34. Зааварчилгаа эргэх холбоо  | Хэсэгчлэн биелүүлсэн  | <ul style="list-style-type: none"> <li>СББМҮҮ-дэд заавар зөвлөмж хүргүүлж байгаагүй ажээ.</li> </ul>   |
| 35. Шийтгэлийн арга хэмжээ   | Хэсэгчлэн биелүүлсэн  | <ul style="list-style-type: none"> <li>Монгол Улсын эрүүгийн ял шийтгэл нь зөвхөн ЭБШХ-д тусгагдсан бөгөөд түүнд МУТСТ хууль, ТТ хууль, УСЖ-ын зөрчлийг гэмт хэрэгт тооцох тухай заалт байхгүй аж.</li> <li>Захиргааны шийтгэлийн арга хэмжээ нь гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэхүйц байж чадахгүй байна.</li> <li>Зөвлөмж 6-ийн зөрчилд хүлээлгэх хариуцлага байхгүй байна.</li> <li>МУТС хуулийг СББМҮҮ-ээс зөвхөн нотариатчид биелүүлэх үүрэгтэй нь тус хуулийн хамрах хүрээ доголдож буйг харуулж байна. Нотариат, ТББ-ад ногдуулах шийтгэл нь гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэхүйц байж чадахгүй байна.</li> </ul> |
| 36. Олон улсын хамтын ажиллагааны арга хэрэгслүүд                    | Хангасан              | -  |
| 37. Эрх зүйн харилцан туслалцаа                                      | Хангасан              | -  |
| 38. Эрх зүйн харилцан туслалцаа: хөрөнгө царцаах, битүүмжлэх, хураах | Дийлэнхийг биелүүлсэн | <ul style="list-style-type: none"> <li>Зөвлөмж 4-өөс эхлэн цуврал доголдол оршиж байна - царцаасан эд хөрөнгийн удирдах, зохицуулах, шилжүүлэх тогтолцоо</li> </ul>  |
| 39. Гэмт хэрэгтнийг  | Дийлэнхийг            | <ul style="list-style-type: none"> <li>Монгол Улсын шилжүүлэн өгөх хууль эрх зүйн</li> </ul>   |

## ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

| шилжүүлэх                                      | биелүүлсэн            | <p>тогтолцоо хангалттай түвшинд бүрджээ. ЭБШХ-ийн 40б-д шилжүүлэн өгөхөөс татгалзах үндэслэлийг тодорхойлсон бага зэргийн доголдол оршиж байна. Тус зүйл нь Монгол Улсын шилжүүлэн өгөх үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй юм.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Шилжүүлэн өгөх хялбаршуулсан механизм байхгүй байна.</li> </ul>   |
|--|-----------------------|--|
| 40. Олон улсын хамтын ажиллагааны бусад хэлбэр | Дийлэнхийг биелүүлсэн | <ul style="list-style-type: none"> <li>• ХСБ-ууд, СМА, зохицуулагчдын хувьд олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрджээ. Гэхдээ: (i) ХСБ-уудын мэдээлэл нууцлах үйл явц тодорхойгүй, хүсэлтийг эрэмбэлэх эсхүл цаг хугацаанд нь гүйцэтгэх механизмгүй байна, (ii) Монголбанк, СЗХ нь хүсэлтийг эрэмбэлэх эсхүл цаг хугацаанд нь гүйцэтгэх механизмгүй байна, тэд хамгийн үр дүнтэй аргыг сонгох боломжтой нь тодорхойгүй байна.</li> <li>• ХОСБ-үүдийг цаг тухайд нь байгуулж чадсан эсэх нь тодорхойгүй байна.</li> <li>• Гадаадын эрх бүхий байгууллагын хүсэлт тус бүрт хариу өгөх боломжтой ч СМА-аас гаргаж өгсөн маш ерөнхий статистикийг эс тооцвол Монголын эрх бүхий байгууллагуудын зүгээс гадаадын түнш байгууллагуудад өгсөн хариултын тоо мэдээг Монгол Улс гаргаж өгөөгүй болно.</li> <li>• Зохицуулагчид гадаад улс орны мэдээллийн нууцлалыг хангах маш ерөнхий заалтууд байдаг ажээ.</li> <li>• СМА нь санал хүсэлтэд хариу өгөх эрх зүйн зохицуулалттай ч цөөн тохиолдолд үүнийг хэрэгжүүлсэн байна.</li> <li>• Зохицуулагчид хуулийн хүрээнд хамтын ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой бөгөөд 18 ХОСБ байгуулжээ. Гэхдээ үндсэн хууль тогтоомжид Шалгуур 40.12- 40.16-г хангах маш ерөнхий заалтууд тусгагдсан ажээ.</li> <li>• СМА нь хамтрагч бус байгууллагатай мэдээлэл солилцох боломжтой ч үүнд СМА-тай адил төстэй үйл ажиллагаа явуулдаг эсхүл МУТСТ зохицуулагчийг ойлгоно (дурын байгууллага бус). Бусад эрх бүхий байгууллага хамтрагч бус байгууллагатай мэдээлэл солилцох боломжтой болохыг Монгол Улс нотлоогүй болно.</li> </ul> |

## ҮГИЙН ТОВЧЛОЛЫН ТАЙЛБАР

|                          |  |
|--------------------------|--|
| АББ                      | Ашгийн бус байгууллага   |
| АТГ                      | Авлигатай тэмцэх газар   |
| АТХ                      | Авлигатай тэмцэх тухай хууль, 2006 он (2012 онд шинэчлэн найруулсан)     |
| АХБ                      | Азийн хөгжлийн банк  |
| ББСБ                     | Банк бус санхүүгийн байгууллага  |
| ББСБ-ын тухай хууль      | Банк бус санхүүгийн байгууллагын тухай хууль 2002                        |
| Бичил уурхайчид          | Гар аргаар олборлогчид буюу бичил уурхайчид                              |
| БМГТ                     | Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан   |
| БНАСАУ                   | Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс                                |
| Гаалийн тухай хууль      | Гаалийн тухай хууль, 2008 он   |
| Гадаадын террористууд    | Гадаадын алан хядагчид   |
| ГЕГ                      | Гаалийн ерөнхий газар  |
| ГТТГТ                    | Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлан                                 |
| ГХЯ                      | Гадаад харилцааны яам  |
| Даатгалын тухай хууль    | Даатгалын тухай хууль, 2004 он   |
| ДНБ                      | Дотоодын нийт бүтээгдэхүүн   |
| ЕАБХАБ                   | Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага                   |
| Зорчигчийн гаалийн журам | Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх журам |
| ИХ                       | Монгол Улсын иргэний хууль, 2002 он                                      |
| Компанийн тухай хууль    | Компанийн тухай хууль, 2012 он   |
| МБ                       | Монголбанк (Төв банк)  |
| МУ                       | Мөнгө угаах  |
| МУТСТ                    | Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх                          |
| МУТСТ хууль              | Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай                    |

|  |  |
|--|--|
|  | хууль  |
| МҮЭ  | Мэдээлэх үүрэгтэй этгээд   |
| НҮБ-ын Аюулгүйн зөвлөл                                     | Нэгдсэн Үндэсний Байгууллагын Аюулгүйн зөвлөл                                    |
| Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль                       | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, 2015 он                                    |
| ОӨУБЕГ   | Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар  |
| ОУВС   | Олон улсын валютын сан   |
| Өргөтгөсөн ХТМ   | Харилцагчийг таньж мэдэх өргөтгөсөн үйл ажиллагаа                                |
| СБ   | Санхүүгийн байгууллагууд   |
| СББМҮҮ   | Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч нар                         |
| СГТ  | Сэжигтэй гүйлгээний тайлан   |
| СГТ-нд дүн шинжилгээ хийх аргачлал                         | Сэжигтэй гүйлгээний тайланд дүн шинжилгээ хийх аргачлал                          |
| СЗХ  | Санхүүгийн зохицуулах хороо  |
| СЗХ-ны хууль   | Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, 2005 он              |
| СМА  | Санхүүгийн мэдээллийн алба   |
| СМА-ны аюулгүйн журам                                      | Санхүүгийн мэдээллийн албаны аюулгүй ажиллагааны журам                           |
| СМА-ны мэдээлэл хүлээж авах, боловсруулах, шилжүүлэх журам | Санхүүгийн мэдээллийн албаны мэдээлэл хүлээж авах, боловсруулах, шилжүүлэх журам |
| СМА-ны нууцлалын журам                                     | Санхүүгийн мэдээллийн албаны үйл ажиллагаанд баримтлах нууцын журам              |
| СЗХАХ  | Санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ  |
| ТЕГ  | Тагнуулын ерөнхий газар  |
| Төв банкны тухай хууль                                     | Төв банк /Монголбанк/-ны тухай хууль, 1996 он                                    |
| Төгрөг   | Төгрөг   |
| ТС   | Терроризмыг санхүүжүүлэх   |
| ТТАЗЗ  | Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөл                                 |

## ҮГИЙН ТОВЧЛОЛЫН ТАЙЛБАР

|  |   |
|--|---|
| ТГХ                                    | Терроризмтой тэмцэх тухай хууль (2013 онд шинэчлэн найруулсан)  |
| ТЭЖО                                   | Террорист этгээдийн жагсаалтад оруулах, жагсаалтад орсон этгээдийн хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох, хянах журам                        |
| УПЕГ                                   | Улсын ерөнхий прокурорын газар  |
| УСЖ                                    | МУТС-ээс урьдчилан сэргийлэх журам, 2016 он   |
| УТНБЭ                                  | Улс төрд нөлөө бүхий этгээд   |
| Үнэт цаасны тухай заавар               | Үнэт цаасны зах зээлийн өөрийгөө зохицуулах байгууллага болон зохицуулалттай этгээдийн дүрэм, журмыг батламжлах, бүртгэх тухай заавар |
| Үнэт цаасны тухай хууль                | Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, 2014 он  |
| ҮОХЗ                                   | Үй олноор хөнөөх зэвсэг   |
| ҮОХЗДС                                 | Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх   |
| ҮЭҮ                                    | Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Монгол Улсын үндэсний эрсдэлийн үнэлгээ   |
| ХАЗ                                    | Хамтын ажиллагааны зөвлөл   |
| ХАЗ-ын журам                           | Хамтын ажиллагааны зөвлөлийн үйл ажиллагааны журам, 2014 он   |
| ХЗДХЯ                                  | Хууль зүй, дотоод хэргийн яам   |
| ХЗХ                                    | Хадгаламж, зээлийн хоршоо   |
| ХЗХ-ны тухай хууль                     | Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль, 2011 он  |
| ХНБММТ                                 | Хилээр нэвтрүүлсэн бэлэн мөнгөний мэдүүлгийн тайлан   |
| ХОСБ                                   | Харилцан ойлголцлын санамж бичиг  |
| Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль | Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль  |
| ХСБ                                    | Хууль сахиулах байгууллагууд  |
| ХТМ                                    | Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа  |
| Хувь хүний нууцын тухай хууль          | Хувь хүний нууцын тухай хууль, 1995 он  |
| Хуулийн этгээдийн тухай хууль          | Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хууль, 2015 он   |
| Хуульчийн эрх зүйн байдлын тухай       | Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, 2012 он   |

|                            |  |
|----------------------------|--|
| хууль                      |  |
| ХҮ                         | Харилцан үнэлгээ                                     |
| ЦЕГ                        | Цагдаагийн ерөнхий газар                             |
| ШХО                        | Шууд хөрөнгө оруулалт                                |
| ШШГЕГ                      | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар              |
| ЭБШХ                       | Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх хууль, 2001 он |
| ЭЗХТ                       | Эрх зүйн харилцан туслалцаа                          |
| ЭЗХТ-ны гэрээ              | Эрх зүйн харилцан туслалцааны гэрээ                  |
| ЭӨ                         | Эцсийн өмчлөгч                                       |
| Эрсдэлд суурилсан аргачлал | Эрсдэлд суурилсан аргачлал                           |
| ЭХ                         | Монгол Улсын эрүүгийн хууль, 2002 он                 |

Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа

*АНДББ-ын Харилцан үнэлгээний тайлангийн 3 дугаар шат*



© APG 2017

[www.apgml.org](http://www.apgml.org)

2007 оны 9 дүгээр сар

Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо

АНДББ-ын 3 дахь үеийн Харилцан үнэлгээний тайлан

Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг 2016 оны 11 дүгээр сарын байдлаар хураангуйлан тайлагнав. Тус тайланд Монгол Улсын МУТСТ тогтолцоо үр дүнтэй эсэх, ФАТФ-ын 40 зөвлөмжийг хангаж буй эсэхэд дүн шинжилгээ хийж, тус тогтолцоог хэрхэн бэхжүүлэх талаар зөвлөмж өгөв.